



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ ХХII БОТЪ

(2024 онд хийж гүйцэтгэсэн судалгаа)

Улаанбаатар хот
2025 он

ННА 67
ДАА 340
М-231

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛСЫН ХАРАА

*Олон улсын жишигт нийцсэн эрдэм, шинжилгээ, сургалт мэдээллийн
үндэсний хүрээлэн болон хөгжинө.*

© Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Зохиогч болон нийтлэгчийн зөвшөөрөлгүйгээр тус номын агуулгыг хэсэгчлэн болон бүтнээр хэвлэх, электрон аливаа хэлбэрээр хувилах, бичлэг хийх, хайлтын системд оруулах, хэвлэн олшруулахыг хориглоно. Хууль зүйн үндэсний хүрээлэн.

Хянан тохиолдуулсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.) Х.Эрдэм-Ундрах

Эмхэтгэсэн: Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын эрхлэгч Б.Ариунжаргал
Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын
эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х.Буянбат
Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын
эрдэм шинжилгээний ажилтан М.Энхжин

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч,
дизайнер Б.Заяа

Хавтасны гэрэл зураг: Цагдаагийн ерөнхий газар

Цаасны хэмжээ: 176/250

Хэвлэлийн хуудас: 22 х.х

“Тоонот принт” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-9142-7-1

ӨМНӨХ ҮГ



Эрхэм хүндэт уншигч та бүхний амар амгаланг айлтган мэндчилье.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгасан эрх зүйн салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх зорилтын хүрээнд бид 2024 онд гүйцэтгэсэн судалгааны тайланг эмхэтгэн “Нийтийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XIX боть)”, Эрүүгийн эрх зүйд холбогдох

судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XX боть)”, “Хувийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XXI боть)”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эрх зүйн зохицуулалтад холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XXII боть)” хэмээх дөрвөн боть эмхэтгэлээ уншигч танаа толилуулж байна.

Энэхүү XXII боть нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эрх зүйн зохицуулалттай холбоотой 3 судалгааг цогц байдлаар хийж гүйцэтгэснээрээ онцлогтой.


Сүүлийн жилүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн гаралт тасралтгүй өссөн үзүүлэлттэй байгаа нь энэ төрлийн харилцаанд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай болохыг илэрхийлж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс гүйцэтгэсэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгааны хүрээнд тус хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь үнэлэхийг зорьсон бөгөөд тус хуулийн зохицуулалтын эерэг, сөрөг тал, эрх зүйн хийдэл, практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, тодорхой санал, зөвлөмж дэвшүүлсэн.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, судалгааны үр дүнд үндэслэн хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулсан. Мөн тус хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардал, ачааллыг тооцож, түүнийг бууруулах боломж болон зардал үр өгөөжийн харьцааг шинжлэн судалж “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо” сэдэвт судалгааны тайланг гүйцэтгэсэн болно.

Уг ботид багтсан бидний судалгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой эрх зүйн зохицуулалтын тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэхэд зохих ёсны хувь нэмрийг оруулахын зэрэгцээ хууль зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж буй эрдэмтэн, судлаач, тус салбарт ажиллаж буй албан хаагчид, оюутнуудын судалгааны чухал эх сурвалж болно гэдэгт итгэж байна.

ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ

ГАРЧИГ

Өмнөх үг	III
Товчилсон үгийн жагсаалт	VI
Хүснэгтийн жагсаалт	VII
Графикийн жагсаалт	X
Зургийн жагсаалт	XI
Нэг. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	1
Хоёр. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан	117
Гурав. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо	171

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн нэгдсэн улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГТЛ	Гаалийн төв лаборатори
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗБГХТГ	Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МЭСНБЭХТХ	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОХУ	Оросын холбооны улс
ОтХ	Опиумын тухай хууль
СМДХЗЖАЭтХ	Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их хурал
УХШИГГ	Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШТС	Шатахуун түгээх станц
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХНӨОтХ	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Тогтоосон шалгуур үзүүлэлт	7
Хүснэгт 1.2. Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагууд	29
Хүснэгт 1.3. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн жагсаалт	47
Хүснэгт 1.4. Нас, хүйс (Хар тамхины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг)	61
Хүснэгт 1.5. Насны байдал (Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг)	62
Хүснэгт 1.6. Насны байдал (Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг)	62
Хүснэгт 1.7. Насны байдал (Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэг)	63
Хүснэгт 1.8. Насны байдал (Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан төрхийн эмгэг)	63
Хүснэгт 1.9. Мансууруулах бодист донтсон хүний боловсролын түвшин (2014-2023)	65
Хүснэгт 1.10. Мансууруулах бодист донтсон хүний нийгмийн байдал	65
Хүснэгт 2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	123
Хүснэгт 2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	124
Хүснэгт 2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	124
Хүснэгт 2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	125
Хүснэгт 2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	125
Хүснэгт 2.6. Тохирох шалгах хэрэгсэл	126
Хүснэгт 2.7. Тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх хэсэг.	126
Хүснэгт 2.8. Зорилтын агуулга, үр дүн	131
Хүснэгт 2.9. Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагууд	135
Хүснэгт 2.10. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ	146
Хүснэгт 2.11. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.	149
Хүснэгт 2.12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал	151
Хүснэгт 2.13. ЭХНӨОтХ-ийн төсөл дэх холбогдох гэмт хэргийн зохицуулалтад тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал.	151

Хүснэгт 2.14. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн гаралт (2018-2023)	158
Хүснэгт 2.15. Гэмт хэрэгт холбогдсон хүний хүйс (2018-2023).	158
Хүснэгт 2.16. Гэмт хэрэгт холбогдсон хүний нас (2018-2023)	159
Хүснэгт 2.17. ЭХАШШ-ээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хянан шийдвэрлэсэн хэрэг (2018-2023)	159
Хүснэгт 2.18. ЭХАШШ-ээр ял шийтгүүлсэн хүн (2018-2023)	160
Хүснэгт 2.19. ЭХАШШ-ээр ял шийтгүүлсэн хүний насны байдал (2018-2023)	160
Хүснэгт 2.20. ЭХАШШ-ээр ял шийтгүүлсэн хүний ялын төрөл (2018-2023)	160
Хүснэгт 2.21. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал	162
Хүснэгт 2.22. Нэг нэр томъёог ялгаатай байдлаар тусгасан байдал	163
Хүснэгт 3.1. Зардалд нөлөөлөх зүйл, заалт	176
Хүснэгт 3.2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь	177
Хүснэгт 3.3. Үндэсний хорооны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах, зөвлөмж, чиглэл өгөх үйл ажиллагаатай холбоотой үүсэх хүний нөөцийн хэрэгцээ	182
Хүснэгт 3.4. Үндэсний хорооны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах, зөвлөмж, чиглэл өгөх үйл ажиллагаатай холбоотой төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал	183
Хүснэгт 3.5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал	184
Хүснэгт 3.6. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал	185
Хүснэгт 3.7. Нийт зардал.	185
Хүснэгт 3.8. Хар тамхитай тэмцэх албаны стандарт үйл ажиллагаатай холбоотой үүсэх хүний нөөцийн зардал	187
Хүснэгт 3.9. Хар тамхитай тэмцэх албаны стандарт үйл ажиллагаатай холбоотой үүсэх хүний нөөцийн зардал	188
Хүснэгт 3.10. Хар тамхитай тэмцэх албаны стандарт үйл ажиллагаатай холбоотой үүсэх нийт хүний нөөцийн зардал	189
Хүснэгт 3.11. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн зардал	190
Хүснэгт 3.12. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал	191
Хүснэгт 3.13. Нийт зардал.	191
Хүснэгт 3.14. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ	193
Хүснэгт 3.15. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх нийт хүний нөөцийн хэрэгцээ	194
Хүснэгт 3.16. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал	195
Хүснэгт 3.17. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал	196
Хүснэгт 3.18. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал	196

Хүснэгт 3.19. Нийт зардал.	197
Хүснэгт 3.20. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ	198
Хүснэгт 3.21. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх нийт хүний нөөцийн хэрэгцээ	199
Хүснэгт 3.22. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал	200
Хүснэгт 3.23. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал	201
Хүснэгт 3.24. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал	201
Хүснэгт 3.25. Нийт зардал.	202
Хүснэгт 3.26. Зардалд нөлөөлөх зүйл, заалт	204
Хүснэгт 3.27. Хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэг, стандарт үйл ажиллагаа	214
Хүснэгт 3.28. Аж ахуйн нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин, (Мянган төгрөгөөр)	216
Хүснэгт 3.29. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлс (Цаг, минутаар)	217
Хүснэгт 3.30. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлс (Цаг, минутаар)	218
Хүснэгт 3.31. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар	218
Хүснэгт 3.32. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар	219
Хүснэгт 3.33. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар	219
Хүснэгт 3.34. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар	220
Хүснэгт 3.35. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар	221
Хүснэгт 3.36. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар	221
Хүснэгт 3.37. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоон үзүүлэлтийг тодорхойлох нь	222
Хүснэгт 3.38. Нийт зардлын дүн	225
Хүснэгт 3.39. Нийт зардлын товч	228

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.1. Гаалийн төв лабораторид ирүүлсэн дээж (2015-2023)	37
График 1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг.	59
График 1.3. Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан төлөвийн эмгэг . .	60
График 1.4. Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг	60
График 1.5. Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэг	60
График 1.6. Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан төрхийн эмгэг.	61
График 1.7. Мансууруулах бодист донтсон хүн, нутаг дэвсгэрээр (2014-2023) . .	64
График 1.8. Бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн тоо.	68

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааны зураглал	35
Зураг 1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг нэвтрүүлэх Монгол Улсын хилийн боомт	36

НЭГ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН
ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
----------------	--

Судалгааны багийн бусад гишүүд:

Х.Буянбат	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
Г. Болор-Эрдэнэ	Эрдэм шинжилгээний ажилтан
О.Түвшинсанаа	Эрдэм шинжилгээний ажилтан
Х.Санчир	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2024.05.29.

АГУУЛГА

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь	4
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	4
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	5
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	6
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	7
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	10
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	11
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	12
3.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомжийн Олон улсын гэрээний нийцэл	12
3.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх (4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл)	28
3.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх (6 дугаар зүйл)	32
3.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах (7 дугаар зүйл)	39
3.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах (8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл)	40
3.6. Мансуурах донтой этгээдийг эмчлэх (12 дугаар зүйл)	49
3.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох үйл ажиллагаа, хариуцлага (13 дугаар зүйл, 16 дугаар зүйл)	66
3.8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт (10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл)	69
ДӨРӨВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА (ЯЛЫН БОДЛОГО)	79
4.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт	79
4.2. Норвегийн Хаант Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт	84
4.3. Нидерландын Хаант Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт	87
4.4. Сингапур улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт	91
4.5. Малайз Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт	99
ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	106
НОМ ЗҮЙ	111

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 18 зүйлтэй баталснаас хойш өнгөрсөн 22 жилийн хугацаанд нийт 7 удаа (2011, 2011, 2015, 2021, 2022, 2022, 2023 онд) тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 63-т Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай хуулийн (Шинэчилсэн найруулга) төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан боловсруулахаар тусгасан. Ингэхдээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд болон тэдгээрийн угтвар бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ял хариуцлагыг нэмэгдүүлэх, мансуурах донтой этгээдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эрт шатанд нь илрүүлэх, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлийг баримтлахаар заасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэжээ. Гэвч Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаа хийгдээгүй бөгөөд “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 63-т заасан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд болон тэдгээрийн угтвар бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ял хариуцлагыг нэмэгдүүлэх, мансуурах донтой этгээдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эрт шатанд нь илрүүлэх, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндэс тодорхойгүй байна.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны дагуу хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа юун түрүүнд тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай.

Иймд хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид бэхжүүлэх шаардлагыг тодорхойлох үүднээс Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг хийх хэрэгцээ шаардлагатай гэж үзлээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургадугаар хавсралтаар баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэв.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлого гэсэн дөрөв дэх бүлгийн “Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангах” хэсгийн 4.3.4-т Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх” гэж заажээ.

Манай улсын хувьд Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 18 зүйлтэй анх баталснаас хойш өнгөрсөн 21 жилийн хугацаанд нийт 7 удаа (2011, 2011, 2015, 2021, 2022, 2022, 2023 он) нэмэлт, өөрчлөлт орж өдгөө тус хуулийн 17 зүйл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Гэвч тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдээгүй бөгөөд УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 63-т Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай хуулийн (Шинэчилсэн найруулга) төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан боловсруулахаар тусгасан боловч хуулийн төслийг боловсруулахад одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, засаж сайжруулах, анхаарах асуудлыг тодорхойлох зайлшгүй шаардлага бий болоод байна.

Иймд хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид боловсронгуй болгох шаардлагыг тодорхойлох үүднээс тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг хийх хэрэгцээ, шаардлагатай гэж үзлээ.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Судалгааны үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаагаар нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлдог.

Хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх болсон шалтгаантай харилцан уялдаа, хамааралтайгаар тогтоох ба тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг сонгоно. Ингэхдээ хуулийг бүхэлд нь эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Энэхүү судалгаагаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар зохицуулсан үндсэн харилцаа, зохицуулалтуудыг агуулгын хувьд бүхэлд нь үнэлэхийг зорьж, үнэлгээ хийх хүрээг тус хуулийн дараах зүйл, заалтуудаар тогтоов. Үүнд:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомжийн Олон улсын гэрээний нийцэл;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх тухай зохицуулсан тус хуулийн 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулсан тус хуулийн 6 дугаар зүйл;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах тухай зохицуулсан тус хуулийн 7 дугаар зүйл;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тухай зохицуулсан тус хуулийн 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл;
- Мансуурах донтой этгээдийг эмчлэх тухай зохицуулсан тус хуулийн 12 дугаар зүйл;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох үйл ажиллагаа тухай зохицуулсан тус хуулийн 13 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйл 20.8 дугаар зүйл, 20.10 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт тухай зохицуулсан тус хуулийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл;

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Мөн тус шалгуур

үзүүлэлт нь хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй байдаг. Иймд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль нь хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд анх батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно.

Үндсэн зорилгыг тус хуулийн нэгдүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах хэмээн заасныг баримтлан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хуулиар зөвшөөрөгдсөн эргэлтэд бүрэн хяналт тавьж, хууль бус эргэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх явдал гэж тодорхойллоо.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран, аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгодог. Харьцуулах доор дурдсан хэлбэрүүд байна. Үүнд:

- 1/ байх ёстой ба одоо байгаа;
- 2/ хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
- 3/ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- 4/тохиолдол судлах.

Дээрхээс “байх ёстой ба одоо байгаа” болон “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг энэхүү судалгаанд тохиромжтой гэж үзэж сонгов.

“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулах хэлбэрээр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш бий болсон үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг Үндсэн хууль болон үндэсний хэмжээний хөтөлбөрийн зорилго, олон улсын байгууллагын зүгээс тогтоосон шаардлага болоод олон улсад сайн жишиг тогтоосон гадаад улсын туршлагатай харьцуулах хэлбэрээр тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорив.

“Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрээр Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зүйл, хэсэг, заалт нь өөр өөр нөхцөл буюу тохиолдолд хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилгод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэх асуултын хүрээнд гүйцэтгэлээ.

Хүснэгт 1.1. Тогтоосон шалгуур үзүүлэлт

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт		Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлт
	Зорилгод хүрсэн түвшин	Практикт нийцэж байгаа байдал		
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомжийн Олон улсын гэрээний нийцэл	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомжийн зохицуулалт, нэр томьёо нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцэж буй эсэхийг тогтооно.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлж чадаж буй эсэх, тийнхүү хэрэгжүүлснээр практикт ямар нэгэн сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болоод хэрэгжилтэд асуудал үүсэж буй эсэхийг судалж тогтооно.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр харьцуулахдаа Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, түүний зохицуулалтыг байх ёстой түвшин хэмээн үзсэн ба ийнхүү харьцуулахдаа мөн “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг хослуулсан.	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомжийн зохицуулалт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцэж буй эсэх.
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх тухай зохицуулсан тус хуулийн 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх харилцаанд хяналтыг бүрэн хэрэгжүүлж хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлж буй эсэхэд үнэлэлт өгнө.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх тухай зохицуулсан тус хуулийн 4 дүгээр зүйл болон 5 дугаар зүйлийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох болно.	“Байх ёстой ба одоо байгаа” болон “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг хослуулан ашиглана.	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх харилцаанд хяналтыг хэрэгжүүлэх боломжтой буй эсэх.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулсан тус хуулийн 6 дугаар зүйл	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх, хяналтыг бүрэн хэрэгжүүлж хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлж буй эсэхэд үнэлэлт өгнө.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулсан тус хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч буй эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох болно.	“Байх ёстой ба одоо байгаа” болон “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг хослуулан ашиглана.	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх.
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах тухай зохицуулсан тус хуулийн 7 дугаар зүйл	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах үйл ажиллагааг бүрэн хянах боломжтой эсэхийг судалж үнэлнэ.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах тухай зохицуулсан тус хуулийн 7 дугаар зүйл нь хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч буй эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлно.	“Байх ёстой ба одоо байгаа” болон “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг хослуулан ашиглана.	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах үйл ажиллагааг бүрэн хянах боломжтой эсэх.
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тухай зохицуулсан тус хуулийн 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тухай зохицуулалт нь тус хуулийн зорилгод нийцэж буй эсэх буюу үйлдвэрлэх, худалдах харилцаанд хяналтыг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд үнэлэлт өгнө.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тухай зохицуулсан тус хуулийн 8 дугаар зүйл болон 9 дүгээр зүйл нь хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч буй эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлно.	“Байх ёстой ба одоо байгаа” болон “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг хослуулан ашиглана.	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх.

Мансуурах донтой этгээдийг эмчлэх тухай зохицуулсан тус хуулийн 12 дугаар зүйл	Мансуурах донтой этгээдийг эмчлэх тухай зохицуулалт нь үр дүнтэй, хэрэгжих боломжтой эсэхэд үнэлэлт өгнө.	Мансуурах донтой этгээдийг эмчлэх тухай зохицуулсан тус хуулийн 12 дугаар зүйл нь хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч буй эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлно.	“Байх ёстой ба одоо байгаа” болон “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг хослуулан ашиглана.	1. Мансуурах донтой этгээдийг эмчлэх тухай зохицуулалт нь үр дүнтэй, хэрэгжих боломжтой эсэх.
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох үйл ажиллагаа тухай зохицуулсан тус хуулийн 13 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйл, 6.4 дүгээр зүйл, 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 16.2 дугаар зүйл, 20.7 дугаар зүйл, 20.8 дугаар зүйл, 20.10 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох үйл ажиллагаа тухай зохицуулсан тус хуулийн 13 дугаар зүйл болон Эрүүгийн хууль, Зөрчлийн холбогдох зохицуулалт нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлэх, гэмт явдалтай тэмцэх зорилгыг хангаж буй эсэхийг судалж, үнэлэлт өгнө.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хуулийн 13 дугаар зүйл болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын хоорондын уялдаа хангагдсан эсэх, хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч буй эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлно.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хүрээнд тус хуулийн зорилт болон эрүүгийн эрх зүйн онол, олон улсын байгууллагын шийдвэр, зөвлөмж, гадаад улсын сайн туршлагыг байх ёстой түвшин гэж үзсэн бөгөөд “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг хослуулан ашигласан.	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох үйл ажиллагаа тухай зохицуулсан тус хуулийн 13 дугаар зүйл болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох зохицуулалт нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлэх, гэмт явдалтай тэмцэх зорилгыг хангаж буй эсэх.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын тухай зохицуулсан тус хуулийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт нь үр дүнтэй эсэх, хэрэгжих боломжтой эсэх, салбар хоорондын уялдааг хангаж чадсан эсэхэд үнэлэлт өгнө.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын тухай зохицуулсан тус хуулийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч буй эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлно.	“Байх ёстой ба одоо байгаа” болон “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг хослуулан ашиглана.	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт нь үр дүнтэй эсэх, хэрэгжих боломжтой эсэх, салбар хоорондын уялдааг хангаж чадсан эсэх.
---	--	---	---	---

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Үндсэн хуулийн эрх зүй, тэр дундаа үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, тус ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн тухай холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх тухай бусад эрх зүйн акт, тус сэдвээрх сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үнэлэх үе шатанд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомжийн Олон улсын гэрээний нийцэл¹

3.1.1. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц²

Энэхүү конвенц нь 1961 оны 03 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, 1964 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол Улс 1990 оны 12 дугаар сарын 6-ны өдөр нэгдэн орсон.

Мансууруулах эмийг гагцхүү анагаах ухааны болон эрдэм шинжилгээний хэрэглээгээр хязгаарлах, энэ зорилго, зорилтод хүрэхэд олон улсын хамтын ажиллагаа шаардлагатайг онцолж, өмнө үйлчилж байсан гэрээнүүдийг нэгтгэн, нэгдсэн конвенц баталсан нь 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц юм. Уг конвенцоор мансууруулах эмийг хянах олон улсын механизмыг бий болгосон. Мансууруулах эм, бэлдмэлийн ангиллыг гаргаж, ангилал тус бүрийн хэрэглээний хязгаарыг тогтоож, нэгдэн орсон улсуудад уг конвенцод нийцсэн дотоодын хууль тогтоомж батлан, мөрдөхийг үүрэг болгосон байдаг.

Тус конвенцын “Шийтгэлийн заалт” гэсэн 36 дугаар зүйлийн 1.а)-д Тал бүр энэхүү конвенцын заалтуудыг зөрчиж мансууруулах эм тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, эзэмших, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдан авах, худалдах, аливаа нөхцөлөөр хүргүүлэх, зуучлах, илгээх, дамжин өнгөрүүлэн илгээх, тээвэрлэх, импортлох болон экспортлох, түүнчлэн тухайн талын үзэж байгаагаар энэхүү конвенцод харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатайгаар үйлдсэн бол шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх, мөн ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг хангах арга хэмжээг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна гэж заасан. Энэ нь гэмт хэрэгт тооцогдох үйлдлүүдийг тоочихоос гадна энэхүү конвенцод харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатай үйлдсэн бол мөн гэмт хэрэг гэж үзэж өргөжүүлж хуульчлах боломжийг улс орнуудад олгожээ.

Түүнчлэн, ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх арга хэмжээг өөрийн Үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна гэж заасан нь нэг талаар гэмт хэрэгт тооцож тохирох шийтгэл хүлээлгэхийг даалгасан ч нөгөө талаар тухайн улсын бодлого, эрх зүйн зохицуулалтаас эрүүгийн хариуцлага хамаарахаар уян хатан шинжтэй зохицуулалт юм.

Энэхүү 1 дэх хэсэгт жагсаасан гэмт хэрэг бүрийг хэд хэдэн оронд үйлдсэн бол тусдаа гэмт хэрэг гэж үзнэ; тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ зүйлд дурдсан

1 2022 онд ХЗҮХ-ээс гүйцэтгэсэн “Монгол Улсын олон улсын гэрээ ба Эрүүгийн хуулийн нийцэл (Зарим төрлийн гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлага)” сэдэвт судалгааны тайлангаас тус дэлгэрүүлж үзнэ үү.

2 Төрийн мэдээлэл, тусгай дугаар IV боть, Монгол Улсын олон улсын гэрээ, (УБ, 2006), 957 дахь тал;

гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэвэл зохих гэмт хэрэг болно; тийм гэмт хэргийн төлөө гадаад улсад оногдуулсан шийтгэлийг рецидив гэмт хэрэгтнээр тогтоох зорилгоор харгалзан үзнэ гэж тус тус заажээ.

Тус конвенцод, улс орнууд конвенцын үндсэн зорилгод нийцүүлэн төрийн бодлого, эрх зүйн хүрээндээ холбогдох арга хэмжээ авах ёстой гэж заасан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих ажлыг чангатгах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, мансууруулах бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг өөрчилж, боловсронгуй болгох зорилгоор Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр болон үндэсний хэмжээний бусад бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна.

Манай улсын Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэгт “Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”-ийг тусгасан бөгөөд тус хуулийн 20.7-20.10 дугаар зүйлд Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцод заасан гэмт хэргийн холбогдох хэм хэмжээг тусгасан. Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг”-ийг хуульчилсан. Тус зүйлийн 20.7.1-д “Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, мөн 20.7.2-т “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж ангилан хуульчилжээ.

Мөн зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө.” гэж заасан нь эрх зүйд урамшууллын аргыг нэвтрүүлсэн хэлбэр юм.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 20.8 дугаар зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах”, 20.9 дүгээр зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших”, 20.10 дугаар зүйлд “Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах” гэмт хэргийг хуульчилсан байна.

Уг конвенцоор мансууруулах бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлан, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн аливаа хэлбэрт хориг тавьсан ба энэ нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах

явдалд тавих эрүүгийн эрх зүйн хоригийн үндэс болсон юм.³ Тус конвенцод гэмт хэрэгт тооцохоор нэрлэж тоочсон нийт үйлдлийг Эрүүгийн хуульд тусгасан эсэхийг харьцуулан авч үзвэл, “үйлдвэрлэх”, “санал болгох, худалдахаар санал болгох”, “түгээх”, “аливаа нөхцөлөөр хүргүүлэх”, “зуучлах”, “дамжин өнгөрүүлж илгээх”, “импортлох болон экспортлох” зэргийг хуульчлаагүй байна. Тухайлбал, “үйлдвэрлэх” үйлдлийн тухайд хууль зүйн ухааны доктор, профессор Б.Болдбаатар “...Эрүүгийн хуульд хууль бус “үйлдвэрлэл”-ийн талаар огт тусгагдаагүй, 2002 оны Эрүүгийн хуулийн 193 дугаар зүйлд заасан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих” зүйл, ангийг хассан нь хүндрэл учруулж байна. Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх нь гэмт этгээдүүд ял завших боломжийг олгосон байна...”⁴ гэж үзжээ.

Мөн профессор С.Жанцан байгалийн жамаар ургаж байгаа каннабисыг их бага янз бүрийн хэмжээгээр түүж аваад, цайруулж, ургамлаас нь мансууруулах хүч ихтэй цэцэг, давирхайг нь салгаж аваад, дараа нь өөр төрлийн эм, химийн бодистой хольж үнэрлэх, тамхинд хольж утааг уушгилан сороход бэлтгэсэн үйлдлүүдийг бэлтгэх, үйлдвэрлэх гэж 2 объектив шинжээр нь салгаж Эрүүгийн хуульд хуульчлаагүй нь энэ төрлийн гэмт хэргийг байгалийн жамаар ургаж байгаа ургамлыг олж авсан гэдгээр зүйлчилж, гэмт этгээдэд ял завшуулах, улмаар гэмт хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаагаар шийдвэрлэхэд шууд ба шууд бусаар сөрөг нөлөө үзүүлнэ⁵ гэж тус тус үзсэн байна.

Конвенцын өөр нэгэн онцлог нь 1972 оны конвенцод өөрчлөлт оруулах тухай протокол бөгөөд үүний гол агуулга нь шийтгүүлж байгаа хүнд хорих, эсхүл албадан эмчилгээ хийх, эсвэл хорихоос гадна давхар эмчилгээ хийх шийтгэл ногдуулах боломжтой болсон явдал юм.⁶ Мөн конвенцын 36.1.b)-д зааснаар мансууруулах эм урвуулан хэрэглэсэн гэмт хэрэг үйлдсэн бол талууд шийтгэл буюу ялын оронд, эсхүл нэмэлт болгож тэднийг эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараах эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах арга хэмжээнд хамруулахаар зааж болохоор тусгаснаас гадна мансууруулах эм урвуулан хэрэглэгч нь нэг талаас өвчтөн байх магадлалтайг онцолж тухайн хүнийг эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараах эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах талаар онцгой анхаарч, боломжтой бүх арга хэмжээг авах бөгөөд энэ зорилгод хүрэх хүчин чармайлтаа уялдуулан зохицуулах үүргийг улс орнуудад хүлээлгэсэн байдаг.

Монгол Улсад “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль”-ийг 2018 онд шинэчлэн найруулсан бөгөөд уг хуулийн дагуу согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах

3 С.Жанцан, Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудал, илтгэл, (2012), 8 дахь тал, <https://docs.google.com/presentation/d/1Ck1YFIU-UHbBVqaknVMoMoHx8dNBtji72IXz1EtVIRw/htmlpresent>

4 Б.Болдбаатар, “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал”, Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2018), 15 дахь тал.

5 С.Жанцан, Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудал, илтгэл, (2012), 13 дахь тал, <https://docs.google.com/presentation/d/1Ck1YFIU-UHbBVqaknVMoMoHx8dNBtji72IXz1EtVIRw/htmlpresent>

6 Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал /Судалгааны тайлан/, (УБ, 2013), 21 дэх тал, https://www.uih.mn/upload/sudalgaa/files/208_7447220.pdf

эрсдэлт нөхцөл байдалд орсон хүн согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулахаар заасан.⁷ Ингэхдээ албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт эмчилгээг явуулах ба энэхүү эмнэлэг нь шүүхийн шийдвэрийг үндэслэн эмчлүүлэх хүнийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй хүлээн авч, холбогдох хууль, журам, стандартын дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхээр байна. Харин уг албадан эмчлэх эмнэлэг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяалалд ажиллахаар тус хуульд тусгасан байна. Гэхдээ тус эмнэлэг нь мансуурах донтой хүнийг албадан эмчлэх ажиллагааг хариуцдаггүй байна. Харин СЭМҮТ-өөс тодруулахад тус байгууллагад мансууруулах бодист донтсон хүний албадан эмчилгээ хийгддэггүй бөгөөд сайн дураараа сэтгэл заслын эмчилгээг хийлгэж үзүүлж байна гэв. СЭМҮТ-ийн зүгээс мансууралтай холбоотой сэтгэл засал, нөхөн сэргээх эмчилгээ л явагддаг⁸ байна.

Мөн СЭМҮТ-тэй хийсэн бүлгийн ярилцлагад “Эрүүгийн цагдаагийн газрын хар тамхитай тэмцэх тасгийн мэдээлснээр Монгол Улс дамжуулагч улс болсонтой холбоотой мансууруулах бодисын хэрэглээ ихсэж байгаа, гэхдээ мансууруулах бодисын донтолт биш хэрэглээ нэмэгдсэн.”⁹ гэснээс үзэхэд Монгол Улсад хар тамхинд донтох эмгэгтэй хүмүүсийг хэрхэн эмчилж байгаа болон эдгээр хүмүүсийн тоо, мэдээлэл тодорхойгүй, албадан эмчлэх мэргэжлийн эмнэлгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл хомс байна. Иймд уг конвенцоор хүлээсэн боломжтой бүх арга хэмжээг авах үүргээ хангалтгүй биелүүлж байна гэж үзэх үндэслэлтэй байна. Энэхүү албадан эмчилгээний талаар тус хуулийн 12 дугаар зүйлд хийсэн үнэлгээ хэсгээс дэлгэрүүлж үзэх боломжтой.

Конвенцод “санхүүгийн үйл ажиллагаа явуулах”, “үйлдэхээр үгсэн тохиролцох” зэрэг үйлдлийг тухайлан дурдсаныг Эрүүгийн хуульд нарийвчлан тусгаагүй ч тухайн гэмт хэрэгт бэлтгэх, худалдах гэдэгт хамааруулан ойлгож болох юм. Мөн Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт хамтран оролцох нэг хэлбэр болох зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн байх шинжийг тус хуулийн 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 20.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 20.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчилсан байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших гэмт хэрэгт тусгай субъектийн үйлдлийг хамруулсан. 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэхдээ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан бол гэмт хэрэгт тооцохоор заасан бөгөөд өмнө нь мэргэжлийн болон албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол ял хүндрүүлэхээр авч үзэж байсныг гэмт хэргийн үндсэн шинж болгон хуульчилжээ. Гэвч конвенцод тусгасан “мансууруулах эмийг урвуулан ашиглах” гэмт хэрэгт гадаад улсад ял шийтгүүлсэн бол харгалзан үзэх тухай заагаагүй байна.

7 Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, (2018), 3.1 дүгээр зүйл.

8 Архинд донтох өвчтэй 883 эмчлүүлэгчийг шүүхийн шийдвэрээр хүлээн авснаас 525 нь анх удаа ирсэн хүн байжээ, СЭМҮТ-ийн их эмч Ж.Гантулгатай хийсэн ярилцлага, <https://ikon.mn/opinion/1r11>

9 ИРИМ хараат бус судалгааны хүрээлэн, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих Үндэсний хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ, (2019), 24 дэх тал.

Харин Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, тус хуулийн 20.10 дугаар зүйлд заасан мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж, торгох ял шийтгэн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалт Эрүүгийн хуульд тусгажээ.

Дээрхээс дүгнэвэл, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, 20.8 дугаар зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах, 20.9 дүгээр зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг завших, 20.10 дугаар зүйлд заасан мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийг үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчилжээ. Харин тухайн конвенцод гэмт хэрэгт тооцох үйлдлүүдийг буюу объектив талын зарим үйлдлийг Эрүүгийн хуульд тусгаагүй байна. Үүнийг зарим үйлдлийг нэгтгэх байдлаар Эрүүгийн хуульд тусгасан байна хэмээн хамруулж ойлгох боломжтой ч конвенцтой нийцүүлэхийн тулд орхигдуулсан зохицуулалтыг тухайлан тусгах шаардлагатай.

Хуульд зайлшгүй тусгаахаар заасан хэм хэмжээг (Хамтран оролцогчдын үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулах гэх мэт) улс орнууд өөрийн улсын бодлого, эрх зүйн хүрээнд нэмж тусгах боломжтой гэж конвенцод заасан Нээлттэй арга хэмжээний хүрээнд тусгай субъектийн үйлдлийг хамруулах, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээс гадна уг конвенцод заасан үүргээ эрх зүйн хүрээнд биелүүлэх үүднээс урамшууллын аргыг хэрэглэх зэрэг нэлээд хүчин чармайлт гаргасан байна гэж үзэв. Хууль зүйн бодлого, конвенцын хүрээнд гэмт хэрэгт тооцохоор заасан үйлдлүүдийг Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцож бүрэн тусгаагүй байдлыг нягтлахын зэрэгцээ Зөрчлийн тухай хуулиар зөрчилд тооцож буй зарим үйлдлийг тус конвенцод нийцүүлэн гэмт хэрэгт тооцож боловсронгуй болгох шаардлагатай.

3.1.2. Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц¹⁰

Тус конвенц нь 1971 оны 02 дугаар сарын 21-ний өдөр батлагдаж, 1976 оны 08 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол Улс 1999 оны 12 дугаар сарын 15-ны өдөр соёрхон баталсан. Энэхүү конвенцоор сэтгэцэд нөлөөлөх бодисын ангилал, хэрэглээний хязгаарыг тогтоосон.

1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцын бий болгосон тогтолцооноос гадуур үлдсэн, тухайн үедээ шинэ зах зээлийн онцлогоос болж үүсэж байсан сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой харилцааг журамлах үүднээс 1971 онд Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцыг баталсан. Энэхүү конвенц батлагдсанаар хууль бус үйлдвэрлэл, хэрэглээг хязгаарлах, хүн амыг хорт зуршлаас хамгаалахад чиглэгдсэн олон улсын эрх зүйн орчин бүрдсэн. Эдгээр үйлдэл нь нийтэд аюултай байдлаар үйлдэгддэг тул бусад гэмт хэргээс ялгагдах ёстой.¹¹ Уг конвенцод 1961 оны конвенцод багтаагүй мансууруулах бодисуудыг нэгтгэн нийт 4 жагсаалт гарган 1 дүгээр жагсаалтад орсон бодисыг хатуу хяналтад

¹⁰ Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, Монгол Улсын олон улын гэрээ, (УБ, 2006), 1005 дахь тал.

¹¹ Монгол Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, (УБ, 2013), 490 дэх тал.

авч, хэрэглэхийг хориглох талаас нь оролцогч орнууд арга хэмжээ авах, мөн 2, 3, 4 дүгээр жагсаалтад орсон бодисыг хяналтад авч зөвхөн эмчийн жороор олгож байхаар зохицуулжээ.

Тус конвенцын 22 дугаар зүйлийн 1.а)-д хариуцлагын зохицуулалтыг нарийвчлан заасан бөгөөд энэ нь нэг талаас Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцод нийцсэн хүрээнд хууль тогтоомж батлах, нөгөө талаас тухайн хууль тогтоомжид заасныг зөрчиж, санаатай үйлдсэн шийтгэвэл зохих аливаа үйлдлийг гэмт хэрэгт тооцож, тохирох ял оногдуулах тухай ойлголт юм.

Мөн 22 дугаар зүйлийн 1.б)-д “Сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэгчид тийм гэмт хэрэг үйлдсэн бол талууд дээрх хэсгийг үл харгалзан шийтгэл буюу ялын оронд, эсхүл нэмэлт болгож тэднийг эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараах эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах арга хэмжээнд 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцүүлэн хамруулахаар зааж болно.” гэсэн зохицуулалт нь холбогдох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зөвхөн шийтгэх зарчмыг баримтлалгүй, хүмүүнлэгийн чанартай арга хэмжээнүүд авах боломжийн талаар тусгасан байна.

Энэхүү конвенцоор сэтгэцэд нөлөөлөх бодисын ангилал, хэрэглээний хязгаарыг тогтоосон ба конвенцын I-IV жагсаалтад орсон бодистой холбоотой гэмт хэрэгт тооцогдох өөр хоорондоо холбоотой үйлдлийг хэд хэдэн оронд үйлдсэн бол үйлдэл бүрийг тусдаа гэмт хэрэг гэж үзнэ; тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ конвенцын хүрээний гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь шийтгэвэл зохих гэмт хэрэг болно; тийм гэмт хэргийн төлөө гадаад улсад оногдуулсан шийтгэлийг рецидив байдлыг тогтоох зорилгоор харгалзан үзнэ; конвенцод дурдсан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураана гэж заасан.

Манай улс Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцын дагуу хүлээх үүргээ биелүүлэх үүднээс, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах зорилт тавьж, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг батлан, дагаж мөрдөж байна.

Тус хуулийн 16.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан. Иймээс сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хуваарилах, худалдах, хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон үйл ажиллагаа¹²-тай холбоотой гэмт хэргийг Эрүүгийн хуульд хуульчилсан.

12 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт.

Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн зохицуулалтыг хамтад нь томьёолж, тус хуулийн 20.7 дугаар зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах”, 20.8 дугаар зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах”, 20.9 дүгээр зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших”, 20.10 дугаар зүйлд “Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах” гэмт хэргийг тус тус хуульчилж, оногдуулах ял, хүндрүүлэх нөхцөл байдлыг тодорхойлон заажээ.

Конвенцын 22 дугаар зүйлийн 2 хэсгийн (a) ii-т заасан гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах¹³ үйлдлийг шийтгэвэл зохих гэмт хэрэг хэмээн тусгасан. 2002 оны Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.3.5-д заасан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “үгсэн тохиролцох” үйлдлийг хамааруулж, олон улсын гэрээнд нийцүүлсэн байсныг 2015 оны Эрүүгийн хуулиас хасаж, Эрүүгийн хуулийн 2.7 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэгт бэлтгэхэд багтаан, гэмт хэргийн хамтран оролцогчдод тооцож хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэхийг завдсан болон үйлдэл хийхээр бэлтгэсэн хүнд хариуцлага хүлээх боломжтой.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд конвенцын “санхүүгийн үйл ажиллагаа явуулах” үйлдлийг үгчлэн хуульчлаагүй боловч тус хуулийн 20.7 дугаар зүйлийн 20.7.2-т зааснаар эдгээрийг худалдах зорилгоор явуулсан үйл ажиллагаа гэж хамааруулсан бололтой. Ингэснээрээ “санхүүгийн үйл ажиллагаа явуулах” үйлдлийн хүрээг хумьж, хязгаарласан байж болзошгүй. Иймээс Эрүүгийн хуульд дээрх үйлдлийг нэмж хуульчлах шаардлагатай эсэхийг нягтлах нь зүйтэй.

Мөн конвенцын 22 дугаар зүйлийн 3-т “1, 2 дахь хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураана.” гэж заасан боловч Эрүүгийн хуульд заасан холбогдох гэмт хэрэгт хөрөнгө хураах ялыг хамтад нь хэрэглэх талаар тусгаагүй байна.

Эдгээрээс дүгнэвэл, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцод сэтгэцэд нөлөөлөх бодисын ангилал, хэрэглээний хязгаарлалтыг тогтоосон байна. Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн зохицуулалтыг хамтад нь томьёолсон учир энэхүү бүлгийн дүгнэлтийг тус судалгааны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцын дүгнэлтийн холбогдох хэсгээс мөн үзнэ үү.

Хамтран оролцогчдын үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулахаас гадна тусгай субъектийн үйлдлийг хамруулах, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээс гадна урамшууллын аргыг хэрэглэсэн нь конвенцод заасан үүргээ хэрэгжүүлж буй арга хэлбэр юм.

Тус конвенцын хүрээнд гэмт хэрэгт тооцогдох зарим үйлдлийг нэгтгэх байдлаар Эрүүгийн хуульд тусгасан байна хэмээн хамруулж ойлгох боломжтой ч

13 Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, 1971, 22 дугаар зүйлийн 2.2 дахь заалт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1292>

конвенцтой нийцүүлэх үүднээс зайлшгүй тусгах шаардлагатай зарим гэмт үйлдлийг орхигдуулсан эсэхийг нягтлах шаардлагатай. Хууль зүйн бодлогын хүрээнд, конвенцын дагуу гэмт хэрэгт тооцогдох үйлдлүүдийг Зөрчлийн тухай хуульд тусгах байдлаар гэмт хэрэг гэж үзэлгүй, зөрчилд тооцож буй эсэхийг мөн харьцуулж үзэх нь зүйтэй. Мөн тус конвенцод заасан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураах үзэл баримтлалыг Эрүүгийн хуульд тусгаж, гэмт хэрэгт хөрөнгө хураах ялыг хамтад нь хэрэглэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

3.1.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц¹⁴

Энэхүү конвенц нь 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр нэгдэн орсон.

Энэ конвенцоор, тус судалгааны 6, 7 дугаар бүлэгт судалсан 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц болон 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцод хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой асуудлыг олон улсын хамтын ажиллагааны түвшинд шийдэх зорилготой.

Өөрөөр хэлбэл, өмнө нь батлагдсан холбогдох хоёр конвенцын туслах хэрэгсэл хэмээн ойлгож болох юм. Тус конвенцод “хууль бус эргэлт” гэдгийг тодорхойлж, нэгдэн орсон улсууд ямар ямар үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохыг зааж, дотоодын хууль тогтоомждоо тусгахыг үүрэг болгосон байдаг. Түүнчлэн дотоодын хууль тогтоомжийг конвенцод нийцүүлэхтэй холбоотой арга замыг тусгасан.

Конвенц нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хяналтын тогтолцоо, хууль бус эргэлтийн эсрэг авах арга хэмжээний талаар, түүнтэй холбоотой мөнгө угаах үйл ажиллагааг зогсоох, эрүүгийн эрх зүйн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг сайжруулах зэрэг зорилтууд тавьсан бөгөөд 1961, 1971 оны конвенцуудыг үр дүнд хүргэхэд арга барил, механизм, тогтолцооны үүднээс туслахад чиглэсэн гэж ойлгож болно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 1 дүгээр зүйлийн “m” хэсэгт “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт” гэж энэхүү конвенцын 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хамааруулан ойлгохоор заажээ.¹⁵ Үүнд:

3 дугаар зүйл. Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлага

1. Тал бүр, санаатайгаар үйлдэгдсэн дараах үйлдлийг дотоодын хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхойлох арга хэмжээ авна:

а) i) 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан уг конвенц болон 1971 оны конвенцын заалтыг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх

¹⁴ Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, Монгол Улсын олон улын гэрээ, (УБ, 2006), 1005 дахь тал.

¹⁵ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, 1988, 1.m хэсэг.

бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдах, ямар ч нөхцөлөөр хамаагүй хүргэх, зуучлах, илгээх, дамжуулан өнгөрүүлж илгээх, тээвэрлэх, экспортлох, импортлох;

ii) 1961 оны конвенц, нэмэлт, өөрчлөлт оруулсан уг конвенцын заалтыг зөрчиж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах;

iii) (i) дэд хэсэгт заасан аливаа үйл ажиллагааг явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, худалдан авах;

iv) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс, бодисыг бэлтгэх, тээвэрлэх, түгээх;

v) (i), (ii), (iii), (iv) дэд хэсэгт тодорхойлсон гэмт хэргийг удирдах, санхүүжүүлэх, зохион байгуулах.

b) i) аливаа гэмт хэрэг болон энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах болон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах, шилжүүлэх;

ii) энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл тийм гэмт хэрэг үйлдэхэд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байрлал, захиран зарцуулах арга, хөдөлгөөн, хөрөнгөтэй холбоотой жинхэнэ эрх эсхүл эзэмшигчийг халхавчлах, нуун дарагдуулах;

c) Үндэсний хууль тогтоомжийнхоо заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо гол зарчмуудыг баримтлан:

i) энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг болон гэмт хэргүүд, эсхүл тухайн гэмт хэрэг болон гэмт хэргүүдэд оролцсон үйлдлийн улмаас бий болсон хөрөнгийг хүлээж авахдаа энэ тухай мэдсээр байж олж авсан, эзэмшсэн, хэрэглэсэн;

ii) I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс болон бодисыг аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэхэд ашиглаж байгаа, эсхүл тийм зорилгоор ашиглахад зориулагдсан болохыг мэдсээр байж эзэмших;

iii) энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон нийтийг аливаа хэлбэрээр өдөөн хатгах, уриалах;

iv) энэ зүйлээр тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, холбогдсон, үйлдэхээр үгсэн тохиролцсон, үйлдэхийг завдсан, түүнчлэн үйлдэх үед хамжсан, хатгасан, дэмжлэг үзүүлсэн эсхүл зөвлөгөө өгсөн.

2. Тал бүр Үндсэн хуулийнхаа заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо зарчмыг баримтлан 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц, 1971 оны конвенцыг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар хадгалах, олж авах, тарималжуулахыг дотоодын хуульдаа гэмт хэрэг гэж тодорхойлоход шаардлагатай байж болох арга хэмжээ авна.

Хууль бус эргэлтийг гэмт хэрэгт тооцож, шийтгэх нь конвенцын үндсэн онцлогийн нэг бөгөөд 3.1 дэх хэсэгт заасан “Тал бүр дараах зүйлийг санаатайгаар үйлдсэн тохиолдолд өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай арга хэмжээг авна” гэснийг бүх талууд заавал биелүүлэх ёстой¹⁶ байна. Иймээс Монгол Улс энэхүү олон улсын гэрээнд заасан төрлийн гэмт хэргүүдийг Эрүүгийн хуульдаа хуульчилж, гэмт хэрэгт тооцох нь зайлшгүй хүлээх үүргийн нэг билээ.

Манай улс Эрүүгийн хуулийн 20.7-20.10 дугаар зүйлд тус конвенцод холбогдох гэмт хэргийг хуульчилсан. Конвенцын 3.1.а).i) заалтын хувьд 1961, 1971 оны конвенцуудтай ихэнх заалтууд нь адилхан бөгөөд Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх, гаргаж авах, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, хүргэх, зуучлах, дамжуулан өнгөрүүлж илгээх, экспортлох болон импортлох зэрэг үйлдлийг тусгаагүй байна. Харин конвенцод заасан “үйлдвэрлэх” гэсэн үйлдлийг манай улс Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 2.1-д хуульчилснаас үзэхэд уг үйлдлийг гэмт хэрэгт тооцолгүй, зөрчилд тооцсон байна. Мөн Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 20.7.3.3-т “улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол” гэж хүндрүүлэн хуульчилсныг экспортлох, импортлох үйлдлийг илэрхийлсэн гэж үзэж болохгүй юм. Харин Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 2.8-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх гэж зааснаас тухайн үйлдлийг зөрчилд тооцсоныг харж болно. Гэрээний талуудын хувьд эдгээр үйлдлийг үндсэн гэмт хэрэгт тооцох ёстой байдаг ч Монгол Улс зөрчилд тооцсон нь олон улсын гэрээнд нийцээгүй байна гэж үзэв.

3.1.а).ii)-т заасан “... мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 20.10 дугаар зүйлд “Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах” гэмт хэрэг гэж конвенцод заасан ургамлуудыг тухайлан дурдалгүй, ерөнхийд нь мансууруулах үйлчилгээтэй бүх ургамлыг хамруулахаар хуульчилснаас үзэхэд конвенцын заалтыг өргөжүүлсэн байна.

Харин 3.1.а).iii)-т заасан гэмт хэргийн төрлийг үзвэл “(i) дэд хэсэгт заасан аливаа үйл ажиллагааг явуулах зорилгоор¹⁷ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, худалдан авах” гэж, (i) дэд хэсэгт заасан бүх үйлдэлд хамааруулах байдлаар хадгалах, худалдан авах үйлдэлд зорилго нэмж гэмт хэрэгт тооцохоор заажээ. Дэлгэрүүлбэл, конвенцын (i) дэд хэсэгт заасан “үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох... гэх мэт” шинжүүд нь бүгд хадгалах болон худалдан авах үйлдлийн зорилго болж өөр өөр гэмт хэргүүд болохоор байна. Эрүүгийн хуулийн зохицуулалтаас авч үзэхэд тус хуулийн 20.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт “худалдаалах зорилгоор/ худалдаалах зорилгогүйгээр” гэж ялгаж заасан нь конвенцод заасан дээрх зорилгуудыг ерөнхийд нь багтаах боломжтой тул зорилгын хувьд хангасан гэж үзье. Харин конвенцод заасан “худалдаж авах” үйлдэл Эрүүгийн хуульд тусгаагдаагүй байна.

16 Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.50, para 3.4. https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf, Сүүлд үзсэн огноо: 2024.06.25.

17 Үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдах, ямар ч нөхцөлөөр хамаагүй хүргэх, зуучлах, илгээх, дамжуулан өнгөрүүлж илгээх, тээвэрлэх, экспортлох, импортлох зорилгоор.

3.1.a).iv) дэх хэсэгт заасан "...тоног төхөөрөмж, эд зүйлс, бодисыг бэлтгэх, тээвэрлэх, түгээх" гэмт хэргийн хувьд "бэлтгэх" үйлдлийг Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт "тээвэрлэх" үйлдлийг мөн зүйлийн 20.7.2-т тусгасан байна. Харин "түгээх" үйлдлийг үгчлэн тусгаагүй. Гэхдээ Эрүүгийн хуулийн бусад зүйлүүд, тухайлбал: 20.12 дугаар зүйлд "Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн ... түгээх" гэж, 20.14 дүгээр зүйлд "...Хууль бусаар эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл ... түгээх" зэргээр "түгээх" үйлдлийг үгчилж хуульчилсан практик байгаа тул энэхүү гэмт үйлдлийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хувьд мөн үгчлэн хэрэглэж болохоор байна. Харин "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх, эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж" гэсэн зорилгыг мөн тусгаагүй ч энэ нь Эрүүгийн хуульд заасан "худалдаалах зорилго"-д хамаарч болох юм. Гэвч конвенцын дээрх зүйлд дурдсан тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэх, тээвэрлэх, түгээх үйлдлийг Эрүүгийн хуульд тусгаагүй байна.

Конвенцын 3.1.a)v)-д, (i), (ii), (iii), (iv) дэд хэсэгт тодорхойлсон гэмт хэргийг удирдах, санхүүжүүлэх, зохион байгуулах зэрэг гэмт хэргийг тусгажээ. Харин Эрүүгийн хуулийн 3.3 дугаар зүйлийн дагуу, гэмт хэрэг үйлдэхийг санаачилсан, удирдсан, төлөвлөсөн, гэмт хэрэг хамтран үйлдэгчдийн үүрэг, оролцоог хуваарилсан, зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан этгээдийг гэмт хэргийн зохион байгуулагч гэж тооцохоор заасан бөгөөд зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан хүнийг тухайн үйлдэлд нь болон зохион байгуулалттай гэмт бүлгийн бусад гишүүний үйлдсэн гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцож ял оногдуулахаар зааснаас үзэхэд "удирдсан" гэх үйлдлийг "зохион байгуулсан" үйлдлээс ялгаж тусгаагүй, харин гэмт хэргийг зохион байгуулсан үйлдэл дотор удирдах үйлдлийг багтааж ойлгож болохоор байна. Мөн конвенцын 3.1.a)v)-д заасанчлан i-iv-т заасан "санхүүжүүлэх" үйлдлийг Эрүүгийн хуульд тусгаагүй байна.

2. Конвенцын 3 дугаар зүйлийн 1.b) хэсэгт заасан гэмт үйлдлүүд

Конвенцын 3.1.b) хэсэгт заасны дагуу, аливаа гэмт хэрэг болон энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж нуун дарагдуулсан, жинхэнэ мөн чанар, эх үүсвэрийг халхавчилсан гэх мэт үйлдлүүд нь мөнгө угаах¹⁸ төрлийн гэмт хэргийн заалтууд болно. Үүнийг конвенцын 3.1.(c).iv) дэх хэсэгт заасан "...гэмт хэрэг үйлдэхэд оролцсон, үгсэн тохиролцсон..." этгээдүүдийг шийтгэхэд өөрийн эрх зүйн тогтолцоонд ямар ч хязгаарлалт байхаас үл хамааран аль нэг тал (b) дэд хэсэгт заасан мөнгө угаах гэмт хэргийг хуульчлах ёстой¹⁹ гэж конвенцын тайлбарт тусгажээ. Гэвч конвенцын (b) дэд хэсэгт заасан энэхүү заалт нь хүнд гэмт хэрэг болох "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бус эргэлт"-ээс үүдэлтэй мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хязгаарладаг. Харин сүүлийн жилүүдэд мөнгө угаах гэмт хэргийг зөвхөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хувьд хязгаарлалгүй эрүүгийн бусад гэмт хэргийн хувьд өргөтгөх хандлага ажиглагдаж байна.²⁰

18 Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.59, para 3.33, https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf,

19 Мөн тэнд, p.63, para 3.43.

20 Мөн тэнд, p.66, para 3.53.

Практикт зарим улс орон конвенцын 3.1.b) хэсэгт заасантай адил, төстэй хэлбэрээр дотоодын хууль тогтоомждоо тусгасан бол бусад улс орнууд өмнө нь байсан эрүүгийн гэмт хэргийн хамрах хүрээг өөрчлөх зэргээр уг гэмт хэргийг хуульдаа тусгадаг байна. Гэсэн ч тухайн үйлдлийг гэмт хэрэгт бүрэн тооцсон тохиолдолд аль ч аргыг хүлээн зөвшөөрдөг.²¹ Монгол Улсын хувьд мөнгө угаах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд хуульчилсан бөгөөд энэ гэмт хэргийн хамрах хүрээ нь конвенцын 3.1.b) хэсэгт заасан гэмт хэргийн ойлголтод багтаж байна.

3. Конвенцын холбогдох бусад зүйлд заасан гэмт хэргүүд

Конвенцын 3.1.c) i) хэсэгт заасан гэмт хэргийн “мэдсэн байх” шинж нь “хүлээн авах үед” бүрдсэн байх ёстой. Бэлэглэсэн болон үнэ цэнийх нь хувьд барааг хүлээн авч, тухайн бараагаа үргэлжлүүлэн хэрэглэж байгаа бөгөөд хожим нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэж, мэдсэн тохиолдолд дээрх зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхгүй.²² Энэ нь Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэргийн шинжийг хангаж байх тул Эрүүгийн хуульд дээрх гэмт хэргийн төрлийг тусгасан байна гэж үзлээ.

Харин 3.1.c) ii)-т заасан “I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс болон бодисыг аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэхэд ашиглаж байгаа, эсхүл тийм зорилгоор ашиглахад зориулагдсан болохыг мэдсээр байж эзэмших;” гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгаагүй бөгөөд харин Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах...” гэж тусгажээ. Энэ нь гэмт хэрэгт ашиглахад зориулсан, эсхүл ашигладаг зэргээр тухайн багаж хэрэгслийн шинжийг тусгаагүй харин ямар ч багаж байж болохоор заасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Иймд дээрх гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгаагүй бөгөөд Зөрчлийн тухай хуульд хуульчлахдаа ойлгомжгүй байдлаар тусгасан гэж үзлээ.

Конвенцын 3.2 дугаар зүйлд заасны дагуу тал бүр Үндсэн хуулийнхаа заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо зарчмыг баримтлан 1961 оны конвенц, нэмэлт, өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц, 1971 оны конвенцыг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар хадгалах, олж авах, тарималжуулахыг дотоодын хуулийнхаа дагуу гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээ авна. Энд заасан “хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар хадгалах, олж авах” үйлдлийг Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.1-д “худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар хадгалсан, олж авсан” гэмт хэрэг хэмээн тусгажээ. Үүнээс үзэхэд конвенцын уг зүйлд заасан “хувийн хэрэгцээнд зориулсан байх” нөхцөлийг “худалдаалах зорилгогүйгээр” гэдэгт хамааруулсан гэж үзэж болно. Учир нь хувийн хэрэгцээнд зориулан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, олж авах, тарималжуулах үйлдлүүд нь конвенцын 3.1-д заасан гэмт хэргийн төрлүүдтэй харьцуулахад нийгмийн хор аюулын шинж нь бага тул энэ нь ялын хэмжээнд нөлөөлнө. Харин Эрүүгийн хуулийн холбогдох заалтаас үзэхэд “худалдаалах зорилгогүйгээр” хадгалсан, олж авсан

21 Мөн тэнд, p.65, para 3.51.

22 Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.73, para 3.68. https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf,

гэмт хэрэгт “худалдаалах зорилготойгоор” хадгалсан, олж авсан гэмт хэргээс бага ял оногдуулж байх тул конвенцод заасан гэмт хэргийн шинжийг дээрх байдлаар тусгасан гэж үзэж байна. Харин тарималжуулах үйлдлийн хувьд, Эрүүгийн хуулийн 20.10 дугаар зүйлийн 1-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцжээ. Гэвч хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар тарималжуулах үйлдлийг эрүүжүүлээгүй байна.

4. Хамтран оролцогчдод хүлээлгэх хариуцлага

Хамтран оролцогчдод хариуцлага хүлээлгэх асуудлын хүрээнд конвенцын 3.1.с) iii)-iv) дэх хэсгүүдэд заасан заалтыг тус тус авч үзье.

Конвенцын 3.1.с) iii)-т тусгагдсан “энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон нийтийг аливаа хэлбэрээр өдөөн хатгах, уриалах” үйлдлийг манай улсын Эрүүгийн хуулийн 3.4-т заасан гэмт хэргийн хатгагчид хамааруулж үзэх эсхүл бие даасан гэмт үйлдэл болгож ялгамжтай шийтгэл оногдуулах эсэхийг анхаарах шаардлагатай.

Харин 3.1.с).iv)-д заасан гэмт хэрэгт хамтран оролцогчдыг тусгасан заалтыг авч үзвэл “аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, холбогдсон, үйлдэхээр үгсэн тохиролцсон, үйлдэхийг завдсан, түүнчлэн үйлдэх үед хамжсан, хатгасан, дэмжлэг үзүүлсэн эсхүл зөвлөгөө өгсөн” гэмт үйлдлүүдийг Эрүүгийн хуулийн гуравдугаар бүлэг буюу гэмт хэрэгт хамтран оролцогчдод ял оноох тухай зохицуулалтад хамруулсан байна. Эрүүгийн хуулийн 3.1 дүгээр зүйлийн 3.1.2-т гүйцэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигчийг гэмт хэрэгт хамтран оролцогчид тооцсон учир уг конвенцын iv-р зүйлийг бүрэн тусгасан байна хэмээн үзэв. Тодруулбал, конвенцод гэмт хэрэгт хамжсан болон зөвлөгөө өгсөн, дэмжлэг үзүүлсэн гэж тусад нь авч үзсэн байх ч Эрүүгийн хуулийн 3.5 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн хүнийг хамжигчид тооцож байх тул гэмт хэрэгт хамтран оролцогчдыг бүрэн хамруулсан гэж хэлж болох юм.

5. Гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл

Конвенцын 3.5-д заасан тодорхой нөхцөлүүдийг талууд тэдгээрийн шүүх болон хэргийн харьяалал тогтоосон эрх мэдэл бүхий байгууллагуудаас 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлсөн хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзэх явдлыг хангана. Өөрөөр хэлбэл, талуудын үүрэг бол тэдний шүүх, эсвэл бусад эрх бүхий байгууллага (Жишээлбэл, зарим мужид хар тамхитай холбоотой гэмт хэргийг шийдвэрлэхэд ашигладаг тусгай шүүхүүд байдаг.) ял оноохдоо эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэх боломжтой эсэхийг баталгаажуулах явдал юм.²³ Энэ заалт нь шүүхийн жишгийг хууль тогтоомжтой адил үздэг нийтлэг эрх зүйн бүлийн орнуудын хувьд заавал хуульчлахгүйгээр хэрэглэгдэх боломжтой. Харин Монгол Улсын хувьд эх газрын эрх зүйн бүлд хамаардаг тул энэхүү заалтыг хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй хуульчлах шаардлагатай юм. Иймд конвенцын 3.5-д заасан гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлүүдийг тус бүрчлэн авч үзье.

23 Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.90, para 3.115, https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf.

а) Гэмт этгээд өөрийн харьяалагддаг зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт оролцсон гэснийг Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйлийн 3.8.3.-т “Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнийг зохион байгуулалттай гэмт бүлэгт элссэн үйлдэлд ба өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулна.” гэж, Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 20.7.4-т хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон мөн тусгасан байна.

Харин тус конвенцын b) гэмт этгээд олон улсын чанартай бусад төрлийн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагаанд оролцсон; c) гэмт этгээд тухайн гэмт хэргийг үйлдсэний улмаас хууль бус бусад үйл ажиллагаанд оролцсон; d) гэмт этгээд хүч, эсхүл галт зэвсэг хэрэглэсэн; f) гэмт хэрэг үйлдэхэд насанд хүрээгүй хүмүүсийг татан оролцуулсан, эсхүл тэднийг ашигласан; g) гэмт хэргийг хорих ял эдлүүлэх газар, сургууль, олон нийтийн үйлчилгээний газар эсхүл тэдгээрийн ойр орчинд, эсхүл сурагч, оюутны сургалт, спорт, олон нийтийн үйл ажиллагаа явуулдаг газарт үйлдсэн; h) холбогдох талын дотоодын хуулиар зөвшөөрсөн хэмжээнд гадаад улсад болон эх орондоо урьд нь ял шийтгэгдсэн, ялангуяа ижил төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн гэх гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлыг конвенцод дэлгэрэнгүй тусгасан боловч Эрүүгийн хуульд эдгээр зохицуулалтыг орхигдуулсан байна.

Мөн конвенцын e) хэсэгт гэмт этгээд албан тушаалтан бөгөөд тухайн гэмт хэрэг нь түүний албан тушаалтай холбоотой байхаар заасан. Энэхүү холбоо нь ихэвчлэн албан тушаалын эрх мэдлийг урвуулан ашиглах, эсвэл нөлөөллийн хэлбэрээр явагдах боловч конвенцын бичвэрт уг холбооны тодорхой хэлбэрийг заагаагүй болно.²⁴ Өөрөөр хэлбэл, энэ нь гэмт этгээд албан тушаалтан бөгөөд тухайн гэмт хэрэгт түүний албан тушаалын чиг үүрэг ямар нэгэн байдлаар холбоотой байхаар өргөн хүрээнд хамруулж ойлгохоор тусгасан. Харин Эрүүгийн хуулийн 20.9 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан үйлдлээр хуульчилснаар тухайн гэмт хэргийн зөвхөн нэг шинжийг хуульчилсан гэж үзэхэд хүргэж байна. Эрүүгийн хуулийн тус заалт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт тусгай субъектийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан зохицуулалт хэдий ч хүрээг нь хязгаарласан зохицуулалт болжээ.

Үүний зэрэгцээ конвенцын монгол орчуулгад конвенцын үндсэн агуулгаас зөрүүтэй байдал үүсэж байна. Тухайлбал, 1961, 1971 оны конвенцуудад “хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хорих эсвэл эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл зэрэг зохих шийтгэлийг оногдуулна”²⁵ гэж заасан байдаг. Харин энэхүү 1988 оны конвенцыг хэлэлцэж байх үед талууд эдгээр заалтыг өмнөх бичвэрүүдээс илүү өргөн хүрээнд, мөн бэхжүүлж тусгахаар шийдсэн нь конвенцын 3.4 дэх заалт юм. Энэ зүйлийн (а) дэд хэсэгт 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн “хүнд шинж чанарыг” зохих ёсоор тусгасан шийтгэл ногдуулах шаардлагатай байдаг бол хөнгөн шинжтэй тохиолдлуудын хувьд (с) дэд хэсэгт заасан бага хэмжээний шийтгэл оногдуулж болдог. Конвенцын албан ёсны хувилбаруудад тухайлбал англи хувилбарт:

24 Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p92, para 3.120, https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf

25 1961 Convention, art. 36, para. 1; and 1971 Convention, art. 22, para. 1, subpara. (a).

“Each Party shall make the commission of the offences established in accordance with paragraph 1 of this article liable to sanctions which take into account the grave nature of these offences, such as imprisonment or other forms of deprivation of liberty, pecuniary sanctions and confiscation”

гэж зааснаас үзэхэд энэхүү (а) дэд хэсгийн заалт нь 3.4 дэх бусад зохицуулалтуудаас ялгаатай бөгөөд энэ нь талуудад санал болгосон биш “... хариуцлага хүлээлгэнэ.” гэж үүрэг болгосон байдлаар тусгагдсан байна. Харин “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн тус конвенцыг Монгол хэл дээр орчуулсан хувилбарт “Тал бүр 1 дэх хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн хэргийн ноцтой шинж байдлыг харгалзан хорих, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасах, торгох болон хөрөнгө хураах ял ногдуулахаар зааж болно.” гэж тусгагдсан байгаа нь эдгээр ялыг оногдуулахаар заахгүй ч байх боломжтой нөхцөлийг бүрдүүлж байгаа тул конвенцоор хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд саад учруулж байна гэж үзэх үндэслэлтэй.

Мөн дээрх заалтууд нь тухайн бодисын учруулж болзошгүй хор уршиг, эмчлэгдэх байдал, хууль бусаар худалдаалах гэмт хэргийн “хүнд” эсвэл “хөнгөн” шинжээс хамаарч өөр өөр шийтгэл ногдуулах шаардлагатайг илэрхийлсэн заалтууд юм.²⁶ Энэ нь хуулийн пропорциональ байдлын буюу гэмт хэрэгт тохирсон ял шийтгэл оногдуулах зарчимтай холбогддог. 1988 оны НҮБ-ын конвенцод заасан гэмт хэргүүдэд ялгамжтай шийтгэл оногдуулахад мансууруулах бодисын хэмжээ бус гэмт этгээдийн санаа зорилгыг үндэслэх нь хамгийн чухал ба энэ нь конвенцын суурь үзэл санаа, амин сүнс нь юм.²⁷ Европын холбооны гишүүн орнуудын хар тамхины тухай хууль тогтоомж нь хувийн хэрэгцээнд ашиглах болон бусад (Илүү ноцтой) зорилгоор ашиглах үйлдлүүдээр ялгаатай зохицуулалттай байна. Монгол Улсад уг гэмт хэргийг худалдаалах болон худалдаалах зорилгогүйгээр гэж ялган зохицуулсан нь пропорциональ зарчмыг баримталсны илрэл юм. Гэхдээ гэмт хэргийг оновчтой ялгаж зохицуулсан эсэх нь өөр асуудал юм.

Дээрхээс дүгнэвэл, Конвенцод 3.1.а).i)-т заасан “үйлдвэрлэх” болон “экспортлох, импортлох” гэмт хэргүүдийг Эрүүгийн хуульд гэмт хэрэг болгон заагаагүй бөгөөд харин зөрчилд тооцон хуульчилсан байна. 3.1.а).ii)-т заасан “... мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах” гэмт хэргийг өргөжүүлж тусгажээ. Харин 3.1.а).iii)-т заасан гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт конвенцын 3.1.а).i)-т заасан зорилгыг агуулсан байж болох ч мөн зорилгоор “худалдаж авах” үйлдэл Эрүүгийн хуульд тусгагдаагүй байна.

Конвенцын 3.1.а).iv)-т заасан гэмт хэргийг хуульд тусгахдаа “түгээх” үйлдлийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хувьд мөн үгчлэн хэрэглэж болохоор байтал тийн хуульчлаагүй байна. Харин “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж” гэсэн зорилгыг мөн тусгаагүй ч, үүнийг Эрүүгийн хуульд заасан “худалдаалах зорилго”-д хамруулж үзэж болно. Түүнчлэн, конвенцын, дээр дурдсан зүйлд тоног

26 Gloria Lai Drugs, Crime and punishment Proportionality of sentencing for drug offences, Series on Legislative Reform of Drug Policies Nr. 20 June 2012, p.4, <https://www.unodc.org/documents/congress/background-information/NGO/IDPC/Drugs-crime-and-punishment-Proportionality-of-sentencing.pdf>

27 The role of the quantity in the prosecution of drug offences, ELDD Comparative Study , EMCDDA, April 2003, p.18, http://eldd.emcdda.eu.int/databases/eldd_comparative_analyses.cfm

төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэх, тээвэрлэх, түгээх үйлдлүүдийг Эрүүгийн хуульд тусгаагүй байна.

3.1.а)v) дахь хэсгийн хүрээнд “удирдсан” гэх үйлдлийг “зохион байгуулсан” үйлдлээс ялгаж тусгаагүй харин гэмт хэргийг зохион байгуулсан үйлдэл дотроо удирдах үйлдлийг багтааж хуульчилсан байна. Харин конвенцын 3.1.а)-гийн i-iv-т заасан “санхүүжүүлэх” үйлдлийг тусгаагүйгээрээ конвенцод заасан гэмт хэргийг бүрэн бус тусгасан байна.

Манай улс Мөнгө угаах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд хуульчилснаар конвенцын 3.1.b) болон 3.1.c) i) хэсэгт заасан гэмт хэргийн ойлголтуудыг хамруулж хуульчилсан гэж ойлгож болохоор байна. Харин 3.1.c) ii)-т заасан гэмт хэргийг Эрүүгийн хуульд биш Зөрчлийн тухай хуульд хуульчилж 3.1.c.iii болон 3.1.c.iv дэх хэсгүүдэд заасныг гэмт хэрэгт хамтран оролцогчдын хувьд Эрүүгийн хуульд бүрэн тусгасан байна гэж үзлээ.

Харин конвенцын 3.2 дугаар зүйлд заасан “хувийн хэрэгцээнд зориулсан байх” нөхцөлийг “худалдаалах зорилгогүйгээр” гэдэгт хамааруулсан гэж үзвэл конвенцод заасан гэмт хэргийн шинжийг хангасан байна. Гэвч конвенцод тусгасан “тарималжуулах” үйлдлийн хувьд Эрүүгийн хуулийн 20.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан” үйлдлийг гэмт хэрэгт тооцсон боловч үүнд хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар тарималжуулах гэмт хэргийг тусгаагүй байна.

Хүндрүүлэх бүрэлдэхүүний хувьд манай улсын Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцын 3.5 дугаар зүйлийн а хэсгийг бүрэн тусгасан ч мөн зүйлийн b,c,d,f,g,h хэсэгт заасан гэмт хэргийн нөхцөлүүдийг тусгаагүй бөгөөд харин 3.5.e) буюу өргөн хүрээнд хамруулан ойлгох заалтыг Эрүүгийн хуульд хамрах хүрээг нь танаж, зөвхөн нэг шинжээр нь хуульчилсан байна. Мөн конвенцын 3.4.а) хэсэг дэх үүрэг болгосон заалтыг “ял ногдуулахаар зааж болно.” гэж талуудад санал болгож буй мэтээр орчуулсан нь конвенцын холбогдох хэм хэмжээг Монгол Улсад хэрэглэх тохиолдолд уг агуулгаас нь өөрөөр ойлгож хэрэглэх эрсдэлийг үүсгэхээр байна.

Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц (1961), Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц (1971) болон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц (1988) нь харилцан уялдаатай бөгөөд сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хянах эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлсэн олон улсын үндсэн гэрээ хэлэлцээрүүд юм. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц болон Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцын гол зорилго нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг анагаах ухаан болон эрдэм шинжилгээний зорилгоор хэрэглэхийг хорихгүйгээр, харин тус бодисуудтай холбоотой хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох болон урьдчилан сэргийлэхэд чиглэсэн болно. Харин Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц нь өмнөх хоёр конвенцын нэмэлт хэрэгсэл юм.

3.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх (4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл)

4 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх

4.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг дор дурдсан зорилгоор дараах байгууллага ашиглаж болно:

4.1.1. эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор эрүүл мэндийн болон эрдэм шинжилгээний байгууллага;

4.1.2. лабораторийн шинжилгээ хийх, сургалт явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага;

4.1.3. харьцуулалт хийх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага;

4.1.4. эмийн ургамлыг тарималжуулсан тохиолдолд сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг үйлдвэрлэх, экспортлох тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгж.

4.2. Эмчийн заалтаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хэрэглэх жор авсан өвчтөн уг эмийг хэрэглэж болно.

4.3. Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын болон байгууллагын жагсаалт, ашиглах журмыг Засгийн газар батална.

5 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх

5.1. Эмчилгээний зорилгоор хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг улсын стандартын шаардлага хангасан жороор олгоно.

5.2. Хүн амын тоог харгалзан мансууруулах эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангийн тоо, байршлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар тогтооно.

3.2.1. Зорилгод хүрсэн түвшин ба Практикт нийцэж байгаа байдал

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зорилт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Тус хуулийн 4 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ашиглаж болох байгууллагуудыг ерөнхийлөн тогтоосон ба шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын болон байгууллагын жагсаалтыг тусгайлан Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагын жагсаалтыг баталсан.

Хүснэгт 1.2. Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагууд

№	Нэг. Эрдэм шинжилгээний байгууллага		Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашигладаг эсэх
	Жагсаалт дахь нэр	Одоогийн нэр	
1.	Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны хүрээлэн	Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит Анагаах ухааны хүрээлэн	Тийм
2.	Шинжлэх ухааны академийн Хими-технологийн хүрээлэн	Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн	Тийм
3.	Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэн	Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	Тийм
4.	Мал эмнэлгийн хүрээлэн	Мал эмнэлгийн хүрээлэн	Тийм
Хоёр. Боловсролын байгууллага			
5.	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль	Тийм
6.	Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал эмнэлэг, биотехнологийн сургууль	Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, Биотехнологийн сургууль	Тийм
7.	Монгол Улсын их сургуулийн Шинэ материал хими-технологийн төв	Одоогийн байдлаар ийм төв байхгүй байна.	Тийм
Гурав. Бусад			
8.	Улсын мэргэжлийн хяналтын газрын Нэгдсэн лаборатори;	Стандарт хэмжил зүйн газрын харьяа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	Тийм
9.	Улсын гаалийн ерөнхий газрын дэргэдэх Гаалийн төв лаборатори	Улсын гаалийн ерөнхий газрын дэргэдэх Гаалийн төв лаборатори	Тийм
10.	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийг удирдах газар	-	Тийм
11.	Эрүүл мэндийн яамны Сэтгэцийн эмгэг мансуурал судлалын төв	-	Тийм
12.	Эрүүл мэндийн яамны Шүүх эмнэлгийн магадлах төв	-	Тийм
13.	Мал эмнэлгийн эм бэлдмэл шалгах улсын нэгдсэн лаборатори	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори	Тийм
14.	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	Тийм
15.	Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэн	Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн шинжлэх ухааны газар, Химийн лаборатори	Тийм

Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны хүрээлэн нь 2015 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор АШУҮИС-ийн харьяанд шилжсэн бөгөөд Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит Анагаах ухааны хүрээлэн болсон байна. Уг хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний төв лабораторийн хамтран ажиллах чиглэлд Эсийн өсгөвөр (Анхдагч эсийн өсгөвөр, шугаман эсийн өсгөвөр), Молекул биологи (Уургийн анализ, Генийн экспресс), Эдийн шинжилгээ (Иммуногистохими, Иммунофлюоресценци) зэрэг багтаж байна.

Онцлог лабораториудтай зарим байгууллагуудыг тухайлан судалбал, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн нь Байгалийн

нэгдлийн химийн лаборатори, Эрдсийн технологийн лаборатори, Экологийн химийн лаборатори, Органик бус химийн лаборатори, Органик химийн лаборатори, Нүүрсний хими технологийн лаборатори, Материал судлал, технологийн лаборатори, Хүнсний химийн лаборатори, Биохимийн лаборатори, Багажит анализын лабораториор шинжилгээ, судалгаа хийж, үйл ажиллагаагаа явуулдаг бол Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн Ургамлын ангилал зүй, филогенетикийн лаборатори, Ургамалжлын экологи, ургамлын эдийн засгийн лаборатори, Ойн фитоценологийн лаборатори, Ургамлын стресс физиологийн лаборатори, Ургамлын интродукц, генетик нөөцийн лабораториуд нь тус тус шинжилгээ судалгаа хийх боломжтой байна.

Стандарт хэмжил зүйн газрын харьяа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн микробиологийн лаборатори, хими, хор судлалын лаборатори зэрэг нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тэдгээрийн түүхий эдэд судалгаа, шинжилгээ явуулж болохоор байна.

Харин Гаалийн төв лаборатори нь 1996 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын чанарын шинжилгээгээр 2003 оноос хойш Стандартчилал, хэмжил зүйн газраас итгэмжлэгдсэн лабораторийн эрхтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Гаалийн төв лаборатори нь харьяа гаалийн газар хороод болон хууль хяналтын бусад байгууллагаас ирүүлсэн сэжигтэй дээжид CA3/CA/05-08 аргачлалын дагуу нил улаан туяа, Раманы хосолсон спектрометр (FTIR/RAMAN) болон CA3/CA/05-07 аргачлалын дагуу хроматограф/масс спектрометр (GC/MS) баражаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын чанарын шинжилгээ хийж, үр дүнг албан тоотоор хүргүүлэн ажилладаг.

Дээрх байгууллагуудаас МУИС-ийн Шинэ материал хими-технологийн төвөөс бусад бүх байгууллагууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ашиглах боломжтой байна.

Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагын жагсаалтад МУИС-ийн шинэ материал хими-технологийн төвийг багтаасан ч энэхүү төв нь одоогоор үйл ажиллагаагаа явуулдаггүй бөгөөд МУИС-ийн бүтцэд байдаггүй. Мөн МУИС-д 1996 онд Шинэ материалын лаборатори байгуулагдан судалгаа шинжилгээ хийж байгаа боловч энэхүү лаборатори нь шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашигладаггүй байна.

Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах журмын²⁸ 3.7 дугаар зүйлд заасны дагуу Улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашигладаг байгууллагыг тогтмол хянаж байхаар үүрэг болгосон байдаг. Гэтэл дээрх байгууллагуудыг хянах байгууллага буюу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгож татан буулгахаар шийдвэрлэсэн. Улмаар хяналтын чиг үүргийг салбар яамд болон тэдгээрийн харьяа байгууллагууд руу шилжүүлсэн

28 Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.

байна. Шилжсэн хяналтуудаас²⁹ энэхүү судалгааны сэдэвтэй холбоотой хамгийн боломжит хяналтууд (Ургамал хамгааллын хяналт, таримал ургамлын үрийн хяналт, эмчилгээний чанарын хяналт зэрэг)-ыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам руу тус тус шилжүүлснээс өөрөөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдэд тухайлсан хяналтыг хаашаа шилжүүлсэн нь тодорхойгүй байна.

Эдгээрээс дүгнэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор холбогдох байгууллагууд ашиглаж байгаа ч ашиглахаар журамд заасан зарим байгууллагын үйл ажиллагаа зогссон, эсхүл огт үйл ажиллагаагаа явуулаагүй байна. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах байгууллагуудад Улсын мэргэжлийн хяналтын байгууллага буюу Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хяналт тавих үүргийг журамд заасан ч уг байгууллага татан буугдсаны улмаас энэхүү чиг үүрэг аль нэг яамны харьяа улсын байцаагчид шилжсэн байх магадлалтай байна. Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх харилцаанд хяналтыг бүрэн хэрэгжүүлж хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлэхэд хүндрэлтэй гэж үзэж байна. Энэ нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зорилтод нийцэхгүй байгаа буюу практикт хэрэгжилтийн хувь сөрөг үр дагавар авчрах боломжтой гэж дүгнэлээ.

Тус хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан улсын стандартын шаардлага хангасан жороор олгох талаар:

Эмийн найрлагад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис эмчилгээний тунгаар орсон байвал эмч эмийн жор бичих бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорыг бичихдээ “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 Монгол Улсын стандартыг мөрдөнө. Мөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 Монгол Улсын стандартад заасан загварын дагуу хэвлүүлэн, дугаарлаж (индекс), харьяа нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудад түгээхээр байна.

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 6 дугаар зүйлд Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор бичих, жорын маягтаар хангах талаар тусгасан бөгөөд үүнд зааснаар Мансууруулах эмийн жорын маягтын дугаар нь тухайн аймаг, нийслэлийн Засаг захиргааны нэгжийн код болон 5 оронтой тоо, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягт нь дээрх код болон 6 оронтой тооноос бүрдэхээр байна. Мөн “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтад орсон мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг эдгээр эмийн жорын маягт болон даатгалын жорын маягт дээр бичиж хавсаргасан байна. Төв эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвүүд нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт захиалж авна. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн

29 Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын чиглэлүүдээр салбарын яамд, тэдгээрийн харьяа байгууллагуудад хандаарай, <https://www.facebook.com/mergejliinhyanalt/>

жорын маягтыг тухайн байгууллагын захиалга болон өмнө авсан жорын маягтын зарцуулалтын тайланг үндэслэн олгоно.” гэж тус тус заажээ. Түүнчлэн уг журамд Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл, тайлан зэргийн загварыг багтаасан байх тул эдгээр зохицуулалт нь нарийвчлан зохицуулагдсан байна. Гэвч Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/66 дугаар тушаал, 2021 оны А/781 дүгээр тушаалаар энэхүү журамд өөрчлөлт орсон ч MNS 5376:2014 буюу 2016 онд шинэчлэгдсэн стандартыг тусгаагүй 2014 оны стандартыг дагаж мөрдөхөөр заасан заалтад өөрчлөлт ороогүй байгаагаас үзэхэд практикт хэрэгжих болон хуулийн зорилгод нийцсэн байх шалгуурыг зарим талаар хангахгүй байна гэж үзлээ.

Мөн хуулийн 5.2-т “Хүн амын тоог харгалзан мансууруулах эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангийн тоо, байршлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар тогтооно” гэсний дагуу нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг эрүүл мэндийн газар мансууруулах эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангийн тоо, байршлыг тухайн засаг, захиргааны нэгжийн хүн амын тоог харгалзан тогтоож байх тул энэхүү заалтын хувьд хуулийн зорилтод хүрээгүй байх эсхүл практикт хэрэгжихгүй байх явдал үгүй байна.

3.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх (6 дугаар зүйл)

6 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх

6.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль тогтоомжид заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

6.2. Экспортлогч, импортлогч талууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө харилцан гэрээ байгуулна.

6.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг экспортлогч, импортлогч талуудын байгуулсан гэрээ, тусгай зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

6.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг энэ хуулийн 6.3-т заасан тусгай зөвшөөрлийг үндэслэн Засгийн газраас тусгайлан тогтоосон хилийн боомтоор нэвтрүүлнэ.

6.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн тухай бүрд энэ тухай гаалийн байгууллага эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

6.6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын тусгай журмыг гаалийн удирдах төв байгууллага баталж мөрдүүлнэ.

3.3.1. Зорилгод хүрсэн түвшин

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх, хяналтыг бүрэн

хэрэгжүүлж хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлж буй эсэхэд үнэлэлт өгнө.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу тухайн хилийн боомт дахь Гаалийн байцаагч хяналт хэрэгжүүлнэ. Энэ харилцаанд нэг талаас гаалийн хилээр бараа нэвтрүүлэх гэж буй ААН гаалийн мэдүүлгийг үнэн зөв мэдүүлж, нөгөө талаас Гаалийн байгууллага ААН-ийн гаалийн мэдүүлгийг үнэн зөв эсэхийг шалгана. Ингэхдээ ААН-ээс гаалийн хилээр оруулах хэлбэрээс хамааран ачааны манифест, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодис, угтвар бодис болон эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөл³⁰, тухайн эм, бэлдмэлийг худалдан авах гэрээ, гаалийн мэдүүлэг, гарал үүслийн бичиг зэргийг шаардаж болно.

Гаалийн ерөнхий газрын ахлах улсын байцаагч Ш:

- ЭМЯ-аас энэ харилцаатай холбоотойгоор авч хэрэгжүүлдэг арга хэмжээ одоогоор байхгүй.
- Гэрээ, тусгай зөвшөөрөл зэргийг тусгайлан шалгадаг мэргэшсэн хүн байхгүй.
- Хууль бусаар улсын хил нэвтрүүлэх зөрчлийг Эрүүгийн шинжтэй, хялбаршуулсан гэж 2 ангилж прокурорын хяналт дор хэрэг нээж хялбаршуулсан зөрчлийг Гаалийн улсын байцаагч шийдвэрлэж, харьяаллын дагуу бусад хууль хяналтын байгууллагад шилжүүлдэг.
- Техник, тоног төхөөрөмж дутмаг, бусад улс оронтой харьцуулахад хуучин хоцрогдсон байдаг ч хүний нөөц хангалттай.

Гаалийн ерөнхий газрын ахлах улсын байцаагч С:

- Хилээр нэвтрэх иргэний бие, ачаанд гаалийн байгууллага л зөвхөн хяналт тавьдаг.
- Тагнуулын ерөнхий газраас ирсэн мэдээллийг үндэслэн Гаалийн улсын байцаагч хилээр нэвтрэх гэж буй иргэний бие болон ачаанд шалгалт хийнэ.
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх гэж буй байгууллагад квот тогтоодог. Энэ квот нь тусгай зөвшөөрлийн хугацаа, тэдгээр бодисын хэмжээг тодорхой заасан байна. Квотын хэмжээнээс хэтэрвэл гаалийн зөрчилд тооцогддог ба дутвал тогтоосон хугацааны дотор ахин адил төрлийн бодис нэвтрүүлэх эрх нь тус байгууллагад үлддэг.

Үүнээс үзэхэд ЭМЯ гаалийн хилээр нэвтэрч буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих эсэх нь тодорхойгүй байна. Харин тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 13.17 дугаар зүйлд зааснаар “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодис, угтвар бодис болон эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх худалдах” тусгай зөвшөөрлийг “Эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” олгодог. Монгол Улсад Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлэгч агентлаг “Эм, эмнэлгийн

30 Зөвшөөрлийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530780109311>

хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар” нь эмчилгээ, оношилгооны өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүн эмнэлэг, мал эмнэлгийн байгууллага болон хүн амыг шаардлагатай эмээр тасралтгүй, жигд хүртээмжтэй хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж, эмийн зохицуулалтын үйл ажиллагааг цогцоор нь хэрэгжүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байна. Тухайн байгууллагад харьяалах асуудлын талаар мэдээлэл авахаар албан бичгээр хандсан боловч мэдээлэл ирүүлээгүй. Иймд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны талаар судалгаандаа тусгах боломжгүй болсон юм.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг гаалийн хилээр нэвтрүүлэх үед нэвтэрч буй хилийн боомтын гаалийн байгууллагад ААН-ын бусад газартай байгуулсан гаалийн мэдүүлгийн бүрдүүлбэрт ордог гэрээ, тусгай зөвшөөрөл зэргийг тусгайлан шалгадаг мэргэшсэн хүн байхгүй ба тухайн цаг үед томилогдсон гаалийн байцаагч хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэдэг. Иймд гаалийн байцаагч нарыг энэ төрлийн гэрээний харилцаанд мэргэшүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хууль бусаар улсын хил нэвтрүүлэх зөрчлийг эрүүгийн шинжтэй, хялбаршуулсан гэж 2 ангилж прокурорын хяналт дор хэрэг нээж хялбаршуулсан зөрчлийг Гаалийн улсын байцаагч шийдвэрлэж, харьяаллын дагуу бусад хууль хяналтын байгууллагад шилжүүлдэг. Энэ тохиолдолд уг хэргийн шийдвэрлэлтэд хараат бус, ашиг сонирхлын зөрчлийг нарийн анхаарч үзэх шаардлагатай харагдаж байна.


Гаалийн ерөнхий газраас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг өөр байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хянадаг. Ингэхдээ хувийн аж ахуй нэгж болон улсын бусад байгууллагуудын хүсэлтийг үндэслэн Гаалийн төв лабораторид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг шинжилдэг ба сэжиг бүхий эд зүйлийг хурааж аван шалгадаг байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхгүй байх зорилгоор зарим бараа материалыг нэг бүрчлэн баглаа боодлыг нь задалж шалгадаг ба хориглосон, хязгаарласан бараа оруулж ирэхийг завдсан байж болзошгүй тагнуулын мэдээлэл дээр үндэслэж үзлэг, шалгалт хийнэ.

Монгол Улсын хилээр нэвтрэх иргэн, ААН гаалийн бүрдүүлэлтийг хийхдээ ижил журмаар адилхан бүрдүүлэлт хийнэ. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хилээр нэвтрүүлэхэд гаалийн мэдүүлэг дээр нэмээд тусгай зөвшөөрөл, гэрээ зэргийг нэмж шаардана. Өөрөөр хэлбэл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тусгай журам байхгүй.

Монгол Улсын хилээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг нэвтрүүлж буй мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодис, угтвар бодис болон эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөл бүхий ААН нөхцөл байдлаас хамааран дараах гаалийн бүрдүүлэлтийг хийнэ. Үүнд:

- Экспорт, импортын барааны гаалийн мэдүүлэг (Тус гаалийн мэдүүлгээр хувь хүний нэр дээр илгээсэн болон зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд хамаарахгүй барааны үнийн дүн 3,000,001 төгрөгөөс дээш бол)
- Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн мэдүүлэг (Олон улсын шуудан илгээмжийн гаалийн мэдүүлгээр улс, хоорондын шуудан илгээмжээр захидал, боодол, илгээлтийн хэлбэртэй биет зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх бол)
- Автомашины гаалийн мэдүүлэг (Суудлын автомашины гаалийн мэдүүлгээр гаалийн хилээр суудлын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх бол)³¹
- Үүн дээр гадаад улсын экспортлогч ААН болон Монгол Улсын импортлогч ААН хоорондын гэрээ, тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, манифест зэрэг бичиг баримт шаардлагатай.

Зураг 1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааны зураглал



Гаалийн байгууллага гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтыг хүлээн авч, шалгахдаа Гаалийн ерөнхий газрын даргын баталсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”³²-ын дагуу хяналт шалгалтыг хийнэ. Ингэхдээ Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”³³-ын дагуу “CAIS” Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем ашиглаж ААН-ийн гаалийн мэдүүлгийг шалгадаг.

31 Бүрдүүлэлт, <https://gaali.mn/services/citizen/sector/clearances/list>

32 Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын 7.1 дүгээр зүйл.


33 Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207582&showType=1>

3.3.2. Практикт нийцэж байгаа байдал

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулсан тус хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч буй эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох болно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6.4-т зааснаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг энэ хуулийн 6.3-т заасан тусгай зөвшөөрлийг үндэслэн Засгийн газраас тусгайлан тогтоосон хилийн боомтоор нэвтрүүлнэ” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 196 дугаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт)” тогтоолын 1 дүгээр зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Буянт-Ухаа, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд дэх хилийн боомт, Улаанбаатар хот дахь гаалийн газраар нэвтрүүлж байхаар тогтоосугай.” гэж заажээ.

Зураг 1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг нэвтрүүлэх Монгол Улсын хилийн боомт




Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 196 дугаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт/” тогтоолын хавсралтад заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсад нэвтрүүлэх 4 гаалийн газрын Замын-Үүд хилийн боомт нь Замын-Үүд (Автозам, Замын-Үүд) Төмөр зам гэх 2 төрөлтэй, Буянт-Ухаа хилийн

боомтод байршил, нэрийн хувьд өөрчлөлт орж “Чингис хаан” Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газар³⁴ гэж өөрчлөгдсөн байна. Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай бичиг баримтын бүрдүүлбэр хийхэд ойлгомжгүй, хууль хэрэгжилт хангагдахгүй тул Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 196 дугаар тогтоол дээрх зарим боомтуудын нэр, төрлийг тодорхой болгож шинэчлэн батлах шаардлагатай байна.

Улсын хилээр нэвтрүүлэх гэж буй эд зүйлийг Гаалийн төв лаборатори 2003 оноос хойш Стандартчилал, хэмжил зүйл газраас итгэмжлэгдсэн лабораторийн эрхтэйгээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг шинжлэх үйл ажиллагаа явуулж байна.³⁵ Ингэхдээ Гаалийн төв лаборатори нь харьяа гаалийн газар хороод болон хууль хяналтын бусад байгууллагаас ирүүлсэн сэжигтэй дээжид СА3/CA/05-08 аргачлалын дагуу нил улаан туяа, Раманы хосолсон спектрометр (FTIR/RAMAN) болон СА3/CA/05-07 аргачлалын дагуу хроматограф/масс спектрометр (GC/MS) багажаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын чанарын шинжилгээ хийж, үр дүнг албан тоотоор хүргүүлэн ажилладаг. 2015 оноос 2023 оныг хүртэл Гаалийн төв лабораторийн илрүүлсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг лабораторид шинжилсэн тоог харьцуулж үзэв.

График 1.1. Гаалийн төв лабораторид ирүүлсэн дээж (2015-2023)



2015 онд Гаалийн төв лабораторид (ГТЛ) гаалийн газар хороо (Гаалийн зөрчил, хөдөлгөөнт хяналтын газраас дотоод зурвасаар) болон хууль хяналтын бусад байгууллага (ЦЕГ-ЗБГХТГ, ТЕГ, ХХЕГ-Хилийн тагнуулын газар, ЦЕГ-Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс)-с ирүүлсэн нийт 201 ширхэг дээжнээс 125-д мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илэрч 76 ширхэг дээжид илрээгүй. Илэрсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын 95 дээжид метамфетамин гидрохлорид (ICE-мөс), 19 дээжид Дельта-9-тетрагидроканнабинол, 1 дээжид Морфин, 2 дээжид Диазепам болон Фенобарбитал, 1 дээжид 3,4-Метилендиокси-п-метамфетамин (MDMA), 7 дээжид Кофеин илэрсэн.

2016 онд ГТЛ-д гаалийн газар хороод болон хууль хяналтын бусад байгууллага (Цагдаагийн Ерөнхий Газар-Эрүүгийн Цагдаагийн Газар, МХЕГ, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар)-аас болон “Монхимо” ХХК-ийн албан хүсэлтээр ирүүлсэн

34 Хилийн боомтын жагсаалт, <https://gaali.mn/categories/border-crossing-point>

35 Гаалийн ерөнхий газраас ирсэн албан бичгийн хариуны хавсралт тоон мэдээ

нийт 42 ширхэг дээжид шинжилгээ хийснээс 10 мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илэрсэн. Үүний 2 дээжид “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” НҮБ-ийн 1971 оны конвенцийн Жагсаалт IV-т заагдсан сэтгэцэд нөлөөт бодис болох Фенобарбитал, 8 дээжид “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” НҮБ-ийн 1971 оны конвенцийн Жагсаалтад заагдаагүй сэтгэцэд нөлөөт бодис болох Кофеин илэрсэн.

2017 онд ГТЛ-д гаалийн газар хороод болон хууль хяналтын бусад байгууллагаас мөн Альянс фүүдс ХХК, “Бунд-Овоо” ХХК, “Кореа стандарт” ХХК-ийн албан хүсэлтээр ирүүлсэн нийт 31 ширхэг дээжид шинжилгээ хийснээс 7 мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илэрсэн. Үүнээс 6 дээжид “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” НҮБ-ийн 1971 оны конвенцийн Жагсаалтад заагдаагүй сэтгэцэд нөлөөт бодис болох Кофеин илэрсэн. 1 дээжид Трамадол илэрсэн.

2018 онд Улаанбаатар хот дахь гаалийн газраас албан хүсэлтээр ирүүлсэн 1 ширхэг сэжигтэй дээжид шинжилгээ хийхэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илрээгүй бөгөөд “үл орлуулагдах амин хүчил” агуулсан бэлдмэл, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газраас ирүүлсэн 2 дээж нь дельта-9-тетрагидроканнабинол (THC) болон каннабисын давирхайн бүрэлдэхүүнд хамаарагдах каннабидиол илэрсэн.

2019 онд Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газраас ирүүлсэн 4 дээжид “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” НҮБ-ийн 1971 оны конвенцийн Жагсаалт II-т заагдсан сэтгэцэд нөлөөт бодис болох ДЕЛЬТА-9-ТЕТРАГИДРОКАННАБИНОЛ, 2 дээжид ECSTACY (MDA) буюу N-Methyl-3,4-methylenedioxyamphetamine илэрсэн.

2021 онд ГТЛ-д Улаанбаатар хотын гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газраас дотоод зурвасаар ирүүлсэн 1 сэжигтэй дээжид шинжилгээ хийхэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илрээгүй.

2022 онд Гаалийн төв лабораторид гаалийн газар хороод болон хууль хяналтын бусад байгууллагаас ирүүлсэн 8 дээжээс УХШИГГ-аас ирүүлсэн “шингэн тамхи” гэх 1 дээж нь “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” НҮБ-ийн 1971 оны конвенцын Жагсаалт II-т заагдсан сэтгэцэд нөлөөт бодис болох Дельта-9-тетрагидроканнабинол болон каннабисын давирхайн бүрэлдэхүүнд хамаарагдах каннабидиол илэрсэн.

2023 онд ГТЛ-д гаалийн газар хороод болон хууль хяналтын бусад байгууллагаас ирүүлсэн 25 дээжээс УХШИГГ-аас ирүүлсэн “электрон тамхины шингэн” гэх 1 дээж нь НҮБ-ын 1961 оны “Мансууруулах эмийн тухай” конвенцын хавсралтад заагдсан каннабисын давирхайн бүрэлдэхүүн болох каннабидиол, каннабидиварол илэрсэн.

Сүүлийн жилүүдэд шингэн тамхи, түүний запаас болох цахилгаан төхөөрөмжид сольж хэрэглэх зориулалттай жижиг савлагаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хийж шингэн тамхи нэрээр хууль бусаар хилээр нэвтрүүлэх тохиолдол нэмэгдсэн байна.

3.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах (7 дугаар зүйл)

7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах

7.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг зохих шаардлага хангасан байр, агуулахад хадгалах бөгөөд сав, баглаа боодол нь түүний бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр хийгдсэн байна.

7.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг дараах тохиолдолд устгана:

7.2.1.эрх бүхий байгууллагын хяналтын үйл ажиллагааны явцад хууль бусаар ашиглаж байгааг илрүүлэн хурааж авсан бөгөөд цаашид ашиглах чанарын шаардлага хангахгүй бол;

7.2.2.эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж байсан болон нөөцөлж хадгалсан боловч хэрэглэх хугацаа дууссан, чанараа алдсан;

7.2.3. сав, баглаа боодол нь шошго, нэр хаяггүй бол.

7.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журмыг Засгийн газар батална.

3.4.1. Зорилгод хүрсэн түвшин

Тус хуулийн 7 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалахад тавигдах шаардлага, тэдгээрийг устгах үндэслэл бүхий гурван тохиолдлыг заасан ба журмаар нарийвчлан зохицуулахаар тусгажээ. Эдгээр нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зорилт болох мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгод бүрэн нийцэж байна гэж үзлээ.

3.4.2. Практикт нийцэж байгаа байдал

Тус хуулийн 7.3-т заасны дагуу “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журам³⁶”-ыг Засгийн газраас баталсан байна. Уг журамд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн 7.2-т заасан тохиолдолд устгах арга хэмжээ авна гэж баталгаажуулсан. Уг журмыг шинэчлэх шаардлагатай хэд хэдэн шаардлага үүссэн байна. Тухайлбал, хууль бус эргэлтээс хураан авсан, эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах боломжгүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар устгахаар заасан. Гэтэл Мэргэжлийн хяналтын байгууллага буюу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасан. Өөрөөр хэлбэл, татан буулгасан байгууллагын дүгнэлтийг үндэслэх асуудал тулгарч байна.

Мөн журмын 4.3-т заасны дагуу тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, шинжилгээ, судалгааны байгууллага нь хүчинтэй хугацаа дууссан, химийн болон

36 Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт,

физикийн үйлчлэлийн улмаас нөхөн сэргээх, дахин боловсруулах боломжгүйгээр шинж чанараа алдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгахдаа:

- Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн байгууллагын даргын шийдвэрээр тусгай комисс томилох;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг устгахдаа улсын мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг байлцуулах;
- Устгасан тухай баримт бичиг үйлдэн улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хуулбарыг хүргүүлэх нөхцөлийг тус тус хангасан байх ёстой байна.

Харин практикт тусгай зөвшөөрөл бүхий компаниудын ирүүлсэн хүсэлтийн дагуу хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм устгуулах тухай улсын байцаагч дүгнэлт үйлдэж, Эрүүл мэндийн яамны харьяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газартай хамтран хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бүтээгдэхүүнийг тусгай компаниар устгуулж, хяналт тавьж ажиллаж байна.³⁷ Өөрөөр хэлбэл, журамд заасны дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагын даргын шийдвэрээр тусгай комисс томилогдож хүчинтэй хугацаа дууссан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгах ажиллагаа явагдахгүй байна гэж дүгнэж болох юм.

Түүнчлэн журмын 5.2-т зааснаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль бусаар бэлтгэхэд ашиглаж байсан тоног төхөөрөмжийг цаашид ашиглах боломжгүй нь улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтээр тогтоогдох ёстой байна. Иймд энэхүү журмын үйлчлэл практикт хэрэгжихээ больсон байх тул хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах (8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл)

8 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл олгох

8.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг энэ хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад зориулалтаар үйлдвэрлэх, худалдах, ашиглах, хэрэглэхийг хориглоно.

8.2. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх байгууллагын худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

8.3. Энэ хуулийн 4.1-д заасан зорилгоор мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.14-т заасны дагуу олгоно.

37 Хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг устгууллаа, <https://mmra.gov.mn/?id=200617> , Сүүлд үзсэн огноо: 2024.03.20.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай зөвшөөрөл авахыг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хадгалах шаардлага, тусгай нөхцөлийг хангасан агуулахтай байх бөгөөд уг агуулахын талаар эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргана.

8.5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаатай олгоно.

8.6.Тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай, Эрүүл мэндийн тухай хуулиар тус тус зохицуулна.

9 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн ашиглалт, зарцуулалтын тайлан

9.1.Тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө гарган эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллага болон энэ хуулийн 14.6-д заасан Үндэсний хороонд тус тус ирүүлнэ.

3.5.1. Зорилгод хүрсэн түвшин ба Практикт нийцэж байгаа байдал

3.5.1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх байгууллагын худалдах тусгай зөвшөөрөл

3.5.1.1. Зорилгод хүрсэн түвшин

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тусгасан. Иймд уг хуулийн тухайн зорилгод хамаарах зохицуулалтууд нь энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэн үйлчлэх ёстой.

МЭСНБЭХТХ-ийн 8.2-т “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх байгууллагын худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно” гэж заасан. Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг хянах тухай хуульд тодорхой тусгаж өгөөгүй ба үүнийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 5/5573 тоот Хууль зүйн үндэсний хүрээлэнд ирсэн албан бичигт “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь эм хангамжийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл, импортын бүртгэл олгох, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг” гэсэн хариуг өгсөн. Энэ нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүнтэй холбоотой үйл ажиллагаагаар тусгай эрх олгох болон хяналт тавих эрх бүхий субъект болохыг харуулж байна. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх байгууллагын худалдах тусгай зөвшөөрлийг

олгох Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрыг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хуульд тусгаагүй нь тодорхой бус байдлыг бий болгож байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт, тэдгээрийн үйлдвэрлэл, импорт, экспорт хадгалалт худалдааг зохицуулах журмыг эрүүл мэндийн сайдын тушаалаар баталдаг. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэх болон ханган нийлүүлэх зэрэг тусгай зөвшөөрлийн хяналтыг хэрэгжүүлэхэд “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам”-ийг дагаж мөрдөнө. Уг журам нь Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/66, А/781 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг авах шаардлагад:

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 2 дугаар зүйлд мансууруулах эмийг импортлох, экспортлох болон тусгай зөвшөөрлийг хэрхэн авах талаар зохицуулсан байна. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, экспортлоход Монгол улсын нутаг дэвсгэрт хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын лицензийг эмийн хэрэглээнээс хамааран Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас 6 сарын хугацаатай олгодог. Мөн нэмж импортлох болон экспортлох бол Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт мэдэгдэж, тус газраас Олон улсын мансууруулах бодисын хяналтын зөвлөлөөр шийдвэрлүүлсэн тохиолдолд импорт, экспортын лиценз олгодог.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын лиценз хүсэхэд дараах баримт бичгийг бүрдүүлдэг. Үүнд:

1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн хуулбар;
2. Экспортлогч, импортлогч талтай байгуулсан албан ёсны гэрээ;
3. Эм, эмийн түүхий эдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
4. Импорт, экспортын лиценз хүссэн өргөдөл /маягтын дагуу/ зэрэг тус тус хамаардаг.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лиценз хүссэн өргөдөл болон баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хянан шийдвэрлэдэг. Тус байгууллага нь лиценз олгохтой холбоотой асуудлаар шаардлагатай тохиолдолд лиценз хүссэн өргөдлийг шийдвэрлэх хугацааг ажлын 10 хоног хүртэл сунгаж болдог.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лицензийн маягтын дагуу ялгамжтай байдлаар бүрдүүлнэ. Үүнд, Мансууруулах эмийн импортын лицензийг шар, сэтгэцэд нөлөөт эмийн импортын лицензийг ногоон өнгийн А4 цаасан дээр 5 хувь үйлдэж, импортлогчид 2 хувийг, Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах, сэтгэц нөлөөт эм, бодис хариуцсан нэгж, Гаалийн ерөнхий газарт

тус тус 1 хувийг хүргүүлнэ. Мөн лицензийн хугацаа дууссан тохиолдолд лиценз эзэмшигч нь дахин хүсэлт гаргах ба уг хүсэлтийг үндэслэн шинээр импортын лиценз олгодог.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 3 дугаар зүйлд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг хэрхэн авах талаар зохицуулсан байна. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх болон ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаатай олгоно. Мөн “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм болон тэдгээрийн угтвар бодисыг ашиглан эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг эмийн хэлбэр бүрд олгоно” гэж тус тус заасан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэхтэй холбогдсон тусгай зөвшөөрлийн талаар тодорхойлсон. Мөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоход дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хадгалах агуулахын талаарх Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дүгнэлт;
2. Тухайн байгууллагад мансуурах донтой, архинд донтох болон өөр бусад шалтгаанаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисыг зүй бусаар хэрэглэдэг хүмүүс ажилладаггүй тухай Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн магадалгаа;
3. Үйлдвэрлэлийн дамжлага болон ханган нийлүүлэх үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцооны тухай танилцуулга;
4. Үйлдвэрлэх болон импортлох эмийн нэр, тун, хэлбэр, тоо хэмжээний талаарх мэдээлэл;
5. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис бүхий ургамал ашиглах тохиолдолд уг ургамлыг ашиглахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;
6. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан бусад баримт бичиг зэргийг тус тус бүрдүүлдэг.

Мөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх байгууллага нь худалдах тусгай зөвшөөрлийн шаардлага хангасан агуулахтай байхыг шаарддаг ба үүнийг Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 3.3.1-д “мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хадгалах агуулахын талаарх Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дүгнэлт” -ийн дагуу олгодог.

Мөн журмын 2.9-д “Импортлогч нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг улсын хилээр нэвтрүүлж, өөрийн агуулахад татан авсан тухай бүр хуульд заасан хугацааны дотор хилийн болон Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт мэдэгдэнэ” гэж заасан нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар байгууллагуудад тусгай зөвшөөрлийг олгохдоо шаардлага хангасан агуулахтай байх талаарх хяналтыг хэрэгжүүлэх дүгнэлт гаргах эрх бүхий субъект юм. Гэвч Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль болон Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх,

ханган нийлүүлэх журмаар тусгай шаардлага хангасан агуулахын талаарх мэдээлэл болон тавигдах шаардлага зэргийг тодорхой байдлаар зохицуулаагүй байна. Түүнчлэн шаардлага хангасан агуулахын талаарх мэдээллийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас мэдээлэл хүссэн ч тодорхой мэдээлэл ирүүлээгүй нь уг агуулахын талаарх мэдээлэлтэй танилцах болон нээлттэй ил тод байдал хангалтгүй байгааг илтгэж байна.

3.5.1.2 Практикт нийцсэн байдал

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тухай зохицуулсан тус хуулийн 8 дугаар зүйл болон 9 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч буй эсэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлно.

Хууль зүйн үндэсний хүрээлэнд Эрүүл мэндийн яамны 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 5/5573 тоот албан бичгээр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үйлдвэрлэл, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 он хүртэл Эрүүл мэндийн яамнаас олгож байсан бөгөөд, 2021 оны 1 дүгээр сараас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар байгуулагдсантай холбоотойгоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу тус газраас тусгай зөвшөөрлийг олгож байна. Монгол Улсын эм хангамжийн салбар нь бүрэн хувийн хэвшлийнх бөгөөд 2023 оны байдлаар 3 эмийн үйлдвэр Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэж, 8 эм ханган нийлүүлэх байгууллага импортолж хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг эмчилгээ оношилгоонд нэн шаардлагатай мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр ханган ажиллаж байна. Мөн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангийн тоо, байршлыг тогтоож, иргэдэд эмчилгээний зорилгоор хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг улсын стандартын шаардлага хангасан жороор, тусгай хяналттайгаар улсын хэмжээнд 377 эмийн сан мансууруулах эмээр үйлчилж байна» гэсэн мэдээллийг ирүүлсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 01/2133 тоот албан бичгээр “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор байгуулагдан, 2021 оноос үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн. Монгол улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий “Монос Фарм” ХХК, “Айвико” ХХК гэсэн 2 эмийн үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд зөвхөн импортын түүхий эд ашиглан үйлдвэрлэдэг. Одоогоор тарималжуулсан түүхий эд ашиглан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл аваагүй байна.” гэх мэдээллийг тус тус ирүүлсэн.

Тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ний өдрөөс өмнө Эрүүл мэндийн яам болон бусад байгууллага руу явуулдаг. Мөн Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан байгууллагууд нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зарцуулалтын тайланг Эрүүл мэндийн яаманд улирал бүр ирүүлж байгаа бөгөөд Эрүүл мэндийн яамнаас НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай, 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай, 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенциудад заасны дагуу

импортын тайланг улирал, жилээр дараа жилийн хэрэгцээг тусгай аргачлалын дагуу гарган заасан хугацаанд Австри улсын Вена хот дахь Мансууруулах эмийн хяналтын зөвлөлд хүргүүлж байна.

Мөн “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэгт заасны дагуу мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор бичсэн эмнэлэг нь эмийн жорын зарцуулалтын бүртгэлийг хийж, харьяа аймаг нийслэлийн эрүүл мэндийн газарт тайлагнадаг. Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн өвчтөний мэдээллийг дээрх газрууд, харьяа эмнэлгүүдээс авах боломжтой” гэсэн мэдээллийг тус тус ирүүлсэн. Уг тайлангаар тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаас илэрсэн зөрчил болон алдааг хэрхэн шийдвэрлэдэг болон ямар хариуцлага тооцдог эсэх талаар дурдаагүй ба уг тайлан нь нийтэд ил тод бус байгаа нь нээлттэй ил тод байдлын хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байдлыг бий болгож байна.

Түүнчлэн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь тусгай зөвшөөрөл авахыг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хадгалах шаардлага, тусгай нөхцөлийг хангасан агуулахын талаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу дүгнэлт гаргах эрх бүхий субъект юм. Уг шаардлага, тусгай нөхцөлийг хангах агуулахын талаар тодорхой стандартын талаар Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмаар тодорхой заагаагүй байна. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хадгалах агуулахын талаарх холбогдох мэдээлэл нь нээлттэй бус тул хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэж байна.

МЭСНБЭХТХ-ийн 9.1-д “Тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө гарган эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллага болон энэ хуулийн 14.6-д заасан Үндэсний хороонд тус тус ирүүлнэ.” гэж тусгасан. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 5.5-д “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилж буй эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллага нь холбогдох бүртгэлийг үнэн зөв хөтөлж, тайланг хугацаанд нь гаргана.”, “Нийтийн үйлчилгээтэй эмийн сан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын, зарцуулалтын болон устгалын бүртгэл, улирлын тайлан; Эмнэлгийн эмийн сан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын, устгалын болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын бүртгэл; Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын болон устгалын бүртгэл, улирлын тайланг тус тус гүйцэтгэж хуульд заасан хугацааны дотор хүргүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн нийтийн үйлчилгээтэй эмийн сангууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайланг хагас жилээр гарган 7 дугаар сарын 10 болон дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлэх бөгөөд эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн тайланг нэгтгэн Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хариуцсан нэгжид ажлын

10 хоногт багтаан хүргүүлнэ. Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр нь дараах тайланг гаргаж ирүүлдэг. Үүнд дараах мэдээллийг хамааруулдаг.³⁸

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн дараа оны хэрэгцээг өмнөх жилийн татан авалт, тухайн жилийн захиалга зэргийг тооцон гаргаж, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх; Импортолсон, үйлдвэрлэсэн болон экспортолсон эм, эмийн түүхий эдийн тайланг улирал болон жилээр гарган улирал бүрийн эхний сарын 05-ны дотор Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт ирүүлэх; Импортолсон, үйлдвэрлэсэн болон экспортолсон эмийн зарцуулалтын тайланг хуульд заасны дагуу жил бүр гаргаж дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах, сэтгэц нөлөөт эм, бодис хариуцсан нэгжид хүргүүлнэ гэх зэргээр тус тус тайлагнадаг.

Түүнчлэн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай” 1961 оны Нэгдсэн Конвенц, “Сэтгэц нөлөөт бодисын тухай” 1971 оны Конвенц, “Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” 1988 оны Конвенцод нэгдэн орсон Талын үүргийн хүрээнд холбогдох тайланг хугацаанд нь Олон улсын мансууруулах бодисын хяналтын зөвлөлд хүргүүлдэг.³⁹

Гэвч энэхүү зохицуулалтын хүрээнд Эрүүл мэндийн яам руу уг тайлангийн талаарх мэдээллийг албан бичгийн дагуу хүссэн боловч тодорхой хариулт өгөөгүй ба Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас мэдээлэл авах боломжтой гэж дурдсан. МЭСНБЭХТХ-аар жил бүр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь тайлан хүлээн авах эрх бүхий субъект биш байтал ийнхүү хариуг өгсөн нь тухайн зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхэд хүндрэл учруулж байна.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 2.6-д “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лицензийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан дэд дарга гарын үсэг зурна. Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргыг эзгүйд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга гарын үсэг зурна.” гэж тус тус заасан ба Эрүүл мэндийн яамны бодлогын хэрэгжилтийн газар гэж тодотгох байсны “яамны” гэх үгийг орхигдуулсан байна. Түүнчлэн уг зохицуулалтаас харахад Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан дэд дарга болон Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга нар аль аль нь гарын үсэг зурах эсхүл аль нэг нь гарын үсгээ зурах нь тодорхой тусагдаагүй байна.

МЭСНБЭХТХ болон Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмаар тусгай шаардлага хангасан агуулахын талаарх мэдээлэл болон тавигдах шаардлага зэргийг тодорхой бусаар зохицуулсан байгаа нь сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна.

38 Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам 5.7.

39 Мөн тэнд, 5.8.

Түүнчлэн шаардлага хангасан агуулахын талаарх мэдээллийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас мэдээлэл хүссэн ч тодорхой мэдээлэл ирүүлээгүй нь уг агуулахын талаарх мэдээлэлтэй танилцах болон нээлттэй ил тод байдал хангалтгүй байгааг илтгэж байна. Иймд энэхүү зохицуулалтыг тодорхой зохицуулахаас гадна, ил тод байдлыг сайжруулах шаардлагатай байна.

Дээрхээс дүгнэхэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх байгууллагын худалдах тусгай зөвшөөрлийг олгох Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар олгож холбогдох хяналт шалгалтыг хийх эрх бүхий субъект бөгөөд уг үйл ажиллагаатай холбоотойгоор Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох байгууллага болон аж ахуй нэгжид тавигдах шаардлага зэргийг зохицуулж байна.

Мөн холбогдох жилийн эцсийн тайланг Эрүүл мэндийн яам руу тус тайлантай холбоотой мэдээллийг албан бичгийн дагуу хүссэн боловч тодорхой хариулт өгөөгүй бөгөөд уг тайлан нь нийтэд нээлттэй ил тод бус байгаа нь мэдээлэлтэй танилцах цаашлаад хэрэгжилтэд хяналт тавих боломжгүй байдлыг үүсгэж байна. Эрүүл мэндийн яамнаас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 5/5573 дугаар албан бичигт 2023 оны байдлаар 3 эмийн үйлдвэр Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэдэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 01/2133 тоот албан бичгээр Монгол улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Монос Фарм ХХК, Айвико ХХК гэсэн 2 эмийн үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг гэсэн мэдээллийг тус тус илгээсэн. Энэ нь тусгай зөвшөөрөл бүхий эмийн үйлдвэрийн тоо зөрүүтэй байгаа нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон тайлан зэрэг нь зөрүүтэй байдлыг үүсгэх боломжтой байна.

3.5.2 мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг ашиглах, импортлох тусгай зөвшөөрөл

3.5.2.1 Зорилгод хүрсэн түвшин

МЭСНБЭХТХ-ийн 8.3-т “Энэ хуулийн 4.1-д заасан зорилгоор мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.14-т заасны дагуу олгоно.” гэж заасан.

Хүснэгт 1.3. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн жагсаалт

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1.14.химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нь тодорхойлсон байгууллагуудад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах зэрэг тусгай зөвшөөрлийг олгодог. Мөн уг үйл ажиллагаатай холбоотойгоор Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлд эрх

бүхий этгээдийн бүрэн эрхэд 1 дүгээр зүйлийн 1.1-д “энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах,” болон мөн хуулийн 1.2-т “зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих,” гэж тус тус заасан. Иймд Байгаль орчин аялал жуулчлалын яам нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах зэрэг тусгай зөвшөөрлийн хяналт шалгалт болон зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах эрх бүхий субъект юм.

Судалгааны хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам руу мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хяналттай холбогдуулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс албан бичиг явуулсан ч тус яам нь “Уг үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нь нууц учир мэдээлэл өгөх боломжгүй гэсэн хариу өгсөн.” Энэ нь төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох боломжийг хязгаарлахаас гадна судалгааны үр дүн бодитой гарах боломжгүй нөхцөл байдал үүсгэж байна.

3.5.2.2 Практикт нийцсэн байдал

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нь тодорхойлсон байгууллагуудад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах зэрэг тусгай зөвшөөрлийг олгодог. Үүнтэй холбоотойгоор мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хяналттай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам руу судалгааны хүрээнд албан бичиг явуулсан ч тус яам нь уг үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нь нууц учир мэдээлэл өгөх боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн. Энэ нь төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох, нээлттэй ил тод байдлыг алдагдуулж байна.

Тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө эрүүл мэндийн яам болон бусад байгууллага руу явуулдаг. Мөн Эрүүл мэндийн яамнаас “Тусгай зөвшөөрөл авсан байгууллагууд нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зарцуулалтын тайланг Эрүүл мэндийн яаманд улирал бүр ирүүлж байгаа бөгөөд Эрүүл мэндийн яамнаас НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай, 1971 оны Сэтгэцэд нөлөөт бодисын тухай, 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенциудад заасны дагуу импортын тайланг улирал, жилээр дараа жилийн хэрэгцээг тусгай аргачлалын дагуу гарган заасан хугацаанд Австри улсын Вена хот дахь Мансууруулах эмийн хяналтын зөвлөлд хүргүүлж байна. Мөн Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэгт заасны дагуу мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор бичсэн эмнэлэг нь эмийн жорын зарцуулалтын бүртгэлийг хийж, харьяа аймаг нийслэлийн эрүүл мэндийн газарт тайлагнадаг. Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн өвчтөний мэдээллийг дээрх газрууд, харьяа эмнэлгүүдээс авах боломжтой” гэсэн мэдээллийг тус тус ирүүлсэн. Уг тайлангаар тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаас илэрсэн зөрчил болон алдааг хэрхэн шийдвэрлэдэг болон ямар хариуцлага тооцдог эсэх талаар дурдаагүй ба уг тайлан нь нийтэд ил тод бус байгаа нь нээлттэй ил тод байдлын хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байдал үүсэж байна.

Түүнчлэн Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Эрүүл мэндийн яамнаас мэдээлэл хүсэхэд тухайн мэдээлэл нь байхгүй эсвэл нууц учраас өгөхгүй байгаа нь судалгааг бодит үр дүнтэй хийхэд саад болж байна. Иймд тус байгууллагуудад тухайн зохицуулалттай холбоотой хяналт-шинжилгээ хийж нөхцөл байдлыг илүү нарийвчлан судлах шаардлагатай.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нь тодорхойлсон байгууллагуудад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах зэрэг тусгай зөвшөөрлийг олгодог бөгөөд энэ талаарх мэдээлэл нь нууцын түвшинд байгаа боломжит мэдээлэлтэй танилцах боломжгүй байна.

3.6. Мансуурах донтой этгээдийг эмчлэх (12 дугаар зүйл)

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан зохицуулалтыг зорилгод хүрсэн түвшин болон практикт нийцсэн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар авч үзлээ.

12 дугаар зүйл. Мансуурах донтой этгээдийг эмчлэх

12.1. Мансуурах донтой этгээд сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргавал ердийн журмаар эмчилнэ.

12.2. Мансуурах донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилнэ.

3.6.1. Зорилгод хүрсэн түвшин

12.1. Мансуурах донтой этгээд сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргавал ердийн журмаар эмчилнэ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 3 дугаар зүйлд “мансуурах дон” гэж мансууруулах төрлийн бодисоос хамааралтай сэтгэцийн өвчнийг ойлгодог. Тухайн этгээдийг мансуурах донтой өвчтэй гэдгийг ерөнхий мэргэжлийн болон сэтгэцийн эмгэг, наркологийн гурваас доошгүй эмч нарын бүрэлдэхүүнтэй комиссын дүгнэлтээр тогтоодог.⁴⁰ Согтуурах, мансуурах донтой хүнд эрүүл мэндийн дүгнэлт гаргах журмын 2.11-д “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв согтуурах, мансуурах донтой эсэхэд дүгнэлт гаргах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах ба дүгнэлттэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь мансуурах донтой этгээдэд дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий субъект юм. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 6.1-д “Согтуурах, мансуурах донтой нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсоны дараа тухайн хүн өөрөө сайн дурын үндсэн дээр энэ төрлийн эмчилгээнд хамрагдах хүсэлтээ цагдаагийн байгууллагад бичгээр гаргасан тохиолдолд хувийн байдлыг

40 Улсын дээд шүүхийн тогтоол, “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн зарим зүйл, заалтын тайлбар” Дугаар 15.

нь харгалзан албадан эмчилгээнд явуулахгүй байж болно” гэж, мөн журмын 6.2-т “Сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргасан хүн эмчилгээнд хамрагдаж байгаа тухай цагдаагийн байгууллагад мэдэгдэх бөгөөд эмчилгээний хугацаа дууссаны дараа эмнэлгийн тодорхойлолтыг цагдаагийн байгууллагад өгнө” гэж заасны дагуу мансуурах донтой нь тогтоогдсон бол өөрийн сайн дурын хүсэлтээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, наркологийн төв зэрэг эмнэлгүүдэд хандаж эмчлүүлдэг.

Улсын хэмжээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, нийслэлийн хэмжээнд Аддиктологийн төв, орон нутгийн хэмжээнд Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд мансуурах донтой хүнийг эмчлэх чиг үүрэгтэй ажиллаж байна.

Аддиктологийн төв нь нийслэлийн хүн амд сэтгэц, донтолтын төрөлжсөн нарийн мэргэшлийн тусламжийг үзүүлнэ. Хэвтэн эмчлүүлэх клиникүүд нийт 83 ортой. Донтолт судлалын клиник 26 ортой. Улсын хэмжээнд сэтгэцийн нийт 165 эмч байгаагаас аддиктологийн чиглэлээр 6-21 эмч ажиллаж байна. Үүнээс аддиктологийн төвд 9 их эмч, нийслэл, орон нутагт 13 их эмч ажиллаж байна. Аддиктологийн төв нь донтох эмгэгийн эмчилгээг дараах алхмуудын хүрээнд хийдэг. Үүнд:

1. Хордлого тайлах, биеийн ерөнхий байдлыг засах, шинж тэмдгийн эмчилгээ;
2. Сэтгэл засал эмчилгээ (Ганцаарчилсан, бүлгийн, 12 алхамт хөтөлбөр, танин мэдэхүйн зан үйлийн сэтгэл засал, хандлагаар анагаахуй);
3. Эм эмчилгээ;
4. Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ – Сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжин туслах бүлэг, амьдрах ухааны сургалт, сэтгэц нийгмийн сэргээн засах үйл ажиллагаа;
5. Сайн санаа, сайхан сэтгэл- 4С хөтөлбөр;

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв мансууруулах бодист донтсон эмчлүүлэгчдийг эмчлэх 34 хэвтэн эмчлүүлэх ор, 25 өдрийн эмчилгээний ор бүхий Донтох эмгэг судлалын клиниктэй бөгөөд 4 эмч, 2 сэтгэл зүйч, 2 нийгмийн ажилтан, 7 сувилагч, 9 туслах сувилагч нийт 24 ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг. Мөн Донтох эмгэг судлалын клиникийн дэргэд өөртөө туслах бүлэг үйл ажиллагаагаа явуулдаг.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон өвчтөнд эмчилгээ хийхдээ эмийн болон эмийн бус буюу сэтгэл засал болон бүлгийн эмчилгээ хийдэг. Эмийн эмчилгээнд хордлого тайлах, дуршил бууруулах, мансууруулах бодист харшил үүсгэх зэрэг эмийг ашигладаг бол эмийн бус аргад мэргэжлийн сэтгэл зүйчтэй харилцаж, зөвлөгөө өгөх, бүлгийн эмчилгээнд мансууруулах бодист донтсон бусад өвчтөнүүд өөр хоорондоо туршлагаа хуваалцаж, нийгмийн ажилтан, хамт олны оролцоотойгоор явагддаг.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон хүнийг эмчлэх мэргэжлийн эмч нарын хувьд СЭМҮТ-ийн Донтох эмгэг судлалын клиникийн эмч нар нь АШУҮИС-ийг хүний их эмчээр төгссөний дараа эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтарсан донтох эмгэг судлалын эмчийн мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагддаг. Мансуурах бодист донтсон хүнийг эмчлэх эмч нарыг бэлтгэх мэргэшүүлэх хөтөлбөр АШУҮИС-д байдаггүй, мөн бусад улс орон руу мэргэжил дээшлүүлэх, туршлага

солилцох сургалт, семинарт хамруулдаггүй⁴¹ зэрэг энэ төрлийн мэргэжлийн эмч нарыг бэлтгэх, чадавхжуулах ажил дутмаг байна.

Мөн СЭМҮТ-д Мансууруулах бодист донтсон хүн нь өөрийн хүсэлтээр сайн дураараа эмчид үзүүлэх нь бага гэж мэргэжилтнүүд үздэг. Тухайлбал, СЭМҮТ-ийн ахлах мэргэжилтэн К.Елена ярилцлагадаа “Мансууруулах бодис хэрэглэдэг хүн надад хандлаа гэхэд гэмт хэрэгтэй холбоотой учраас төрийн албан хаагчийн хувьд цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах ёстой. Гэтэл нөгөө талаас үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах ёстой. Тэр үед цагдаад мэдээлэхдээ “Энэ хүнд хэрэг үүсгэхгүй” гэсэн амлалт авдаг байсан. Өөрөөр хэлбэл, бидэнд хандсан хүнд ямар хүн мансууруулах бодис борлуулж байгаа, ямар хүмүүс нийлдэг гэх хүрээллийг нь судалдаг байсан. Ийм маягаар хар тамхины сүлжээ илрүүлж, дэвшилттэй ажиллаж байсан үе бий”⁴² гэж дурдсан байна. Үүнээс үзэхэд мансуурах бодист донтсон этгээд нь эмнэлэгт хандах нь эрсдэлтэй байдаг учраас сайн дураараа эмчлүүлэх нь бага байх магадлалтай байна.

Мансууруулах бодист донтсон эмчлүүлэгчдийг эмчлэх 34 хэвтэн эмчлүүлэх ор, 25 өдрийн эмчилгээний ор байдаг ба эмчлүүлэгсдийн хувьд харьцангуй бага эмчлүүлдэг учир хүртээмжтэй байдаг гэсэн мэдээлэл өгсөн. Энэ нь мансууруулах бодист донтсон этгээд маш бага эмчлүүлж байгааг харуулж байна.

СЭМҮТ-ийн Донтох эмгэг судлалын клиникийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч Б.Энхчимэг ярилцлагадаа “Донтолттой хүнд бол нэгээс найман сар цаашлаад хэдэн жилээр эмчилгээ хийх” шаардлагатай. Жил эмчилгээ хийгээд “сайхан болчихлоо” гээд гаргаад явуулсан хүнээ орхихгүй байх хэрэгтэй. Тэр хүний ажлын байр, нийгмийн асуудал гэх мэт хувь хүнийг тойрсон хэрэгцээг уялдуулж өгөхгүй бол бүрэн эдгээж авна гэдэг хэцүү. Жишээ нь, нэг хүн эмчилгээнд орсны дараа эрүүл амьдралд дасан зохицох явц, бодис хэрэглэдэг найз нөхдийн хамаарал, татахыг хүсэх мэдрэмжээ захирахад бэрхшээлтэй хэвээр байдаг. Тиймээс тэр хүнийг байнгын мэргэжлийн эмч дагаж, зөвлөж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эмчилгээгээ үр дүн байлгахын тулд нэг хүнийг маш удаан хугацаанд дагах, зөвлөх шаардлагатай болдог. Тэгэхээр энэ бол асар их хөдөлмөр, цогц уялдаатай систем байх ёстой. Үүгээрээ донтолт гэдэг нь гүнзгийрээд явдаг учраас дан ганц эрүүл мэндийн ажилтан, цагдаагийн байгууллагын хийдэг ажил биш. Бүхий л системээ уялдуулах ёстой”⁴³ гэх зөвлөмжийг өгсөн байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон хүмүүс нь зөвхөн эмнэлэгт эмчлэгдэхээс гадна гэр бүл, найз нөхөд, ажлын байр зэрэг бусад нийгмийн харилцаан дээр анхаарч цогц эмчилгээг хэрэгжүүлэх нь давтан ирж эмчлүүлэгсдийн тоог багасгах боломжтой байна.

41 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Донтох эмгэг судлалын клиникийн холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс, 2023.12.28.

42 К.Елена. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ахлах мэргэжилтэн “Донтох эмгэгтэй нэг хүн уушгины хатгалгаатай 60 хүнтэй тэнцдэг” ярилцлага, <https://gogo.mn/r/42jem>, Сүүлд үзсэн огноо: 2024.01.30.

43 Б.Энхчимэг СЭМҮТ-ийн Донтох эмгэг судлалын клиникийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч “Хар тамхины хамааралтай хүн АВТОБУСАНД Ч зүгээр явж чадахгүй” ярилцлага, https://news.zindaa.mn/3941?fbclid=IwAR3jhav5rDYDpdJ-YcHpyUoxJlpySyiH_InDJV4Ug8do-oxze162gB90Q4A Сүүлд үзсэн огноо: 2024.01.30.

12.2.Мансуурах донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилнэ.

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулиар (Цаашид “СМДХЗЖАЭтХ” гэх) согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна.

Согтуурч, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүнийг албадан эмчлүүлэх тухай хүсэлтийг өрхийн болон сумын эмч, эсхүл сэтгэц, наркологийн эмч; сум, хорооны нийгмийн ажилтан; аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага; гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүн болон цагдаагийн байгууллагын алба хаагч нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бичгээр гаргана.

Мөн тус хуульд зааснаар албадан эмчлүүлэх хүсэлт гаргах эрх бүхий этгээдийн хүсэлтийг харгалзан холбогдох материалыг бүрдүүлж шүүхэд өгөх бөгөөд шүүх тухайн этгээдийг албадан эмчилгээ хийлгэх болон дуусгавар болгох шийдвэрийг гаргана. Албадан эмчлэх эмнэлэг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяалалд ажиллана. Мөн албадан эмчлэх эмнэлэг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байх ба түүнийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэрийг Засгийн газар гаргана гэж тус тус заасан.

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх газар нь Төв аймгийн Баян сумд байрлах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Төмөр замын Мааньт өртөөн дэх “Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар” юм. Гэвч тус газарт одоогийн байдлаар мансуурах донтой этгээдийг албадан эмчилсэн тохиолдол бүртгэгдээгүй зөвхөн архины хамааралтай хүмүүст албадан эмчилгээ хийж байна.⁴⁴

Мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх эмнэлэг байдаг ч эмчлүүлэх өвчтөн байдаггүй байна. Энэ талаарх асуудлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэргэжилтний ярилцлагад: “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэхдээ шүүхийн шийдвэрийн дагуу хэрэгжүүлдэг учир одоогийн байдлаар мансууруулах донтой этгээдийг албадан эмчлэх шүүхийн шийдвэр гарсан тохиолдол байхгүй буюу мансууруулах донтой этгээдийг албадан эмчилсэн тохиолдол бүртгэгдээгүй гэж дурдсан. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх шүүхийн шийдвэр байдаггүй нь мансууруулах бодист холбогдсон этгээдийг шууд эрүүгийн хуулиар хорих ял оноож байгаатай холбоотой...”⁴⁵ гэлээ.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих ял эдлүүлэх албаны эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан хэлтсийн холбогдох мэргэжилтэнтэй

44 Төв аймгийн Баян сумын “Согтуурах мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын” холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс, 2023.12.15.

45 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс, 2023.12.15.

хийсэн ярилцлагаар "...Хорих ангид ял эдэлж байхдаа мансууруулах бодист донтсон этгээд эмчлэгдсэн тохиолдол байхгүй учир нь шүүхийн шийдвэр гарах хугацаанд мансууруулах бодисыг хэрэглээд дууссан байдаг болохоор эмчлүүлэх тохиолдол бүртгэгдээгүй. Харин цагдан хоригдох явцад хэд хэдэн тохиолдол илэрч СЭМҮТ-рүү эмчлүүлэхээр явуулж байсан..."⁴⁶ гэх мэдээллийг өгсөн.

Дээрх ярилцлагуудаас үзвэл, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулиар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт харьяалагдана гэж заасан ч бодит байдал дээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон этгээд албадан эмчлүүлсэн тохиолдол Согтуурах мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт бүртгэгдэж байгаагүй байна. Өөрөөр хэлбэл, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх шүүхийн шийдвэр гарсан тохиолдол байхгүй байгаа нь мансууруулах бодистой холбогдсон гэм буруутай этгээд нь шууд хорих ял авч байгаатай холбоотой байна. "Согтуурах мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар" нь зөвхөн архины хамааралтай согтуурах донтой өвчтөнд албадан эмчилгээ хийж байна. Тиймээс СМДХЗЖАЭТХ-ийн 11 дүгээр зүйлд заасан зохицуулалт нь практикт хэрэгжихгүй байгаагаас Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12.2-т "Мансуурах донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилнэ" гэсэн зохицуулалт мөн практикт хэрэгжихгүй, зорилгодоо нийцэхгүй байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон этгээдийн эмчилгээний талаарх бусад улсын туршлагаас авч үзвэл:

Япон улсын Эрүүл мэнд, нийгэм хамгааллын сайдын тушаалаар эмийн үйлдвэрлэлийг лицензтэй болгож 1951 онд батлагдсан Сэргээх төрлийн бодистой эм бэлдмэлүүдийг хянах тухай хуулиар худалдан борлуулах, хууль бусаар хэрэглэхийг бүрэн хориглосон юм. Энэ хууль батлагдсаны дараагаар мансууруулах бодис хэрэглэж баривчлагдсан хүний тоо эрс нэмэгдэж 1954 онд 55000-д хүрч байлаа. Энэ нь мансууруулах бодисын хамааралтай хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэж хорих ялаар шийтгэх болсонтой шууд холбоотой гэж үздэг. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнийг эрхийг хязгаарлах бодлого нь үр дүнгүй болох нь нотлогдож тэдгээрийг эмчилгээ, үйлчилгээнд хамруулж эдгэрүүлэх арга замыг эрэлхийлэхэд хүргэсэн юм. Ингээд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус борлуулалтад тавих хяналтыг сайжруулах, нэгэнт донтох өвчтэй болсон хүнийг эмчлэх бие, сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах бодлогыг төрөөс баримталж эхэлсэн.

Хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх 5 жилийн төлөвлөгөөг 1998, 2003, 2008, 2013 онуудад Засгийн газраас батлан гаргаж хэрэгжүүлсэн бөгөөд Ерөнхий сайдаар ахлуулсан Хар тамхитай тэмцэх зөвлөл ажиллаж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний төрлийг судалсан байдлыг авч үзвэл:

46 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих ял эдлүүлэх албаны эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан хэлтсийн ахлах мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс 2023.12.15.

82 хувь нь метамфетамин

11 хувь каннабис

3 хувь нь хорт бодис (цавуу, газ үнэртэх)

2 хувь нь сэтгэцэд нөлөөт эм

1 хувь нь опиод төрлийн бодис хэрэглэж байгаа гэсэн үр дүн гарчээ.

Донтох эмгэгтэй хүмүүст үзүүлэх нийгэм сэтгэл зүйн тусламж үйлчилгээг 1975 онд Токио хотод 12 алхамд тулгуурласан архины хамааралтай хүмүүсийн АА-гийн (alcoholics anonymous) эдгэрлийн хөтөлбөр нэвтэрч эхэлсэн нь мансууруулах бодисын хамааралтай хүнийг эдгэрүүлэх NA (narcotics anonymous) оюун санааны эмчилгээний хөтөлбөр эхлэх суурь бааз болж өгсөн. Ингээд 1980 оноос хар тамхичдын өөртөө туслах бүлгийн эдгэрлийн хөтөлбөрүүд Япон улсын бүс нутгуудад үүсгэх байгуулагдаж эхэлсэн түүхтэй.

1985 онд Япон улсын иргэн Цунио Кондо болон АНУ-ын Фр.Роу нарын хүмүүс хар тамхинд донтогчдыг нийгэмшүүлэх төвийн Токио хотод үүсгэн байгуулсан байна. Энэ төв нь мансууруулах бодисын хамааралтай хүмүүсийг 6 сарын хугацаатайгаар байрлуулан оюун санаа, зан төрхийг өөрчлөх эмчилгээг явуулж эхэлсэн юм. Хорих ялаар шийтгэгдсэн мансууруулах бодисын хамааралтай хүмүүст зарцуулах 1 жилийн төсөв 30 мянган долларт хүрч ямар ч үр дүнгүй болох нь тогтоогдсон тул төр, засгаас нийгмийн халамжид суурилсан донтох эмгэгийн сэргээх үйл ажиллагааг илүүтэй дэмжиж эхэлсэн.

Засгийн газраас 2019 онд донтох эмгэгийн нөхөн сэргээх төвөөр үйлчлүүлсэн хүмүүсийн эмчилгээний үр дүнг тодорхойлох судалгааг 2 жилийн хугацаанд явуулсан байна. Донтох эмгэгийн 46 төвөөр үйлчлүүлсэн 695 хүнийг судалгаанд хамруулжээ. 6 сар тутам эдгэрэлтийн үйл явцыг тодорхойлсон байна.

Эхний 6 сарын хугацаанд 5.3 хувь дахилт өгсөн бол дараагийн 6 сарын хугацаанд 5.8 хувь дахилт өгч, 3 дахь 6 сарын хугацаанд 4.0 хувь, сүүлчийн 6 сарын хугацаанд 4.5 хувь нь мансууруулах бодис дахин хэрэглэж дахилт өгсөн гэсэн үр дүн гарчээ. 24 сар буюу 2 жилийн дараа нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээнд хамрагдсан хүмүүсийн 80 хувь нь эдгэрэлтийн түвшинд орсон дүн гарсан байна.⁴⁷

Мансууруулах донтолтоос урьдчилан сэргийлэх төвийн тогтолцоо, бодлогод үзүүлэх нөлөө:

- 1985 онд DARC хар тамхинд донтох эмгэгийн нөхөн сэргээх төв байгуулагдсан.
- 1994 онд Мансууруулах бодисын донтолтыг сэргээх төвийг Халамжийн газар гэж хүлээн зөвшөөрсөн.
- 1999 онд Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй гэж бодисын хэрэглээний эмгэгийг ангилсан.
- 2006 онд Мансууруулах донтолтоос урьдчилан сэргийлэх төвийн ажилтнууд хар тамхитай холбогдсон гэмт хэрэгтнүүдийг дахин хэрэглэхээс урьдчилан сэргийлэх хөтөлбөртэй хамтран ажилладаг.
- 2013 Хорих ялын тухай хуулийг хэсэгчлэн түдгэлзүүлсэн. Хар тамхинд донтох өвчтэй хүмүүсийг эрүүлжүүлэх төвтэй хамтран ажиллаж байна.

47 Такехито Ичикава, Ёокояма Жуничи “Мансууруулах бодисын хэрэглээтэй тэмцэж ирсэн япон улсын түүх, төрөөс баримталж байсан бодлого”

Донтох эмгэгийн нөхөн сэргээх төвийн үйлчилгээ нь орон байраар хангах, сэтгэц заслын эмчилгээ үйлчилгээнд хамруулах, амьдрах ухааны зөв дадалд сургах, хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх зэргээс бүрддэг. Донтох эмгэгийн нөхөн сэргээх төвүүд нь улсын төсвөөс санхүүжүүлэх хэлбэрээр явагдаж байна.

Хар тамхины нийлүүлэх бодлогоор хууль бусаар хил нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх, хууль бус наймаа хийдэг байгууллагуудын устгах зэрэг нь хамаардаг. Хар тамхины эрэлтийн бодлогод урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хар тамхи хэрэглэгчдийг баривчлах, эмчилгээ болон нөхөн сэргээх зэрэг нь тус тус багтдаг. Мөн донтолттой хоригдол нь донтолтын эсрэг ямар ч эмчилгээ хийлгэлгүй хоригдох нь олон удаа шоронд хоригдох нөхцөлийг үүсгэдэг. Энэ нь хорих ангийн ачааллыг улам ихэсгэдэг гэж үзсэн.

Хуулийн нэмэлт өөрчлөлт- Хорих ялыг хэсэгчлэн түдгэлзүүлэх

Өмнө нь хорих ангид бүх цагийг өнгөрөөдөг байсан бол одоо үед Хорих ялын зарим хэсгийг түдгэлзүүлэх, Туршилтаар танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ болон хар тамхины шалгалт хийх, Өөртөө туслах бүлгүүдийг холбох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Туршилтын журмаар байгаа хүмүүс нь тогтмол байранд амьдрах ёстой. Туршилтын ажилтнуудтай ярилцлага хийнэ. Орон гэргүй хүмүүсийн хувьд хувийн хэвшлийн байгуулсан нөхөн сэргээх сувилал ор, хоолоор хангадаг.

Одоогийн байдлаар япон улс донтогчдыг эмчлэхдээ сэдэл өгөх, ярилцлага хийх, танин мэдэхүйн-зан үйлийн эмчилгээнд суурилсан эмчилгээний хөтөлбөрүүд зэрэгт суурилсан сэтгэл зүйн эмчилгээ нь туслах үүрэг гүйцэтгэдэг.

Танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ нь тодорхой зан үйл /донтолт/-д төвлөрч, танин мэдэхүйн үйл ажиллагаан дээр төвлөрч уг зан үйлийг өөрчлөх зорилготой. Энэ аргыг одоо олон төрөлжсөн эмнэлгийн байгууллага Сэтгэцийн эрүүл мэндийн төв, нөхөн сэргээх эмчилгээнд ганцаарчилсан болон бүлгийн эмчилгээ болгон санал болгож байна.

Шийтгэлийн арга хэмжээ нь донтогчдод бага нөлөө үзүүлдэг тул эмнэлгийн тусламж, халамжийн дэмжлэггүйгээр дахин хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд хэцүү байдаг. 2008 оны бодлого нь олон улсын хар тамхины стратегитай тэнцвэртэй байхыг харуулсан. Хамгийн нэн тэргүүний зорилт бол анхан шатны урьдчилан сэргийлэлтийг хэвээр байлгаж уг түвшинд хар тамхинаас хамааралтай хүмүүсийг эмчлэх, нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн гэр бүлд үзүүлэх дэмжлэгийн нэмэгдүүлэх замаар дахин хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд анхаарах талаар асуудал болгон тавьсан. Мөн мансууруулах донтолтын нөхөн сэргээх төвүүд болон мансууруулах бодист хамааралтай донтогчид хамтран хэрэгжүүлсэн. Хар тамхины хэрэгт холбогдсон этгээдүүдийг бодлогоор шийтгэх бус эмчлэх болсон. Зөвхөн гэмт хэрэгт хөдөлмөр эрхлүүлэх журмаар шийтгэх бол донтох өвчинд боловсрол олгох журмаар хар тамхины хэрэглээний дахилтаас урьдчилан сэргийлэх арга замыг хэрэгжүүлж байна.

Хорьж нийгмээс тусгаарлах нь дараах ач холбогдолтой байдаг. Үүнд:

- ✓ Нөхөн сэргээх боломж өгөх
- ✓ Донтогчдод донтолтынхоо талаар ойлголт өгөх
- ✓ Танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ
- ✓ Нөхөн сэргээх үлгэр дуурайлал өгөх
- ✓ Нийгмийн нөөцтэй холбогдох /эмнэлэг зэрэг/ гэсэн тус тус үүргийг хэрэгжүүлдэг.

Мөн 12 нэгж хичээлийн хөтөлбөртэй. Үүнийг 3 хэсэгт хувааж авч үзвэл:

- Донтолтыг ойлгох, дахилтаас урьдчилан сэргийлэх танин мэдэхүйн зан үйлийн ойлголт
- Мансууруулах бодисын донтолтыг нөхөн сэргээх хөтөлбөрийн хүрээнд бүлгийн ажил ганцаарчилсан ярилцлага хийх
- Мансууруулах бодисын хамааралтай нөхөн сэргээгдсэн этгээдээс өөртөө туслах бүлгийн хүрээнд сэтгэгдлийн сонсох зэрэг нь багтсан байдаг.

Австрали Улс нь мансууруулах эм болон согтууруулах ундаанд донтохыг гэмт хэрэг бус нэг төрлийн өвчин гэдэг үүднээс нь 1990-ээд оноос эхлэн хандаж ирсэн ба хор хохирлыг багасгах (harm reduction principle) зарчимд тулгуурлан донтох өвчнөөр өвлөгчдийг албадан эмчлэх аргаар донтой өвчинтэй тэмцдэг. Австрали улсын Шинэ Өмнөд Уэльсийн Хар тамхи болон согтууруулах ундаанд донтох өвчнөөр өвчлөгчдийг эмчлэх тухай хуулийн (Drug and Alcohol Treatment Act 2007) гол онцлог нь донтох өвчнөөр өвчлөгчдийг богино хугацаанд халамжлан эмчлэх, эрүүл мэндийг нь нөхөн сэргээн хорыг гадагшлуулах түүнчлэн урт хугацаанд тодорхой төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээх эмчилгээг үргэлжлүүлэхэд дэмжин ажиллах зорилготой. Үүний зэрэгцээ Донтогчдыг эмчлэх хөтөлбөрийг тодорхойлон тусгасан. Өөрөөр хэлбэл, уг хуулийн зорилго нь донтох өвчнөөр өвчлөгчдийн эрх, ашгийг хамгаалан тэдний саналаар болон албадан журмаар байж болох хамгийн сайн эмчилгээг хамгийн дарамт багатай байдлаар үзүүлэн улмаар тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилготой. Тус улсад донтогчдын асуудлыг дагнасан шүүхээр шийдвэрлэж байна. Уэльсийн Анагаахын шүүхийн тухай хуулийн (Drug Court Act 1988) дагуу анагаах шүүхүүд бий болсон ба уг хуулийн зорилго нь бодист донтогчдыг багасгах, тэднийг эмчлэн нийгэмшүүлэх мөн донтох өвчнөөр өвчилсний улмаас тэд гэмт хэрэг үйлдэж болзошгүй осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх явдал юм.⁴⁸ Уг шүүх нь донтогч гэмт хэрэгтнийг шоронд хорих бус харин албадан эмчилж нийгэмшүүлэх зорилготой байна.

Шведийн Эрүүл мэндийн нийгмийн хамгааллын яамнаас тодорхойлсон холбогдох стратегийн дагуу дараах цогц гурван хөтөлбөрийн хүрээнд эм болон, согтууруулах ундаанд донтох өвчинтэй тэмцдэг байна. Үүнд; урьдчилан сэргийлэх, эмчлэх болон нийлүүлэлтийг хязгаарлах хамраана. Шведийн Нийгмийн халамжийн тухай хуульд (Social Welfare Act 1980) донтогч өвчнөөр өвчлөгч нь уг өвчнөөс ангижрахад шаардлагатай тусламж, халамжийг хүртэх ёстой талаар тусгасан. Донтох өвчнөөр өвчлөгч насанд хүрэгчдэд зориулсан “Хар тамхи болон согтууруулах ундаанд донтогчдын халамжлах тухай” (Care of Alcohol and Drug Abusers Special

48 Art 3, Drug Court Act 1988.

Provisions Act) болон “Эм болон согтууруулах ундаанд донтогч Хүүхдийг халамжлах тухай” (Care of Young Special Provisions act) тусгайлсан албадан эмчлэх хуультай. Албадан журмаар эмчлэх нь харьцангуй бага байдаг нь донтох өвчнөөр өвчилсөн этгээдтэй маш сайн хэлэлцэн сайн дураар эмчилгээнд хамрагдахыг ухуулдагтай холбоотой гэж тооцогддог. Эм болон согтууруулах ундаанд донтогчдыг халамжлах тухай хууль нь хувь хүний онцлог, хэрэгцээнд тохирсон эмчилгээг үзүүлэхийг зорьсон. Швед улсад донтох өвчинтэй тэмцэхэд гүйцэтгэх нийгмийн ажилтнуудын үүрэг маш чухал. Тодруулбал; тэд донтох өвчтэй хүмүүсийг олж илрүүлэх, хоргүйжүүлэх, эмчилгээний төвүүдтэй холбох, эмчилгээний олж дараах сувилгаа болон донтох өвчнөөр өвчлөгсдийг дахин нийгэмшүүлэх үйл ажиллагаанд тус тус тодорхой үүрэг гүйцэтгэж ерөнхийлөн холбох үүргийг эмчилгээний бүхий л үе шатанд (care chain) гүйцэтгэдэг. Энэ нь тухайн улсын нийгмийн халамжийн үйлчилгээ сайн үзүүлдэг бодлоготой холбоотой. Эмчилгээний үе шат гэдэг нь маш чухал ойлголт ба энэ нь донтох өвчний хүрээнд хяналт тогтооход мөн донтох өвчинтэй тэмцэхэд маш чухал ойлголт болж өгдөг. Үндсэндээ нийгмийн ажилтан нь цагдаагийн байгууллага, эмчилгээний газар мөн донтогчийн ойр дотнын хүмүүстэй холбоотой ажилладаг. Үндэсний эмчилгээний зөвлөл нь эмчилгээний төвүүдийг төрөлжүүлсэн нь донтогч өвчнөөр өвчилсөн хүн бүрд харьцангуй тохирох шаардлагатай нөхцөл байдлыг бүрдүүлэхэд ач холбогдолтой болсон байна. Зарим эмчилгээний төвүүд нь зөрчил гаргадаг, гэмт хэрэгт холбогдох донтох өвчтөнүүдийг хариуцан ажилладаг, зарим нь донтолт нь тархийг гэмтээсэн, ходоодыг нь шархлуулсан зэрэг суурь болон донтолтоос шалтгаалсан өвчтэй болсон донтогчдыг, зарим нь тусгай анхаарал халамж шаардлагатай донтогч нарыг эмчлэн зэргээр төрөлжсөн байна. Швед улсын хууль нь албадан эмчлэх талаарх хууль ч хуулийн нэрээс эхлээд өвчтөнийг халамжлах асуудлыг гол болгосон ба ийм учраас ч эмчилгээний арга барил нь уян хатан, хувь хүний хүсэл эрмэлзэл болон чадвар дээр суурилсан байх ёстой гэдэг байр сууринаас ханддаг байна.⁴⁹

Манай улсын хувьд мансуурах донтой этгээдийг албадан эмчилсэн тохиолдол байхгүй нь тухайн хүнийг эмчлэх бус цээрлүүлэх ёстой гэсэн зарчмын хүрээнд хэрэгжиж байгааг илтгэж байна. Энэ нь донтох өвчтэй этгээдүүдэд буцаж нийгэмших боломжийг олгоход хүндрэл үүсгэж байна.

Мансууруулах бодист донтсон этгээд нь сайн дурын үндсэн дээр эмнэлэгт хандах нь эрүүгийн гэмт хэрэгт холбогдох боломжтой учир өөрийн хүсэлтээр эмнэлэгт эмчлүүлэхээс татгалзах боломжтой байна. Өөрөөр хэлбэл сайн дураараа эмнэлэгт очиж эмчлүүлдэг хүмүүс байгаа ч нөгөө талаас цагдаад бүртгүүлэхгүйн тулд эмчлүүлэхгүй түүнээс их хүмүүс байх боломжтой байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12.2-т хуулиар албадан эмчлэх тухай асуудлыг зохицуулсан боловч бодит байдал дээр хэрэгжих нөхцөл үүсэхгүй байгаа нь манай улсын хувьд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон этгээдийг албадан эмчлэх бус шууд ял оногдуулах бодлогын хүрээнд уг зохицуулалт хэрэгжиж байгаагийн илрэл юм. Япон улсын хувьд мансууруулах бодист донтсон өвчтөний эмчилгээ нь үр дүн сайтай өндөр үзүүлэлттэй байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүний эрхийг хязгаарлах бодлого нь үр дүнгүй болох нь нотлогдож тэдгээрийг эмчилгээ, үйлчилгээнд хамруулж эдгэрүүлэх арга замыг эрэлхийлэхэд хүргэсэн юм. Хорих ялаар шийтгэгдсэн мансууруулах бодисын хамааралтай хүмүүст зарцуулах 1 жилийн төсөв 30 мянган долларт

49 <https://nli.gov.mn/pdf/dontoh.pdf>

хүрч ямар ч үр дүнгүй болох нь тогтоогдсон тул төр, засгаас нийгмийн халамжид суурилсан донтох эмгэгийн сэргээх үйл ажиллагааг илүүтэй дэмжиж эхэлсэн. Энэ хүрээнд олон сэргээн засах төвүүд байгуулагдаж эмчлэгдсэн өвчтөнүүдэд судалгааны үр дүнд 2 жилийн дараа бүрэн эдгэрсэн эерэг үр дүн үзүүлсэн байна. Мөн донтолттой хоригдол нь донтолтын эсрэг ямар ч эмчилгээ хийлгэлгүй хоригдох нь олон удаа шоронд хоригдох нөхцөлийг үүсгэдэг. Энэ нь шоронгийн ачааллыг улам ихэсгэдэг гэж үзсэн. Хуулийн шинэчлэлтийн дагуу өмнө нь шоронд бүх цагийг өнгөрөөдөг байсан бол одоо хорих ялын зарим хэсгийг түдгэлзүүлэх болсон. Энэ нь туршилтаар танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ болон хар тамхины шалгалт хийх, өөртөө туслах бүлгүүдийг холбох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Бусад улс, орнуудын жишигт мансуурах өвчтэй этгээдэд захиргааны журмаар албадан эмчлэгдэх байдал давамгайл байгаа нь эхлээд өвчтөнийг халамжлах асуудлыг чухалчилсан байдагт оршино. Ийм ч учраас эмчилгээний арга барил нь уян хатан, хувь хүний хүсэл эрмэлзэл суурилах болон донтох өвчнөөр өвчлөгчдийн эрх, ашгийг хамгаалан тэдний саналаар болон албадан журмаар байж болох хамгийн сайн эмчилгээг хамгийн дарамт багатай байдлаар үзүүлэн улмаар тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалдаг.

Энэ хуулийн зорилтод мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж заасан бөгөөд дээрх байдлаар ердийн журмаар сайн дураараа эмчлүүлэх этгээдийн хувьд эмчлэгдэх боломж хязгаарлагдмал мөн албадан эмчлэгдэх боломж байхгүй байгаа нь тус хуулийн зорилтод нийцэхгүй байна.

3.6.2. Практикт нийцсэн байдал

Манай улсын хувьд донтсон хүнд үзүүлэх эмчилгээний тогтсон стандарт байхгүйтэй холбогдуулан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон этгээдэд үзүүлэх сайн дурын болон албадан эмчилгээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, эмчилгээний стандарт бий болгох ажлын хүрээнд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант донтох эмгэгийн оношилгоо, эмчилгээний стандарт болон опиодод донтох эмгэгийн диаморфины орлуулах эмчилгээний тусгайлсан стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд дараах стандартуудыг боловсруулан баталжээ. Үүнд:


- MNS 5396-3:2018: Опиодын хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ F11;
- MNS 5396-4:2018: Каннабинойдын хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ F12;
- MNS 5396-5:2018: Тайвшруулах болон нойрсуулах бодисын хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ F13;
- MNS 5396-6:2018: Кокайны хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ F14;
- MNS 5396-7:2018: Дэгдэмтгий, ууршигтай бодисын хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ F18;

- MNS 5396-8:2018: Сэргээгч эм бодисын хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ F15;
- MNS 5396-9:2018: Хий үзэгдэл үүсгэгч бодисын хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ F18;
- MNS 5396-10:2018: Олон төрлийн сэтгэц идэвхт бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ F19;
- Опиод ба опиодын уламжлалууд (диаморфины)-ын орлуулах эмчилгээ стандартууд багтаж байна.

Дэлхий дахинд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс үүдэлтэй эмгэгийн үеийн сэтгэл зүйн тусгайлсан стандарт байдаггүй буюу сэтгэл заслын хөтөлбөрүүд дотор багтаж явдаг. Харин Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс үүдэлтэй эмгэгийн үед үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ Миннесота эмчилгээний хөтөлбөрт багтсан байдаг. Иймд 2021 оноос эрүүл мэндийн бүх төрлийн тусламж үйлчилгээг олон улсын Uptodate хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх болсон ба уг хөтөлбөрт сэтгэл зүйн тусламжийн асуудал багтсан байдаг тул стандарт боловсруулах шаардлагагүй болжээ. Мансуурах донтой буюу байнга мансууруулах төрлийн бодисыг хэрэглэдэг этгээд олон улсын ангиллын системийн ICD-10 V(F1)-д хамаардаг бол сонирхон хэрэглэдэг хараахан донтоогүй байгаа этгээдүүд нь сэтгэцийн тулгамдсан асуудалтайд тооцогддог байна.


СЭМҮТ-ийн тоон мэдээллээр дээрх эмчилгээний төрлүүдийн тоон үзүүлэлтийг 2012 оноос хойш дараах байдлаар тодорхойлжээ.

График 1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг




2012-2023 онд жилд дунджаар хар тамхины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй (Хар тамхины бүх төрлийн бодисын хамааралтай сэтгэцийн болон зан төрхийн эмгэг) 23 хүн буюу нийт 272 хүн эмчилгээ хийлгэсэн байна.

График 1.3. Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан төлөвийн эмгэг




2012-2023 онд жилд дунджаар F12: Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй (Каннабисын гаралтай тарьж ургуулсан бүх төрлийн хар тамхи) 15 хүн буюу нийт 179 хүн эмчилгээ хийлгэсэн байна. 2012 оны байдлаар энэхүү эмчилгээнд 1 хүн хамрагдаж байсан бол 2023 онд 22 хүн болж өссөн үзүүлэлттэй байна.

График 1.4. Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг




2012-2023 онд жилд дунджаар F13: Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй (Тайвшруулах, нойрны эмийн найрлагад хар тамхи, мансууруулах бүх төрлийн бодис орсон эм) 15 хүн буюу нийт 184 хүн эмчилгээ хийлгэсэн байна.

График 1.5. Дээдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэг



2012-2023 онд жилд дунджаар F18: Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэгтэй (Мансууруулах бүх төрлийн шатдаг хий буюу газ зэрэг хамаарна) 10 хүн буюу нийт 114 хүн эмчилгээ хийлгэсэн байна. 2012 онд энэхүү эмчилгээнд 2 хүн хамрагдаж байсан бол 2023 онд 12 болж өссөн үзүүлэлттэй байна.

График 1.6. Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан төрхийн эмгэг



2012-2023 онд жилд дунджаар F19: Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй (Хар тамхи, мансууруулах төрлийн бодисыг хамтад нь буюу бусад төрлүүдийг хамт хэрэглэсэн тохиолдол) 24 хүн буюу нийт 283 хүн эмчилгээ хийлгэсэн байна. 2012 онд энэхүү эмчилгээнд 3 хүн хамрагдаж байсан бол 2023 онд 72 болж огцом өссөн үзүүлэлттэй байна.

СЭМҮТ-өөс ирүүлсэн тоон мэдээллээр 2019 онд 6 хүн, 2020 онд 3 хүн, 2021 онд 2 хүн, 2022 онд 10 хүн, 2023 онд 9 хүн тус тус давтан хэвтэн эмчлүүлсэн.

Харин СЭМҮТ-д амбулаториар болон хэвтэн эмчлүүлсэн (стационар) мансууруулах бодист донтсон хүмүүсийн нас, хүйсийг судлан үзэхэд:

Хүснэгт 1.4. Нас, хүйс (Хар тамхины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг)

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Нас										
15-19 нас	2	0	0	3	2	0	0	3	2	1
20-24 нас	1	1	1	3	3	1	3	6	8	0
25-29 нас	2	1	1	3	5	2	6	11	6	0
30-34 нас	1	8	4	0	1	3	4	3	4	4
35-39 нас	4	8	6	3	7	5	2	4	0	4
40-44 нас	1	1	2	2	5	5	3	1	0	0
45-49 нас	0	0	1	0	2	4	4	2	2	2
50-54 нас	4	7	5	3	3	1	3	5	3	0
55-59 нас	1	2	1	0	0	1	1	1	4	0
60-аас дээш	0	0	1	2	1	2	1	3	5	2
Хүйс										
Эрэгтэй	8	22	10	11	23	15	15	18	11	5

Эмэгтэй	8	6	12	8	6	9	12	21	23	8
Нийт	16	28	22	19	29	24	27	39	34	13

2014-2023 онд F11: Хар тамхины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй нийт 251 хүн эмчилгээ хийлгэснээс дийлэнх нь 20-39 насныхан байна. 2023 онд 11 хүн хэвтэн эмчлүүлснээс насны хувьд хамгийн бага нь 15-19 настай байна.

Хүйсийн хувьд 138 эрэгтэй, 113 эмэгтэй хүн эмчилгээ хийлгэсэн байна. 2021 оноос хойш СЭМҮТ-д амбулаториор болон хэвтэн эмчлүүлсэн хар тамхины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй хүмүүсийн 50-аас дээш хувь нь эмэгтэй хүн байна.

Хүснэгт 1.5. Насны байдал (Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг)

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Нас										
15-19 нас	2	2	2	6	3	2	9	0	2	1
20-24 нас	6	7	2	11	12	11	6	13	8	12
25-29 нас	1	1	6	3	2	1	3	5	3	9
30-34 нас	0	1	1	2	2	4	0	2	5	0
35-39 нас	0	0	0	0	1	0	2	1	0	0
40-44 нас	0	0	0	0	0	0	0	2	0	0
Хүйс										
Эрэгтэй	9	9	10	18	18	15	17	20	18	19
Эмэгтэй	0	2	1	4	2	3	3	3	0	3
Нийт	9	11	11	22	20	18	20	23	18	22

2014-2023 онд F12: Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй нийт 174 хүн эмчилгээ хийлгэснээс дийлэнх нь 20-34 насныхан байна. 2023 онд 22 хүн хэвтэн эмчлүүлснээс 20-24 насны хүн 12 буюу 54.5 хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд эрэгтэй хүн 153 буюу 87.9 хувийг, эмэгтэй хүн 21 буюу 12.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1.6. Насны байдал (Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг)

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Нас										
1-4 нас	0	0	0	0	0	0	0	0	2	1
5-9 нас	0	0	0	0	2	0	4	6	3	1
10-14 нас	0	0	0	0	0	0	2	0	0	0
15-19 нас	0	0	0	1	1	0	1	1	6	0
20-24 нас	1	2	2	1	0	0	1	1	2	6
25-29 нас	0	0	1	1	2	1	0	0	1	0
30-34 нас	1	0	0	2	0	0	0	0	0	0
35-39 нас	0	0	0	0	0	1	0	1	0	0
40-44 нас	6	1	0	1	0	0	0	0	0	0
45-49 нас	3	0	0	0	2	0	0	1	0	0

50-54 нас	1	2	0	3	1	2	2	0	0	0
55-59 нас	8	0	1	0	0	0	0	0	3	2
60-64 нас	1	0	4	1	3	2	1	1	0	0
65-69 нас	6	0	2	0	0	0	1	0	3	3
70-аас дээш	4	0	2	3	0	3	4	0	2	1
Хүйс										
Эрэгтэй	4	3	4	4	4	7	6	7	8	9
Эмэгтэй	27	2	8	9	7	2	10	4	14	5
Нийт	31	5	12	13	11	9	16	11	22	14

2014-2023 онд F13: Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй нийт 144 хүн эмчилгээ хийлгэсэн байна. Хүйсийн хувьд эрэгтэй хүн 56 буюу 38.9 хувийг, эмэгтэй хүн 88 буюу 61.1 хувийг эзэлж байна. 2023 онд хэвтэн эмчлүүлсэн 9 хүнээс 5 буюу 55.6 хувь нь 20-24 насныхан байна.

Хүснэгт 1.7. Насны байдал (Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэг)

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Нас									
5-9 нас	0	0	0	0	0	0	0	0	0
10-14 нас	0	1	1	0	8	0	2	0	2
15-19 нас	0	0	3	11	15	8	5	8	9
20-24 нас	0	0	0	0	0	1	4	7	8
25-29 нас	0	0	0	0	1	0	0	0	0
40-44 нас	0	1	0	0	0	0	0	0	0
45-аас дээш	0	0	1	1	0	0	2	0	0
Хүйс									
Эрэгтэй	0	2	5	12	17	8	11	12	18
Эмэгтэй	0	0	0	0	7	1	2	3	1
Нийт	0	2	5	12	24	9	13	15	19

2014-2023 онд F18: Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэгтэй нийт 111 хүн эмчлүүлснээс 15-24 насныхан дийлэнх хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд эрэгтэй хүн 97 буюу 87.4 хувийг, эмэгтэй хүн буюу 12.6 хувийг тус тус эзэлж байна.

2023 онд 5-9 насны 1 хүүхэд энэхүү эмгэгээр оношлогдон хэвтэн эмчлүүлсэн байна. Түүнчлэн, өсвөр насныхан буюу ерөнхий боловсролын сурагчид газ үнэрлэж мансуурах тохиолдол их байна.

Хүснэгт 1.8. Насны байдал (Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан төрхийн эмгэг)


Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Нас										
10-14 нас	0	0	0	0	0	0	0	1	6	0
15-19 нас	2	3	0	5	7	6	0	4	22	19

20-24 нас	1	0	5	7	7	5	8	5	24	26
25-29 нас	3	4	0	1	5	6	1	0	11	12
30-34 нас	3	1	3	3	3	5	3	2	2	7
35-39 нас	0	2	0	2	1	3	2	0	0	2
40-44 нас	0	1	0	0	1	1	0	1	4	6
45-49 нас	0	2	0	0	0	0	2	0	0	0
50-аас дээш	2	1	0	2	0	0	0	0	0	0
Хүйс										
Эрэгтэй	7	9	6	15	19	22	10	9	45	42
Эмэгтэй	4	5	2	5	5	4	6	4	24	30
Нийт	11	14	8	20	24	26	16	13	69	72

2014-2023 онд F19:Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй 273 хүн эмчилгээ хийлгэснээс дийлэнх нь 15-29 насныхан байна. Энэ нь оюутан, залуучуудын мансууруулах төрлийн олон бодисыг хамтад нь хэрэглэсэн тохиолдол их байгааг харуулж байна. Мөн насны бүлгийн хувьд 10-14 настай хүүхдүүд энэхүү эмгэгийн улмаас СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлсэн тохиолдол 2021 онд 1, 2022 онд 6 бүртгэгдсэн байна. Хүйсийн хувьд эрэгтэй хүн 184 буюу 67.4 хувийг, эмэгтэй 89 хүн буюу 32.6 хувийг тус тус эзэлж байна.

Дээрхээс дүгнэвэл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант донтох эмгэгийн оношилгоо, эмчилгээний стандарт болон опиодод донтох эмгэгийн диаморфины орлуулах эмчилгээний тусгайлсан стандартуудын хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс үүдэн эмчилгээ хийлгэж байгаа (хэвтэн эмчлүүлж байгаа) хүний тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байгаа нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нийгэмд нэмэгдэж байгааг харуулж байна.

График 1.7. Мансууруулах бодист донтсон хүн, нутаг дэвсгэрээр (2014-2023)



2014-2023 оны хооронд улсын хэмжээнд нийт 1526 хүн мансууруулах бодист донтож эмчилгээ хийлгэснээс Улаанбаатар хотод 1296 хүн, орон нутагт 230 хүн эмчилгээ хийлгэсэн байна. Улаанбаатар хотод эмчилгээ хийлгэсэн хүний тоо 2014 онд 107 байсан бол 2023 онд 276 болж 169 буюу 2.6 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 1.9. Мансууруулах бодист донтсон хүний боловсролын түвшин (2014-2023)

Боловсрол	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Боловсролгүй	1	0	2	3	3	3	5	1	0	0
Бага	25	19	31	39	36	33	22	28	59	5
Суурь боловсрол	2	5	6	5	3	1	4	1	10	18
Бүрэн дунд	15	20	8	20	23	22	11	16	38	85
Мэргэжлийн болон техникийн	0	0	2	2	1	1	3	0	8	12
Диплом	0	0	0	0	0	0	0	0	2	6
Бакалавр	0	0	0	0	0	0	0	3	5	17
Магистр	0	0	0	0	0	0	0	0	0	1
Нийт	43	44	49	69	66	60	45	49	122	144

СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлсэн (стационар) мансууруулах бодист донтсон хүний боловсролын түвшнийг судлан үзэхэд дийлэнх нь бага болон бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Тухайлбал, 2023 онд хэвтэн эмчлүүлсэн хүмүүсийн 85 нь бүрэн дунд боловсролтой байна.

Хүснэгт 1.10. Мансууруулах бодист донтсон хүний нийгмийн байдал

Нийгмийн байдал	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
0-15 насны хүүхэд	0	0	2	6	6	3	2	1	9	7
Ажилгүй	10	10	7	18	19	27	19	3	5	3
Ажилчин	9	7	7	4	3	3	4	21	42	57
Албан хаагч	0	5	4	10	6	9	2	3	3	9
Оюутан	7	5	4	7	6	4	2	10	10	20
Тэтгэвэрт	9	1	9	10	2	0	5	3	13	12
Малчин	0	2	0	0	1	0	1	0	1	1
Бусад	8	14	16	14	23	14	10	8	39	35
Нийт	43	44	49	69	66	60	45	49	122	144

Мансууруулах бодист донтон эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн дийлэнх нь ажилчин болон оюутнууд байна. Тухайлбал, 2023 онд хэвтэн эмчлүүлсэн 144 хүний 57 буюу 39.6 хувь нь ажилчин, 20 буюу 13.9 хувь нь оюутан байна.

Түүнчлэн, 2016-2023 онд 15 хүртэлх насны 36 хүүхэд бүртгэгдсэн байна. Энэ талаар СЭМҮТ-ийн Донтох эмгэг судлалын клиникийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч Б.Энхчимэг “Стрессээ тайлж сураагүй, гэр бүлийн эрүүл орчинд амьдраагүй, хайр энхрийлэлгүй орчинд өссөн хүүхэд аливаа зүйлд донтох нь элбэг байдаг. Үүнээс гадна тухайн хүүхдийг хамгаалах хүнгүй, эцэг, эхгүй гэдэг мэдрэмж нь ямар нэг донтолт үүсгэх магадлалыг нэмэгдүүлдэг.Өсвөр насныхан ямар нэг зүйлийг олон талаас нь харж чаддаггүй. Тиймээс ямар нөлөө авч байна түүндээ автах магадлал өндөр байдаг нь аюултай”⁵⁰ гэж дурдсан байна.

50 “Б.Энхчимэг: Хар тамхины хамааралтай хүн автобусанд ч зүгээр явж чадахгүй» <https://news.zindaa.mn/394> Сүүлд үзсэн огноо: 2024.01.21.

Дээрхээс дүгнэхэд СЭМҮТ-ийн донтох эмгэг судлалын клиникийн амбулаторийн буюу өдрөөр эмчлүүлсэн болон хэвтэж эмчлүүлсэн мансууруулах бодист донтсон этгээдийн өвчлөл нь сүүлийн жилүүдэд харьцангуй өссөн үзүүлэлттэй байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эмчилгээний стандартын F19: Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан төрхийн эмгэгт хамгийн их буюу 273 тохиолдол бүртгэгдсэн байгаа нь мансууруулах бодист донтсон хүн нэг төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх бус бусад төрлүүдийг хамтад нь хэрэглэх тохиолдол нэмэгдэж байгааг харуулж байна. Мөн эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн зонхилох хувийг 20-29 насныхан эзэлж байна. Эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн боловсролын байдлын хувьд бага болон бүрэн дунд боловсролтой, нийгмийн байдлын хувьд ажилчин, оюутнууд дийлэнх хувийг эзэлж байна. Мөн СЭМҮТ-ийн мэдээллээр нийт 2019-2023 оны хооронд 30 хүн давтан эмчлүүлснээс сүүлийн хоёр жилд давтан эмчлүүлсэн хүний тоо өссөн үзүүлэлттэй байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон этгээдүүдэд эмчилгээ хийхэд эмийн болон эмийн бус буюу сэтгэл засал болон бүлгийн эмчилгээ хийгддэг бөгөөд эдгээр эмчилгээнүүдийг хийсэн ч гэр бүл найз нөхдийн хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг хүн байх нь эмчлүүлсэн өвчтөн буцаж хэрэглэх нөхцөл байдлыг үүсгэх хандлагатай учир энэ талаар цогц бодлогыг авч хэрэгжүүлэх, эмчилгээний чанарыг сайжруулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмэнд донтохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох үйл ажиллагаа, хариуцлага (13 дугаар зүйл, 16 дугаар зүйл)

13 дугаар зүйл. Хориглох зүйл

13.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хориглоно:

13.1.1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шуудангийн илгээмжээр явуулах;

13.1.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дуу, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хэвлэмэл зургийг нийтэд түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компьютерын сүлжээг ашиглан сурталчлах;

13.1.3. мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг жоргүйгээр болон хүчингүй жороор олгох, түүнчлэн жорд заасан тоо, хэмжээнээс илүү олгох;

13.1.4. эмчилгээнд хэрэглэх жагсаалтад орсноос бусад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх;

13.1.5. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг иргэн Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

13.1.6.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг иргэн эмчийн заавар, жоргүйгээр хэрэглэх;

13.1.7.тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгж хоёр талын гэрээнд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг төстэй өөр зүйлээр орлуулах болон зөвшөөрсөн тоо, хэмжээг хэтрүүлэн Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

13.1.8.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг тусгай зөвшөөрөлгүйгээр импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хадгалах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

13.1.9.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг насанд хүрээгүй хүнд худалдах, олгох;

13.1.10.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хүүхдийн бусад байгууллага байрладаг нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, хадгалах.

16 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3.7.1. Зорилгод хүрсэн түвшин ба Практикт нийцэж байгаа байдал

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох үйл ажиллагааг тус хуулийн 13 дугаар зүйлд заасан. Тус зүйлд заасан ихэнх үйл ажиллагааг өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд хуульчилсан байна. Иймд МЭСНБЭХТХ-ийн 13, 16 дугаар зүйлийн хэрэгжилтийг Эрүүгийн хуулийн 20.7, 20.8, 20.9, 20.10 дугаар зүйл болон Зөрчлийн тухай хуулийн 5.1, 6.4 дүгээр зүйлийн хамтаар үнэлэх нь тохиромжтой гэж үзлээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйл)

20.7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах

1.Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.байнга тогтвортой;

3.2.улсын хилээр нэвтрүүлж;

3.3.улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.


4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн 2009 оноос 2023 оны байдлаарх нөхцөл байдлыг энэ хэсэгт авч үзье.

График 1.8. Бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн тоо



2009 оноос 2023 оны хооронд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн тоон мэдээллийг харвал, 2013 оноос 2019 оны хооронд тус гэмт хэрэг тасралтгүй өссөн үзүүлэлттэй байх ба 2009 оныг 2023 онтой харьцуулбал тус гэмт хэргийн гаралт 23 дахин өссөн байна.

Ковид 19 цар тахлын үед буюу 2020, 2021 онд буурсан үзүүлэлттэй байх боловч 2022 оноос ахин өссөөр цар тахлын өмнөх хамгийн өндөр үзүүлэлт болох 2019 оны нөхцөл байдалтай адил хэмжээнд хүрэх төлөвтэй байна.

3.8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт (10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл)

10 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэг

10.1.Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэгтэй.

10.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ.

11 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа

11.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түүнчлэн эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл урлаг, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага сурталчилгаа явуулах үүрэгтэй.

11.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт тусгайлан тусгана.

11.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар Монгол Улсын хилээр нэвтрэх гаалийн мэдүүлэгт монгол, орос, хятад, англи хэл дээр хэвлэмлээр бичсэн байна.

11.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд агуулсан сав, баглаа боодлын шошго дээр түүний хор аюултайг анхааруулсан тусгай санамж бичиг байна.

11.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар эрх бүхий байгууллагаас бэлтгэж, хянасан сурталчилгааны материалыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өмчийн хэлбэр харгалзахгүй түгээх үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих

14.1.Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бүртгэл, хуваарилалт, үйлдвэрлэл, зарцуулалт, хадгалалт, худалдаа, хэрэглээ хуульд заасан журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

14.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолтод хяналт тавина.

14.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолт, ургамлын тархцад хяналт тавина.

14.4.Гаалийн болон хил хяналтын байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх явдлыг таслан зогсоох үүрэгтэй.

14.5.Цагдаа, тагнуул, хил хяналтын болон холбогдох бусад байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтийг таслан зогсоох, энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

14.6.Энэ хуулийн 14.1-14.5-т заасан байгууллагын авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зохисгүй хэрэглээг бууруулах, эргэлтэд хяналт тавих, эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүрэгтэй Үндэсний хороо ажиллах бөгөөд уул Үндэсний хороо орон тооны ажлын албатай байна.

14.7.Энэ хуулийн 14.6-д заасан Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтооно.

15 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлтэй хийх тэмцэлд дэмжлэг үзүүлэх

15.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагад зайлшгүй шаардагдах хөрөнгийг улсын төсвөөс гаргана.

15.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор амьтан сургах, хяналтын болон лабораторийн шинжилгээний техник хэрэгслээр хангахад төрөөс зохих дэмжлэг, хөнгөлөлт үзүүлнэ.

3.8.1. Зорилгод хүрсэн түвшин ба Практикт нийцэж байгаа байдал

Тус хуулийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой зохицуулалт хэрэгжих боломжтой эсэх, практикт хэрэгжүүлэхэд гарч буй эерэг, сөрөг үр дагавар болон тулгамдаж буй асуудлыг тодорхойлно.

3.8.1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар болон Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг зэрэг бусад төрийн болон төрийн бус байгууллагууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Гэвч энэ төрлийн асуудал эрхэлсэн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох байдал дутмаг байна.

Гаалийн ерөнхий газар нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хилээр нэвтрэх үеийн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэнэ. Мөн гаалийн байгууллагаас сэжигтэй бараа, бүтээгдэхүүнийг илрүүлэх хамгийн үр дүнтэй арга нь эрэлч нохой ашиглах гэсэн ч одоогоор яг энэ чиглэлээр мэргэшсэн амьтан гаршуулах байгууллага байхгүй бөгөөд үндэсний хөтөлбөрт нохойн сургалтын төв байгуулна

гэж заасан ч хэрэгжиж эхлээгүй байна. Цагдаа, дотоодын хэргийн сургалтын төвд таван нохойг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээдийг таних, илрүүлэх чиглэлээр 2016 оноос хойш бэлдэж байна.⁵¹ Гэвч энэ төрлийн бодисууд хурдан хувирч өөрчлөгддөг тул тус ажлыг эрчимжүүлэх, санхүүжилтийг тогтмол төлөвлөж байх шаардлагатай.

Хар тамхитай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газар уг асуудлаар тусгайлсан төсөв шаардлагатай байна гэж мэдэгдсэн юм. Хар тамхитай тэмцэх газраас мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулдаг.

Хар тамхитай тэмцэх газраас авч хэрэгжүүлдэг урьдчилан сэргийлэх ажиллагааны талаар Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн ажилтнаас дараах байдлаар тодруулга авав.

Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн ажилтан Б-тэй хийсэн ярилцлагаас:

- Хар тамхитай тэмцэх газраас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэг бүрчилсэн арга хэмжээ, тусгай арга хэмжээ, ерөнхий арга хэмжээ зохион байгуулж ажилладаг.

- Нэг бүрчилсэн арга хэмжээ гэдгийг жишээгээр тайлбарлавал сургуулийн сурагч хар тамхи хэрэглэсэн зөрчил үйлдсэн бол тухайн сургуульд албан мэдэгдлийг Хар тамхитай тэмцэх газраас хүргүүлнэ. Тус мэдэгдэлд тухайн хүүхдийн ар гэрт асуудлыг мэдэгдэх, тусгай хувийн хэрэг нээн хамтран ажиллах талаар тусгана. Мэдэгдэл хүргүүлснээс нэг сарын дотор сургуулийн захиргаанаас хариу мэдэгдэж, тухайн хүүхдэд чиглэсэн арга хэмжээний талаар богино тайлан илгээдэг. Гэхдээ энэ арга хэмжээ нь нийгмийн ажилтан болон багш ажилчдын мэдээлэл, чадвар дутмагаас хангалттай сайн үр дүнд хүрдэггүй. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, бусад журамд зааснаар дээрх арга хэмжээг авах шаардлагатай байдаг ч энэ нь хугацаа алдаж улмаар үр дүн муу байх тохиолдол их байна. Үүнийг манай байгууллагын зүгээс сургуулийн нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулах хэлбэрээр шийдэх боломжтой гэж үзэж байгаа.

- Сургалт, семинар зохион байгуулахад тараах материалаас эхлээд зардал гардаг боловч тус зардалд зарцуулах төсөв байдаггүй. Хууль зүй, дотоод хэргийн яам, дээд газруудад хүсэлт гаргадаг боловч үр дүнд хүрдэггүй. 2023 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын тусламжтай 21 аймаг тойрсон сургалт хийсэн. Уг нь энэ асуудалд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах газар, Эрүүл мэндийн яам зэрэг олон байгууллага хуульд заасан чиг үүргийн хувьд хамтран ажиллах ёстой. Боловсролын ерөнхий газарт сургуулийн хүүхдийн боловсролын хөтөлбөрт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар хөтөлбөрийг тусгайлан оруулж өгөх санал хүргүүлсэн боловч дорвитой арга хэмжээ аваагүй юм.

51 ГХУСА33-ын захиалгат үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа 2023, “Эс Ай Си Эй” ХХК

- Энэ төрлийн донтогч, хэрэглэгч нарт зориулсан эмчилгээний стандарт байдаггүй. СЭМҮТ-ийн өмнөх дарга нь хар тамхинд эмчилгээ байхгүй гэж хэлсэн бичлэг одоо надад ч байна. Манай улсын хувьд хар тамхинд донтогчид зориулсан 10 хоногийн хөтөлбөр бий. Гэтэл Швед улс 5-6 жилийн олон төрлийн чиглэл бүхий хөтөлбөртэй, харин ОХУ-д 6 сарын эмчилгээний хөтөлбөр байдаг. СЭМҮТ 30 ор бүхий донтогчдод зориулсан тасагтай боловч түүнд нь архинд донтсон хүмүүс хэвтчихдэг. Гэтэл архинд донтох, хар тамхинд донтох гэдэг өөр зүйл учир эдгээр хүмүүс олон шалтгааны улмаас хамтдаа хэвтэн эмчлүүлэх боломжгүй. Мөн СЭМҮТ-ийн санхүүжилт нь гүйцэтгэлээр санхүүждэг тул эмчилгээний үеийн төсөв муу байдаг.

- Бидний ажилд бас нэгэн хүндрэл байгаа нь хар тамхины хэрэгт холбогдсон олны танил хүмүүс, дуучид өөрсдийн олон нийтийн хэрэгслээр өөрийн хэрэглэсэн хар тамхины төрлийг өөр олон улсад цай, хоолонд хэрэглэдэг эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй мэтээр олон нийт тэр дундаа насанд хүрээгүй хүмүүст буруу ухуулга хийж байна. Тухайлбал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглээд баригдаж ирсэн хүүхдүүдээс тухайн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хаанаас, хэрхэн олж авсан, анх хэрэглэх болсон шалтгааныг тодруулахад миний сонсдог дуучин тэгсэн, тэр хүн аюулгүй, хэрэглэхэд өндөрт нисэж байгаа юм шиг мэдрэмж төрдөг хэрэглэж үзмээр санагдсан гэх мэтээр хариулдаг. Ийм учраас Харилцаа холбооны зохицуулах хороонд хүсэлт хүргүүлж тухайн олны танил хүмүүсийн хийсэн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхийг уриалсан, сурталчилсан агуулгатай контентыг устгаж, хориглож өгөхийг хүссэн боловч одоог хүртэл тэдгээр дуу, дүрс бүхий контентууд олон нийтийн сүлжээнд байсаар байна.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтийн хувьд эмийн санд тусгай журмаар худалддаг нийт 46 эмийн жагсаалтад хэвийн журмаар худалддаг өвчин намдаах, ханиад анагаах эм зэрэг олноор хэрэглэвэл мансуурах боломжтой эмүүдийг нэмэх тухай хүсэлтийг ЭМЯ-д хүргүүлсэн боловч ямар нэгэн арга хэмжээ аваагүй. Жишээ нь 2022 онд 8 хүүхэд өвчин намдаах төрлийн эмийг олныг нухаж, шингэнтэй холин судсандаа шахсанаар хялгасан судаснууд бөглөрч улмаар нас барсан. ЕБС-ын сурагчид, өсвөр насны хүүхдүүд цэвэр хар тамхи олж авах боломж хомс тул эмийн сангаас мансуурах боломжтой эмийн тусламжтай мансуурч улмаар амь насаараа хохирох аюултай. Иймд ЭМЯ-аас мансуурах боломжтой тодорхой эмийн төрлүүдийг тусгай журмаар худалдаалах эмийн жагсаалтад яаралтай багтаах хэрэгтэй байна.

- Мөн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ургадаг олсны төрлийн ургамлыг устгавал энэ төрлийн гэмт хэргийг 70 хувиар бууруулах боломжтой. Олсны ургамлыг устгах олон арга бий. Жишээ нь тайрч, өөр ургамал тарих, шатаах, хор цацах гэх мэт. Гэтэл энэ төрлийн ургамлыг шатааж устгаснаас хор цацаж устгах нь хамгийн үр дүнтэй болох нь Ботаникийн ургамал судлалын хүрээлэнгээс гаргасан судалгаагаар тогтоогдсон. Түүнчлэн, Төв аймагт хор цацаж олсны ургамал устгах туршилт хийх хүсэлт гаргасан боловч тухайн орон нутгийн удирдлагууд газар ашиглах зөвшөөрөл олгохгүй байгаа. Нөгөөтээгүүр, олсны ургамлыг хор цацаж устгахад 5 тэрбум орчим төгрөг шаардлагатай. Гэтэл энэ төрлийн ургамал ургадаг аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийт 125 сая төгрөг төсөвлөсөн байна.

- Мөн гадаад улсаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байх зорилгоор ажиллах Атташе (Дипломат ажилтан) шаардлагатай байна. БНХАУ хилээ хаасан цагаас Турк улсаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд орж ирэх тохиолдол ихэссэн. Одоогоор энэ 2 улсаас зэрэг орж ирэх болсон. Гэвч манайд атташе ажиллуулах төсөв мөн л байхгүй байна.

ГХУСА33-өөс бусад байгууллагуудтай хамтран Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой олон нийтэд зориулсан сурталчлан таниулах ажил хийгдэж байгаа ч тодорхой стандарт байхгүй, үр дүнгийн үнэлэлт хэмжилт хийгдэхгүй байгаа тул оновчтой байж чадахгүй байна. Энэ нь сурталчилгааг нийгмийн аль хэсэгт зориулах эсэх талаар судалгаа дутмаг мөн Монгол Улсад нөлөөллийн стандарт гэх зүйл дутагдсантай холбоотой байж болох юм. Жишээлбэл 2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд Олон улсын мансуурлын эсрэг тэмцэх өдрийн хүрээнд олон нийтэд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээний улмаас хүний бие, эд эрхтэнд учрах хор уршгийн талаар 3 зурагт хуудас, байгууллагын үйл ажиллагаа, бүтэц орон тоог сурталчилсан агуулгатай 13 зурагт хуудас, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон эцэг, эх, асран хамгаалагчид мэдээлэл хүргэх зорилготой 2 богино хэмжээний бичлэг бэлтгэж түгээсэн байна. Мөн энэхүү шалгуур үзүүлэлтэд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг 80 хувиас дээш хувиар дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл, бүтэн жилийн турш яг энэ төрлийн гэмт хэргийн эсрэг 3 зурагт хуудас, 2 богино хэмжээний бичлэг бэлтгэжээ.

Дээрх тайлангаас үзэхэд гэмт хэргийн эсрэг богино хэмжээний бичлэг, зурагт хуудас хийсэн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа биш бөгөөд тухайн сурталчилгааг хийж, тараасны дараах гэмт хэргийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэх нь тайлангийн гол зорилго нь байх ёстой харагдаж байна. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэснээр гарах өөрчлөлт, сөрөг нөлөө, эрүүл мэндэд учирч болох асуудал, донтох аюулын талаар сурталчилгаа бэлдэхдээ баримталдаг шинэ стандартыг ашиглавал сурталчилгааны үр дүнг хэмжин дараагийн сурталчилгаа, сургалтад юуг илүү анхаарах шаардлагатай талаар мэдээлэлтэй, туршлагатай болох боломжтой юм.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнийг жигших, шийтгэх, тухайн нөхцөл байдлаас гарах, аврагдах ямар ч боломжгүй талаар сурталчилгаа түлхүү явагдах нь далд хэрэглээ рүү хөтлөх, улам даамжруулж болзошгүй байдаг. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд зэрэгт донтсон бол эмчилгээ хийлгэж энгийн болох боломж байдаг, эдгэх боломжтой бид тусална гэдэг утгатай суртал, нөлөөллийн ажлууд хийх, хэрэглэсэн тохиолдолд хаана хандаж тусалцаа авч болох талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Мөн холбогдох төрийн, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг албаны хүмүүс онцолсон. Жишээлбэл нийгэмд нөлөөлөгч (Инфлюэнсер), кино, жүжиг зэрэг бусдад нөлөөлж болох энтертайнмент бүтээлүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис сурталчилсан, хэрэглэхийг уриалсан дүрс, агуулга байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, тэдгээрт хууль сахиулах байгууллага зохих арга хэмжээг авдаг байх шаардлагатай байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчдийг муу муухайгаар дүрслэх сурталчилгаа, эдгэрэх боломжгүй мэт мэдээлэл түгээснээр хэрэглэгчид

далд хэлбэрийн эргэлтийг илүү дэлгэрүүлэх боломжтой. Эдгээр нь нуугдсанаар тухайн төрлийн эм, бодисын хууль бус борлуулагч нарыг олох боломж багасна. Ингэснээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг илрүүлэлт, хууль бус эргэлтийг хянахад улам удааширч, илрүүлэх магадлал буурах юм.

Өөрөөр хэлбэл, иргэдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор нөлөөг тайлбарлан таниулах, хорт зуршлаас сэргийлэх мэдлэг олгох, сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн боловсрол олгох нь чухал болохоос мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн түүнд донтсон хүмүүсийг нийгмээс тусгаарлах, тэдгээрийг үзэн ядаж жигших сэтгэлгээг нийгэмд түгээх ёсгүй юм. Жишээ нь Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын албан ёсны цахим хаягт дараах уриалга бүхий зурагт хуудаснууд нийтлэгдсэн байна. Үүнд:

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэснээр шоронд, шороонд”
- “Хар тамхи бол үхлийн хавх”

Энэ нь нэг удаагийн тохиолдлоор хэрэглэсэн этгээдийг тухайн нөхцөл байдлаас гарах цаашид хэрэглэхгүй байх боломжгүй мэт ойлголтыг төрүүлж болзошгүй байна. Гэхдээ “Анзаар” аяны хүрээнд “хорт зуршлаа хойноо үлдээе” гэх зэрэг уриа үгтэй сайн жишээнүүд бий.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий албан хаагчдын нийгмийн баталгаа, аюулгүй байдал нь байгууллага тус бүрийн үндсэн чиг үүрэг, дотоод бүтэц, зохион байгуулалтаас хамаарч харилцан адилгүй байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн зарим байгууллагын албан хаагчдын цалин хангамж, нийгмийн баталгаа нь тэдний ажлын ачаалал, ажиллах нөхцөл байдал зэрэгтэй нийцэхгүй байна. Үүнээс болж гаалийн бүсэд ажилладаг хууль сахиулах байгууллагад ажлын байрны тогтворгүй байдал бий болж, энэ чиглэлээр мэргэших боловсон хүчний хомсдолтой байна гэж судалгаанд хамтрагдсан байгууллагын төлөөллүүд дурдсан. Тиймээс цаашид нарийвчилсан судалгааг холбогдох байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд хийж, шаардлагатай арга хэмжээг авч, анхаарч ажиллах нь чухал байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис төрлийн гэмт хэрэгт яллагдагчийн насыг өмнөх онтой харьцуулахад 13-17 насны яллагдагч 4 дахин өссөн, 18-25 насныхан 15 хувиар буурсан үзүүлэлттэй харагдаж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээтэй холбоотой хичээлийг 2019 оноос хойш ЕБС болон их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлээр дамжуулан оруулахаар тусгасан байна. Гэвч тухайн эрүүл мэндийн хичээлийг ямар мэргэжлийн эмч эсвэл сургагч багш нар орж байгаа эсэх талаар тухайлсан судалгаа байхгүй байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг шинжлэх лаборатори, тоног төхөөрөмж харьцангуй сайжирсан магадлан итгэмжлэгдсэн байгаа нь сайшаалтай ч сэжиг бүхий этгээдээс мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг илрүүлэх багаж хэрэгслээр (Анхан шатны) цагдаа, яаралтай түргэн тусламжийн эмч, хил хамгаалах, гаалийн байгууллагын алба хаагчдыг хангах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн хилийн боомтууд энэ төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан нь ололттой байгаа ч жижиг боомтуудыг тоног төхөөрөмжөөр хангах,

байгаа төхөөрөмжийг сайжруулах хэрэгтэй байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг илрүүлэх үйл ажиллагаа нь тоног төхөөрөмжийн хүчин чадал, мэргэжилтнүүдийн чадвараас шалтгаалдаг тул тэдгээрийг тогтмол шинэчлэлт, сайжруулалт хийдэг байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль бусаар хилээр оруулах, худалдаалах зэрэг үйл ажиллагаанууд байнга сайжирч, шинэчлэгдэж, шинэ аргуудыг хууль бус үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй тул хууль сахиулах байгууллагууд тэдгээрийг давсан шинэ технологи, үйл ажиллагааны шинэ арга, техник тогтмол хийх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дурдсанаар дунд сургуулийн сурагчдад боловсрол олгох “Хасах 25” хөтөлбөр жил бүр зохион байгуулагддаг. Мөн сургуулийн нийгмийн ажилтан, багш нарт энэ төрлийн сургалт давтамжтай ордог боловч ерөнхий боловсролын сургуулийн насны яллагдагчдын тоо өссөн үзүүлэлттэй харагдаж байгаа нь анхаарал татаж байна. Мөн Боловсролын байгууллагаас ирүүлсэн тайлангуудад сургалт зохион байгуулагдсан хэдэн хүн хамрагдсан гэдэг мэдээлэл байгаа боловч үр дүн, үр нөлөөний талаар хэмжигдэхүйц мэдээлэл дурдагдаагүй байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын найрлагад хийсэн шинжилгээнээс илэрсэн бодисын төрлөөс үзэхэд сүүлийн жилүүдэд “Метамфетамин” бодисын илрэлт багасаж эсрэгээрээ “ТНС” бодисын илрэлт нэмэгджээ. 2016 онд илэрсэн нийт бодисын 52.3 хувийг Метамфетамин бүрдүүлж байсан бол энэ үзүүлэлт 2020 онд 8.3 хувь болж буурсан. Харин ТНС бодисын хувьд 2016 онд илэрсэн нийт бодисын 38.5 хувийг бүрдүүлж байсан бол 2020 онд 48.6 болж өссөн байна. Энэ нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг шинжлэх лабораторийн техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирсан, хууль бусаар эргэлдэж буй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нэр төрөл олширч буйг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг илрүүлэх багаж, хэрэгсэл, техникийн шинэчлэлийн тусламжтай мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг нарийн шинжилж аль төрөлд хамаарах бодис гэдгийг илрүүлж байна. Энэ нь шинээр хар тамхи гарч ирсэн бус манай улс одоо л илрүүлж чаддаг болж байна гэж нэг талаас дүгнэж болох юм. Товчхондоо энэ төрлийн гэмт хэрэг илрүүлэлт нь өмнө жилүүдээс их байгаа нь технологийн шинэчлэл, хууль сахиулах байгууллагын ажилтны ур чадвар нэмэгдсэн явдал гэж үзэж болно.

Иймд энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудад тасралтгүй шинэчлэл, сайжруулалт хийх шаардлагатай. Мөн энэ төрлийн сургалтад хамрагдсан, туршлагатай мэргэжлийн боловсон хүчин тогтвортой байх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй юм.

Гэвч Хар тамхитай тэмцэх газарт урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах төсөв байдаггүй. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Цагдаагийн газартай хамтарсан аян зохион байгуулж 21 аймаг тойрсон хар тамхинаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах төсөв гаргуулан явсан. Үүнээс үзвэл Хар тамхитай тэмцэх газарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсөв батлагдахгүй байгаа нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлт, хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх талаар Монгол Улс бодлогын хүрээнд дэмжихгүй байгааг харуулж байна.

3.8.1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих

Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналттай холбоотой бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

14.1.Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бүртгэл, хуваарилалт, үйлдвэрлэл, зарцуулалт, хадгалалт, худалдаа, хэрэглээ хуульд заасан журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

А. Хяналтыг хэрэгжүүлэгч этгээд тодорхой эсэх (нарийвчлан зохицуулсан журмаар болон байгууллагын дотоод журмаар үүнийг тодорхой заасан эсэх МЭСНБЭХТХ-ийн 14.1 дүгээр зүйлд заасан “Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18.3 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт зааснаар Эрүүл мэндийн яам юм.

Б. Хяналтын хэлбэр тодорхой эсэх (хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхээр эрх зүйн актад зохицуулсан тухай) Монгол улсын эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” 68 дугаар тушаал⁵² нь Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 10.1, 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 15.12.4 дэх заалтууд, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зорилготой боловч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2022 оны 06 сарын 17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон тул “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” тушаалаар баталсан журмыг шинэчлэн батлах ёстой юм. Иймд хяналтын хэлбэр тодорхойгүй. Дээрх тушаалаар батлагдсан журмаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс байхгүй тул яаралтай шинэ журам батлах эсхүл тушаалын үндэслэл хэсэг дэх хуулийг солих шаардлагатай байна.

В. Зөрчилд авах арга хэмжээ тодорхой эсэх. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эмийн хадгалалт, хамгаалалтын журам зөрчих”-ийг хориглоно, 15.11 дүгээр зүйлд “энэ хуулийн 14.1, 14.2, 15.9 дэх хэсгийг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд импортын зөвшөөрлийг хүчингүй болгоно.”, 29 дүгээр зүйлд “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага”, 29.1 дүгээр зүйлд “энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, 29.2 дугаар зүйлд “энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тус тус заажээ. Зөрчилд авах арга хэмжээ нь тодорхойгүй байна.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналттай холбоотой бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

52 Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2015.02.24-ний өдрын “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” 68 дугаар тушаал, <https://legalinfo.mn/mn/detail/11090>

14.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолт, ургамлын тархцад хяналт тавина.

А. Хяналтыг хэрэгжүүлэгч этгээд тодорхой эсэх (Нарийвчлан зохицуулсан журмаар болон байгууллагын дотоод журмаар үүнийг тодорхой заасан эсэх) МЭСНБЭХТХ-ийн 14.3 дугаар зүйлд заасан “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам юм.

Б. Хяналтын хэлбэр тодорхой эсэх (Хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхээр эрх зүйн актад зохицуулсан тухай) Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолт, ургамлын тархцад тогтмол хяналт тавьдаг эсэх нь тодорхойгүй байна.

В. Зөрчилд авах арга хэмжээ тодорхойгүй байна.

Гаалийн болон хил хяналтын байгууллага

14.4.Гаалийн болон хил хяналтын байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх явдлыг таслан зогсоох үүрэгтэй.

А. Хяналтыг хэрэгжүүлэгч этгээд тодорхой эсэх (Нарийвчлан зохицуулсан журмаар болон байгууллагын дотоод журмаар үүнийг тодорхой заасан эсэх) МЭСНБЭХТХ-ын 14.4 дүгээр зүйлд заасан “Гаалийн болон хил хяналтын байгууллага” гэж Гаалийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гаалийн байгууллага, албан тушаалтан нь улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, гаалийн бүрдүүлэлт хийх...” гэж зааснаар Гаалийн ерөнхий газар хяналтыг хэрэгжүүлнэ.

Б. Хяналтын хэлбэр тодорхой эсэх (Хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхээр эрх зүйн актад зохицуулсан тухай) 2019 оны 12 сарын 04-ний өдөр Гаалийн ерөнхий газрын даргын журам батлах тухай А/275 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журмаар зохицуулсан.

В. Зөрчилд авах арга хэмжээ тодорхой эсэх. Хил, боомт дээр ажиллаж буй алба хаагч нарын мэдлэг, техник, технологийн хоцрогдол, хангалтгүй. Монгол Улсын хил, боомт дээр ажиллаж байгаа алба хаагчид мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж мэдэх, илрүүлэх талаар ойлголт, туршлага багатай, алба хаагчид ойр ойрхон солигддог, ажиллах хүч тогтвортой ажилладаггүй байдал, хүний нөөцийн дутагдал болон одоо ашиглаж байгаа “R-Scan”, Буянт-Ухаа дахь “DHL” олон улсын шуудан, илгээмжийн газарт ашиглаж буй “Fiscancmez-T100100” рентген төхөөрөмж нь цаг үеийн шаардлага хангахгүй байгаа нь гэмт этгээдүүдэд хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэх таатай боломжийг бий болгож байна.

Үндэсний хорооны хяналттай холбоотой бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

14.6.Энэ хуулийн 14.1-14.5-т заасан байгууллагын авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зохисгүй хэрэглээг бууруулах, эргэлтэд хяналт тавих, эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүрэгтэй Үндэсний хороо ажиллах бөгөөд уул Үндэсний хороо орон тооны ажлын албатай байна.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх. Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүн” баталжээ.⁵³

Эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлсэн эсэх. Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар “Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай”⁵⁴ тогтоол баталжээ.

Олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн эсэх. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үзэхэд олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

53 Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531434075371&showType=1>

54 Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар “Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530843645471>

ДӨРӨВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА (ЯЛЫН БОДЛОГО)

4.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт

А. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх гол эрх зүйн зохицуулалт

Мансууруулах эмийг худалдаалах тухай хууль (BtMG)

ХБНГУ-ын мансууруулах бодис, донтолттой тэмцэх бодлогын чиглэлээр үндэсний гол хууль тогтоомжид НҮБ-ын мансууруулах бодист хяналт тавих гурван конвенцын дагуу батлагдсан Мансууруулах эмийг худалдаалах тухай хууль⁵⁵ (BtMG) үүнийг даган гасан журмууд хамаардаг. Энэхүү хууль нь мансууруулах эмийн хууль ёсны худалдаа болон хууль бус үйлдлийг нэгдсэн байдлаар зохицуулдаг бөгөөд мансууруулах эмийг үйлдвэрлэх, тариалах, зах зээлд гаргах, худалдаалах, импортлох, экспортлох үйл ажиллагаа зэргийг хамардаг. Эдгээр үйл ажиллагаа нь Германы Холбооны Эм, эмнэлгийн хэрэгслийн хүрээлэн (Bundesinstitut für Arzneimittel und Medizinprodukte, BfArM)-ээс зөвшөөрөл авах шаардлагатай үйл ажиллагаанд тооцогддог (BtMG 3-р хэсэг).

Мансууруулах эмийг жороор олгох талаар Германы Мансууруулах эмийг жороор олгох журам (Betäubungsmittel-Verschreibungsverordnung, BtMVV)⁵⁶-д зохицуулсан байдаг бол мансууруулах бодисын дотоод, гадаад худалдааны (импорт, экспорт) талаар Мансууруулах бодисын дотоод худалдааны тухай журам (BtMBinnenhandelsverordnung, BtM-BinnenhandelsVO)⁵⁷ болон Мансууруулах бодисын гадаад худалдааны тухай журам (BtM -Außenhandelsverordnung, BtMAußenhandelsVO)⁵⁸-д илүү нарийвчлан тусгасан байна.

Германы шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль (NpSG)

Германы шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль (NpSG) нь 2016 оны 11-р сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэхүү хууль нь шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодис (NPS) түгээхтэй тэмцэх буюу тэдгээрийг хэрэглэх, хордуулах бодис болгон ашиглах боломжийг хязгаарлах зорилготой.

Уг хуульд захиргааны зөрчил болон эрүүгийн хуулиар хориглосон үйлдлүүдийг хооронд нь ялгамжтай зохицуулсан байдаг⁵⁹ ба NPS-тэй харьцах (худалдан авах, эзэмших гэх мэт) өргөн хүрээтэй захиргааны хуулийн хоригийг агуулж байгаа бөгөөд энэ нь NPS-ийг хураан авч, шаардлагатай бол устгах үндэслэлийг бүрдүүлдэг.

55 Act on the trade in narcotic drugs (BtMG) of 28 July 1981, which came into force on 1 January 1982, current version 1 Mar. 1994, German Federal Law Gazette I p. 681, 1187: http://www.gesetze-im-internet.de/btmg_1981/ Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

56 BtMVV: http://www.gesetze-im-internet.de/btmvv_1998/BJNR008000998.html Сүүлд үзсэн огноо: 2024.01.10.

57 BtM-BinnenhandelsVO: <https://www.gesetze-im-internet.de/btmbinhv/BJNR014250981.html> Сүүлд үзсэн огноо: 2024.01.05.

58 BtM-AußenhandelsVO: <https://www.gesetze-im-internet.de/btmahv/BJNR014200981.html> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

59 Klaus Weber, (2017) Kommentar, Einleitung zum NpSG, marg. no. 27.

Хуулийн эрүүгийн хэрэгт холбогдох заалтууд нь ялангуяа үйлдвэрлэгчид, дилерүүд/худалдагчид болон зах зээлд гаргаж буй хүмүүст чиглэсэн бөгөөд хэрэглэгчдэд чиглэгдээгүй байна.

Үүнээс гадна ХБНГУ-ын мансууруулах бодисын хууль бус эргэлтийн тогтолцоо нь Эрүүгийн хууль, Замын хөдөлгөөний тухай хууль, Урьтал бодист хяналт тавих тухай хууль зэргээр зохицуулагддаг.

Эрүүгийн хууль⁶⁰

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт эрүүгийн хууль, эрүүгийн процессын хуулийн ерөнхий заалтууд мөн хамаарна. Тухайлбал, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох (316 дугаар зүйл), мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх (323а дугаар зүйл) Донтолтын эсрэг эмчилгээг зөрчих (323б дүгээр зүйл), Цагдан хорих (64 дүгээр зүйл), жолоо барих эрхийг хасах (69 (2) дугаар зүйл) зэрэг хар тамхины хэрэглээ, түүний үр дагаврыг тусгайлан тусгасан хэд хэдэн заалтыг агуулдаг.

Замын хөдөлгөөний тухай хууль⁶¹

Уг хуулийн 24а (2)-т заасан зөрчил нь хэн нэгэн “мансууруулах бодис” хэрэглэж, дараа нь түүний нөлөөгөөр тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохыг хэлдэг. “Мансууруулах бодисууд”-ыг хуулийн 24а-д заасан жагсаалтад оруулсан. Зөрчлийн хувьд, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох тохиолдолд 3000 еврогийн торгууль ногдуулдаг (24а (4) StVG дуугар зүйл). Торгуулиас гадна жолоо барихыг хориглох нь ихэвчлэн давхар шийтгэл болон ногдуулдаг (25 (1) дүгээр зүйл StVG).

Урьтал бодист хяналт тавих тухай хууль

BtMG-тэй холбоотой өөр нэг хууль бол Германы Урьтал бодист хяналт тавих тухай хууль (Grundstoffüberwachungsgesetz, GÜG) юм. Урьтал бодист хяналт тавих хуулийн зорилго нь тодорхой химийн бүтээгдэхүүн, нэгдэл (прекурсор)-ийг хууль бусаар эргэлтэд оруулж, хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тэдгээрийн хууль ёсны худалдаанд хяналт тавихад оршино. Уг хууль нь хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэхэд урьтал бодисыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрүүгийн шийтгэл, торгуулийн тухай хэд хэдэн заалтыг хуулийн 19-20-р хэсэгт заасан бөгөөд эдгээр нь BtMG-ын эрүүгийн зүйл заалттай нягт уялдаатай байна.

Б. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал ба хуваарь

Мансууруулах эмийг худалдаалах тухай хууль (BtMG)-д мансууруулах эмийн хууль ёсны худалдаа болон хууль бус үйлдлийн нэгдсэн зохицуулалтыг багтаасан боловч “мансууруулах эм” гэсэн ерөнхий тодорхойлолтыг агуулаагүй байна. Харин хяналтад байх тодорхой бодисуудыг гурав ангилж, жагсаасан. Үүнд:

60 StGB: https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html Сүүлд үзсэн огноо: 2023.12.24.

61 StVG: https://www.gesetze-im-internet.de/englisch_stvg/englisch_stvg.html Сүүлд үзсэн огноо: 2023.12.24..

1. Худалдаалахыг хориглосон, жороор олгохгүй мансууруулах эм: I жагсаалт, жишээ нь: героин, LSD, каннабис, псилоцибин, MDMA (экстази);
2. Худалдаалах боломжтой боловч жороор олгох боломжгүй мансууруулах эм: II жагсаалт, жишээ нь: мепробамат, метамфетамин;
3. Худалдаалах болон жороор олгох боломжтой мансууруулах эм: III жагсаалт, жишээ нь: морфин, метадон, амфетамин, кодеин, дигидрокодеин, кокаин, каннабис (НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцод заасны дагуу тариалалт нь улсын хяналтад байдаг).

Мансууруулах эмийг худалдаалах тухай хууль нь тухайн бодисоос үүдэлтэй аюулын түвшингээр нь “хатуу” болон “зөөлөн” гэж ялгагдаггүй байна. Хэдий хуулийн дагуу ангилагдаагүй ч ял шийтгэл оногдуулахдаа героин, фентанил, кокаин, крек зэрэг “хатуу”, амфетамин зэрэг “дунд зэргийн”, каннабис гэх мэт “зөөлөн” мансууруулах эм зэргийг харгалзан үздэг.⁶²

I жагсаалтад орсон бодисуудын хувьд зөвхөн онцгой тохиолдолд шинжлэх ухааны зорилгоор эсвэл нийтийн ашиг сонирхолд нийцсэн бусад шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл олгоно. II ба III жагсаалтад орсон бодисууд, тэдгээрийн хэрэглээг хуульд мөн тусгайлан зохицуулсан байдаг.

Харин Германы шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль (NpSG) нь нь Мансууруулах эмийг худалдаалах тухай хууль шиг хуваарь гарган бодисуудыг тус тусад нь жагсаалгүй бодисыг бүлгээр нь хориглож, шинэлэг арга барилыг ашигласанд тооцогддог.

Өмнө нь шинээр гарч ирж буй бодисуудыг хянах эсвэл хориглохын тулд BtMG-ийн хуваарьт тус тусад нь нэмж оруулах шаардлагатай байв. Гэхдээ BtMG-ийн хуваарьт багтсан химийн бодисын найрлагад бага зэргийн өөрчлөлт ороход л шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын тоонд өөрчлөлт орж байсан ба хуульд өөрчлөлт оруулахын тулд харьцангуй урт хугацаа шаардагддаг тул эдгээр бодисыг BtMG-д цаг тухайд нь оруулах бараг боломжгүй байсан. Тиймээс хориг тавиагүй нь ялангуяа залуу хэрэглэгчдэд энэ бодис нь хор хөнөөлгүй гэсэн хуурамч сэтгэгдэл төрүүлж байсны зэрэгцээ BtMG-ын эрүүгийн заалтыг тойрч байсан байна. Иймээс Германы шинэ сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль нь эрүүгийн хариуцлагын цоорхой болоод байсан BtMG-ийн сул талыг нөхөж гарч ирсэн хууль юм.

Уг хуулиар дараах хоёр бодисын бүлгийг багтаасан. Үүнд:

- 2-фенетиламины гаралтай нэгдлүүд (жишээлбэл, амфетаминтай холбоотой бодисууд, түүний дотор катинон);
- каннабимиметик бодис/синтетик каннабиноид (жишээлбэл, каннабистай адил нөлөөт бодис).

Эхний бүлэгт фармакологийн нөлөө үзүүлдэг 2000 орчим бодисыг тодорхойлсон байдаг бөгөөд одоогоор мансууруулах зорилгоор урвуулан ашиглаж болно гэж үздэг.⁶³

62 BGH decision of 15 June 2016, NStZ 2016,614-615.

63 Explanatory memorandum: Bundesrat Printed Paper 231/16 of 6 May 2016, p.22, https://www.bundesrat.de/SharedDocs/drucksachen/2016/0201-0300/231-16.pdf?__blob=publicationFile&v=1 Сүүлд үзсэн огноо: 2023.12.24.

Сэтгэцэд нөлөөт зарим бодисыг зүй бусаар хэрэглэх, тэдгээрийн нөлөөллийн хэмжээнээс шалтгаалан 2019 онд NpSG-ийн хуваарийг дараах гурван бодисын бүлгээр өргөтгөсөн байна. Үүнд:

- Бензодиапезин;
- N-(2-аминоциклогексил)амидын гаралтай нэгдлүүд;
- Триптамины гаралтай нэгдлүүд зэрэг багтаж байна.

Харин эрүүл мэндэд онцгой хор хөнөөлтэй, багагүй хэмжээгээр хэтрүүлэн хэрэглэдэг бодисуудыг BtMG-ийн хуваарьт үргэлжлүүлэн оруулах боломжтой юм.

В. Хариуцлага

Мансууруулах эмийг худалдаалах тухай хууль (BtMG)-ийн 29-30 дугаар зүйлүүдэд эрүүгийн гэмт хэргийг, 32 дугаар зүйлд захиргааны зөрчлийг тус тус тусгасан байна. 29(1) дүгээр зүйлд мансууруулах эм тариалах, үйлдвэрлэх, худалдаалах, импортлох, экспортлох, дамжин өнгөрүүлэх, худалдах, нийлүүлэх, зах зээлд гаргах, олж авах, жороор олгох, шууд хэрэглэхэд бэлэн үлдээх, хангах, түүнчлэн ашгийн төлөө бус худалдах, мансууруулах эм хадгалах, сурталчлах, өөртөө болон өөр хүн, амьтанд мансууруулах эм, эмийн жор авахын тулд буруу, дутуу мэдээлэл өгсөн, мансууруулах бодисыг зөвшөөрөлгүйгээр олж авах, тараах боломжийг бусдад олгосон, энэ боломжийг олон нийтэд болон хувьдаа давуу байдал олох зорилгоор мэдээлэх, эсхүл зөвшөөрөлгүйгээр бусдыг хар тамхи, мансууруулах эм хэрэглэхэд өдөөсөн зэрэг үйлдлүүдэд 5 жил хүртэл хугацаагаар хорих ял, эсвэл хөрөнгө санхүүгийн шийтгэл оногдуулахаар заасан. Мансууруулах эм хэрэглэх нь өөрөө шийтгэгдэх гэмт хэрэг биш боловч хэрэглэхтэй холбоотой эзэмшилд байдаг тул хадгалах үйлдэлд тооцогддог. Энэ үндсэн зарчим нь бүх мансууруулах бодист адил хамаардаг байна.

Гэхдээ гэмт этгээд мансууруулах бодисыг “бага хэмжээгээр” тарьсан, үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, тээвэрлэсэн, олж авсан, өөрөөр олж авсан, хадгалсан тохиолдолд шүүх хуулийн 29(1), 29(2), 29(4)-т заасан эрүүгийн шийтгэлээс татгалзаж болно.⁶⁴

Хэрэв хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д заасан үйлдэл нь худалдаалах зорилгоор хийгдсэн эсвэл олон хүний эрүүл мэндэд аюул учруулсан бол энэ нь ноцтой гэмт хэрэгт тооцогдох бөгөөд хамгийн багадаа 1 жилийн хорих ялаар шийтгэнэ.⁶⁵ Хуулийн 29а дугаар зүйлд зааснаар 21-ээс дээш насны хүн 18-аас доош насны хүнд хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар нийлүүлсэн, эсхүл түүнд шууд хэрэглүүлэхээр хангасан бол, хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар их хэмжээгээр худалдаалах, их хэмжээгээр үйлдвэрлэсэн, борлуулсан, эсхүл зөвшөөрөл авалгүйгээр хадгалсан бол хамгийн багадаа 1 жилийн хорих ялаар шийтгэхээр заасан. Харин хүнд биш тохиолдолд 3 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.

64 Act on the trade in narcotic drugs (BtMG) of 28 July 1981, which came into force on 1 January 1982, current version 1 Mar. 1994, German Federal Law Gazette I p. 681, 1187: 29(5), http://www.gesetze-im-internet.de/btmq_1981/ Сүүлд үзсэн огноо: 2023.12.22.

65 Мөн тэнд, 29 (3).

29(1) дүгээр зүйлд зааснаар зөвшөөрөлгүйгээр хар тамхи тариалсан, үйлдвэрлэсэн, худалдаалсан, эдгээр үйлдлийг зохион байгуулалттай гэмт бүлэглэл гүйцэтгэсэн эсхүл 29а(1)1-д заасан үйлдлийг худалдаалах зорилгоор үйлдсэн, мансууруулах бодисыг тараасан эсхүл шууд хэрэглэхэд бэлэн болгож хангаснаар хүний амь нас хохирсон, мансууруулах бодисыг хууль бусаар их хэмжээгээр хилээр оруулж ирсэн зэрэг үйлдэлд хуулийн 30(1)-д заасны дагуу доод тал нь 2 жилээс доошгүй хугацаагаар хорих ялыг заасан ба хүнд гэмт хэрэгт тооцогдохгүй тохиолдолд 3 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр байна.

Харин их хэмжээгээр тариалсан, үйлдвэрлэсэн, зөөвөрлөсөн, импортлолсон, экспортлолсон, эдгээр үйлдлийг зохион байгуулалттай бүлэглэн гүйцэтгэсэн, 21-ээс дээш насны этгээд хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар тээвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, нийлүүлэх болон бусад хэлбэрээр худалдаалахгүйгээр зах зээлд гаргах, эсхүл эдгээр үйлдлийг сурталчлахад 18 нас хүрээгүй хүнийг оролцуулсан, мөн галт зэвсэг болон мөн чанараараа хүнийг гэмтээх зориулалттай бусад зүйлийг эзэмшиж байх үедээ их хэмжээтэй хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар худалдаалсан, импортлолсон, экспортлолсон, худалдаалахгүйгээр олж авсан зэрэг үйлдэлд бол 5 жилээс доошгүй хугацаагаар хорих ялаар шийтгэхээр 30а дугаар зүйлд тус тус заажээ. Хүнд гэмт хэрэг биш тохиолдолд 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

“Case law” буюу шүүхүүд олон тооны шийдвэрээрээ мансууруулах бодисуудын хувьд дээр дурдсан заалтууд дахь “бага биш” буюу их хэмжээний босго утгыг тогтоосон байна. ХБНГУ-ын Холбооны Шүүх (Bundesgerichtshof, BGH)⁶⁶ эдгээр босго утгыг хэрэглээнд дасаагүй хэрэглэгчийн дундаж хэрэглээний нэгжийн үржвэрт үндэслэн тогтоодог. Хэрэглээний нэгжийг тодорхойлохдоо тухайн бодисыг хэрэглэгчдийн туршлагын талаарх тайланг ашиглаж болдог байна.

Захиргааны зөрчлийн хувьд хар тамхины наймаанд оролцсон тухай мэдээлээгүй, өргөдөлд буруу мэдээлэл өгсөн эсвэл буруу баримт бичгийг хавсаргасан, өөрчлөлтийг зөв, бүрэн эсвэл шууд мэдээлээгүй, биелүүлэх ёстой шаардлагыг зөрчсөн, мансууруулах бодисыг зөвшөөрөлгүйгээр импортлох, экспортлох, хүргэлт, худалдан авалтаа үнэн зөв, бүрэн буюу хойшлуулалгүйгээр мэдээлээгүй, эсвэл хүлээн авснаа баталгаажуулаагүй, эмийн сангаас зөв, цаг тухайд нь асуугаагүй, шуудангийн илгээмжид хар тамхи байрлуулах зэрэг 15 дэд хэсэгт хамаарах үйлдлийг багтаажээ. Захиргааны зөрчилд 25,000 евро хүртэл торгох шийтгэл хүлээлгэж болохоор байна.

Үүнээс гадна, Германы шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль (NpSG)-д NPS-ийг дамжуулах буюу худалдаалах, зах зээлд гаргах, захиран зарцуулах, түүнчлэн NPS-ийг үйлдвэрлэх, нэвтрүүлэхэд чиглэсэн үйлдэлд 3 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ял шийтгэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тухай хуулийн хүрээнд тусгасан. Мөн худалдаалах зорилгоор эсвэл бүлэглэн үйлдсэн, 18-аас доош насны хүмүүсийг хангасан, эсвэл эрүүл мэндэд аюул учруулсан бол 1 жилээс 10 жил хүртэл хорих ялаар шийтгэн хүндрүүлэх нөхцөлийг бий болгосон байна.

66 BGH decision of 7 February 2018, StV 2018, p. 504 and BGH, judgment of 14 January 2015, BGHSt 60, 134, 136 et seq. para. 35 with further refs.

4.2. Норвегийн Хаант Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт

А. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх гол эрх зүйн зохицуулалт

Норвегийн Хаант Улсын (Норвегийн) дээд шүүх 2022 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг бага хэмжээгээр хэрэглэсэн, хадгалсан мансууруулах бодист донтсон этгээдийг шийтгэхгүй байх шийдвэр гаргасан.⁶⁷ Энэ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон этгээдийг шийтгэх бус тусламж үзүүлэх гэсэн Норвегуудын сүүлийн үеийн үзэл санаатай холбоотой.

Норвеги улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист хяналт тавих гол хуулиуд нь Эрүүгийн хууль болон Эмийн тухай 132 дугаар хууль⁶⁸ байна. Эмийн тухай хуулиар хүн, амьтанд хэрэглэх эмтэй холбоотой нийтлэг зарчим, үүргийг тодорхойлсон байдаг. Хуулийн (VIII) бүлэгт Мансууруулах бодис; (VIII а)-д Мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэхэд ашиглаж болох бодисын талаар тус тус тусгасан байна.

Норвеги Улсын Эрүүгийн хуульд зааснаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, хэмжээнээс хамаарч ялын хэмжээ өөр өөр байдаг.⁶⁹

Б. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал ба хуваарь

22 дугаар зүйлд зааснаар Хаан энэ бүлгийн заалтад ямар бодис, эм, ургамал, мөөг, холимог (хар тамхи) хамаарахыг журмаар баталж, үйлдвэрлэх, эргэлт (худалдах, худалдан авах, шилжүүлэх, зуучлах бусад үйл ажиллагаа), импорт, экспорт, шилжүүлэх (дамжуулах) зохицуулалтыг батална), эдгээрийг хүргэх, илгээх, хадгалах, түүнчлэн эм үйлдвэрлэхэд ашиглах ургамал тариалах боломжтойг тогтооно.

Уг журамд зарим эмийг эзэмших, ашиглах, үйлдвэрлэх, олж авах, худалдах, импортлох, экспортлох, шилжүүлэхийг хориглох заалт оруулж болно. Уг журам нь чөлөөт боомт, чөлөөт агуулах, дамжин өнгөрөх агуулахад мөн хамаарна.

В. Хариуцлага

Эрүүгийн хууль

23 дугаар бүлэг. Нийгмийн эрүүл мэнд, орчныг хамгаалах

231 дүгээр зүйл. Мансууруулах бодисын гэмт хэрэг

Мансууруулах эм гэж тооцогдох бодисыг хууль бусаар үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, олж авсан, хадгалсан, илгээсэн, нийлүүлсэн этгээдэд Мансууруулах бодисын тухай хуулийн 22 дугаар зүйлийн дагуу торгох, эсхүл хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

67 Drug use and human rights, Report 2023, <https://www.nhri.no/en/2023/drug-use-and-human-rights/> Сүүлд үзсэн огноо: 2023.12.22.

68 Act No. 132 on Medicines etc, <https://www.fao.org/faolex/results/details/en/c/LEX-FAOC189016/> Сүүлд үзсэн огноо: 2023.12.21.

69 Variation of penalties for drug law offences by drug in the European Union, Norway and Türkiye, <https://www.emcdda.europa.eu/media-library/penalties-law-drug-offences-european-union-norway-and-turkey-en> Сүүлд үзсэн огноо: 2023.12.24.

Мансууруулах бодисыг хайхрамжгүй хандсан тохиолдолд торгох эсвэл нэг жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оногдуулдаг.

232 дугаар зүйл. Хар тамхи, мансууруулах бодисыг хүндрүүлэх гэмт хэрэг

Мансууруулах бодисыг хүндрүүлсэн гэмт хэрэгт 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оногдуулдаг. Гэмт хэргийг хүндрүүлсэн эсэхийг дараах нөхцөл байдлаар тогтооно. Үүнд:

- а. Бодисын төрөл;
- б. Тоо хэмжээ;
- в. Гэмт хэргийн мөн чанар.

Энэ төрлийн хүнд гэмт хэрэгт 3-15 жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл оногдуулна. Онц хүндрүүлсэн нөхцөл байдал үүссэн тохиолдолд 21 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оногдуулж болно.

Энэ гэмт хэргийг болгоомжгүйгээр үйлдсэн хүндрүүлсэн гэмт хэргийн нөхцөлтэй үйлдсэн бол зургаан жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оногдуулж болно.

27 дугаар бүлэг. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон түүнтэй адилтгах гэмт хэрэг

333 дугаар зүйл. Гэмт хэргийн улмаас их хэмжээний орлого олох.

Гэмт хэргийн улмаас их хэмжээний орлого олсон бол зургаан жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ. Их хэмжээний орлогыг тогтоохдоо тухайн гэмт хэрэг үйлдэж олсон орлого, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн олж авсан давуу байдал их байгаа эсэх, гэмт хэрэг үйлдсэн этгээд гэмт хэргээс байнга орлого авч байсан эсэх зэрэгт онцгой ач холбогдол өгнө.

Орлого нь хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс олсон бол уг орлоготой холбогдсон бодисын шинж чанар, тоо хэмжээг харгалзан үзнэ.

Хэрэв олсон орлого нь хулгайн гэмт хэрэг, хүний наймаа, хар тамхи, мансууруулах бодисыг онц хүндрүүлсэн гэмт хэргээс олсон бол 15 жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

338 дугаар зүйл. Их хэмжээний мөнгө угаах

Их хэмжээний мөнгө угаасан бол зургаан жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ. Мөнгө угаах гэмт хэргийг хүндрүүлсэн эсэхийг тогтоохдоо олсон орлого нь ямар төрлийн үйлдлээр олсон, орлогын хэмжээ, гэмт хэрэгтэн байнга мөнгө угаасан эсэх зэрэгт онцгой ач холбогдол өгнө. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс олсон орлогын хувьд тухайн олсон орлогыг холбогдсон бодисын шинж чанар, тоо хэмжээг харгалзан үзнэ.

Хэрэв олсон орлого нь хулгайн гэмт хэрэг, хүний наймаа, хар тамхи, мансууруулах бодисыг онц хүндрүүлсэн гэмт хэргээс олсон бол 15 жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эмийн тухай хууль (Lov om legemidler)

1 дүгээр бүлэг. Хамрах хүрээ, тодорхойлолт.

1 дүгээр зүйл.

Энэхүү хууль нь эмийн бүтээгдэхүүн болон эмнэлгийн зориулалтаар ашиглах бусад бараанд хамаарна. 22 дугаар хэсгийн дагуу Хаан хар тамхи гэж тодорхойлсон бодис, эм, ургамал, мөөг, холимогт энэ хууль мөн хамаарна.

5 дугаар бүлэг. Эмийн үйлдвэрлэл ба импорт.

15а дугаар зүйл.

Мансууруулах бодис нийлүүлэх гэдэг нь бөөний болон жижиглэнгийн худалдаанаас бусад эмийн худалдаа, худалдан авалттай холбоотой, биет байдлаар харьцдаггүй, бие даан болон өөр хуулийн этгээдийн болон хувь хүний нэрийн өмнөөс хэлэлцээр хийдэг аливаа төрлийн бизнесийг хэлнэ.

Эмийн дистрибьютер гэж эхний догол мөрийн дагуу эмийн бүтээгдэхүүн түгээх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, этгээдийг ойлгоно.

Яам нь журмын дагуу эмийн бодисуудад тавигдах нэмэлт шаардлагыг тодорхойлж болно.

8 дугаар бүлэг. Мансууруулах бодис

23 дугаар зүйл.

Мансууруулах бодис үйлдвэрлэх нь зөвхөн 12 дугаар зүйлд⁷⁰ заасны дагуу зөвшөөрөлд тодорхой заасан хэмжээгээр л явагдах ёстой.

Мансууруулах бодис импортлох, бөөний болон жижиглэн худалдаалах нь зөвхөн 13, 14, 16-д заасны дагуу зөвшөөрөлд тодорхой заасан тохиолдолд л явагдах ёстой. Эмийн сангууд энэ заалтаас чөлөөлөгдөнө.

Хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар хууль ёсны эрхгүйгээр хар тамхи хадгалах, хэрэглэх мөн нэр, оршин суугаа газар, өвчин эмгэг, өвчний шинж тэмдгийн талаар худал мэдээлэн ийм барааг худалдан авах эрхтэй болохыг хориглоно. Мөн эмийн жор, хүсэлтийг олгосон хүнээс өөр хэн нэгэнд шилжүүлэх, олж авах ёсгүй байна.

24 а-д Эрүүгийн хуулийн § 234 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт үндэслэсэн журмын дагуу допингийн бодис гэж тооцогддог бодисыг хууль ёсны эрхгүйгээр олж авах, хадгалах, хэрэглэхийг хориглох ба энэхүү хориг нь ийм бодис агуулсан бэлдмэлд мөн хамаарахаар заажээ. Эдгээрийг зөрчсөн бол торгох эсхүл 6 сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх эсхүл давхар ял оноохоор зохицуулсан байна.

70 Lov om legemidler, <https://lovdata.no/dokument/NL/lov/1992-12-04-132> Сүүлд үзсэн огноо: 2023.12.26.

8а дугаар бүлэг. Мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэхэд ашиглаж болох бодисууд

25а дугаар зүйл.

Мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэхэд ашиглаж болох бодисыг импортлох, экспортлох, дамжин өнгөрүүлэх, үйлдвэрлэх, хүлээн авах, эзэмших, харьцах, худалдах зэрэгт тусгай зөвшөөрөл шаардсан журмыг хаан ийм төрлийн бодис тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргаж болно.

10 дугаар бүлэг. Торгууль, эд хөрөнгө хураах, албадан эмчилгээ.

31 дугаар зүйл.

Энэхүү хууль тогтоомж, хуулийн дагуу гаргасан журам, хориглолт, тушаалыг санаатай, болгоомжгүй зөрчсөн тохиолдолд торгох, 3 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёуланг нь шийтгэнэ. Амьтны эмийн тухай журмыг зөрчсөн тохиолдолд зөвхөн 88 дугаар зүйл зөрчсөн тохиолдолд л торгууль ногдуулна.

24 дүгээр зүйлд заасан мансууруулах бодис эзэмших, хэрэглэхээр олж авсан бол торгох, 6 сар хүртэл хугацаагаар хорих, эсхүл хоёулыг нь шийтгэнэ.

Хэрэв эрүүгийн гэмт хэрэг нь мансууруулах бодист хамааралгүй эмийн бүтээгдэхүүнийг шилжүүлэхтэй холбоотой бөгөөд ялангуяа хүндрүүлэх нөхцөл байдал байгаа бол торгох, 2 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл хоёулыг нь шийтгэнэ.

32 дугаар зүйл.

Эрүүгийн хуульд заасан эд мөрийн баримтаар хураах болзлыг хангасан тохиолдолд улсын яллагч хар тамхины жагсаалтад орсон эд зүйлсийг хураах шийдвэр гаргаж болно. Шийдвэр нь бичгээр, үндэслэлтэй байх ёстой. Улсын яллагчийн шийдвэрийг аль болох өмчлөгч, эзэмшигчид мэдэгдэх ёстой бөгөөд битүүмжлэгдсэнээс хойш 1 сарын дотор хэргийг шүүхэд шилжүүлэхийг шаардаж болно.

Хураагдсан эм бэлдмэлийг яах вэ гэдгийг яам шийддэг.

Мөн алдагдсан эд хөрөнгөд тооцогдох эмийг яах вэ гэдгийг яам шийддэг.

4.3. Нидерландын Хаант Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт

А. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх гол эрх зүйн зохицуулалт

1928 онд хүчин төгөлдөр болсон Нидерландын опиумын тухай хууль 1976 онд үндсэндээ нэмэлт өөрчлөлт оруулсан нь одоогийн хар тамхины хууль тогтоомжийн үндэс суурь болсон. Опиумын тухай хуулиар хар тамхины наймаа, тариалалт, үйлдвэрлэл болон хадгалалтыг гэмт хэргийн шинжтэй гэж тодорхойлсон ба хяналт

тавих гол хууль юм.⁷¹

Б. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал ба хуваарь

Опиумын тухай хууль нь хар тамхитай холбоотой асуудлыг зохицуулах ба түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь ХБНГУ-тай адилаар жагсаалтад хамааруулсан 1 дэх жагсаалтад орсон хар тамхи буюу хатуу хар тамхи (жишээлбэл, героин, кокаин, MDMA/экстази, амфетаминууд) ба 2 дахь жагсаалтад орсон хар тамхи буюу зөөлөн хар тамхи (жишээлбэл, каннабис, галлюциноген мөөг) гэж ангилдаг. Мансууруулах бодис хадгалах, худалдах, үйлдвэрлэхийг хориглодог боловч Нидерланд улс кофе шопуудад тодорхой хатуу нөхцөлөөр зөөлөн хар тамхи буюу 2 дох жагсаалтад орсон хар тамхийг зарахыг зөвшөөрдөг. Гэхдээ кофе шопуудад тогтоосон дүрэм журам эсвэл «хатуу зарчим»-ийг дагаж мөрдвөл каннабис (хэш ба марихуан) зарахыг зөвшөөрдөг.Үүнд:⁷²

Ямар нэгэн таагүй байдал үүсгэхгүй байх; хатуу хар тамхи зарахыг хориглоно; насанд хүрээгүй хүмүүст каннабис зарахыг хориглоно; эмийг сурталчлахыг хориглоно; Нэг удаагийн гүйлгээнд их хэмжээгээр /5 граммаас дээш каннабис/ худалдахыг хориглоно.

Нидерландад кофе шопуудад зөөлөн эм зарахтай холбоотой хүлээцтэй ханддаг бодлогыг баримталдаг.⁷³ Учир нь зөөлөн хар тамхи хэрэглэдэг хүмүүсийг хатуу хар тамхи хэрэглэхээс урьдчилан сэргийлэхийн тулд засгийн газар кофе шопуудад зөөлөн эм зарахыг зөвшөөрдөг байна. Марихуан, хэш зэрэг зөөлөн эмүүд нь экстази, кокаин гэх мэт хатуу эмүүдээс эрүүл мэндэд бага хор хөнөөл учруулдаг. Гэхдээ Нидерландад зөөлөн эмүүд бас хууль бус байдаг. Энэ нь эдгээр эмийг зарж борлуулсан, үйлдвэрлэсэн, худалдаалсан эсвэл эзэмшсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх ёстой.⁷⁴

Хотын захиргаа өөрийн хилийн дотор кофе шоп ажиллуулахыг зөвшөөрөх эсэх болон зөөлөн хар тамхи зарах тусгай зөвшөөрөл олгох талаар шийдвэрлэдэг. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, золгүй явдалтай тэмцэхийн тулд Голландын засгийн газар 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс шинэ дүрмийг нэвтрүүлсэн нь зөвхөн “Нидерландын оршин суугчид” кофе шопоор зочилж, каннабис худалдан авахыг зөвшөөрдөг.⁷⁵

Кофены дэлгүүрийн эзэд тус дэлгүүрт байгаа каннабис худалдаж авсан бүх хүмүүсийг 18 ба түүнээс дээш насны Нидерландын оршин суугчид мөн эсэхийг

71 Drug Laws In The Netherlands <https://www.drugpolicyfacts.org/node/4046> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

72 European Monitoring Centre for Drugs and Drug Addiction, “Netherlands County drug report”. 2017 <https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=&ved=2ahUKEwiU0Pbi2PwDAXUDna8BHeiSBnUQFnoECCUQAQ&url=https%3A%2F%2Fwww.emcdda.europa.eu%2Fsystem%2Ffiles%2Fpublications%2F4512%2FTD0616155ENN.pdf&usq=AOvVaw3u2ObZ78vznknt87ZHWqiY&opi=89978449> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

73 Government of the Netherlands, Difference between hard and soft drugs <https://www.government.nl/topics/drugs/difference-between-hard-and-soft-drugs> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

74 Government of the Netherlands, why are coffee shops allowed to sell soft drugs in the Netherlands <https://www.government.nl/topics/drugs/why-are-coffee-shops-allowed-to-sell-soft-drugs-in-the-netherlands>. Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

75 Government of the Netherlands, toleration policy regarding soft drug and coffee shop <https://www.government.nl/topics/drugs/toleration-policy-regarding-soft-drugs-and-coffee-shops>. Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

шалгах эрхтэй. Мөн зөөлөн хар тамхи худалдаж авсан хүнээс хүчинтэй иргэний үнэмлэх, оршин суух зөвшөөрөл болон хотын хүн амын бүртгэлийн хуулбарыг тус тус шаардах эрхтэй байна.⁷⁶

В. Хариуцлага

Опиумын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2-т "10 дугаар зүйлийн хоёроос зургаа дахь хэсэг, 10А дугаар зүйлийн нэгдүгээр хэсэг, 11а дугаар зүйл болон 11 дүгээр зүйлийн хоёроос тав дахь хэсгүүдэд заасан.

ОтХ-ийн 10 дугаар зүйлийн хоёроос зургаа дахь хэсэгт Нидерландын нутаг дэвсгэрт хар тамхийг оруулах, гаргах; ургуулах, бэлтгэх, эмчлэх, боловсруулах, худалдах, хүргэх, хангах, тээвэрлэх; бэлэглэх; үйлдвэрлэх хоригийг санаатайгаар зөрчсөн, бэлтгэх болон сурталчилсан бол дөрвөн жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсхүл 103.000 флорын торгох ялаар шийтгэнэ.⁷⁷

ОтХ-ийн 10А дугаар зүйлийн нэгдүгээр хэсэг Нидерландын нутаг дэвсгэрт эсвэл гадна талд I дэх жагсаалтад буй хар тамхийг ургуулах, боловсруулах, худалдах, хүргэх, хангах, тээвэрлэх, үйлдвэрлэх, бэлтгэх болон сурталчлах зорилгоор:

1. Өөр этгээдийг уг үйлдлийг хийх, үйлдэх, хамтран хийх, өдөөн хатгах, үүнд нь туслах, эсвэл энэ зорилгоор боломж, арга хэрэгсэл, мэдээллээр хангахыг оролдох;

2. Өөрийгөө эсвэл бусдад энэ үйлдлийг хийх боломж, арга хэрэгсэл, мэдээллээр хангахыг оролдсон;

3. Өөрийн мэдэлд байгаа эд зүйл, тээврийн хэрэгсэл, бодис, мөнгө болон бусад төлбөрийн хэрэгсэл нь тухайн үйлдлийг хийхээр төлөвлөж байгааг мэдэх буюу сэжиглэх ноцтой үндэслэл байгаа бол зургаан жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсхүл 103.000 флорын торгох ялаар шийтгэнэ.⁷⁸ ОтХ-ийн 11А дугаар зүйлд "2 дугаар зүйлийн "с"-д I дэх жагсаалтад орсон хар тамхийг санаатайгаар бэлэглэсэн бол зөрчсөн этгээдийг зургаан жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсвэл 103.000 флорын торгох ялаар шийтгэнэ.", "2 дугаар зүйлийн "b" хэсгийн I дэх жагсаалтад орсон хар тамхийг санаатайгаар ургуулах, бэлтгэх, бэлтгэх, боловсруулах, худалдах, хүргэх, хангах, тээвэрлэх болон үйлдвэрлэсэн бол найман жилээс дээшгүй хугацаагаар хорих, 103.000 флорын эсвэл ногдуулна.", "2-р зүйлийн "a" I дэх жагсаалтад орсон хар тамхийг Нидерландын нутаг дэвсгэрт эсвэл гадна талд санаатайгаар хоригийг санаатайгаар зөрчсөн хүн бүр арван хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсвэл 103.000 флорын торгууль ногдуулна."

✓ 11.2-т 3 дугаар зүйлийн b, c, d II дах жагсаалтад орсон хар тамхийг санаатайгаар ургуулах, бэлтгэх, эмчлэх, боловсруулах, худалдах, хүргэх, хангах, тээвэрлэх, бэлэглэх болон үйлдвэрлэсэн тохиолдолд зөрчсөн этгээдийг хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл 25.750 флорын торгох ялаар шийтгэнэ.

✓ 11.3-т Мэргэжил, бизнесийн үйл ажиллагаа явуулахдаа Б-д заасан 3-р зүйлд ургуулах, бэлтгэх, эмчлэх, боловсруулах, худалдах, хүргэх, хангах,

76 Government of the Netherlands, toleration policy regarding soft drug and coffee shop <https://www.government.nl/topics/drugs/toleration-policy-regarding-soft-drugs-and-coffee-shops> .Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

77 Opium Act 11.2 <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

78 Opium Act 10a.1 <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

- тээвэрлэх; заасан хориглолтыг санаатайгаар зөрчсөн бол зургаан жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсхүл 103.000 флорын торгох ялаар шийтгэнэ.
- ✓ 11.4-т 3-р зүйлийн А-д Нидерландын нутаг дэвсгэрт эсвэл гадна талд заасан хориглолтыг санаатайгаар зөрчсөн этгээдийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсвэл 103.000 флорын торгууль ногдуулна.
 - ✓ 11.5-д Хоёр, дөрөв дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь их хэмжээний бодистой холбоотой бол зургаан жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсхүл тавдугаар ангиллын торгууль ногдуулна. Зөвлөлийн захиалгаар тогтоосон бүтээгдэхүүний тоо хэмжээнээс давсан тоо хэмжээг их хэмжээгээр гэж хэлнэ.

ОтХ-ийн 11А дугаар зүйлд “10 дугаар зүйлийн гурав, дөрөв, тав дахь хэсгийн, 10а нэг дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн гурав, дөрөв, тавдугаар хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэх зорилготой байгууллагад оролцсон бол найман жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ эсвэл 103.000 флорын торгуулиар торгуулна.”⁷⁹

ОтХ-ийн 13 дугаар зүйлийн 3-т зааснаар Голландын эрүүгийн хууль нь Нидерландын нутаг дэвсгэрийн гадна дараах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай хэн бүхэнд хамаарна.

1.Нидерландын нутаг дэвсгэрт эсвэл гадна талд заасан хориглолтыг санаатайгаар зөрчсөн этгээдийг арван хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсвэл 103.000 флорын торгох ялаар шийтгэх хэсэгт заасан гэмт хэргийг бэлтгэх, сурталчлах зорилгоор үйлдсэн бол мөн “I болон II дугаар жагсаалтуудад заасны дагуу бүтээгдэхүүнийг худалдах, хүргэх, нийлүүлэхийг дэмжих зорилготой аливаа мэдээллийг задруулах, хуурамч жор санал болгох, жор бичиж өгсөн хүний нэр, хаягаас өөр нэр, хаягаар жор өгсөн, зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх нөхцөлийн шаардлага хангаагүй тохиолдол” зэргийг заасан гэмт хэргийн аль нэг нь, эсхүл

2.“Нидерландын нутаг дэвсгэрт эсвэл гадна талд заасан хориглолтыг санаатайгаар зөрчсөн этгээдийг арван хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсвэл 103.000 флорын торгох ялаар шийтгэнэ” заасан шийтгэл оногдуулах гэмт хэрэг хар тамхины гэмт хэргийг үйлдэхийг завдах буюу оролцохыг хамардаг.

Опиумын тухай хууль

Опиумын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт I болон II дугаар жагсаалтуудад заасны дагуу бүтээгдэхүүнийг худалдах, хүргэх, нийлүүлэхийг дэмжих зорилготой аливаа мэдээллийг задруулах, хуурамч жор санал болгох, жор бичиж өгсөн хүний нэр, хаягаас өөр нэр, хаягаар жор өгсөн , зүй бусаар ашигласан тохиолдолд зургаан сараас дээшгүй хугацаагаар баривчлах, эсхүл 25.750 флорын торгох ялаар шийтгэнэ. Мөн Нидерландын нутаг дэвсгэрт оруулах, гаргах; ургуулах, бэлтгэх, эмчлэх, боловсруулах, худалдах, хүргэх, хангах, тээвэрлэх; бэлэглэх; үйлдвэрлэх хоригийг зөрчсөн этгээдийг нэг сараас дээшгүй хугацаагаар баривчлах, эсхүл 5.150 флорын торгууль ногдуулах нь зөрчилд хамаардаг.⁸⁰

79 Opium Act 11a <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

80 Opium Act 13.1 <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

Замын хөдөлгөөний тухай хууль

Замын хөдөлгөөний тухай хуулиар жолоо барих чадварт сөргөөр нөлөөлөх аливаа мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглодог.⁸¹ Мансууруулах бодис хэрэглэсэн үедээ хүний амь насыг хохироосон зам тээврийн осол гаргасан тохиолдолд дээд тал нь есөн жилийн хорих ял эсвэл дээд тал нь 45 000 флорын торгуулдаг. Мансууруулах бодис хэрэглэсэн үедээ осол гаргаж, бие махбодод нь гэмтэл учруулсан бол дээд тал нь гурван жилийн хорих ял эсвэл дээд тал нь 11 250 флорын торгуультай. Хэрэв хүн тээврийн хэрэгсэл жолоодох чадварт сөргөөр нөлөөлдөг мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол түүний жолооны үнэмлэхийг дээд тал нь таван жилийн хугацаагаар түдгэлзүүлэх зэрэг тус тус шийтгэл оногдуулдаг. Нидерландын цагдаа нар жолоо барихад нөлөөлсөн гэж сэжиглэж байгаа бол хар тамхины шинжилгээ авах эрхтэй. Зам тээврийн осолд орсон хэн ч байсан шинжилгээ хийлгэж болно. Газар тариалан, цэцэрлэгжүүлэлтийн тусгай зориулалтаас бусад тохиолдолд олсны ургамал тариалахыг хориглоно. Ерөнхийдөө арваас илүүгүй тариалсан бол зөвхөн хувийн хэрэгцээнд зориулж ангилах бөгөөд хариуцлага хүлээхгүй. Худалдаалах зорилгоор зөөлөн болон хатуу мансууруулах бодис эзэмших нь хувийн хэрэгцээнд ашиглахаас илүү ноцтой гэмт хэрэг гэж үздэг. Хар тамхи импортлох, экспортлоход оногдуулах ялын дээд хэмжээ нь арван хоёр жил хорих, эсхүл 103 000 флорын торгууль юм. Зөөлөн эм импортлох, экспортлоход ногдуулах шийтгэлийн дээд хэмжээ нь дөрвөн жил хорих эсхүл 103 000 флорын торгууль юм. Хамгийн дээд тал нь 30 грамм каннабис худалдсан, үйлдвэрлэсэн бол нэг сар баривчлах эсхүл 5000 флорын торгох юм. Нэгээс олон удаа гэмт хэрэг үйлдсэн бол торгуулийн дээд хэмжээг гуравны нэгээр нэмэгдүүлж болно.⁸²

Хувийн хэрэгцээнд зориулж 5-аас илүүгүй ургамал тарьсан тохиолдолд цагдаа нар зөвхөн ургамлыг хураан авдаг. Хэрэв 5-аас дээш ургамал илэрвэл Улсын прокурорын газар эрүүгийн хэрэг үүсгэнэ. Цагдаагийн байгууллага каннабис тариалахтай тэмцэхэд орон сууцны хороолол, Татвар, гаалийн газар, эрчим хүчний компаниуд зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг. Каннабис тарьж байгаа нь тогтоогдсон түрээслэгчдийг албадан нүүлгэж болно. Эрчим хүчний компани хууль бусаар цахилгаан тог татсан хүмүүст нэмэлт буцаан дүгнэлт гаргадаг.⁸³

4.4. Сингапур улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт

А. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх гол эрх зүйн зохицуулалт

Мансууруулах бодисыг зүй бусаар ашиглах тухай хууль 1973 нь хар тамхитай холбоотой гэмт хэргийг зохицуулдаг гол хууль юм. Энэ нь хяналттай хар тамхины наймаа, үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, хэрэглэх зэрэг хар тамхины төрөл бүрийн гэмт хэрэгт шийтгэл ногдуулах мөн Хар тамхитай тэмцэх төв хэлтэст

81 Road traffic law 1994 in article 8, section 1.

82 European parliament, "The drug policies of the Netherlands and Sweden" [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2001/300758/IPOL-LIBE_ET\(2001\)300758_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2001/300758/IPOL-LIBE_ET(2001)300758_EN.pdf) Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

83 Government of the Netherland, toleration policy regarding soft drug and coffee shop <https://www.government.nl/topics/drugs/toleration-policy-regarding-soft-drugs-and-coffee-shops> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

хууль сахиулах эрх мэдлийг олгодог.⁸⁴ Мөн “Мансууруулах бодисын тухай хууль 1987” гэж амьсгалах үед мансуурч болзошгүй зарим бодисыг зүй бусаар ашиглахыг хориглох тухай хууль байдаг.

Б. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал ба хуваарь

Мансууруулах бодисыг зүй бусаар ашиглах тухай хуульд мансууруулах бодисыг – А ангилал, В ангилал, С ангилалд хамааруулдаг. А ангилалд хамаардаг мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт оногдуулах шийтгэл нь хамгийн хатуу байдаг байна. А ангиллын мансууруулах бодисыг хуулийн нэгдүгээр жагсаалтын 1-р хэсэгт тодорхойлсон ба Сингапурт хамгийн түгээмэл А ангиллын 3 мансууруулах бодис нь: (а) каннабис (б) героин; ба (в) метамфетамин юм.⁸⁵ В ангиллын мансууруулах бодисыг хуулийн нэгдүгээр жагсаалтын 2-р хэсэгт тодорхойлсон. Үүнд: (а) Кодеин; (б) Норкодеин; ба (в) Зипепрол г.м ордог.⁸⁶ С ангиллын мансууруулах бодисыг хуулийн нэгдүгээр жагсаалтын 3-р хэсэгт тодорхойлсон. Үүнд: (а) Бензфетамин; (б) хлорфентермин; ба (в) Триазолам г.м мансууруулах бодисууд хамаардаг.⁸⁷ Хуулийн хоёрдугаар жагсаалтад мансууруулах бодисын хэмжээ мөн ямар гэмт хэрэг болон А,В,С ангиллаас хамаарч түүнд оноох ялын хэмжээг тусгасан. Хуулийн дөрөвдүгээр жагсаалтад тодорхой заагдсан мансууруулах бодисуудыг заасан.

В. Хариуцлага

Хяналтад байх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист хамаарах гэмт хэргүүд

Мансууруулах бодисыг зүй бусаар ашиглах тухай хууль

Хяналтад байх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис худалдаалах

(1) Энэ хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд тухайн хүн Сингапурт байгаа эсэхээс үл хамааран өөрийн нэрийн өмнөөс эсвэл өөр хүний нэрийн өмнөөс (а) хяналтад байдаг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис худалдаалах; (б) хяналтад байдаг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис худалдаалахыг санал болгох; эсвэл (с) хяналтад байдаг мансууруулах ба сэтгэцэд нөлөөт бодис худалдаалах зорилгоор аливаа үйлдэл хийх эсвэл бэлтгэх үйлдэл хийх санал гаргах нь гэмт хэрэг болно.

(2) Энэ хуулийн зорилгын үүднээс тухайн хүн өөрийн эзэмшилд байгаа мансууруулах бодисыг худалдаалах зорилгоор эзэмшиж байгаа бол хяналтад байдаг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

84 Keeping Singapore Drug-Free, <https://www.mha.gov.sg/what-we-do/keeping-singapore-drug-free> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

85 A Comprehensive Guide To Drug Offences: Types And Penalties, <https://www.daslaw.com.sg/a-comprehensive-guide-to-drug-offences-types-and-penalties/> Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

86 Мөн тэнд.

87 Мөн тэнд.

Хяналтад байх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх

6.Энэ хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хяналтад байх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх нь гэмт хэрэгт тооцогдоно.

Хяналтад байх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох ба экспортлох

7. Энэ хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд хяналтад байх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис Сингапур улс руу импортлох эсвэл экспортлох нь гэмт хэрэг болно.

Хяналтад байх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эзэмших, хэрэглэх

8.Энэ хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд: (а) аливаа хүн өөрийн мэдэлд хяналтад орсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эзэмшсэн; эсвэл татах, өөрөө хэрэглэх, эсвэл өөр аргаар тодорхой эмийг хэрэглэх нь гэмт хэрэг болно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг иргэн эсвэл байнгын оршин суугч Сингапур улсаас гадуур хэрэглэх

8А.(1) 8(b) хэсэг нь Сингапур улсын иргэн, эсвэл Сингапур улсад байнга оршин суудаг, түүнчлэн Сингапур улсад хяналтад байдаг мансууруулах ба сэтгэцэд нөлөөт бодис татсан, өөртөө хэрэглэсэн, эсхүл тодорхой эмийг өөр хэлбэрээр хэрэглэсэн бол 31(4) заалтын дагуу шээсний шинжилгээний үр дүнд илэрсэн хүний хувьд хүчинтэй.

Гаанс, багаж хэрэгсэл г.м эзэмших

9.Энэ хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хяналтад байдаг мансууруулах ба сэтгэцэд нөлөөт бодис татах, хэрэглэх зориулалттай гаанс, тариур, хэрэгсэл, аппарат болон бусад эд зүйлийг тухайн этгээд эзэмшиж байгаа нь гэмт хэрэгт тооцогдоно.

Каннабис, опиум, кока ургамал тариалах

10. Каннабис овгийн ургамал, папавер somniferum буюу намуу цэцэг, кокайн гаргаж авах боломжтой эритроксилол төрлийн ургамлыг тарималжуулах нь гэмт хэрэгт тооцогдоно.

Хяналтад байдаг мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэхэд хэрэгтэй тоног төхөөрөмж, материал, бодисыг үйлдвэрлэх, нийлүүлэх, эзэмших, импортлох, экспортлох

10А. Аливаа этгээд нь

(а) аливаа хяналттай тоног төхөөрөмж, хяналттай материал эсвэл хяналттай бодис үйлдвэрлэдэг;

(б) аливаа хяналттай тоног төхөөрөмж, хяналттай материал эсвэл хяналттай бодисыг өөр хүнд нийлүүлдэг;

(с) өөрийн мэдэлд хяналттай төхөөрөмж, хяналттай материал эсвэл хяналттай бодис байгаа;

(d) эсвэл аливаа хяналттай тоног төхөөрөмж, хяналттай материал, хяналттай бодис импортолдог эсвэл экспортолдог, хяналтад байгаа төхөөрөмж, хяналттай материал, хяналттай бодисыг хяналттай эм үйлдвэрлэх эсвэл үйлдвэрлэхэд ашиглахыг 6-р хэсгийг зөрчиж байгааг мэдсэн буюу итгэх үндэслэлтэй байх нь гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

2) Хяналттай аливаа төхөөрөмж, хяналттай материал эсвэл хяналттай бодис нь 10В хэсгийн дагуу гаргасан аливаа журмын дагуу олгосон эсвэл бусад хэлбэрээр олгосон зөвшөөрөлтэй төхөөрөмж, материал ба бодис нь (1) (d) дэд хэсгийг зөрчиж байгаа аливаа этгээдэд хамгаалалт болохгүй юм.

Хяналттай тоног төхөөрөмж, материал, бодисын тухай журам

10Б (1) Сайд журмын дагуу дараах зүйлсэд зохицуулалт хийж болно

(a) аливаа хяналттай тоног төхөөрөмж, хяналттай материал, хяналттай бодисыг импортлох, экспортлохыг зорьж буй этгээдэд тусгай зөвшөөрөл олгох;

(b) аливаа хяналттай тоног төхөөрөмж, хяналттай материал, хяналттай бодисын импорт, экспортын зохицуулалт, хяналт;

(c) аливаа хяналттай тоног төхөөрөмж, хяналттай материал, хяналттай бодисыг импортлох, экспортлох, үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, түгээх, нийлүүлэхтэй холбогдуулан ашигласан байрыг бүртгэх шаардлага тавих;

(d) аливаа хяналттай төхөөрөмж, хяналттай материал, хяналттай бодистой холбоотой гүйлгээний баримт бичигт шаардлага тавих;

(e) аливаа хяналттай төхөөрөмж, хяналттай материал, хяналттай бодисын талаар бүртгэл хөтлөх, мэдээлэл өгөхийг шаардах;

(f) журмын дагуу хөтөлж буй бүртгэлд хяналт шалгалт хийх, гаргах; болон

(g) аливаа хяналттай төхөөрөмж, хяналттай материал, хяналттай бодисын илгээмжийн тэмдэглэгээ

(2) (1)-д заасан зохицуулалт нь ялангуяа дараах зүйлийг шаардаж болно.

(a) зохицуулалтад заасан аливаа хяналттай тоног төхөөрөмж, хяналттай материал эсвэл хяналттай бодисыг эдгээр улс руу экспортлох тухай мэдэгдэл; болон
(b) заасан нөхцөл байдалд шаардлагатай мэдэгдлийг өгсөн болохыг нотлох баримт бүрдүүлэх, мөн аливаа ийм тоног төхөөрөмж, материал, бодисыг шаардлагатай мэдэгдэлгүйгээр экспортолж байгаа бол тухайн дүрэм журмын дагуу байгаа тоног төхөөрөмж, материал, бодист хамаарах хязгаарлалтын эсрэг экспортлогдсон гэж үзнэ.

(3) Энэ хэсгийн дагуу хийгдсэн зохицуулалтууд нь янз бүрийн хяналттай төхөөрөмж, хяналттай материал эсвэл хяналттай бодистой холбоотой болон өөр тохиолдол, нөхцөл байдалтай холбоотой өөр өөр заалтуудыг оруулж болно.

(4) Энэ хэсгийн дагуу гаргасан журмууд нь түүний аль нэг заалтыг зөрчсөн аливаа этгээд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай бөгөөд 10,000 доллароос илүүгүй торгууль эсвэл 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар эсвэл журамд заасны дагуу аль алианаар нь шийтгэгдэнэ.

(5) 1992 оны Авлига, хар тамхины наймаа болон бусад онц хүнд гэмт хэрэг (тэтгэмж хураах) тухай хуулийн дагуу буюу түүнтэй холбоотой эрүүгийн процессын зорилгоос бусад тохиолдолд энэ хэсэгт заасан журмын дагуу олж авсан аливаа мэдээллийг задруулах ёсгүй.

Эзэмшигч, түрээслэгчийн үүрэг хариуцлага

11. (а) 8(б) хэсгийг зөрчиж ямар нэгэн хяналттай эмийг татах, хэрэглэх, хэрэглэх зорилгоор; эсвэл (b) аливаа хяналттай мансууруулах бодисыг хууль бусаар худалдаалах, хууль бусаар үйлдвэрлэх зорилгоор аливаа газар, байрны өмчлөгч, түрээслэгч, оршин суугч, хариуцсан этгээд нь тухайн газар, байр, түүний аль нэг хэсгийг нээх, хадгалах, ашиглахыг зөвшөөрөх нь гэмт хэрэг болно.

Хяналттай хар тамхи хэрэглэх, худалдаалах цуглаан зохион байгуулах, төлөвлөх

11А.(1) Аль ч газар 2 ба түүнээс дээш хүн цугларсан тохиолдолд тухайн цуглалалт дээр хяналттай мансууруулах бодис хэрэглэж байгаа, эсхүл худалдаалах гэж байгаа гэдгийг мэдэж байж цуглааныг зохион байгуулсан эсвэл төлөвлөж байгаа аливаа этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, - гурваас доошгүй жил, хорин жилээс дээшгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлж мөн 10-аас илүүгүй удаа саваагаар зодуулах үүрэгтэй.

(2) Тухайн хүн тухайн цуглалалтад хэрэглэх, худалдаалах зорилгоор хяналттай мансууруулах бодис нийлүүлээгүй ч (1) дэд зүйлд заасан гэмт хэрэгт буруутай байж болно.

Хүүхдийг хар тамхи, мансууруулах бодист өртүүлэх, өсвөр насныханд хар тамхи хэрэглэхийг зөвшөөрөх

11Б.-(1) Хяналтад байгаа хар тамхи, мансууруулах бодис эсвэл хар тамхины наймаанд хамаарах эд зүйлс эзэмшсэн 21-ээс дээш насны аливаа хүн;

хяналтад байгаа эм, эмийн хэрэгслийг санаатай эсвэл болгоомжгүйгээр аливаа газар ил гарсан эсвэл аливаа хөргөгч, шүүгээ, хайрцаг, авдар эсвэл түгжээгүй бусад зүйлд орхисон ;

болон хяналтад байгаа эм, эмийн хэрэгслийг ил задгай орхисон; эсвэл хяналттай мансууруулах бодис, эмийн хэрэгсэл байрладаг хөргөгч, шүүгээ, хайрцаг, авдар болон бусад эд зүйлсийг ямар ч хүүхэд хэрэглэх боломжтой гэдгийг мэдэж байсан бол гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болно.

(2) Аливаа хяналттай мансууруулах бодис эзэмшиж буй 21 ба түүнээс дээш насны аливаа хүн - залуу хүн татахыг зөвшөөрч, үзүүлж (өөртөө эсвэл өөрт нь хамаарахгүй) эсвэл хяналттай мансууруулах бодис хэрэглэхийг; эсвэл залуу хүн (өөртөө эсвэл өөрт нь эсэхээс үл хамааран) хяналттай мансууруулах бодис татах эсвэл хэрэглэхээс сэргийлэхийн тулд бүх боломжит арга хэмжээг авдаггүй тохиолдолд гэмт хэрэг үйлдсэнд тооцож гэм буруутай болно.

(3) (1) эсвэл (2) дэд зүйлд заасан гэмт хэрэгт буруутай аливаа этгээд - 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлж мөн мөн хоёр дахь удаагаа буюу дахин давтан үйлдсэн бол хоёр жилээс доошгүй, 10 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ.

(4) Энэхүү хуулийн дагуу хяналтад байгаа мансууруулах бодис, мансууруулах бодис эзэмшихийг зөвшөөрсөн тохиолдолд (1) дэд зүйл нь хяналтад байгаа мансууруулах бодис, эмийн хэрэгсэл эзэмшиж буй этгээдэд хамаарахгүй.

(5) Энэ хэсэгт -“хүүхэд” гэж 16 нас хүрээгүй аливаа хүнийг; “эмийн хэрэгсэл” гэж хяналттай мансууруулах бодисыг татах, хэрэглэх, хэрэглэхэд зориулагдсан аливаа гуурс, тариур, хэрэгсэл, аппарат болон бусад зүйлийг хэлнэ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдсан этгээдийг бусдад зуучлах

11C.-(1) (А) мэдэж байгаа эсвэл итгэх шалтгаантай хүн - өөр хүн (В) хяналтад байгаа аливаа мансууруулах бодисыг өөртөө зориулж байгаа эсэхээс үл хамааран худалдан авахаар төлөвлөж байгаа; болон В (эсвэл В хяналттай эмийг худалдан авч байгаа хүн) хяналттай эмийг эзэмшихийг энэ хуулийн дагуу зөвшөөрөхгүй; эсвэл өөр хүн (В) энэ хуулийн дагуу ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр татах, (өөртөө эсвэл өөрт нь хамаарахгүй) эсвэл хяналттай мансууруулах бодис хэрэглэхийг зорьж байгаа бол, В-г (ямар нэгэн цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгаа эсэхээс үл хамааран) А нь хяналттай мансууруулах бодис худалдаалж байгааг мэдэх буюу үзэх үндэслэлтэй, В-г хяналттай мансууруулах бодисоор хангах магадлалтай хүнд зуучилсан бол гэмт хэрэг үйлдсэн байна.

(2) (1)-д заасан гэмт хэрэгт буруутай аливаа этгээд - 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлж; мөн хоёр дахь удаагаа буюу дахин давтан үйлдсэн бол хоёр жилээс доошгүй, 10 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

(3) (1)-д заасан гэмт хэргийн мөрдөн байцаалтын явцад яллах тал дараах зүйлийг нотлох шаардлагагүй.

В нь танилцсаны дараа хяналттай аливаа эмийг худалдан авах, татах, хэрэглэх, эсвэл тухайн үед А эсвэл В нь Сингапурт байгаа тохиолдолд, танилцуулга хийх үед А болон В хоёулаа Сингапурт байгаа нөхцөлд.

(4) Энэ хэсэгт “танилцуулах” гэдэг нь нэг хүний хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг болон бусад мэдээллийг өөр хүнд өгөхийг багтаасан болно.

Тухайн хүнд каннабис тариалах, хяналттай мансууруулах бодис үйлдвэрлэх, хэрэглэхийг зааварлах гэх мэт.

11D.-(1) Аливаа цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан өөр хүнд (Б) заах, зааварчилгаа өгөх, эсхүл Б-д үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн аливаа этгээд (А) дараах үйл ажиллагааг Б-г явуулах гэж байгааг мэдэж байгаа буюу итгэх үндэслэлтэй байвал гэмт хэрэг үйлдсэнд тооцно

- а. каннабис овгийн аль нэг ургамал, эсвэл папавер *somniferum* буюу намуу цэцэг төрлийн аливаа ургамлыг эсвэл кокаин гаргаж авах боломжтой эритроксилон овгийн аливаа ургамлыг тариалах;

- b. хяналтад байдаг аливаа мансууруулах бодис үйлдвэрлэх;
- c. аливаа хяналтад байдаг мансууруулах бодис татах, үзүүлэх, хэрэглэх;
- d. аливаа хяналтад байдаг мансууруулах бодисын наймаанд бэлтгэсэн, эсвэл хууль бусаар худалдаалах зорилгоор аливаа үйлдэл хийх, худалдаалах;
- e. хяналтад байдаг аливаа мансууруулах бодисын Сингапур улсруу импортлох, Сингапур-аас экспортлох,

(2) (1)-д дурдсан аливаа үйл ажиллагаа явуулах тухай мэдээллийг (ямар нэгэн цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан эсвэл ашиглаагүй) тараасан, нийтэлсэн, эсвэл түгээх, нийтлэхэд хүргэсэн аливаа этгээд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болно.

(3) (1)-д заасан гэмт хэрэгт буруутай аливаа этгээд - 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлж; мөн хоёр дахь удаагаа буюу дахин давтан үйлдсэн бол бол хоёр жилээс доошгүй, 10 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ.

(4) (2)-д заасан гэмт хэрэгт буруутай аливаа этгээд - (а) шийтгэгдсэн тохиолдолд 10,000 доллараас хэтрэхгүй торгууль эсвэл 5 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл аль алианаар нь шийтгүүлэх болон мөн хоёр дахь удаагаа буюу дахин давтан үйлдсэн бол бол нэг жилээс доошгүй, таван жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ.

(5) (1)-д заасан гэмт хэрэгт яллахдаа Б-д заасан, зааварчилгаа өгсөн, мэдээллээр хангасан тухайн дэд хэсэгт дурдсан аливаа үйл ажиллагаатай холбогдуулан прокурор нотлох шаардлагагүй.

Б нь зааж, зааварчилсны дараа эсвэл мэдээллээр хангасны дараа Б нь үйл ажиллагаагаа явуулдаг; эсвэл тухайн үед А эсвэл В хоёрын аль нэг нь Сингапурт байгаа тохиолдолд, Б-г зааж, зааварчилж эсвэл мэдээллээр хангасан үед А ба В хоёулаа Сингапурт байсан тохиолдолд.

(6) Энэ хуулийн дагуу хэрэв заах, зааварлах, мэдээлэл өгөхийг зөвшөөрсөн тохиолдолд Б-д заасан аливаа үйл ажиллагааг явуулахыг Б-д заах, зааварлах, эсхүл Б-д мэдээлэл өгөхөд (1) дэд зүйл хамаарахгүй.

(7) дэд хэсэгт зааснаар хэрэв А нь Б-д аливаа үйл ажиллагааг явуулахыг зааж, зааварласан, эсхүл Б-д мэдээлэл өгсөн нь (1) дэд хэсэгт зааснаар нотлогдож мөн заах, зааварлах, мэдээлэл өгөх нь шударга ёсыг хэрэгжүүлэх, гэмт хэрэг мөрдөн шалгах, яллах, шинжлэх ухаан, анагаах ухаан, боловсрол, урлагтай холбоотой хууль ёсны зорилготой бол (1) дээд хэсгээр ялласан тохиолдолд энэ нь хамгаалалт(өөрийгөө өмгөөлөх эрхтэй) юм.

(8) Хэрэв энэ хуулийн дагуу мэдээлэл түгээх, нийтлэхийг зөвшөөрсөн бол (1)-д дурдсан аливаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг түгээх, нийтлэхтэй холбоотой (2) дэд зүйл хамаарахгүй.

(9) (1)-д дурдсан аливаа үйл ажиллагаа явуулсан тухай мэдээллийг тараасан, нийтэлсэн мөн мэдээллийг нийтлэх эсвэл тараах нь шударга ёсыг хэрэгжүүлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, шинжлэх ухаан, анагаах ухаан, боловсрол, урлагтай

холбоотой хууль ёсны зорилготой бол (2) дэд хэсгээр ялласан тохиолдолд энэ нь хамгаалалт (өөрийгөө өмгөөлөх эрхтэй) юм.

Залуу хүн эсвэл эмзэг бүлгийн хүмүүсийг тодорхой гэмт хэрэг үйлдэхэд хүргэх

11Д. 21 эсвэл 21-ээс дээш насны аливаа хүн ямар нэгэн залуу хүн эсвэл эмзэг бүлгийн хүнийг 5(1) эсвэл 7-д заасан аливаа гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн эсвэл зуучилсан бол гэмт хэрэгт буруутайд тооцно.

Гэмт хэрэг гэж шийтгэгдэх завдах , өдөөн хатгах

12. Энэ хуульд заасан аливаа гэмт хэргийг үйлдэхэд өдөөн хатгасан, эсхүл энэ хуульд заасан аливаа гэмт хэргийг үйлдэхэд бэлтгэсэн, эсхүл үйлдэхийг завдсан аливаа этгээд тухайн гэмт хэрэг үйлдсэнд тооцож, түүнд оногдуулсан ялыг хүлээнэ.

Сингапур улсад эсвэл Сингапур улсын гадна гэмт хэрэг үйлдэхэд өдөөн хатгах, зуучлах

13.Аливаа этгээд

Сингапур улсаас бусад аливаа газарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийтгэгдэх гэмт хэргийг үйлдэхэд туслалцаа үзүүлсэн, дэмжсэн эсвэл зөвлөгөө өгсөн;

Сингапур улсад энэ хуульд заасан аливаа гэмт хэргийг үйлдэхэд туслалцаа үзүүлсэн, өдөөн хатгасан, зөвлөгөө өгсөн эсвэл туслалцаа үзүүлсэн, өдөөн хатгасан, зөвлөгөө өгсөн зэрэг бүрдүүлж буй бүх үйлдэл эсвэл зарим нь Сингапур улсын гадна үйлдэгдсэн эсвэл;

Энэ хуулийн дагуу гэмт хэрэг гэж заасан Сингапур улсаас гадна бэлтгэсэн, дэмжлэг үзүүлсэн үйлдэл нь Сингапур улсад үйлдэгдсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

(d) (a) эсвэл (b) хэсэгт дурдсан гэмт хэргийн хувьд 2 жилээс доошгүй, гэхдээ 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсвэл 4000 доллароос доошгүй мөн 40.000 доллароос дээшгүй хэмжээгээр торгох эсвэл аль алианаар нь;

(b) хэсэгт дурдсан гэмт хэргийн хувьд тухайн этгээдэд тусалсан, дэмжсэн, зөвлөсөн гэмт хэрэгт ижил ялыг онооно.

Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг

Энэ хуулийн дагуу хуулийн этгээдийн үйлдсэн аливаа гэмт хэрэг нь тухайн байгууллагын захирал, менежер, нарийн бичгийн дарга болон бусад ижил төстэй албан тушаалтны зөвшөөрлөөр үйлдэгдсэн, эсхүл тэдний хайхрамжгүй байдлаас үүдэлтэй болох нь нотлогдсон тохиолдолд, эсхүл ямар нэгэн байдлаар үйл ажиллагаа явуулах гэж буй аливаа этгээд, тэр ч байтугай байгууллага уг гэмт хэрэгт буруутай бөгөөд зохих ёсоор шийтгэгдэх ёстой.

Мансууруулах бодисын тухай хууль

Мансууруулах бодисын тухай хуулийн 1987 хоёрдугаар хэсэгт мансууруулах бодистой холбоотой гэмт хэргүүдийг заасан.

Мансууруулах бодисыг зүй бусаар ашиглах гэмт хэрэг

3. (1) Хүн өөрийгөө мансууруулах зорилгоор мансууруулах бодис хэрэглэх эсвэл амьсгалах ёсгүй.

(2) (1) дэд хэсгийг зөрчсөн аливаа хүн гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

Мансууруулах бодисыг нийлүүлэх гэмт хэрэг

4. (1) Аливаа этгээд нь мансууруулах бодис эсвэл түүний утаа нь 3(1)-р заалтыг зөрчиж хэрэглэх эсвэл амьсгалах гэж байгааг мэдэж байгаа эсвэл мэдэх хангалттай үндэслэл байгаа бол бусдад мансууруулах бодис зарах эсвэл нийлүүлэх эсхүл нийлүүлэхээр санал болгохыг хориглоно.

(2) (1)-ийн дэд хэсгийг зөрчсөн аливаа хүн гэмт хэрэг үйлдсэнд тооцох бөгөөд 5000 доллараас илүүгүй торгууль эсвэл 2 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял, эсхүл аль алиныг онооно.⁸⁸

4.5. Малайз Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтэд тавих хяналт

А. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх гол эрх зүйн зохицуулалт

Малайз Улс нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдсан тохиолдолд цаазаар авах ял ногдуулдаг. Тодорхой хэмжээний хууль бус бодис, тухайлбал 200 граммаас дээш героин зэрэгт цаазаар авах ял оногдуулдаг ба хар тамхи хэрэглэгч, худалдаалагч гэж ялгадаггүй бөгөөд хууль бусаар мансууруулах бодис хадгалсан нь ноцтой гэмт хэрэг гэж үздэг. Малайз Улсад хуулиар хориглосон бодис найрлагад орсон эм уудаг, түүнийгээ биедээ авч явдаг бол заавал эмчийн жорын бичгийг хамтад нь авч явах ёстой.

Тус улс нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг “Аюултай эмийн тухай хууль 1952 (Dangerous Drugs Act 1952)”, “Хорны тухай хууль 1952 (Poisons Act 1952)” зэрэг хуулиудаар зохицуулдаг.

Эдгээр хуулиудаас Аюултай эмийн тухай хууль 1952 (Malay: Akta Dadah Berbahaya 1952) нь опиум болон бусад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, ашиглахтай холбоотой зохицуулалтыг улам боловсронгуй болгох болон шүүхийн харьяаллын талаар зохицуулсан хууль юм. Малайз Улс хар тамхины гэмт хэрэгт хатуу шийтгэл ногдуулдаг. Гэсэн хэдий ч “Аюултай эмийн тухай хууль 1952”-д 2023 оны дөрөвдүгээр сард нэмэлт өөрчлөлт орж хар тамхины хэрэгт цаазаар авах ялыг хэвээр үлдээж, шүүгч гэмт хэрэгтнүүдэд торгох, хорих зэрэг ялаас сонгож ял оногдуулах боломжтой болгосон.

88 Intoxicating Substances Act 1987, <https://sso.agc.gov.sg/Act/ISA1987?ProvIds=P12-#P12->, Сүүлд үзсэн огноо: 2024.01.24.

Аюултай эмийн тухай хууль (1952)

II бүлэг “Түүхий опиум, кока навч, намуун цэцгийн сүрэл, каннабисын хяналт”

4 дүгээр зүйл. Түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис импортлохыг хязгаарлах.

(1) Эрүүл мэндийн сайдын зөвшөөрснөөс бусад тохиолдолд Малайз руу түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис импортлохыг хориглоно.

6В дугаар зүйл. Тодорхой ургамал тарих, тариалахыг хязгаарлах.

(а) өөрийн нэрийн өмнөөс эсвэл өөр этгээдийн нэрийн өмнөөс түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис зэргийг шууд болон шууд бус аргаар олж авч болох аливаа ургамлыг тарьж ургуулах;

(b) түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис зэргийг шууд болон шууд бус аргаар олж авч болох аливаа ургамлыг өөр этгээдийн эзэмшиж байгаа буюу эзэмшиж буй газар, эсхүл ийм саванд тарьж ургуулахыг зөвшөөрөх. газар; эсхүл

(с) хар тамхины түүхий эд, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабисыг шууд болон шууд бус аргаар олж авах, өөр хэн нэгэн этгээд өөрийн эзэмшиж байгаа эсвэл эзэмшиж буй газар, эсхүл уг газрын аль ч хэсэгт тарьж ургуулах, тариалахыг зөвшөөрөх. ийм газар эсвэл ийм саванд үлдэх.

(2) Сайд (эрүүл мэндийн) судалгаа шинжилгээ, боловсролын, туршилтын эсвэл эмчилгээний зорилгоор түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис зэрэг ургамал тариалах, үржүүлэх зөвшөөрлийг төрийн албан хаагчид өгөхөөс татгалзаж болохгүй.

(4) Түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис зэрэг ургамал эзэмшдэг газар дээр нь ургасан, тухайн ургамал ургадаг газар олсон эсхүл тухайн ургамал бүхий агуулах эзэмшдэг бол тухайн этгээдийг түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис зэрэг ургамал шууд болон шууд бус аргаар олж авсан, тарьсан, үржүүлээгүй нь батлагдах хүртэл буруутай гэж үзнэ.

7 дугаар зүйл. Түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабисын үйлдвэрлэл, худалдааны хяналт.

Сайд (эрүүл мэндийн) түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис тариалах, үйлдвэрлэх, эзэмших, худалдах, түгээхийг хориглох, хянах, хязгаарлах талаар журам батална.

Журмыг 47 дугаар зүйлийн дагуу боловсруулна.

III бүлэг Боловсруулсан опиум, каннабис, каннабисын давирхайд тавих хяналт

8 дугаар зүйл. Каннабис ба каннабисын давирхайн хэрэглээ.

Энэ хэсэгт бэлтгэсэн хар тамхи, каннабис, каннабисын давирхай болон уг давирхайн суурь болсон бодисын тухай зохицуулна.

9 дүгээр зүйл. Каннабис ба каннабисын давирхай эзэмших.

(1) Боловсруулсан опиумыг:

(а) Малайз руу импортлох буюу экспортлох;

(б) өөрийн эзэмшилд байлгах, захиран зарцуулах, хяналт тавих;

(в) үйлдвэрлэх, худалдах эсвэл өөр хэлбэрээр худалдаа хийхийг хориглоно.

10 дугаар зүйл. Опиум боловсруулах зорилгоор байр, агуулах ашиглах.

(1) Хэрэв хэн нэгэн этгээд

(а) Байрны өмчлөгч буюу оршин суугч нь тухайн байрыг опиум боловсруулах, бэлтгэх, худалдах, хэрэглэх зорилгоор ашиглахыг зөвшөөрвөл;

(2) Хэрэв хэн нэгэн этгээд:

(а) өөрийн эзэмшилд боловсруулсан опиумыг хэрэглэхтэй холбоотой ямар нэгэн хоолой (Пиццо), бусад хэрэгсэл, эсхүл хар тамхины бэлдмэлийг татах, эсвэл өөр хэлбэрээр хэрэглэхэд ашигласан багаж хэрэгсэлтэй байх;

(3) Энэ зүйлд заасан “хэрэглэх” гэдэг нь идэх, зажлах, утаа гаргаж татах, залгих, уух, амьсгалах, эсвэл ямар нэгэн байдлаар биедээ нэвтрүүлэхийг хэлнэ.

IV бүлэг. Аюултай эмийн хяналт

11 дүгээр зүйл. 4 дүгээр хэсгийн зохицуулах зүйл

Энэ хэсэг нь нэгдүгээр жагсаалтын III, IV, V хэсэгт жагсаасан аюултай эмд хамаарна.

Хэрэв сайд кокаин, морфин, кокаин, морфины нунтаг, опиумын бусад алкалоид, эсвэл ямар ч төрлийн мансууруулах бодис, эсвэл үр дүнтэй байх боломжтой бодис эсхүл үр дүнтэй бодис болгон хувиргах чадвартай бодисыг дериватив гэж үзвэл эмийн найрлагад хэрэглэх бодисын жагсаалтад оруулж болно.

12 дугаар зүйл. Зарим аюултай эмийн импорт, экспортыг хязгаарлах.

(1) Сайдын зөвшөөрснөөс бусад этгээд:

(а) Нэгдүгээр жагсаалтын III, IV, V хэсэгт заасан аливаа аюултай эмийг Малайз руу импортлох;

(б) Нэгдүгээр жагсаалтын III ба IV хэсэгт заасан аливаа аюултай эмийг Малайзаас экспортлохыг хориглоно.

(2) Энэ хэсэгт хамаарах аливаа аюултай эмийг эрх олгогдоогүй этгээд хадгалах, эзэмшиж болохгүй.

16 дугаар зүйл. Зарим аюултай эмийн үйлдвэрлэл, борлуулалтыг хянах.

(1) Нэгдүгээр жагсаалтын III, IV, V хэсэгт заасан аюултай эмийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн эмийг үйлдвэрлэх, худалдах, эзэмших, түгээхэд хяналт тавих журмыг сайд батална. Гэхдээ дараах тохиолдлыг энэ хуулиар зохицуулна. Үүнд:

(а) тусгай зөвшөөрөлтэй байрнаас бусад газарт ийм төрлийн эмийг үйлдвэрлэхийг хориглох;

(б) журмын дагуу тусгай зөвшөөрөл авснаас бусад этгээд ийм эмийг үйлдвэрлэх, худалдах, түгээхийг хориглох;

20 дугаар зүйл. Аюултай эмийг импортлох.

Хоёрдугаар жагсаалтад заасан С маягтын импортын зөвшөөрлийг түүнд заасан аливаа аюултай эмийг Малайз улсад импортлохыг зөвшөөрч, зохих болзлыг харгалзан хууль ёсны дагуу ашиглах боломжтой аливаа этгээдэд Сайд зөвшөөрөл олгож болно.

(1) хэсгийн дагуу импортын зөвшөөрөл олгосон тохиолдолд сайд мөн импортлохоор төлөвлөж буй аюултай эмтэй холбогдуулан хоёрдугаар хавсралтад заасан А маягтын импортын гэрчилгээг олгоно. Энэ хэсэгт заасны дагуу импортын зөвшөөрөлтэй этгээд эм, олон удаагийн давтамжтай импортлохоор төлөвлөж байгаа бол түүнд импортын гэрчилгээний зөвшөөрлийг нэг тус бүрээр олгоно. (хилээр оруулж ирэх бүртээ зөвшөөрөл авах ёстой)

Энэ зүйлийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр импортын зөвшөөрлийг эзэмшээгүй л бол Малайзад ямар ч аюултай эмийг импортлохгүй.

Б. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал ба хуваарь

1952 оноос Аюултай эмийн тухай хуулиар опиум, аюултай эм, холбогдох материалыг импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, ашиглахыг тусгайлан зохицуулдаг болсон. Үүний дагуу Малайз Улс нь I, II, III жагсаалтаар одоогоор хүлээн зөвшөөрөгдсөн, хууль бусаар ашиглагдах өндөр магадлалтай бодисуудыг тодорхойлжээ. (First Schedule, Second Schedule, Third Schedule⁸⁹)

Энэ хуулийн 39А дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хэмжээ ялын хэмжээнд нөлөөлж болох нөхцөлийг заасан байна.

39А дугаар зүйл. Зарим аюултай эмүүдийн тогтоосон хэмжээгээр торгуулийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Энэ хуулийн эсрэг гэмт хэргийн зүйл нь:

- (a) 2-5 грамм жинтэй героин;
- (b) 2-5 грамм морфин;
- (c) 2-5 грамм моноацетилморфин;
- (d) нийтдээ 2-5 грамм героин, морфин, моноацетилморфин, эсхүл аюултай эмийн аль нэг нь нийт 2-5 грамм;
- (e) 5-15 грамм кокаин;
- (f) 20-50 грамм каннабис;
- (g) 20-50 грамм каннабисын давирхай;

89 Dangerous Drugs Act 1952 and Regulations, <https://pharmacy.moh.gov.my/en/documents/dangerous-drugs-act-1952-and-regulations.html>

- (h) нийт 20-50 грамм каннабис ба каннабисын давирхай;
- (i) 100-250 грамм түүхий опиумын;
- (j) 100-250 грамм боловсруулсан опиум;
- (к) 100-250 грамм түүхий болон боловсруулсан опиум;
- (l) 250-750 грамм кока навч;
- (м) 5-30 грамм 2-Амино-1-(2,5-диметокси-4метил) фенилпропан
- (n) 5-30 грамм амфетамин;
- (o) 5-30 грамм 2,5-диметоксиамфетамин (DMA)
- (p) 5-30 грамм Диметоксибромомфетамин (DOB)
- (q) 5-30 грамм 2,5-диметокси-4-этиламфетамин (DOET)
- (r) 5-30 метамфетамин;
- (s) 5-30 грамм 5-метокси-3, 4метилендиоксиамфетамин (MMDA);
- (t) 5-30 метилендиоксиамфетамин (MDA);
- (u) 5-30 грамм N-этил MDA;
- (v) 5-30 грамм N-гидрокси MDA;
- (w) 5-30 грамм N-метил-1-(3,4метилендиоксифенил)-2-бутанамин
- (x) 5-30 грамм 3, 4 метилендиоксиметамфетамин (MDMA);
- (y) 5-30 грамм Параметоксиамфетамин (PMA);
- (z) 5-30 грамм 3, 4, 5-триметоксиамфетамин (3, 4, 5-TMA)

Тухайн этгээдийг гэм буруутай нь тогтоогдсон хэсэгт заасан гэмт хэрэгт оногдуулсан шийтгэлийн оронд 2-5 жил хүртэлх хугацаагаар хорих мөн 3-9 удаа ташуурдах ял шийтгэнэ.

(2) Энэ хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь цаазаар авах ялаар шийтгүүлэхгүй, гэмт хэргийн зүйл нь:

- (a) 5 грамм ба түүнээс дээш жинтэй героин;
- (b) 5 грамм ба түүнээс дээш жинтэй морфин;
- (c) 5 грамм ба түүнээс дээш жинтэй моноацетилморфин;
- (d) нийтдээ 5 грамм ба түүнээс дээш жинтэй героин, морфин, моноацетилморфин;
- (e) 15 грамм ба түүнээс дээш жинтэй кокаин;
- (f) 50 грамм ба түүнээс дээш жинтэй каннабис;
- (g) 50 грамм ба түүнээс дээш жинтэй каннабисын давирхай;
- (h) 50 грамм ба түүнээс дээш жинтэй каннабис ба каннабисын давирхай;
- (i) 250 грамм ба түүнээс дээш түүхий опиум;
- (j) 250 грамм ба түүнээс дээш боловсруулсан опиум;
- (к) нийт 250 грамм ба түүнээс дээш жинтэй түүхий болон боловсруулсан опиум;
- (l) 750 грамм ба түүнээс дээш кока навч;
- (м) 30 грамм ба түүнээс дээш жинтэй 2-Амино-1-(2,5-диметокси-4метил) фенилпропан
- (n) 30 грамм ба түүнээс дээш жинтэй амфетамин;

- (o) 30 грамм ба түүнээс дээш жинтэй 2,5-диметоксиамфетамин (DMA)
- (p) 30 грамм ба түүнээс дээш жинтэй Диметоксибромомфетамин (DOB)
- (q) 30 грамм ба түүнээс дээш жинтэй 2,5-диметокси-4-этиламфетамин (DOET)
- (r) 30 грамм ба түүнээс дээш жинтэй метамфетамин;
- (s) 30 грамм ба түүнээс дээш жинтэй 5-метокси-3, 4метилендиоксиамфетамин (MMDA);
- (t) 30 грамм ба түүнээс дээш жинтэй метилендиоксиамфетамин (MDA);
- (u) 30 грамм ба түүнээс дээш жинтэй N-этил MDA;
- (v) 30 грамм ба түүнээс дээш жинтэй N-гидрокси MDA;
- (w) 30 грамм ба түүнээс дээш жинтэй N-метил-1-(3,4метилендиоксифенил)-2-бутанамин
- (x) 30 грамм ба түүнээс дээш жинтэй 3, 4 метилендиоксиметамфетамин (MDMA);
- (y) 30 грамм ба түүнээс дээш жинтэй Параметоксиамфетамин (PMA);
- (z) 30 грамм ба түүнээс дээш жинтэй 3, 4, 5-триметоксиамфетамин (3, 4, 5-TMA)

Тухайн этгээдийг гэм буруутай нь тогтоогдсон хэсэгт заасан гэмт хэрэгт оногдуулсан шийтгэлийн оронд бүх насаар нь буюу таваас доошгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ мөн арваас доошгүй удаа ташуурдах шийтгэл оногдуулна.

48 дугаар зүйл. Хар тамхитай тэмцэх ажилтныг төрийн албан хаагчид тооцно.

Энэ хуулийн дагуу хар тамхитай тэмцэх чиглэл бүхий албан хаагчдыг Эрүүгийн хуулийн хүрээнд төрийн албан хаагч гэж үзнэ.

В. Хариуцлага

4 дүгээр зүйлийн (2). Энэ заалтыг зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг гурваас таван жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

Түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис экспортлохыг хязгаарлах 5 дугаар зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн сайдын зөвшөөрснөөс бусад тохиолдолд Малайзаас түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабисыг экспортлохыг хориглодог бөгөөд 3-5 жилийн хорих ялтай байна.

6 дугаар зүйл. Түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис эзэмшихийг хязгаарлах.

Түүхий опиум, кока навч, намуу цэцгийн сүрэл, каннабис эсвэл тэдгээрийг шууд болон шууд бусаар олж авсан хадгалдаг эсвэл эзэмшиж буй этгээд, 4, 5 дугаар зүйлд заасан эсхүл 7 дугаар зүйлд заасан журмаас бусад тохиолдол энэ хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 20,000 рингитээс илүүгүй хэмжээгээр торгох, эсвэл 5 хүртэлх жилийн хорих ял шийтгэнэ.

6 дугаар зүйлийн В хэсэг.

(3) Энэ хэсгийг зөрчсөн аливаа хүн энэ хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай бөгөөд бүх насаар нь хорих ялаар шийтгэгдэж, дор хаяж зургаан удаа ташуурдуулна. (Ташуурдах нь бие махбодын шийтгэл, хүний эрхийг зөрчсөн үйлдэл юм. Малайзад энэ нь 50 гаруй төрлийн эрүүгийн гэмт хэрэгт оногддог⁹⁰.)

9 дүгээр зүйл. Каннабис ба каннабисын давирхай эзэмших.

(2) 1 дүгээр хэсэгт заасан үйлдлийг хийсэн этгээдийг энэ хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэх бөгөөд хорин мянган рингит хүртэлх хэмжээгээр торгох эсхүл таван жил хүртэлх хугацаагаар хорих ял, эсхүл аль алинаар нь ял шийтгэнэ.

10 дугаар зүйл. Опиум боловсруулах зорилгоор байр, агуулах ашиглах.

1 дүгээр хэсгийн (б). Дээр дурдсан зорилгоор ашигласан аливаа байрны ашиглалтыг зохион байгуулсан этгээдийг энэ хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож арван мянган рингит хүртэлх хэмжээгээр торгох, эсхүл гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял, эсхүл аль алинаар нь ял шийтгэнэ.

2 дугаар хэсгийн (б). боловсруулсан опиумыг татдаг, эсвэл өөр аргаар бэлтгэсэн хар тамхи хэрэглэх эсхүл өөр аргаар бэлтгэсэн опиум хэрэглэх зорилгоор ашигладаг газар байнга очдог бол энэ хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай бөгөөд таван мянган рингит хүртэл хэмжээгээр торгох эсхүл хоёр жил хүртэлх хугацаагаар хорих ял, эсхүл аль алинаар нь ял шийтгэнэ.

12 дугаар зүйл. Зарим аюултай эмийн импорт, экспортыг хязгаарлах.

(3) Энэ зүйлд заасныг зөрчсөн этгээдийг энэ хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож зуун мянган рингит хүртэлх хэмжээгээр торгох эсхүл 5 жил хүртэлх хугацаагаар хорих, эсхүл аль алинаар нь ял шийтгэнэ.

(4) Аливаа хорих анги, нөхөн сэргээх төв, цагдаагийн хорих газар, цагдан хорих газарт ажилладаг төрийн албан хаагч дээр дурдсан ял шийтгэлээс гадна 3 удаа ташуурдах шийтгэл хүлээлгэнэ.

39 дүгээр зүйл. Ерөнхий торгууль

Энэ хуульд заасны дагуу тусгайлан шийтгэл оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүн бүрийг гэмт хэрэг тус бүрээр нь таван мянган рингит хүртэлх хэмжээгээр торгох эсхүл хоёр жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл аль алинаар нь шийтгэнэ.

90 Abolish whipping – cruel, inhumane, degrading penal punishment – in Malaysia, <https://aliran.com/civil-society-voices/abolish-whipping-cruel-inhumane-and-degrading-penal-punishment-in-malaysia>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.26

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомжийн Олон улсын гэрээний нийцэл:

Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлийн эсрэг гэмт хэргийн төрлүүдийг Эрүүгийн хуульд ерөнхийдөө тусгасан байна. Ингэхдээ гэмт хэрэгт хамтран оролцох, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэхээс бусад арга хэмжээ авах, урамшууллын аргыг ашигласан зохицуулалт тусгасан зэрэг сайн талыг дурдах нь зүйтэй. Гэвч судалгааны дүнд, олон улсын гэрээ ба Эрүүгийн хуулийн нийцлийн хувьд хангалтгүй дараах нийтлэг тал байгааг тодруулсан.

Монгол Улсын олон улсын гэрээний хэм хэмжээг Эрүүгийн хуульд тусгасан (Тусгасан: бүрэн, бүрэн бус, өргөжүүлсэн, зөрчилтэй, эсхүл огт тусгаагүй гэх мэт) байдал жигд бус, хангалттай хэмжээнд гэж үнэлэгдсэнгүй. Тухайлбал, олон улсын гэрээнд гэмт хэрэгт тооцохоор тоочиж заасан зарим гэмт үйлдлийг хооронд нь нэгтгэх байдлаар орхигдуулсан байна. Түүнчлэн, Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцод гэмт хэрэгт тооцохоор нэрлэж тоочсон нийт үйлдлээс “үйлдвэрлэх”, “санал болгох, худалдахаар санал болгох”, “түгээх”, “аливаа нөхцөлөөр хүргүүлэх”, “зуучлах”, “дамжин өнгөрүүлж илгээх”, “импортлох болон экспортлох” зэргийг Эрүүгийн хуульд хуульчлаагүй байна.

Мөн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 3.1.а).i)-т заасан гэмт хэргийн “түгээх” үйлдлийг Эрүүгийн хуульд тусгаагүй. Үүнийг Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан “бусдад өгсөн”, “илгээсэн” зэрэг үйлдлүүдээр илэрхийлсэн гэж үзэж болох юм. Гэхдээ Эрүүгийн хуулийн 20.12, 20.14 дүгээр зүйлд заасан бусад төрлийн гэмт хэрэгт “түгээх” үйлдлийг хуульчилсан практик байгаа тул мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хувьд мөн “түгээх” үйлдлийг тусгах боломжтой гэж үзэж байна. Мөн Эрүүгийн хуульд конвенцын тус зүйлд заасан “бэлтгэх” болон “бэлдэх” үйлдлүүдийн ялгааг гаргаж хуульчлаагүй зөвхөн бэлтгэх үйлдлийг тусгасан байна.

Хууль тогтоомжийн тухай хууль, түүний хүрээнд батлагдсан аргачлалуудын дагуу дотоодын хууль тогтоомжийг боловсруулахдаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг нягтлахаас гадна Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцэж буйг судалж тодруулах ёстой. Гэтэл Эрүүгийн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хэм хэмжээний нийцэл хангалттай бус байна. Эрүүгийн хуулийг олон улсын гэрээнд нийцүүлж боловсронгуй болгох шаардлагатай. Ингэснээр зөрчилдөөнгүй болохын зэрэгцээ гэрээгээр хүлээсэн үүргээ үр дүнтэй биелүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцын хүрээнд хамаарах санал:

а. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцод заасны дагуу гэмт хэрэгт тооцогдох зарим үйлдлийг Эрүүгийн хуульд нэгтгэх байдлаар тусгасан байгааг анхаарч, зайлшгүй тусгах шаардлагатай үйлдлийг Эрүүгийн хуульд гэмт хэрэгт нэг бүрчлэн тооцож хуульчлах;

б. Тус конвенцод заасны дагуу гэмт хэрэгт тооцогдох үйлдлийг Зөрчлийн тухай хуульд тусгаж зөрчилд тооцож буй байдлыг нягталж, шийдвэрлэх.

Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцын хүрээнд:

а. Тус конвенцод гэмт хэрэгт тооцохоор заасан “санхүүгийн үйл ажиллагаа явуулах” үйлдлийг Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай эсэхийг судалж тодруулах.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын хүрээнд:

а. Конвенцын 3.1.а).i) дэх хэсгийн дагуу “үйлдвэрлэх” болон “экспортлох, импортлох” гэмт үйлдлийг Эрүүгийн хуульд тусгах;

б. 3.1.а).iii)-т заасан “худалдаж авах”, мөн 3.1.а).iv) дэх хэсэгт дурдсан “түгээх” болон “тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэх, тээвэрлэх, түгээх” үйлдлийг Эрүүгийн хуульд тусгах;

с. 3.1.а)v) дахь хэсгийн хүрээнд “удирдсан” гэх үйлдлийг “зохион байгуулсан” үйлдлээс ялгаж хуульчлах, мөн “санхүүжүүлэх” үйлдлийг нэмж тусгах;

д. 3.2 дугаар зүйлд заасны дагуу хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар тарималжуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцох;

е. 3.5 дугаар зүйлийн b,c,d,f,g,h хэсэгт заасан гэмт хэргийн төрлүүдийг Эрүүгийн хуульд хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хуульчлах. Эрүүгийн хуульд тусгахдаа конвенцод бүрэн нийцүүлэх;

ф. 3.5.е хэсэгт заасны дагуу тусгай субъектийн үйлдсэн холбогдох гэмт хэргийн хүрээг өргөжүүлэн хуульчлах;

г. Конвенцын 3.4 дэх хэсгийн орчуулгад “ял ногдуулахаар зааж болно” гэснийг “ял оногдуулна” гэж өөрчлөн найруулж, конвенцын агуулгад нийцүүлэх.

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх тухай зохицуулсан тус хуулийн 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор холбогдох байгууллагууд ашиглаж байгаа ч ашиглахаар журамд заасан зарим байгууллагын үйл ажиллагаа зогссон, эсхүл огт үйл ажиллагаагаа явуулж байгаагүй байна. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах байгууллагуудад Улсын мэргэжлийн хяналтын байгууллага буюу Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хяналт тавих үүргийг журамд заасан ч уг байгууллага татан буугдсаны улмаас энэхүү чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдийн эрх зүйн орчин тодорхойгүй болсон.

Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх харилцаанд хяналтыг бүрэн хэрэгжүүлж хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлэхэд хүндрэлтэй. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх тухай зохицуулсан тус хуулийн 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлийн зорилгодоо хүрсэн түвшин хангалтгүй байна.

Практикт нийцсэн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зорилгод нийцэхгүй байгаа нь практикт хэрэгжилтэд сөрөг үр дагавар үзүүлэх эрсдэлтэй.

Хуулийн хэт ерөнхий зохицуулалт болон нийцүүлэн баталсан хэм хэмжээний актууд өөр хоорондоо зөрчилтэй байгаагаас практикт хэрэгжих боломжгүй байна.

3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулсан тус хуулийн 6 дугаар зүйл:

Тус харилцааг хуульд хэт ерөнхий байдлаар зохицуулснаас тусгайлсан бус ерөнхий зохицуулалт бүхий хэм хэмжээний актаар зохицуулагдаж байна. Мөн хуульд заасан төрийн байгууллага үйл ажиллагаа хэрхэн холбогдох нь тодорхойгүйгээс Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хяналтын механизмтай хангалттай уялдаж чадахгүй байна.

Монгол Улсын хил, боомт дээр ажиллаж байгаа гаалийн байгууллагын алба хаагчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж мэдэх, илрүүлэх талаар ойлголт, туршлага багатай, алба хаагчид ойр ойрхон солигддог, тогтвортой ажилладаггүй, хүний нөөцийн дутагдалтай байдал болон гаалийн байгууллагын ашиглаж буй техникийн эвдрэл, технологийн хоцрогдол, хангалтгүй буюу хүрэлцээгүй байдал нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналтыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулсан зохицуулалт зорилгодоо хүрч чадаагүй байна.

4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгах тухай зохицуулсан тус хуулийн 7 дугаар зүйл:

Тусгай зөвшөөрөл бүхий компаниудын ирүүлсэн хүсэлтийн дагуу хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгуулах тухай улсын байцаагч дүгнэлт үйлдэж, Эрүүл мэндийн яамны харьяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газартай хамтран хүчинтэй хугацаа дууссан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг тусгай компаниар устгуулж, хяналт тавин ажиллаж байна. Журамд заасны дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагын даргын шийдвэрээр тусгай комисс томилогдож хүчинтэй хугацаа дууссан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгах ажиллагаа явагдах ёстой ч одоо тус ажиллагаа хэрхэн явагдаж байгаа нь тодорхойгүй байна.

5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тухай зохицуулсан тус хуулийн 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл:

Төрийн байгууллагын зүгээс тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавьдаг болох нь тодорхойгүй байна. Хуульд энэхүү хяналтыг аж ахуй нэгжийн гаргах тайлангаар дамжуулан хэрэгжүүлэх тухай заасан боловч тайланд юуг дурдах, тайлангийн дагуу бодит нөхцөл байдалд шалгалт хийх тухай зэрэг хяналтыг хэрэгжүүлэх тухай эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Мөн түүнчлэн уг харилцааг зохицуулж буй хэд хэдэн хууль, захиргааны хэм хэмжээний актын хоорондын нийцэл алдагдсан, хэрэгжиж буй эрх зүйн актуудад эрх, үүрэг хүлээсэн субъект тодорхойгүй байх, эсвэл энэ тухай огт заагаагүй байх зэрэг нийтлэг эрх зүйн хийдэл түгээмэл байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тухай зохицуулсан тус хуулийн 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл нь тус хуулийн зорилгыг хангаж чадахгүй байгаагаас практикт бодит хяналт хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

6. Мансуурах донтой этгээдийг эмчлэх тухай зохицуулсан тус хуулийн 12 дугаар зүйл:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Мансууруулах бодист донтсон хүн сайн дурын үндсэн дээр эмнэлэгт хандсан тохиолдолд хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байгаагаас иргэд цагдаагийн байгууллагад бүртгүүлэхгүйн тулд сайн дураараа эмнэлгийн үйлчилгээ авах, эмнэлэгт хандахаас зайлсхийж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12.2-т хуулиар албадан эмчлэх тухай зохицуулсан боловч ийнхүү албадан эмчилсэн тухай мэдээлэл бүртгэгдээгүй байна. Энэ нь мансуурах донтой хүнийг албадан эмчлэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй, энэ талаар баримтлах бодлого тодорхойгүй байгаатай холбоотой. Нөгөөтээгүүр ердийн журмаар буюу сайн дураараа эмчлүүлэх хүсэлтэй хүн эмнэлгийн тусламж авах боломж хязгаарлагдмал, албадан эмчлэгдэх боломж, нөхцөл байхгүй байгаа нь тус хуулийн 12 дугаар зүйл нь зорилгодоо хүрч чадахгүй байгааг харуулж байна.

Практикт нийцсэн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Тус хуулийн 12 дугаар зүйлд заасан зохицуулалт практикт бүрэн хэрэгжихгүй байна. СЭМҮТ-ийн донтохэмгэг судлалын клиникт амбулатори болон хэвтэн эмчлүүлсэн эмчлүүлэгчийн тоон мэдээнээс харвал мансууруулах бодист донтсон этгээдийн өвчлөл нь сүүлийн жилүүдэд харьцангуй өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа Улаанбаатар хотод тус үзүүлэлт илүү өндөр байгаа нь энэ талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ хэрэгтэй байгааг харуулж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн эмчилгээний стандартын F19: Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан төрхийн эмгэг хамгийн их буюу 283 тохиолдол бүртгэгдсэн нь донтогчдын хувьд нэг төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх бус бусад төрлүүдийг хамтад нь хэрэглэх тохиолдол ихэссэн байгааг харуулж байна. Мөн эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн дийлэнх нь 20-29 насныхан байна. СЭМҮТ-ийн мэдээллээр 2019-2023 онд 30 хүн давтан эмчлүүлсэн бол сүүлийн хоёр жилийн хугацаанд давтан эмчлүүлсэн хүний тоо харьцангуй өссөн үзүүлэлттэй байна.

7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох үйл ажиллагаа тухай зохицуулсан тус хуулийн 13 дугаар зүйл:

2009-2023 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн тоон мэдээллийг харвал, 2013 оноос 2019 оны хооронд тус гэмт хэрэг тасралтгүй өссөн үзүүлэлттэй байх ба 2009 оныг 2023 онтой харьцуулбал тус гэмт хэргийн гаралт 15 жилийн өмнөхөөс 23 дахин өссөн байна. Ковид 19 цар тахлын үед буюу 2020, 2021 онд буурсан үзүүлэлттэй байх боловч 2022 оноос ахин өссөөр цар тахлын өмнөх хамгийн өндөр үзүүлэлт болох 2019 оны нөхцөл байдалтай адил хэмжээнд хүрэх төлөвтэй байна.

8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт тухай зохицуулсан тус хуулийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл:

2009-2023 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн тоон мэдээллийг харвал 2013 оноос 2019 оны хооронд тус гэмт хэрэг тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна. 2009 онд бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн тоог 2023 онтой харьцуулахад 23 дахин өссөн байна. Ковид-19 цар тахлын үед (2020, 2021 онд) буурсан үзүүлэлттэй байх боловч 2022 оноос дахин өсөж, цар тахлын буюу 2019 оны нөхцөл байдалтай ижил хэмжээнд хүрэх төлөвтэй байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн бодлого тодорхойгүй байгаагаас хуулийн дагуу үүрэг хүлээсэн байгууллагуудын урьдчилсан сэргийлэх ажил нь зөвхөн олон нийтэд хандсан мэдээлэл, сурталчилгаагаар хязгаарлагдаж байна. Олон нийтэд түгээж буй сурталчилгааны агуулга нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэсэн хүмүүсийг нийгмээс тусгаарлахад чиглэж байгаа нь учир дутагдалтай байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг хянах, таслан зогсоох тухайд хуульд заасан байгууллага бүр хүлээсэн үүргийнхээ дагуу хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ч үр дүн хангалтгүй байгаа нь тус хуулиар зохицуулж буй харилцааны өөрчлөлттэй холбоотой. Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг хянах, таслан зогсоох чиглэлээр салбар хоорондын уялдааг хангах шинэ бүтэц, зохион байгуулалтыг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын тухай зохицуулсан тус хуулийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл нь зорилгод хүрэх түвшин хангалтгүй байгаагаас практикт нийцэхгүй байна.

НОМ ЗҮЙ

Олон улсын гэрээ

1. Төрийн мэдээлэл, тусгай дугаар IV боть, Монгол Улсын олон улсын гэрээ, (УБ, 2006);
2. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, (1961);
3. Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, (1971);
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, (1988);

Хууль тогтоомж

Монгол хэлээр

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992);
2. Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”;
3. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, (2018);
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, (2002);
5. Зөвшөөрлийн тухай хууль, (2022);
6. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, (1993);
7. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, (2001);
8. Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2015.02.24-ний өдрийн “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” 68 дугаар тушаал;
9. Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт;
10. Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт;
11. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам;
12. Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт;
13. Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар “Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тогтоол;
14. Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”;
15. Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”;
16. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/227 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Химийн шинжилгээ хийх журам”;

Гадаад хэлээр

1. Act No. 132 on Medicines etc, <https://www.fao.org/faolex/results/details/en/c/LEX-FAOC189016/>
2. Act on the trade in narcotic drugs (BtMG) of 28 July 1981, which came into force on 1 January 1982, current version 1 Mar. 1994, German Federal Law Gazette I p. 681, 1187: http://www.gesetze-im-internet.de/btmg_1981/
3. Act on the trade in narcotic drugs (BtMG) of 28 July 1981, which came into force on 1 January 1982, current version 1 Mar. 1994, German Federal Law Gazette I p. 681, 1187: 29(5), http://www.gesetze-im-internet.de/btmg_1981/
4. BtM-AußenhandelsVO: <https://www.gesetze-im-internet.de/btmahv/BJNR014200981.html>
5. BtM-BinnenhandelsVO: <https://www.gesetze-im-internet.de/btmbinhv/BJNR014250981.html>
6. BtMVV: http://www.gesetze-im-internet.de/btmvv_1998/BJNR008000998.html
7. Dangerous Drugs Act 1952 and Regulations, <https://pharmacy.moh.gov.my/en/documents/dangerous-drugs-act-1952-and-regulations.html>
8. Intoxicating Substances Act 1987, <https://sso.agc.gov.sg/Act/ISA1987?ProvIds=P12-#P12->
9. Lov om legemidler, <https://lovdata.no/dokument/NL/lov/1992-12-04-132>,
10. Netherlands' Road traffic act, 1994.
11. New South Wales, Drug Court Act 1988.
12. Opium Act, 2009, <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01>
13. StGB: https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html.
14. StVG: https://www.gesetze-im-internet.de/englisch_stvg/englisch_stvg.html.

Ном, өгүүлэл, нийтлэл, тайлан

Монгол хэлээр

1. С.Жанцан, Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудал, илтгэл, (УБ, 2012);
2. Б.Болдбаатар, “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал”, *Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам*” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (УБ, 2018);
3. Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал, судалгааны тайлан, (УБ, 2013);
4. ИРИМ хараат бус судалгааны хүрээлэн, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих Үндэсний хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ, (УБ, 2019);
5. Монгол Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, (УБ, 2013);
6. ГХУСАЗЗын захиалгат үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа, (УБ, 2023), “Эс Ай Си Эй” ХХК.

7. Такехито Ичикава, Ёкояама Жуничи, “Мансууруулах бодисын хэрэглээтэй тэмцэж ирсэн япон улсын түүх, төрөөс баримталж байсан бодлого”, 2023.
8. ХЗҮХ-ийн судалгааны тайлан, <https://nli.gov.mn/pdf/dontoh.pdf>

Гадаад хэлээр

1. Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.50, para 3.4. https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf,
2. Gloria Lai Drugs, Crime and punishment Proportionality of sentencing for drug offences, Series on Legislative Reform of Drug Policies Nr. 20 June 2012, <https://www.unodc.org/documents/congress/background-information/NGO/IDPC/Drugs-crime-and-punishment-Proportionality-of-sentencing.pdf>,
3. The role of the quantity in the prosecution of drug offences, ELDD Comparative Study , EMCDDA, April 2003, http://eldd.emcdda.eu.int/databases/eldd_comparative_analyses.cfm,
4. Explanatory memorandum: Bundesrat Printed Paper 231/16 of 6 May 2016, p.22, https://www.bundesrat.de/SharedDocs/drucksachen/2016/0201-0300/231-16.pdf?__blob=publicationFile&v=1
5. Drug use and human rights, Report 2023, <https://www.nhri.no/en/2023/drug-use-and-human-rights/>
6. Variation of penalties for drug law offences by drug in the European Union, Norway and Türkiye, https://www.emcdda.europa.eu/media-library/penalties-law-drug-offences-european-union-norway-and-turkey_en,
7. Drug Laws In The Netherlands <https://www.drugpolicyfacts.org/node/4046>,
8. European Monitoring Centre for Drugs and Drug Addiction, “Netherlands County drug report”. 2017 <https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=&ved=2ahUKEwiU0Pbi2PwDaxUDna8BHeiSBnUQFnoECCUQAQ&url=https%3A%2F%2Fwww.emcdda.europa.eu%2Fsystem%2Ffiles%2Fpublications%2F4512%2FTD0616155ENN.pdf&usq=AOvVaw3u2ObZ78vznknt87ZHWgiY&opi=89978449>,
9. Abolish whipping – cruel, inhumane, degrading penal punishment – in Malaysia, <https://aliran.com/civil-society-voices/abolish-whipping-cruel-inhumane-and-degrading-penal-punishment-in-malaysia>,
10. European parliament, “The drug policies of the netherlands and sweden” [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2001/300758/IPOL-LIBE_ET\(2001\)300758_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2001/300758/IPOL-LIBE_ET(2001)300758_EN.pdf)
11. A Comprehensive Guide To Drug Offences: Types And Penalties, <https://www.daslaw.com.sg/a-comprehensive-guide-to-drug-offences-types-and-penalties/>

Шүүхийн шийдвэр

Монгол хэлээр

1. Улсын дээд шүүхийн тогтоол “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн зарим зүйл, заалтын тайлбар” Дугаар 15.

Гадаад хэлээр

1. BGH decision of 15 June 2016, NStZ 2016,614-615.
2. BGH decision of 7 February 2018, StV 2018, p. 504 and BGH, judgment of 14 January 2015, BGHSt 60, 134, 136 et seq. para. 35 with further refs.

Цахим эх сурвалж

Монгол хэлээр

1. Архинд донтох өвчтэй 883 эмчлүүлэгчийг шүүхийн шийдвэрээр хүлээн авснаас 525 нь анх удаа ирсэн хүн байжээ, СЭМҮТ-ийн их эмч Ж.Гантулгатай хийсэн ярилцлага.
2. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын чиглэлүүдээр салбарын яамд, тэдгээрийн харьяа байгууллагуудад хандаарай.
3. Бүрдүүлэлт, <https://gaali.mn/services/citizen/sector/clearances/list>
4. Хилийн боомтын жагсаалт.
5. Хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг устгууллаа.
6. К.Елена. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ахлах мэргэжилтэн “Донтох эмгэгтэй нэг хүн уушгины хатгалгаатай 60 хүнтэй тэнцдэг” ярилцлага.
7. Б.Энхчимэг СЭМҮТ-ийн Донтох эмгэг судлалын клиникийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч “Хар тамхины хамааралтай хүн АВТОБУСАНД Ч зүгээр явж чадахгүй” ярилцлага.

Гадаад хэлээр

1. Government of the Netherland, Difference between hard and soft drugs <https://www.government.nl/topics/drugs/difference-between-hard-and-soft-drugs>
2. Government of the Netherland, why are coffee shops allowed to sell soft drugs in the Netherlands <https://www.government.nl/topics/drugs/why-are-coffee-shops-allowed-to-sell-soft-drugs-in-the-netherlands>
3. Government of the Netherland, toleration policy regarding soft drug and coffee shop <https://www.government.nl/topics/drugs/toleration-policy-regarding-soft-drugs-and-coffee-shops>
4. Keeping Singapore Drug-Free, <https://www.mha.gov.sg/what-we-do/keeping-singapore-drug-free>

Ярилцлага

1. Гаалийн ерөнхий газраас ирсэн албан бичгийн хариуны хавсралт тоон мэдээ.
2. Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн Донтох эмгэг судлалын клиникийн холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс, 2023.12.28.
3. Төв аймгийн Баян сумын “Согтуурах мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын” холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс, 2023.12.15.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс, 2023.12.15.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын эмнэлгийн хэлтсийн ахлах мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс 2023.12.15.
6. Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн Донтох эмгэг судлалын клиникийн холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс, 2023.12.28.

ХОЁР. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН
ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга Хууль зүйн
ухааны доктор (Ph.D)

О.Энххүслэн

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

Б.Ариунжаргал

Эрдэм шинжилгээний ажилтан (LL.M)

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2024.05.29.

АГУУЛГА

УДИРТГАЛ	119
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	122
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	123
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	123
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	124
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	124
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	124
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	125
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	126
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	127
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	138
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	145
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	150
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	162
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	165
НОМ ЗҮЙ	169

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.3.4-т “...архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна” гэж, 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлнэ” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2-т “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэний төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн бөгөөд уг зорилтын хүрээнд 2021-2030 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна. Тухайлбал,

1/ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.8-д “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт, сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ” гэж, 2.2.9-д “Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах...” гэж;

2/ Мөн уг арга хэмжээний 2.2.35-д “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна” гэж, 7.3.6-д “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна” гэж;

3/ Түүнчлэн уг арга хэмжээний 7.3.9-д “...мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ” гэж, 7.3.13-т “Тусгай чиг үүрэг бүхий байгууллага болон хилийн боомтын хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг илрүүлэх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, түүхий эд (перкурсор)-д хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, нохойн сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно” гэж тус тус заажээ.

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 4.3.4-т “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ” гэж заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1961 онд баталсан Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 1971 онд баталсан Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, 1988 онд баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцод Монгол Улс нэгдэн орсон бөгөөд үндэсний хууль тогтоомжийг эдгээр конвенцод нийцүүлэх үүргийг хүлээсэн байдаг.

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 63-т мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд болон тэдгээрийн угтвар бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ял хариуцлагыг нэмэгдүүлэх, мансуурах донтой этгээдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эрт шатанд нь илрүүлэх, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заажээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших 22 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ болон түүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн гаралт жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль батлагдах үед буюу 2002 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ болон түүнтэй холбоотой гэмт хэрэг улсын хэмжээнд нийт 2 бүртгэгдэж, шийдвэрлэгдэж байсан бол энэ тоо 2014 онд 62, 2015 онд 79, 2016 онд 98, 2018 онд 128, 2019 онд 170, 2020 онд 181, 2021 онд 187, 2022 онд 230, 2023 онд 238 болж жил ирэх бүр өссөн дүнтэй гарчээ. Сүүлийн 7 жилийн байдлаар, 2017 онд 52, 2018 онд 61, 2019 онд 192, 2020 онд 159, 2021 онд 173, 2022 онд 221, 2023 онд 197 зөрчил гарсан байна.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль ёсны эргэлтийг тодорхой зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэн, хаана, ямар зорилгоор хууль ёсны эргэлтэд оруулах нь тодорхой бус байгааг анхаарч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай болжээ.

Дээрх үндэслэлийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/”-ын дагуу тус Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оршино. Ийнхүү үнэлэхдээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн зохицуулалт, агуулга нь үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар үнэллээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Журмын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Зардал¹
6. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ болон хуулийн төслийн бүтэц нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилго, хууль батлагдах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх;
2. Хуулийн төсөлд өөрчлөгдсөн зохицуулалт болох мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагын тогтолцоо зэрэг зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Хуулийн төсөлд тусгагдсан нэр томъёонууд нь ойлгомжтой эсэх, мөн хууль зүйн техникийн алдаа бий эсэх;
4. Хуулийн төсөлд шинээр тусгагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сан, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах гэмт хэрэг, зөрчил үйлдэж, ял, шийтгэл хүлээсэн этгээдэд хяналт тавих зэрэг шинээр орж ирсэн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх;
5. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх зэргийг шалгах;

1 Хуулийн төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн зардлын тооцоо” сэдэвт судалгаа гүйцэтгэсэн байх тул дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөө үнэлнэ.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субьектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үр нөлөөг тооцно. Үүнд:

Хүснэгт 2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1	Хуулийн зорилт нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл
2	Хуулийн төслийн бүтэц, хамрах хүрээ нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэх	Хуулийн төсөл бүхэлдээ
3	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн бодлогын зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод нийцэх эсэх	Хуулийн төслийн 5, 6, 7 дугаар зүйл
4	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд төрөөс тавих хяналтын зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод нийцэх эсэх	Хуулийн төслийн 9, 10 дугаар зүйл

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулгын хүрээнд зохицуулалтуудыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

Хүснэгт 2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх	Хуулийн төслийн 11-23 дугаар зүйл
2	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагын зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх	Хуулийн төслийн 24-40 дүгээр зүйл
3	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагын тогтолцооны зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх	Хуулийн төслийн 41-49 дүгээр зүйл

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томьёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг болон хууль зүйн техникийн алдаатай зохицуулалтыг сонгон авч үнэллээ.

Хүснэгт 2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл, заалт
1	Хуулийн төсөл нь нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх буюу хууль зүйн техникийн алдаагүй эсэх	Хуулийн төсөл бүхэлдээ

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй эсхүл шинээр оруулсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас

иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтыг сонгосон болно.

Хүснэгт 2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллын зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Хуулийн төслийн 8 дугаар зүйл
2	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Хуулийн төслийн 50-55 дугаар зүйл
3	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээний зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Хуулийн төслийн 56-61 дүгээр зүйл
4	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Хуулийн төслийн 62-66 дугаар зүйл
5	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах гэмт хэрэг, зөрчил үйлдэж, ял, шийтгэл хүлээсэн этгээдэд хяналт тавих зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Хуулийн төслийн 67-70 дугаар зүйл

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Тус хуулийн төслийн хүрээнд биржийн холбогдох үйл ажиллагаа нь бусад хуулийн зохицуулалттайг нийцэж буй эсэх талаар шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх нь ач холбогдолтой гэж үзлээ.

Хүснэгт 2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл, заалт
1	Хуулийн төсөл нь дотроо болон бусад хууль, дагалдах хуулийн төслүүдтэй харилцан уялдаатай эсэх	Хуулийн төсөл бүхэлдээ

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Хүснэгт 2.6. Тохирох шалгах хэрэгсэл

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 2.7. Тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх хэсэг

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл Хуулийн төсөл бүхэлдээ Хуулийн төслийн 5, 6, 7 дугаар зүйл Хуулийн төслийн 9, 10 дугаар зүйл	Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлал, хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага болон тус хуулийн хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 11-23 дугаар зүйл Хуулийн төслийн 24-40 дүгээр зүйл Хуулийн төслийн 41-49 дүгээр зүйл	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Тодорхойлоогүй нэр томъёонуудыг тайлбарлах байдлаар санал болгох, хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх саналыг гаргах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 8 дугаар зүйл Хуулийн төслийн 50-55 дугаар зүйл Хуулийн төслийн 56-61 дүгээр зүйл Хуулийн төслийн 62-66 дугаар зүйл Хуулийн төслийн 67-70 дугаар зүйл	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд баримт бичгийн судалгаа хийж дүгнэх.
5	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Харилцан уялдааг судлах, ингэхдээ холбогдох хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийх.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой байдлаар томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд хуулийн төслийн 1, 5, 6, 7, 9, 10 дугаар зүйл болон зохицуулалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн зорилт буюу хуулийн төслийн 1 дүгээр зүйл нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг “...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино...” гэж тодорхойлсон.

Тус хуулийн төслийн үзэл баримтлалд дурдагдсанаар хууль батлагдсаны дараа дараах эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар гаргахаар тусгажээ.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, түүний зорилт, хэрэгжүүлэх үндсэн зарчим тодорхой болно. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдал хангагдаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийт, ялангуяа хүүхэд, залуучуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар таниулах эрх зүйн орчин боловсронгуй болно;

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүх үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх журмыг хуульд тодорхой тусган, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хийдлийг арилган, үйл ажиллагаа явуулах нөхцөл, шаардлагыг тодорхой болгоно;

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журмыг тодорхой болгож, энэхүү үйл ажиллагаанд эрэлч нохой болон орчин үеийн шаардлагад нийцсэн, өдөр тутам ашиглахад хялбар, найдвартай, өртөг зардал багатай тоног төхөөрөмжийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдон шийтгүүлж байсан этгээд суллагдсаны дараа тодорхой хугацаанд хяналт тогтоох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг бий болгоно.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, мансуурах донтой хүнд стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгэм хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах зохицуулалт бий болно.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай тогтоож, ял шийтгэлийн бодлогыг чангаруулна.

- Нийтийн эрүүл мэндийг хамгаалах, мансуурах донг эмчлэх шинэ арга, ажиллагааны талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж нэмэгдэнэ.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах, үр дүнг үнэлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээнд тогтмол судалгаа, мониторинг хийх мэдээллийн нэгдсэн цахим сан бий болно.

- Мансууруулах эм худалдах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын зарцуулсан, худалдан борлуулсан эм, бэлдмэлийн тоо хэмжээ, зориулалтад хяналт тавих, тайлагнах журам хуульчлагдана:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг судлан үзэж, гэмт этгээдэд хүлээлгэх хариуцлагыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээ, үйлчлэл болон бусад объектив талыг харгалзан ялгамжтай тогтоож, ял шийтгэлийн бодлогыг чангаруулна.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, тэдгээрийг таслан зогсоох ажилд ахиц, дэвшил гарах төдийгүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх иргэдийн мэдлэг дээшилж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамааралтай иргэдэд эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.²

Тус хуулийн зорилт нь дээрх хууль батлагдсаны дараа бий болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагаврыг бүхэлд нь оновчтой байдлаар тусгасан буюу хуулийн зорилгод нийцэж байна. Мөн одоо хэрэгжиж буй хуулийн зорилтын уламжлалт шинж чанарыг агуулсан байна.

2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зорилтыг "...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж тодорхойлсон.

Одоогийн хуулийн зорилтод хүн амын удмын санг хамгаалах тусгаагүй байгаагаар ялгаатай байна. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.1.3.4-т "...архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна" гэж зохицуулсан тул удмын санг хамгаалах талаар хуулийн зорилтод тусгах эсэхийг эргэн харах нь зүйтэй.

2 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, (УБ, 2024).

Хуулийн төслийн бүтэц, хамрах хүрээ нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагад нийцэх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тус хуулийн төсөл нь нийтдээ дараах 12 бүлэг зохицуулалтуудаас бүрдэж байна.

- Нийтлэг үндэслэл;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн бодлого;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд төрөөс тавих хяналт;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагын тогтолцоо;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сан;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах гэмт хэрэг, зөрчил үйлдэж, ял, шийтгэл хүлээсэн этгээдэд хяналт тавих;

Энэхүү бүлэг зохицуулалтуудыг хуулийн төслийн танилцуулгад дараах байдлаар агуулгыг авч үзсэн.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахтай тэмцэх хууль тогтоомж, хуулийн нэр томьёоны тодорхойлолт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахтай тэмцэх үйл ажиллагаанд баримтлах зарчмын тухай;

Хоёрдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахтай тэмцэх төрийн бодлого болон төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бусаар ашиглахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийн тухай;

Гуравдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллын тухай;

Дөрөвдүгээр бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд төрөөс тавих хяналт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахыг хориглох болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах онцгой нөхцөлийн тухай;

Тавдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага, тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам, тусгай зөвшөөрөл олгох журам, тусгай зөвшөөрлийн хураамж, тусгай зөвшөөрлийн хугацаа, хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг хориглох, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох журам, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайлан болон тайланг хадгалах журмын тухай;

Зургадугаар бүлэгт мансууруулах эм, эмийн түүхий эд үйлдвэрлэх, хилээр нэвтрүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх, эмийн сангаас олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон уг бодисын угтвар бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх, гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаанд ашиглах, зэвсэгт хүчинд эмчилгээний зорилгоор ашиглах, мэргэжлийн байгууллага сургалтын зорилгоор ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах, улсын нөөцөд ашиглах, мал, амьтны эмийг амьтан барих үйл ажиллагаанд ашиглах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хадгалах, тээвэрлэх, устгахад тавих шаардлага болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал устгах журмын тухай;

Долдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахтай тэмцэх төрийн байгууллагын тогтолцоо, Үндэсний хороо, түүний чиг үүрэг, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, хар тамхитай тэмцэх алба, түүний чиг үүрэг, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын чиг үүргийн тухай;

Наймдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам, магадлан шинжилгээ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист хийх магадлан шинжилгээ хийх эрх бүхий байгууллагын тухай;

Есдүгээр бүлэгт мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, шинжилгээ-оношилгоо, биеийн болон сэтгэл заслын эмчилгээний тусламж, үйлчилгээ, тусгай төв, нийгмийн хамгааллын нөхөн сэргээх арга хэмжээний тухай;

Аравдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сан, сангийн төрлийн тухай;

Арван нэгдүгээр бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил үйлдэж, ял, шийтгэл хүлээсэн этгээдэд хяналт тавих, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг цуцалж, албадан гаргах журмын тухай;

Арван хоёрдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас урьдчилан сэргийлэх, хууль бусаар ашиглахтай тэмцэх талаар хүн, хуулийн этгээдийн үүрэг, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар.³

Тус хуулийн төслийн бүлэг зохицуулалтууд нь хууль батлагдсаны дараа бий болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагаврыг бий болгохоор байгаа бөгөөд хуулиар зохицуулах харилцааг бүхэлд нь зохицуулсан байна.

Хуулийн төслийн 5, 6, 7 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн бодлогын зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод нийцэх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор төрөөс дараах бодлогыг баримтлахаар зохицуулсан.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг бүрэн хянах;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлыг эрт шатанд илрүүлэх, мансуурах, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар хэрэглэж мансуурсан хүнд эрүүл мэндийн болон сэтгэц-нийгмийн сэргээн засах, нийгмийн хамгааллын нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорт зуршлаас татгалзуулах, нийгэмшүүлэх цогц оновчтой аргаар мансуурах, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар хэрэглэгчийн тоог бууруулах;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх, таслан зогсоох, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах.

Төрөөс баримтлах дээрх бодлого нь одоогийн баримталж буй бодлоготой нийцэлтэй байх ёстой. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх, хууль бус эргэлтэд хяналт тавих талаар Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжиж байна. Тус хөтөлбөрийн зорилт, үр дүнг дараах байдлаар тодорхойлсон.

Хүснэгт 2.8. Зорилтын агуулга, үр дүн

	Зорилтын агуулга	Зорилтын үр дүн
Зорилт 1.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр НҮБ-аас баталсан гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орж, дотоодын хууль тогтоомжийг Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцүүлэх замаар эрх зүйн орчин боловсронгуй болно. Ингэснээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий гадаад, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжирна.

3 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн товч танилцуулга, (УБ, 2024).

Зорилт 2.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын уялдаа холбоог сайжруулах;	Мансууруулах эм, эд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох ажилд ахиц дэвшил гарч, гэмт хэрэг, зөрчлийн тоо буурна.
Зорилт 3.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах;	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх хүүхэд, залуучууд, иргэдийн мэдлэг дээшилж, донтсон болон хэрэглэгч болсон иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн болон нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бий болно. Ингэснээр нөхөн үржихүй болон хүн амын удмын санг хамгаалах, энэ төрлийн гэмт хэргийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурах нөхцөл бүрдэнэ.
Зорилт 4.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах, тэдгээрийг арилгах арга замыг оновчтой тодорхойлох;	Төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагаас шинжлэх ухааны үндэслэлтэй хийсэн суурь болон хавсарга судалгааны дүнд суурилан төлөвлөж боловсруулдаг болно. Ингэснээр энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажил үр дүнтэй хэрэгжих нөхцөл бий болно.
Зорилт 5.	Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах, эрүүл мэнд, шүүх эрх мэдлийн байгууллагуудын алба хаагчдыг мэргэшүүлж, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх	Төрийн байгууллагууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг богино хугацаанд илрүүлэх, таслан зогсоох, шинжлэн судлах орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдаж, алба хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилснээр энэ төрлийн гэмт хэргийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд ахиц дэвшил гарна.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 онд үнэлж, хөтөлбөрийн зорилт бүрээр тусгайлсан дүгнэлтийг өгсөн.

Нэгдүгээр зорилт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох” 93.6 хувийн хамгийн өндөр биелэлттэй байна. Энэхүү зорилтын хүрээнд 9 үйл ажиллагаа авч хэрэгжүүлсний 3 нь үр дүнтэй, 6 нь тодорхой үр дүнтэй байна. Олон улсын геополитикийн нөхцөл байдлаас хамаарч аливаа гэмт хэргийн хэлбэр, нөхцөл байдал хувьсан өөрчлөгдөж байна. Иймд иргэдийн зорчих хөдөлгөөн, гэмт хэрэгт өртөх, оролцох магадлалд үндэслэн. харилцан туслалцаа үзүүлэх улс хоорондын гэрээг шинэчлэх, өргөжүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай.

Хоёрдугаар зорилт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын уялдаа холбоог сайжруулах” 87.0 хувийн биелэлттэй. Дээрх зорилтын хүрээнд 6 үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн бөгөөд үр дүнтэй 1, тодорхой үр дүнтэй 4, эрчимжүүлэх шаардлагатай 1 үйл ажиллагаа байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий албан хаагчдын нийгмийн баталгаа, аюулгүй байдал байгууллага тус бүрийн үндсэн чиг үүрэг, дотоод бүтэц, зохион байгуулалтаас хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал,

цагдаагийн байгууллага болон Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй ажилтан албан хаагчдын тогтвортой байдал, нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Гуравдугаар зорилт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах” 84.4 хувийн биелэлттэй байна. Зорилтын хүрээнд 13 үйл ажиллагаа хэрэгжүүлснээс үр дүнтэй 5, тодорхой үр дүнтэй 8 үйл ажиллагаа байна. Энэхүү зорилтын үйл ажиллагаа бүрэн хангахын тулд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, хөтөлбөрийг сурталчлах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг харуулсан урлагийн бүтээл, нийтлэл, нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлэх, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр хар тамхи, мансууруулах төрлийн бодис хэрэглэх, бэлтгэх, борлуулах, хэрэглэх аргачлалыг харуулсан, уриалан дуудсан сөрөг сурталчилгаа хийхийг хориглох, хариуцлага оногдуулах эрх зүйн орчныг бий болгох зэрэг үйл ажиллагаанд анхаарч ажиллах хэрэгтэй.

Дөрөвдүгээр зорилт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах, тэдгээрийг арилгах арга замыг оновчтой тодорхойлох” 77.6 хувийн биелэлттэй байна. Тус зорилтын хүрээнд 5 үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үр дүнтэй 1, тодорхой үр дүнтэй 2, эрчимжүүлэх шаардлагатай 2 үйл ажиллагаа байна. Цаашид байгууллага хооронд ашиглах мэдээллийн нэгдсэн санг бий болгох, салбар зөвлөлүүд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх төвийг байгуулах тогтмол ажиллуулах нөхцөлийг бий болгох чиглэлд анхаарах хэрэгтэй байна.

Тавдугаар зорилт “Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах, эрүүл мэнд, шүүх эрх мэдлийн байгууллагуудын алба хаагчдыг мэргэшүүлж, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх” 88.1 хувийн биелэлттэй байна. Энэхүү зорилтын хүрээнд 8 үйл ажиллагаа авч хэрэгжүүлсний 4 нь үр дүнтэй, 2 нь тодорхой үр дүнтэй, 2 нь эрчимжүүлэх шаардлагатай байна. Цаашид мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх нохойн сургалтын төв байгуулах, сэжиг бүхий этгээдээс мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг илрүүлэх багаж хэрэгслээр (анхан шатны) замын болон хэв журмын цагдаа, яаралтай түргэн тусламжийн эмч, хил хамгаалах, гаалийн байгууллагын алба хаагчдыг хангах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай байна⁴.

Дээрхээс дүгнэвэл, хуулийн төслийн 5 дугаар зүйлд тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор төрөөс баримтлах бодлого нь “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-тэй нийцэж байна. Гэвч тухайн төрөөс баримтлах бодлогыг тодорхойлохдоо зарим бодлогыг нарийвчилж тодорхойлоогүй байна. Түүнчлэн хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг бүхэлд нь нарийвчлан тодорхойлсон төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох нь зүйтэй. Иймд төрөөс баримтлах бодлогыг өргөн хүрээнд тодорхойлж, нарийвчлан тусгах талаар анхаарах шаардлагатай.

4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, “Эс Ай Си Эй” ХХК, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ”, (УБ, 2023), 75-76 дахь тал.

Хуулийн төслийн 9, 10 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд төрөөс тавих хяналтын зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод нийцэх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 9, 10 дугаар зүйлд тусгаснаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг дор зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, бэлтгэх, мансууруулах бодис бүхий ургамал тарималжуулах, түүх, хилээр нэвтрүүлэх, импортлох, экспортлох, реэкспортлох, худалдах, худалдан авах, үйлчлэх, олгох, тээвэрлэх, илгээх, хадгалах, хэрэглэх, ашиглах, олж авах, бусдад өгөх, бусдад болон өөртөө хэрэглэх, бусдад хэрэглүүлэх, дамжуулах, зуучлахыг хориглохоор тусгажээ.

- Эм, эмийн түүхий эд үйлдвэрлэх;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Судалгаа, шинжилгээ, сургалтын зорилгоор энэ хуульд заасан эрх бүхий төрийн байгууллага.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой зөвшөөрөх үйл ажиллагааг 4, 5 дугаар зүйлд тусгасан.

4 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх

4.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг дор дурдсан зорилгоор дараах байгууллага ашиглаж болно:

4.1.1.эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор эрүүл мэндийн болон эрдэм шинжилгээний байгууллага;

4.1.2.лабораторийн шинжилгээ хийх, сургалт явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага;

4.1.3.харьцуулалт хийх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага;

4.1.4.эмийн ургамлыг тарималжуулсан тохиолдолд сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг үйлдвэрлэх, экспортлох тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгж.

4.2. Эмчийн заалтаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хэрэглэх жор авсан өвчтөн уг эмийг хэрэглэж болно.

4.3. Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын болон байгууллагын жагсаалт, ашиглах журмыг Засгийн газар батална.

5 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх

5.1.Эмчилгээний зорилгоор хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг улсын стандартын шаардлага хангасан жороор олгоно.

5.2.Хүн амын тоог харгалзан мансууруулах эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангийн тоо, байршлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар тогтооно.

Энэхүү зохицуулалт нь хуулийн төслийн холбогдох зохицуулалттай агуулгын хувьд ижил байна. Тухайн зохицуулалтын хэрэгжилтийг авч үзье.

Эмчилгээ, судалгааны чиглэлээр ашиглах зорилгоор:

Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагын жагсаалт баталсан.

Хүснэгт 2.9. Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагууд

Нэг. Эрдэм шинжилгээний байгууллага			
Д/д	Жагсаалт дахь нэр	Одоогийн нэр	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашигладаг эсэх
1.	Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны хүрээлэн	Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит Анагаах ухааны хүрээлэн	Тийм
2.	Шинжлэх ухааны академийн Хими-технологийн хүрээлэн	Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн	Тийм
3.	Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэн	Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	Тийм
4.	Мал эмнэлгийн хүрээлэн	Мал эмнэлгийн хүрээлэн	Тийм
Хоёр. Боловсролын байгууллага			
5.	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль	Тийм
6.	Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал эмнэлэг, биотехнологийн сургууль	Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, Биотехнологийн сургууль	Тийм
7.	Монгол Улсын их сургуулийн Шинэ материал хими-технологийн төв;	Одоогийн байдлаар үйл ийм төв байхгүй байна.	Тийм
Гурав. Бусад			
8.	Улсын мэргэжлийн хяналтын газрын Нэгдсэн лаборатори;	Стандарт хэмжил зүйн газрын харьяа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	Тийм
9.	Улсын гаалийн ерөнхий газрын дэргэдэх Гаалийн төв лаборатори	Улсын гаалийн ерөнхий газрын дэргэдэх Гаалийн төв лаборатори	Тийм
10.	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийг удирдах газар		Тийм
11.	Эрүүл мэндийн яамны Сэтгэцийн эмгэг мансуурал судлалын төв		Тийм
12.	Эрүүл мэндийн яамны Шүүх эмнэлгийн магадлах төв		Тийм
13.	Мал эмнэлгийн эм бэлдмэл шалгах улсын нэгдсэн лаборатори	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори	Тийм
14.	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	Тийм
15.	Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэн.	Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн шинжлэх ухааны газар, Химийн лаборатори	Тийм

Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны хүрээлэн нь 2015 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор АШУҮИС-ийн харьяанд шилжсэн бөгөөд Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит Анагаах ухааны хүрээлэн болсон байна. Уг хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний төв лабораторийн хамтран ажиллах чиглэлд Эсийн өсгөвөр (Анхдагч эсийн өсгөвөр, шугаман эсийн өсгөвөр), Молекул биологи (Уургийн анализ, Генийн экспресс), Эдийн шинжилгээ (Иммуногистохими, Иммунофлюоресценци) зэрэг багтаж байна.

Онцлог лабораториудтай зарим байгууллагуудыг тухайлан судалбал, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн нь Байгалийн нэгдлийн химийн лаборатори, Эрдсийн технологийн лаборатори, Экологийн химийн лаборатори, Органик бус химийн лаборатори, Органик химийн лаборатори, Нүүрсний хими технологийн лаборатори, Материал судлал, технологийн лаборатори, Хүнсний химийн лаборатори, Биохимийн лаборатори, Багажит анализын лабораториор шинжилгээ, судалгаа хийж, үйл ажиллагаагаа явуулдаг бол Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн Ургамлын ангилал зүй, филогенетикийн лаборатори, Ургамалжлын экологи, ургамлын эдийн засгийн лаборатори, Ойн фитоценологийн лаборатори, Ургамлын стресс физиологийн лаборатори, Ургамлын интродукц, генетик нөөцийн лабораториуд нь тус тус шинжилгээ судалгаа хийх боломжтой байна.

Стандарт хэмжил зүйн газрын харьяа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн микробиологийн лаборатори, хими, хор судлалын лаборатори зэрэг нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тэдгээрийн түүхий эдэд судалгаа, шинжилгээ явуулж болохоор байна.

Харин Гаалийн төв лаборатори нь 1996 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын чанарын шинжилгээгээр 2003 оноос хойш Стандартчилал, хэмжил зүйн газраас итгэмжлэгдсэн лабораторийн эрхтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Гаалийн төв лаборатори нь харьяа гаалийн газар хороод болон хууль хяналтын бусад байгууллагаас ирүүлсэн сэжигтэй дээжид CA3/CA/05-08 аргачлалын дагуу нил улаан туяа, Раманы хосолсон спектрометр (FTIR/RAMAN) болон CA3/CA/05-07 аргачлалын дагуу хроматограф/масс спектрометр (GC/MS) багажаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын чанарын шинжилгээ хийж, үр дүнг албан тоотоор хүргүүлэн ажилладаг.

Дээрх байгууллагуудаас МУИС-ийн Шинэ материал хими-технологийн төвөөс бусад бүх байгууллагууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ашиглах боломжтой байна.

Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагын жагсаалтад МУИС-ийн шинэ материал хими-технологийн төвийг багтаасан ч энэхүү төв нь одоогоор үйл ажиллагаагаа явуулдаггүй бөгөөд МУИС-ийн бүтцэд байдаггүй. Мөн МУИС-д 1996 онд Шинэ материалын лаборатори байгуулагдан судалгаа шинжилгээ хийж байгаа боловч энэхүү лаборатори нь шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашигладаггүй байна.

Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах журмын⁵ 3.7 дугаар зүйлд заасны дагуу Улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашигладаг байгууллагыг тогтмол хянаж байхаар үүрэг болгосон байдаг. Гэтэл дээрх байгууллагуудыг хянах байгууллага буюу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгож татан буулгахаар шийдвэрлэсэн. Улмаар хяналтын чиг үүргийг салбар яамд болон тэдгээрийн харьяа байгууллагууд руу шилжүүлсэн байна. Шилжсэн хяналтуудаас⁶ энэхүү судалгааны сэдэвтэй холбоотой хамгийн боломжит хяналтууд (Ургамал хамгааллын хяналт, таримал ургамлын үрийн хяналт, эмчилгээний чанарын хяналт зэрэг)-ыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам руу тус тус шилжүүлснээс өөрөөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдэд тухайлсан хяналтыг хаашаа шилжүүлсэн нь тодорхойгүй байна.

Эдгээрээс дүгнэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор холбогдох байгууллагууд ашиглаж байгаа ч ашиглахаар журамд заасан зарим байгууллагын үйл ажиллагаа зогссон, эсхүл огт үйл ажиллагаагаа явуулаагүй байна. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах байгууллагуудад Улсын мэргэжлийн хяналтын байгууллага буюу Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хяналт тавих үүргийг журамд заасан ч уг байгууллага татан буугдсаны улмаас энэхүү чиг үүрэг аль нэг яамны харьяа улсын байцаагчид шилжсэн байх магадлалтай байна. Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх харилцаанд хяналтыг бүрэн хэрэгжүүлж хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлэхэд хүндрэлтэй гэж үзэж байна. Энэ нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зорилтод нийцэхгүй байгаа буюу практикт хэрэгжилтийн хувь сөрөг үр дагавар авчрах боломжтой гэж дүгнэлээ.

Иймд эмчилгээ, судалгааны чиглэлээр ашиглах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавихад хүндрэлтэй байх нөхцөл байдал хуулийн төсөл батлагдсанаар үргэлжлэх боломжтой тул хяналтын байгууллагыг тодорхой болгох шаардлагатай.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх зорилгоор:

Эмийн найрлагад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис эмчилгээний тунгаар орсон байвал эмч эмийн жор бичих бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорыг бичихдээ “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 Монгол Улсын стандартыг мөрдөнө. Мөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 Монгол Улсын стандартад заасан загварын дагуу хэвлүүлэн, дугаарлаж (индекс), харьяа нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудад түгээхээр байна.

5 Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.

6 Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын чиглэлүүдээр салбарын яамд, тэдгээрийн харьяа байгууллагуудад хандаарай, <https://www.facebook.com/mergejliinhyanal/>

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын 6 дугаар зүйлд Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор бичих, жорын маягтаар хангах талаар тусгасан бөгөөд үүнд зааснаар Мансууруулах эмийн жорын маягтын дугаар нь тухайн аймаг, нийслэлийн Засаг захиргааны нэгжийн код болон 5 оронтой тоо, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягт нь дээрх код болон 6 оронтой тооноос бүрдэхээр байна. Мөн “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтад орсон мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг эдгээр эмийн жорын маягт болон даатгалын жорын маягт дээр бичиж хавсаргасан байна. Төв эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвүүд нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт захиалж авна. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг тухайн байгууллагын захиалга болон өмнө авсан жорын маягтын зарцуулалтын тайланг үндэслэн олгоно.” гэж тус тус заажээ. Түүнчлэн уг журамд Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл, тайлан зэргийн загварыг багтаасан байх тул эдгээр зохицуулалт нь нарийвчлан зохицуулагдсан байна. Гэвч Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/66-р тушаал, 2021 оны А/781 дүгээр тушаалаар энэхүү журамд өөрчлөлт орсон ч MNS 5376:2014 буюу 2016 онд шинэчлэгдсэн стандартыг тусгаагүй 2014 оны стандартыг дагаж мөрдөхөөр заасан заалтад өөрчлөлт ороогүй байгаагаас үзэхэд практикт хэрэгжих болон хуулийн зорилгод нийцсэн байх шалгуурыг зарим талаар хангахгүй байна гэж үзлээ.

Иймд хуулийн төслөөр эм, эмийн түүхий эд үйлдвэрлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах талаар тусгахдаа шинэчилсэн стандартыг баримтлах нь зүйтэй байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих эсэхийг үнэлнэ. Энэхүү хүрээнд хуулийн төслийн 11-23, 24-40, 41-49 дүгээр зүйлд баримтын судалгааны аргад тулгуурлан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 11-23 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд зааснаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох дараах үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж болохоор зохицуулжээ.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох, экспортлох, реэкспортлох;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах эмийн сангийн үйлчилгээ эрхлэх;

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх.

Дээрх тусгай зөвшөөрөл олгох процессыг мөн нарийвчлан тусгасан.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хураамж;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг хориглох;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайлан;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайланг хадгалах;

Одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох процесс, тулгамдаж буй асуудлыг авч үзье.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодисын импортлох тусгай зөвшөөрлийг 2022 оны байдлаар “Азифарм, Еврофарм, ЭНТО, Чигатуссин, Моносфарм трейд, Монгол эм импекс концерн, Монос трейд” ХХК гэсэн 7 байгууллага, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг “Айвико, Монос Фарм” ХХК-ууд авсан ба Монгол Улсын дээрх жагсаалтад заасан 14 нэрийн мансууруулах эм, 35 нэрийн сэтгэцэд нөлөөт эмийг импортолж байна. 2021 онд Засгийн газрыг хэрэгжүүлэгч агентлаг “Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар” байгуулагдсан нь эм эмнэлгийн хэрэгслийн хяналт шалгалт, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа болон бусад холбогдох үйл ажиллагаанд томоохон дэвшил

гарсан байна.⁷

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх талаар:

Судалгааны энэ хэсэгт хамааралтай мэдээллийг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайлангийн “3.3.2. Практикт нийцэж байгаа байдал” болон “3.3.1. Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн үнэлгээний хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

Дээрх судалгааны үр дүнгээс үзвэл, тус хуулийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой зохицуулалтын практик хэрэгжилт хангалтгүй байна. Харин мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх талаар зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан зохицуулсан байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, худалдах талаар:

Энэхүү судалгааны тайлангийн эмхэтгэлийн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайлангийн “3.5.1.1. Зорилгод хүрсэн түвшин” болон “3.5.1.2. Практикт нийцсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн үнэлгээг үзнэ үү.

Дээрхээс дүгнэвэл, тус хуулийн төслийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх, үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт нь хууль болон журмын уялдаагүй, тодорхойгүй, нэг мөр хэрэгжих боломжгүй байсныг хуулийн төслөөр нарийвчлан тодорхойлж, процессыг бүрэн тусгасан, тайлан гаргах, ил тод байдлыг хангаж байгаа нь ач холбогдолтой зохицуулалт болсон байна.

Хуулийн төслийн 24-40 дүгээр зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагын зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 24-40 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагыг тусгай зөвшөөрлийн төрөл бүрээр нарийвчлан тодорхойлсон байна.

- Мансууруулах эм, эмийн түүхий эд үйлдвэрлэхэд тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлоход тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хилээр нэвтрүүлэхэд тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэхэд тавих шаардлага;

7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, “Эс Ай Си Эй” ХХК, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ”, (УБ, 2023), 29-32 дахь тал.

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмийн сангаас олгоход тавих шаардлага;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэхэд тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүхэд тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаанд ашиглахад тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг зэвсэгт хүчинд эмчилгээний зорилгоор ашиглахад тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг мэргэжлийн байгууллага сургалтын зорилгоор ашиглахад тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглахад тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын нөөцөд ашиглахад тавих шаардлага;
- Мал, амьтны эмийг амьтан барих үйл ажиллагаанд ашиглахад тавих хяналт;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хадгалахад тавих шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэхэд тавихад шаардлага;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгахад тавих шаардлага;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал устгахад тавих шаардлага;

Одоогийн эрх зүйн зохицуулалтын тухайд Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам”-аар голчлон зохицуулж байна. Тус журмын 3 дугаар зүйлд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагыг зохицуулсан.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх болон ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаатай олгоно. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм болон тэдгээрийн угтвар бодисыг ашиглан эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг эмийн хэлбэр бүрд олгоно. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоход дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хадгалах агуулахын талаарх Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дүгнэлт;

- Тухайн байгууллагад мансуурах донтой, архинд донтох болон өөр бусад шалтгаанаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисыг зүй бусаар хэрэглэдэг хүмүүс ажилладаггүй тухай Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн магадалгаа;

- Үйлдвэрлэлийн дамжлага болон ханган нийлүүлэх үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцооны тухай танилцуулга;

- Үйлдвэрлэх болон импортлох эмийн нэр, тун, хэлбэр, тоо хэмжээний талаарх мэдээлэл;

- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис бүхий ургамал ашиглах тохиолдолд уг ургамлыг ашиглахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;

- “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуульд заасан бусад баримт бичиг.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх, экспортлох болон ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтээ хугацаа дуусахаас 2 сарын өмнө бичгээр гаргах;

- Үйлдвэрлэх, экспортлох болон импортлох эмийн хэрэгцээг өмнөх оны эхний улиралд багтаан зөвшөөрөл олгогч байгууллагад мэдэгдэж, тухайн жилийн хэрэгцээнд тусгуулсан байх;

- Импортлох, экспортлох болон үйлдвэрлэсэн эмийн түүхий эд, эмийн нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан хэмжээ, экспортлогчийн нэрийг илтгэсэн бүртгэлийг тогтмол хөтлөх;

- Холбогдох тайланг зөвшөөрөл олгогч байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлж байх.

Дүгнэвэл, одоогийн эрх зүйн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлагыг нэгдсэн байдлаар зохицуулж чадахгүй байгаа нь харагдаж байна. Түүнчлэн журмаар зохицуулахдаа ерөнхий байдлаар зохицуулж тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг бууруулж байна. Тус хуулийн төслөөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг төрөл бүрээр нь тусгайлан зохицуулж, тавигдах шаардлагыг тусгасан нь үр дүнтэй зохицуулалт болохоор байна.

Хуулийн төслийн 41-49 дүгээр зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагын тогтолцооны зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ
--

Хуулийн төслийн 41-49 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагын тогтолцооны зохицуулалтыг тусгахдаа дараах төрийн байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан зохицуулжээ.

- Улсын Их Хурал
- Засгийн газар
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
- Үндэсний хороо;
- Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

- Хар тамхитай тэмцэх алба;
- Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Тагнуулын байгууллага;
- Гаалийн байгууллага;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга.

Одоогийн эрх зүйн зохицуулалт буюу 2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлд төрийн байгууллагуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих чиг үүргийг нарийвчлан зохицуулаагүйгээс гадна хэрэгжилт хангалтгүй байна.

Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналттай холбоотой бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

14.1.Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бүртгэл, хуваарилалт, үйлдвэрлэл, зарцуулалт, хадгалалт, худалдаа, хэрэглээ хуульд заасан журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

А. Хяналтыг хэрэгжүүлэгч этгээд тодорхой эсэх (нарийвчлан зохицуулсан журмаар болон байгууллагын дотоод журмаар үүнийг тодорхой заасан эсэх МЭСНБЭХТХ-ийн 14.1 дүгээр зүйлд заасан “Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18.3 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт зааснаар Эрүүл мэндийн яам юм.

Б. Хяналтын хэлбэр тодорхой эсэх (хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхээр эрх зүйн актад зохицуулсан тухай) Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” 68 дугаар тушаал нь Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 10.1, 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 15.12.4 дэх заалтууд, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зорилготой боловч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2022 оны 06 сарын 17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон тул “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” тушаалаар баталсан журмыг шинэчлэн батлах ёстой юм. Иймд хяналтын хэлбэр тодорхойгүй. Дээрх тушаалаар батлагдсан журмаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс байхгүй тул яаралтай шинэ журам батлах эсхүл тушаалын үндэслэл хэсэг дэх хуулийг солих шаардлагатай байна.

В. Зөрчилд авах арга хэмжээ тодорхой эсэх. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эмийн хадгалалт, хамгаалалтын журам зөрчих”-ийг хориглоно, 15.11 дүгээр зүйлд “энэ хуулийн 14.1, 14.2, 15.9 дэх хэсгийг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд импортын зөвшөөрлийг хүчингүй болгоно.”,

29 дүгээр зүйлд “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага”, 29.1 дүгээр зүйлд “энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, 29.2 дугаар зүйлд “энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тус тус заажээ. Зөрчилд авах арга хэмжээ нь тодорхойгүй байна.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналттай холбоотой бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

~~14.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолтод хяналт тавина.~~

14.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолт, ургамлын тархцад хяналт тавина.

А. Хяналтыг хэрэгжүүлэгч этгээд тодорхой эсэх (нарийвчлан зохицуулсан журмаар болон байгууллагын дотоод журмаар үүнийг тодорхой заасан эсэх) МЭСНБЭХТХ-ийн 14.3 дугаар зүйлд заасан “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам юм.

Б. Хяналтын хэлбэр тодорхой эсэх (хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхээр эрх зүйн актад зохицуулсан тухай)Байгаль орчин, аялал жуулчлалын яам мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолт, ургамлын тархцад тогтмол хяналт тавьдаг эсэх нь тодорхойгүй байна.

В. Зөрчилд авах арга хэмжээ тодорхойгүй байна.

Гаалийн болон хил хяналтын байгууллага

14.4.Гаалийн болон хил хяналтын байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх явдлыг таслан зогсоох үүрэгтэй.

А. Хяналтыг хэрэгжүүлэгч этгээд тодорхой эсэх (нарийвчлан зохицуулсан журмаар болон байгууллагын дотоод журмаар үүнийг тодорхой заасан эсэх) МЭСНБЭХТХ-ийн 14.4 дүгээр зүйлд заасан “Гаалийн болон хил хяналтын байгууллага” гэж Гаалийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гаалийн байгууллага, албан тушаалтан нь улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, гаалийн бүрдүүлэлт хийх...” гэж зааснаар Гаалийн ерөнхий газар хяналтыг хэрэгжүүлнэ.

Б. Хяналтын хэлбэр тодорхой эсэх (хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхээр эрх зүйн актад зохицуулсан тухай) 2019 оны 12 сарын 04-ний өдөр Гаалийн ерөнхий газрын даргын журам батлах тухай А/275 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журмаар зохицуулсан.

В. Зөрчилд авах арга хэмжээ тодорхой эсэх. Хил, боомт дээр ажиллаж буй алба хаагч нарын мэдлэг, техник, технологийн хоцрогдол, хангалтгүй. Монгол Улсын хил, боомт дээр ажиллаж байгаа алба хаагчид мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж мэдэх, илрүүлэх талаар ойлголт, туршлага багатай, алба хаагчид ойр ойрхон солигддог, ажиллах хүч тогтвортой ажилладаггүй байдал, хүний нөөцийн дутагдал болон одоо ашиглаж байгаа “R-Scan”, Буянт-Ухаа дахь “DHL” олон улсын шуудан, илгээмжийн газарт ашиглаж буй “Fiscancmez-T100100” рентген төхөөрөмж нь цаг үеийн шаардлага хангахгүй байгаа нь гэмт этгээдүүдэд хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэх таатай боломжийг бий болгож байна.

Үндэсний хорооны хяналттай холбоотой бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

14.6. Энэ хуулийн 14.1-14.5-д заасан байгууллагын авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зохисгүй хэрэглээг бууруулах, эргэлтэд хяналт тавих, эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүрэгтэй Үндэсний хороо ажиллах бөгөөд уул Үндэсний хороо орон тооны ажлын албатай байна.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх. Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүн” баталжээ.⁸

Эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлсэн эсэх. Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар “Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай”⁹ тогтоол баталжээ.

Олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн эсэх. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үзэхэд олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Иймд тус хуулийн төсөлд тусгасны дагуу төрийн байгууллагын чиг үүргийг нарийвчлан зохицуулж байгаа нь одоо үүсээд буй хүндрэл бэрхшээлийг даван туулах гарц болохоор байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагуудыг өргөн хүрээнд тодорхойлж, хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан авч үзсэн нь ач холбогдолтой зохицуулалт байна.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон болон логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгана. Ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг нарийвчлан давхар шалгана. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

8 Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531434075371&showType=1>

9 Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар “Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530843645471>

Хүснэгт 2.10. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 3.1.9 дэх заалт	Төслийн 3.1.8-д “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт”, 3.1.9-д “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт” гэх ойлголтыг тодорхойлсон бөгөөд энэхүү 2 ойлголт нь өөр хоорондоо нягт уялдаа холбоотой.	Төслийн 3.1.8-д “... ашиглах, устгах, олж авах...” гэж, төслийн 3.1.9-д “...ашиглах, олж авах...” гэж тодорхойлсон нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд “устгах” үйлдэл хамаарахгүй байдлаар тусгасныг нягтлан үзэх шаардлагатай.
2	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.21 дэх заалт	Төслийн 3.1.21-д “...хоол, унданд нь хийх...” гэх зохицуулалтыг тусгасан.	Төслийн 3.1.21-д тус ойлголтыг ийнхүү тусгах шаардлагатай эсэхийг сайтар нягтлах.
3	Төслийн 3 дугаар бүлэг	Төслийн 3 дугаар бүлэг нь нэг зүйлтэй байна.	Тус бүлгийг өөр бүлэгт нэгтгэн зохицуулах.
4	Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт	Төслийн 6.1.8-д “...илүү хэмжээний...” гэсний “илүү” гэх үг нь оновчгүй, найруулга зүйн алдаатай байдлыг бий болгож байна.	Төслийн 6.1.8-д “...илүү хэмжээний...” гэснийг “... их хэмжээний...” гэж өөрчлөх.
5	Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг	Төслийн 6.3-т “...үр дүнтэй тэмцэж урьдчилан сэргийлэх...” гэж өөр хоорондоо ялгаатай агуулгыг таслалгүйгээр үргэлжлүүлэн бичсэн байна.	Төслийн 6.3-т “үр дүнтэй тэмцэж, урьдчилан сэргийлэх” гэх.
6	Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт	Төслийн 7.1.4-т “сэтгээд” гэж алдаатай бичсэн үгийг засах.	Төслийн 7.1.4-т “сэтгээд” гэж алдаатай бичсэнийг “сэтгэцэд” гэж засах.
7	Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг	Төслийн 9.1-д “хэрэглэх” гэх үгийг 2 удаа бичсэн нь найруулга зүйн алдаатай байдлыг бий болгож байна.	Төслийн 9.1-д заасан “хэрэглэх” гэх эхний үгийг хасах. Тус үгийг хасах нь тухайн зохицуулалтын агуулгыг алдагдуулахгүй бөгөөд тухайн хэсэгт заасан “...бусдад болон өөртөө хэрэглэх...” гэдэгт “хэрэглэх” гэх ойлголт нь хамаарч байна.
8	Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг	Төслийн 11.3-т “...Энэ хуулийн 10.3-т зааснаас бусад тохиолдолд мөн хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэхийг хориглоно...” гэж хэт нуршуу, ойлгомжгүй байдлаар бичигджээ.	Тус зохицуулалтыг өөрчлөн найруулах. “Энэ хуулийн 10.3-т заасан үндэслэл энэ зүйлд хамаарахгүй”
9	Төслийн 12 дугаар зүйлийн 12.2.9 дэх заалт	Төслийн 12.2.9-д “компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаарх дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх” гэж заасны ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Төслийн 12.2.9-д заасныг өөрчлөн найруулах. Тухайлбал, “дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн” гэснийг “олон улсын” гэж өөрчилж болох юм.
10	Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалт	Төслийн 13.1.6-д “... зүй бусаар хэрэглэдэг хүн бий эсэх...” гэж тусгажээ.	Төслийн тус зохицуулалтад “хүн бий эсэх” гэснийг өөрчлөх. Тухайлбал, албан хаагч, ажилтан гэх мэт нэр томъёог ашиглах.

11	Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг	Төслийн 14.5-д "...цахим хэлбэрээр хариу өгнө..." гэснийг өөрчлөх.	Төслийн 14.5-д "цахим хэлбэрээр хариу өгнө" гэснийг "цахимаар хариу өгнө" гэж өөрчлөх.
12	Төслийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг	Төслийн 24.6-д "Энэ хуулийн 24.5-д заасан тайлангийн маягтыг Үндэсний хороо батална" гэж заасан боловч төслийн 24.5-д тайлангийн маягттай холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.	Төслийн 24.5-д тайлангийн маягттай холбоотой зохицуулалт тусгагдаагүй учир төслийн 24.6-д заасныг дахин нягталж, засах нь зүйтэй.
13	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалт, Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг Төслийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг	Төслийн 3.1.9-д "...1961 оны нэгдсэн конвенц..." гэж, төслийн 25.3-т "...1961 оны конвенцын 31 дүгээр зүйл..." гэж, төслийн 46.2-т "...1961 оны нэгдсэн конвенц..." гэж нэг конвенцыг ялгамжтай байдлаар бичжээ.	Төслийн 3.1.9-д "...1961 оны нэгдсэн конвенц..." гэж, төслийн 25.3-т "...1961 оны конвенцын 31 дүгээр зүйл..." гэж, төслийн 46.2-т "...1961 оны нэгдсэн конвенц..." гэж тус тус ялгамжтай байдлаар бичсэнийг нэг мөр болгох.
14	Төслийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг	Төслийн 25.8-д "Энэ хуулийн 25.7-д заасан тайлангийн маягтыг Үндэсний хороо батална" гэж заасан боловч төслийн 25.7-д тайлангийн маягттай холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.	Төслийн 25.7-д тайлангийн маягттай холбоотой зохицуулалт тусгагдаагүй учир төслийн 25.8-д заасныг дахин нягталж, засах нь зүйтэй.
15	Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг	Төслийн 26.1-д "... бүртгэлд орсноос бусад болон тусгай зөвшөөрөлд заасан тоо..." гэж заасны "бусад болон" гэсэн нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Төслийн 26.1-д заасан зохицуулалтын "бусад болон" гэснийг өөрчлөн, засаж сайжруулах.
16	Төслийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг	Төслийн 38.1-д "...тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хууль, стандартад заасан хадгалах нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр тээвэрлэж болно..." гэж тус зохицуулалтад хоёр удаа "үндсэн дээр" гэж тусгасан нь найруулга зүйн алдаатай байдлыг бий болгож байна.	Төслийн 38.1-д заасан зохицуулалтад хоёр удаа "үндсэн дээр" гэж тусгасныг засах.
17	Төслийн 55 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист магадлан шинжилгээ, дахин шинжилгээ хийх эрх бүхий байгууллага	Төслийн 55 дугаар зүйлийг "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист магадлан шинжилгээ, дахин шинжилгээ хийх эрх бүхий байгууллага" гэж нуршуу байдлаар бичсэнийг засах.	Төслийн 55 дугаар зүйлийн "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист магадлан шинжилгээ, дахин шинжилгээ хийх эрх бүхий байгууллага" гэснийг "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист шинжилгээ хийх эрх бүхий байгууллага" гэж өөрчлөх.
18	Төслийн 62 дугаар зүйлийн 62.2.2 дахь заалт	Төслийн 62.2.2-т "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдүүлэх" гэж тусгасан нь найруулга зүйн алдаатай байна.	Төслийн 62.2.2-т заасан зохицуулалтыг өөрчлөн найруулах.
19	Төслийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалт	Төслийн 64.1.3-т "энэ хуульд заасны дагуу ашиглах эрх бүхий байгууллагын мэдээлэл" гэж хэт ерөнхий байдлаар тусгасан байна. Юуг ашиглах эрх бүхий байгууллага гэдгийг тодорхой байдлаар тусгах.	Төслийн 64.1.3-т заасан зохицуулалтыг нарийвчлан тусгах.

20	Төслийн 68 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах	Төслийн 68 дугаар зүйл нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах гэх боловч төслийн 68.1-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураасны дараах асуудлыг илүү зохицуулсан зохицуулалт байна.	Төслийн 68 дугаар зүйлийг нягтлан, өөрчлөн найруулах.
21	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.12 дахь заалт	Төслийн 3.1.6, 46.1.12-т "...Нэгдсэн Үндэсний байгууллага..." гэж, алдаатай байдлаар бичжээ. Төслийн 3.1.6-д заалтад "...зөвлөмжид туссан..." гэснийг засах.	Төслийн 3.1.6, 46.1.12-т алдаа бичсэнийг үгийг засах. Зүй нь "... Нэгдсэн Үндэстний байгууллага..." гэх.
22	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт	Төслийн 3.1.6-д заалтад "...зөвлөмжид туссан..." гэснийг засах.	Төслийн 3.1.6-д "... зөвлөмжид туссан..." гэснийг "...зөвлөмжид тусгасан..." гэж өөрчлөх.
23	Төслийн 45 дугаар зүйлийн 45.1.7 дахь заалт	Төслийн 45 дугаар зүйлийн 45.1.7 дахь заалтыг 45.4.7 гэж буруу дугаарласан байна.	Төслийн 45 дугаар зүйлийн 45.1.7 дахь заалтыг 45.4.7 гэж буруу дугаарласныг засах.
24	Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт	Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг 13.3.3 гэж буруу дугаарласан байна.	Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг 13.3.3 гэж буруу дугаарласныг засах.
25	Төслийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг	Төслийн 55.3-т "...импортлох тухай гэрээ урьдчилан байгуулсан байна..." гэснийг засах.	Төслийн 55.3-т "...импортлох тухай гэрээ..." гэснийг "гэрээг" гэж өөрчлөх.
26	Төслийн 60 дугаар зүйлийн 60.2.5 дахь заалт	Төслийн 60.2.5-д "...хүн ам дахь мансууруулах эм..." гэсэн нь найруулга зүйн алдаатай байна.	Төслийн 60.2.5-д заасан "...хүн ам дахь ..." гэснийг "хүн амын" гэж өөрчлөх.
27	Төслийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг	Төслийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг нь 8 заалтаас бүрдэж байна. Гэсэн хэдий ч төслийн 61.2.6 дахь заалтыг орхигдуулан дугаарласан байна.	Төслийн 61 дүгээр зүйлийн 61.2.5 дахь заалтын дараа 61.2.6 дахь заалтыг орхигдуулан 61.2.7 гэж дугаарласан байна. Иймд төслийн 61.2.7-61.2.9 дэх заалтыг 61.2.6-61.2.8 гэж өөрчлөх.
28	Төслийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь заалт	Төслийн 67.3-т "өмнө, өмнө" гэж давхардуулан оруулсан байна.	Төслийн 67.3-т давхардуулан тусгасан "өмнө" гэх үгийн нэгийг хасах.

Тус хуулийн төслийн зарим зүйл, заалт нь бодлогын баримт бичгийн зүйл, заалт шиг хэт ерөнхий байдлаар тусгагдсан байна.

Түүнчлэн, энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 2.11. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн бүтэц, хэлбэр	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт; 28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5 Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Харилцан уялдаа хэсэгт төслийн зарим зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилтэй байгааг судлан үзсэн болно.
29.1.6 Хэм хэмжээ тогтоогдоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	

30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.2. Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Өмнөх хүснэгтэд төслийн зарим зүйл, заалт нуршуу, тодорхойгүй, найруулга зүйн алдаатай байдлыг судлан үзсэн.
30.1.4. Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "... бүрэн хянах.." гэсний "бүрэн" гэх үг нь хүч оруулсан утгатай байна. Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "... бүх үйл ажиллагааг..." гэсний "бүх" гэх үг нь хүч оруулсан утгатай байна. Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "... зөвхөн мөн хуулийн..." гэсний "зөвхөн" гэх үг нь хүч оруулсан утгатай байна. Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "зөвхөн хүн, мал, амьтанд..." гэсний "зөвхөн" гэх үг нь хүч оруулсан утгатай байна. Хуулийн төслийн хэд хэдэн зүйл, заалтад "зөвхөн" гэх үгийг ашигласан байх бөгөөд зарим зүйл, заалтын хувьд "зөвхөн" гэх үгийг ашиглах шаардлагагүй байгааг анхааран үзэх нь зүйтэй.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тухайн хууль тогтоомжийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуй, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалт байх тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 8 дугаар зүйл, 50-55 дугаар зүйл, 56-61 дүгээр зүйл, 62-66 дугаар зүйл, 67-70 дугаар зүйлд дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллын зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний утгвар бодисын ангиллыг тодорхойлсон нь өмнөх хуульд байгаагүй шинээр тусгасан зохицуулалт байна. Тус төслөөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний утгвар бодисын ангиллыг дараах байдлаар авч үзжээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хүний эрүүл мэндэд үзүүлэх хор уршиг, урвуулан хэрэглэх эрсдэл, урвуулан хэрэглэсний улмаас бие болон сэтгэцийн хамаарал үүсгэх сөрөг нөлөө, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэгцээтэй байдал, үндэсний аюулгүй байдалд үзүүлж болзошгүй эрсдэл зэргийг харгалзан дараах байдлаар ангилсан.

Хүснэгт 2.12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал

“А” ангилал	“А” ангиллын бодист Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах, хэрэглэхийг хориглосон, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглаж, хэрэглэдэггүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хамаарна.
“Б” ангилал	“Б” ангиллын бодист хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хяналттайгаар ашиглаж, хэрэглэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хамаарна.
“В” ангилал	“В” ангиллын бодист энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан ангилалд хамаарах бодис агуулаагүй боловч тухайн бодисыг урвуулан хэрэглэснээр мансууруулах, сэтгэцэд нөлөө үзүүлэх эрсдэлтэй эм, бодис хамаарна.
“Г” ангилал	“Г” ангиллын бодист мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын угтвар бодис хамаарна.
“Д” ангилал	“Д” ангиллын бодист мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамал хамаарна.

Ийнхүү ангиллыг зохицуулсан нь тухайн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой зохицуулалт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нөлөөтэй байхаас гадна Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зохицуулалтын хувьд ач холбогдолтой. Тус хуулийн төслийн дагалдан гарах хуулийн төсөлд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл багтсан ба холбогдох гэмт хэргийн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллыг тусгажээ.

Хүснэгт 2.13. ЭХНӨОтХ-ийн төсөл дэх холбогдох гэмт хэргийн зохицуулалтад тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал

Эрүүгийн хуульд нэмж буй гэмт хэрэг	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллын талаар зохицуулалт
20.19 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авахаар захиалах, худалдан авах	2.5.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 хүртэл килограмм хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг захиалсан, худалдан авсан; 3.Энэ зүйлд заасан гэмт хэргийг: 3.3.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 грамм болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 килограмм болон түүнээс дээш хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг захиалсан, худалдан авсан;
20.20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад дамжуулах, зуучлах	2.5.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 хүртэл килограмм хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг дамжуулсан, зуучилсан; 3.Энэ зүйлд заасан гэмт хэргийг: 3.3.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 грамм болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 килограмм болон түүнээс дээш хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг дамжуулсан, зуучилсан;

20.21 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад өгөх, хэрэглэх, хэрэглүүлэх	2.5.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 хүртэл килограмм хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг бусдад өгсөн, эсхүл бусдад хэрэглэсэн, хэрэглүүлсэн; 3.Энэ зүйлд заасан гэмт хэргийг: 3.4.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 грамм болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 килограмм болон түүнээс дээш хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг бусдад өгсөн, эсхүл бусдад хэрэглэсэн, хэрэглүүлсэн;
20.27 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэх, тээвэрлэх, илгээх, хадгалах	2.5.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 хүртэл килограмм хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэсэн, тээвэрлэсэн, илгээсэн, хадгалсан; 3.Энэ зүйлд заасан гэмт хэргийг: 3.4.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 грамм болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 килограмм болон түүнээс дээш хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэсэн, тээвэрлэсэн, илгээсэн, хадгалсан;
20.28 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах	2.4.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 хүртэл килограмм хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдсан; 3.4.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 грамм болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 килограмм болон түүнээс дээш хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдсан;
20.30 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх	2.4.Засгийн газраас баталсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 хүртэл грамм, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 хүртэл килограмм хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн; 3.3.Засгийн газраас баталсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 10 грамм болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон 1 килограмм болон түүнээс дээш хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн;
20.31 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэх	2.5.Засгийн газраас баталсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 1 хүртэл килограмм, эсхүл “Б” жагсаалтад орсон 5 хүртэл килограмм хэмжээтэй бодисыг хууль бусаар үйлдвэрлэсэн; 3.4.Засгийн газраас баталсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын “А” жагсаалтад орсон 1 килограмм болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл “Б” жагсаалтад орсон 5 килограмм болон түүнээс дээш хэмжээтэй бодисыг хууль бусаар үйлдвэрлэсэн бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээрх байдлаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллыг тухайлан зохицуулж, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зохицуулалт тусгаж байгаа нь олон улсын сайн жишгийг дагасан боловсронгуй зохицуулалт юм.

Хуулийн төслийн 50-55 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 50-55 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх зохицуулалтыг дараах байдлаар зохицуулсан.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг газар дээр нь буюу зөөврийн техник, хэрэгсэл, тандагч ашиглан шалгах;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах магадлан шинжилгээ;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах дахин шинжилгээ;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист магадлан шинжилгээ, дахин шинжилгээ хийх эрх бүхий байгууллага.

Одоогийн эрх зүйн зохицуулалт буюу 2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, шинжилгээ хийх зохицуулалтыг тусгаагүй бөгөөд журмаар зохицуулж байсан. Тодруулбал, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/227 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Химийн шинжилгээ хийх журам”-ын 3 дугаар зүйлд дараах байдлаар тусгасан.

- Спиртийн агууламж тодорхойлох шинжилгээ хийх биологийн дээж (цус, шээс, ходоодны шингэн) 4 мл-ээс дээш хэмжээтэй;
- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох шинжилгээ хийхэд цус 10 мл-ээс дээш хэмжээтэй, шээс 40 мл-ээс дээш хэмжээтэй;
- Үсний дээжийг толгойны ар тал буюу дагзны хэсгээс шаардлага хангахуйцаар 2 хэсэг газраас (А, В сорьц) авсан;
- Үсний дээжийг шинжилгээнд авахаас өмнө дагалдах хуудсыг асуулт тус бүрээр гаргацтай бичиж ирүүлсэн;
- Хумсны дээж авахдаа баруун гарын бүх хурууны хумсыг 1 уутанд, зүүн гарын бүх хурууны хумсыг 1 уутанд тус бүр хийж, гаргацтай хаяглан ирүүлсэн;
- Шинжилгээ хийхэд зориулж авсан дээжийг хаяглахдаа он, сар, өдөр, цаг, минутыг гаргацтай бичсэн;
- Шинжилгээний дээжийг 1 удаагийн лац ашиглан битүүмжлэн ирүүлсэн.

Ийнхүү журмаар зохицуулсан байсныг хуульд тусгаж зохицуулж байгаа нь Үндсэн хуулийн 16.13 дугаар зүйлд заасан хүний халдашгүй байх эрхийг бэхжүүлэх ач холбогдолтой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж тусгасан ба Монгол Улсын иргэн дээрх эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхээр хуульчилсан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж төрөөс тус эрхийг баталгаажуулах талаар тусгасан.

Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хэн боловч дур мэдэн халдаж болохгүй туйлын эрх¹⁰. Нэгэнт хүн бүр эрх зүйн этгээд байхын дээр Монгол Улсын төртэй харилцан эрх эдэлж, үүрэг хүлээх байдлаар эрх зүйн харилцаанд оролцох ёстой болсон учраас Үндсэн хуульд тусгагдсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх ёстой¹¹.

Мөн түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9 дүгээр зүйлд “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй. Баривчлагдсан шалтгааныг хүн бүрд баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ. Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно. Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй. Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.” гэж тус эрхийг баталгаажуулсан байдаг.

Үндсэн хуулиар хамгаалсан туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлахад наад зах нь дараах зургаан гол нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хууль тавьдаг: (1) хүний эрхэд тавьж буй аливаа хязгаарлалтыг хуульд тодорхой заах; (2) хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байх; (3) хязгаарлалт нь эдгээр зорилгын нэгэнд хүрэхэд зайлшгүй, тохирсон байх (proportionality); (4) үндсэн эрхийг аль болох эдлүүлэх; (5) ялгаварлан гадуурхахгүй байх; (6) хараат бус шүүхээр

10 Г.Совд, Монгол улсын Үндсэн хууль, хүний эрх /Харьцуулсан эрх зүй/, (УБ, 1999), 51 дэх тал.

11 Г.Эрдэнэбат, Хүний халдашгүй эрх, (УБ, 2002), 9 дэх тал.

хянагддаг байх. Иймд, үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь эдгээр зургаан нөхцөлийг аль нэгийг хангаагүй бол уул эрхийн зөрчил болно.¹²

Хуулийн төслийн 56-61 дүгээр зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээний зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 56-61 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээний зохицуулалтыг дараах байдлаар зохицуулсан.

- Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Шинжилгээ-оношилгоо;
- Биеийн болон сэтгэл заслын эмчилгээний тусламж, үйлчилгээ;
- Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ;
- Тусгай төв;
- Нийгмийн хамгааллын нөхөн сэргээх арга хэмжээ.

2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлд мансуурах донтой этгээдийг эмчлэх зохицуулалт одоогийн эрх зүйн орчинд үйлчилж байна. Тус зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй, практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна. /Тус зохицуулалтын практикт хэрэгжилтийн талаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайлангийн “3.6.2. Практикт нийцсэн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн үнэлгээг үзнэ үү./

Харин хууль, эрх зүйн зохицуулалтын хувьд одоогийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Мансуурах донтой этгээд сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргавал ердийн журмаар эмчилнэ” гэж, мөн зүйлийн 12.2-т “Мансуурах донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилнэ” гэж тус тус заасан.

Тус зохицуулалтын хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй үнэлгээг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайлангийн “3.6.1. Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн үнэлгээнээс үзнэ үү.

Дээрх судалгааны тайлангаас үзвэл, манай улсын хувьд мансуурах донтой этгээд сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргавал ердийн журмаар эмчилнэ гэсэн хуулийн зохицуулалт практикт хангалттай хэрэгждэггүй байна.

Харин тус хуулийн төслийн зохицуулалтаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх үйл ажиллагааг өмнөх хуультай харьцуулахад нарийвчлан зохицуулсан нь илүү үр дүнтэй байж болох юм. Түүнчлэн одоогийн зохицуулалтад үүсээд буй эрүүл

12 О.Мөнхсайхан, “Монгол улсын үндсэн хууль: туйлын эрхээс бусад үндсэн эрхийн хязгаарлалтад тавих гол нөхцөл” эрдэм шинжилгээний өгүүлэл, (2021), 1 дэх тал.

мэндийн байгууллагын хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэж, харилцан уялдаатай ажиллах нөхцөл байдлыг хангах нь зүйтэй.

Хуулийн төслийн 62-66 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ
--

Хуулийн төслийн 62-66 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалтыг дараах байдлаар авч үзсэн.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сан;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн төрөл;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн мэдээллийн сан;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн мэдээллийн сан;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж мансуурсан болон хамааралтай хүнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан.

Одоогийн 2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн талаар зохицуулалт тусгагдаагүй. Гэсэн хэдий ч Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-т энэ талаар тодорхойлсон.

Тодруулбал, тус хөтөлбөрийн 3 дугаар зорилтын 1 дэх үйл ажиллагааг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, хөтөлбөрийг сурталчлах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” гэж тодорхойлсон.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас үзвэл 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдөр “Олон улсын мансуурлын эсрэг тэмцэх өдөр”-ийн хүрээнд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан цахим хэлбэрээр арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан. Тухайлбал; Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний улмаас хүний бие, эд эрхтэнд учрах хор уршгийн талаар 3 зурагт хуудас, байгууллагын үйл ажиллагаа, шинэ бүтэц орон тоог сурталчилсан агуулгатай 13 зурагт хуудас, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон эцэг, эх, асран хамгаалагч нарт зориулсан зөвлөмж бүхий 2 видео шторкийг бэлтгэн цахим хуудсаар түгээжээ.

Мөн 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 25-ны өдрүүдэд ГЕГ-ын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газартай хамтран Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр, Цагаан хад дахь гаалийн хяналтын бүсэд хяналт шалгалт явуулж, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ухуулга, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд арга хэмжээний хүрээнд улсын хилээр нэвтэрч байгаа хүнд даацын 700 тээврийн хэрэгслүүдэд гаалийн байгууллагатай хамтарсан гэнэтийн үзлэг шалгалтыг албаны нохой, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илүүлэх багажийн тусламжтайгаар явуулж, жолооч нарт “Мими” гэх бодисын хор уршиг,

хууль эрх зүйн мэдээлэл агуулсан 1200 тараах материалыг өгч, Хүнсний мухлаг, дэлгүүр, байгууллага аж ахуй, нэгжийн орох гарах хэсэг, ШТС, хяналтын пост зэрэг газруудад байршуулсан байна.

Ийнхүү мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, хөтөлбөрийг сурталчлах тодорхой хэмжээний арга хэмжээ хийгдсэн боловч мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэнтэй холбоотой нэмэлт мэдээлэл тусгагдаагүй байна. Цаашид мэдээллийн нэгдсэн сан бий болгоход анхаарах шаардлагатай.¹³

Түүнчлэн тус хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын 1 дэх үйл ажиллагааг “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага хооронд ашиглах мэдээллийн нэгдсэн сан бий болгох” гэж тодорхойлсон.

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт тухайн байдлаар тодорхойлсон. Цагдаа, тагнуул, хил, гааль, шүүхийн шийдвэр биелүүлэх, эрүүл мэндийн байгууллага зэрэг чиг үүргийн байгууллагууд хооронд гэмт хэрэг, зөрчлийн болон сэжигтэй этгээд /хэрэглэгч, донтогч, тээвэрлэгч, зохион байгуулагч, хорих болон хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн г.м/ бүлэг, бөөгнөрөл, байр байгууламжийн талаар мэдээ, мэдээллийг шуурхай солилцох, мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглуулах зорилгоор 9 байгууллагаас шаардлагатай 24 мэдээлэл, судалгааг нэгтгэж, 12 дэд сан бүрдүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/27 дугаар тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-ээс Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн нэгдсэн санг боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулж, зөвлөмжийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан арга хэмжээний хүрээнд энэ ажлыг тэвчиж болох зардал гэж үзэн санхүүжилтийг Сангийн яамнаас буцаан татсаны улмаас зохион байгуулаагүй.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад байгууллага бүр өөрийн ашигладаг тодорхой мэдээллийн сантай боловч хууль хүчний байгууллага бүрийг хамарсан нэгдсэн мэдээллийн сан байхгүй байна.

Нэгдсэн мэдээллийн сантай болох ажил хийгдэх үндэс тавигдсан боловч нийгэм эдийн засгийн хүнд байдалтай холбоотой хэрэгжээгүй тул дээрх үйл ажиллагааг “эрчимжүүлэх шаардлагатай” хэмээн үзэж байна.¹⁴

Дээрхээс дүгнэвэл, хуулийн төсөлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалтыг тусгаж байгаа нь одоогийн

13 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, “Эс Ай Си Эй” ХХК, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ”, (УБ, 2023), 38-39 дэх тал.

14 Мөн тэнд, 48-49 дэх тал.

нөхцөл байдалд тохирсон, бодлогын баримт бичигт нийцсэн, үр дүнтэй зохицуулалт байгаа боловч урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, сурталчлах үйл ажиллагааг мөн мэдээллийн санд оруулах талаар анхаарч авч үзэх шаардлагатай.

Хуулийн төслийн 67-70 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах гэмт хэрэг, зөрчил үйлдэж, ял, шийтгэл хүлээсэн этгээдэд хяналт тавих зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 67-70 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах зохицуулалтуудыг тусгасан.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил үйлдэж, ял, шийтгэл хүлээсэн этгээдэд хяналт тавих;
- Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг цуцалж, албадан гаргах.

Үүнтэй холбоотойгоор одоогийн нөхцөл байдал болон хууль, эрх зүйн тулгамдаж буй асуудлыг авч үзье.

Нөхцөл байдал:

Хүснэгт 2.14. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн гаралт (2018-2023)¹⁵

Нутаг дэвсгэр	2018	2019	2020	2021	2022	2023
Нийслэл	150	201	178	145	204	204
Орон нутаг	45	56	24	42	25	34
Улсын хэмжээнд	195	257	202	187	229	238

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 2023 онд улсын хэмжээнд 238 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлийн хэмжээнд 204 буюу 85.7 хувь, орон нутгийн хэмжээнд 34 буюу 14.3 хувь нь бүртгэгдсэн байна.

Хүснэгт 2.15. Гэмт хэрэгт холбогдсон хүний хүйс (2018-2023)

Хүйс	2018	2019	2020	2021	2022	2023
Эмэгтэй	31	25	15	13	25	28
Эрэгтэй	222	291	254	197	213	192
Нийт	253	316	269	210	238	220

2023 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хүний хүйсийн байдлаар судлан үзвэл, 192 буюу 87.3 хувийг эрэгтэй, 28 буюу 12.7 хувийг эмэгтэй хүн эзэлж байна. Тус гэмт хэрэгт өсвөр насны

15 Цагдаагийн байгууллагын тоон мэдээ.

6 хүн холбогдсон байна. Өмнөх онтой харьцуулахад нийт гэмт хэрэг үйлдсэн хүн 18 буюу 7.6 хувиар, эрэгтэй хүн 21 буюу 9.9 хувиар тус тус буурсан бол эмэгтэй хүн 3 буюу 12 хувиар өссөн байна.

Хүснэгт 2.16. Гэмт хэрэгт холбогдсон хүний нас (2018-2023)

Нас	2018	2019	2020	2021	2022	2023
14-15 нас	4	1	1	0	2	3
16-17 нас	16	23	14	7	4	3
18-24 нас	117	148	156	98	108	71
25-29 нас	46	72	45	52	64	61
30-34 нас	40	45	36	35	37	40
35-39 нас	15	18	8	6	13	25
40-44 нас	12	6	6	8	8	13
45-49 нас	3	1	1	3	2	3
50-54 нас	0	1	0	1	0	0
55-59 нас	0	0	2	0	0	0
60-64 нас	0	1	0	0	0	1

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүний насны байдлыг судлан үзвэл, 2023 онд 14-15 насныхан 3 буюу 1.4 хувийг, 16-17 насныхан 3 буюу 1.4 хувийг, 18-24 насны хүн 71 буюу 32.2 хувийг, 25-29 насны хүн 61 буюу 27.7 хувийг, 30-34 насны хүн 40 буюу 18.2 хувийг, 35-39 насны хүн 25 буюу 11.4 хувийг, 40-44 насны хүн 13 буюу 5.9 хувийг, 45-49 насны хүн 3 буюу 1.4 хувийг, 60-64 насны хүн 1 буюу 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.17. ЭХАШШ-ээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хянан шийдвэрлэсэн хэрэг (2018-2023)¹⁶

Зүйл, заалт	2018	2019	2020	2021	2022	2023	Нийт
Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйл	Шийдвэрлэсэн хэрэг	128	170	192	147	177	990
	Ял шийтгүүлсэн хүн	104	154	211	186	241	1091
Эрүүгийн хуулийн 20.8 дугаар зүйл	Шийдвэрлэсэн хэрэг	1	0	0	0	1	2
	Ял шийтгүүлсэн хүн	1	0	0	0	1	2
Эрүүгийн хуулийн 20.9 дүгээр зүйл	Шийдвэрлэсэн хэрэг	2	0	0	0	1	3
	Ял шийтгүүлсэн хүн	2	0	0	0	1	3
Эрүүгийн хуулийн 20.10 дугаар зүйл	Шийдвэрлэсэн хэрэг	1	1	0	1	0	3
	Ял шийтгүүлсэн хүн	1	2	0	2	0	5

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2018-2023 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой нийт 998 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэрэг 990 буюу 99.2 хувийг эзэлж байна.

Харин Эрүүгийн хуулийн 20.8 дугаар зүйлд заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах”, Эрүүгийн хуулийн 20.9 дүгээр зүйлд заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших”, Эрүүгийн хуулийн

20.10 дугаар зүйлд заасан “Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах” гэмт хэргийн нийт 8 буюу 0.8 хувийг эзэлж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хэрэгт нийт 1101 хүн ял шийтгүүлснээс Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэрэгт 99.1 хувь буюу 1091 хүн ял шийтгүүлсэн бол Эрүүгийн хуулийн 20.8-20.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт 0.9 хувь буюу 10 хүн ял шийтгүүлсэн байна.

Хүснэгт 2.18. ЭХАШШ-ээр ял шийтгүүлсэн хүн (2018-2023)

Он	Ял шийтгүүлсэн хүн	Үүнээс		
		Эмэгтэй	Өсвөр насны хүн	Урьд ял шийтгүүлсэн хүн
2018	108	12	3	27
2019	156	12	9	46
2020	211	13	14	66
2021	188	5	4	40
2022	243	20	3	68
2023	195	19	3	59

2019-2023 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт нийт 993 хүн ял шийтгүүлсэн байна. Үүнээс 2019 онд хамгийн бага буюу 156 хүн ял шийтгүүлснээс 12 буюу 7.6 хувь нь эмэгтэй, 9 буюу 5.7 хувь нь өсвөр насны хүн, 46 буюу 29.5 хувь нь урьд ял шийтгүүлсэн хүн байна. Харин 2022 онд энэ төрлийн гэмт хэрэгт хамгийн их буюу 243 хүн ял шийтгүүлснээс 20 буюу 8.2 хувь нь эмэгтэй, 3 буюу 1.2 хувь нь өсвөр насны хүн, 68 буюу 28 хувь нь урьд ял шийтгэл эдэлж байсан.

Харин 2023 онд энэ төрлийн гэмт хэрэгт нийт 195 хүн ял шийтгүүлсэн байна. Үүнээс 19 буюу 9.7 хувь нь эмэгтэй, 3 буюу 1.5 хувь нь өсвөр насны хүн, 59 буюу 30.2 хувь нь урьд ял шийтгүүлсэн хүн байна.

Хүснэгт 2.19. ЭХАШШ-ээр ял шийтгүүлсэн хүний насны байдал (2018-2023)

Нас	2018	2019	2020	2021	2022	2023
14-15 нас	1	0	1	0	0	1
16-17 нас	2	9	12	4	3	2
18-21 нас	24	41	45	41	38	24
22-29 нас	42	66	87	77	114	89
30-34 нас	25	25	44	53	59	42
35 ба түүнээс дээш	14	15	22	13	29	37
Нийт	108	156	211	188	243	195

2018-2023 онд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүмүүсийн дийлэнх нь 18-34 насны хүн байна.

Хүснэгт 2.20. ЭХАШШ-ээр ял шийтгүүлсэн хүний ялын төрөл (2018-2023)

Он	Торгох	НТАХ	Зорчих эрхийг хязгаарлах	Хорих	Нийт
2018	1	0	0	107	108
2019	2	0	0	154	156
2020	0	1	0	210	211
2021	2	1	61	124	188
2022	1	0	71	171	243
2023	0	0	68	127	195
Нийт	6	2	200	893	1101

2018-2023 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс энэ төрлийн гэмт хэрэгт нийт 1101 хүнд ял оногдуулсан байна. Үүнээс 893 хүн буюу 81.1 хувьд хорих ял, 200 буюу 18.2 хувьд зорчих эрхийг хязгаарлах ял, 6 буюу 0.5 хувьд торгох ял, 2 буюу 0.2 хувьд нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан байна. 2018 онд 107 хүн буюу 99.1 хувьд, 2019 онд 154 хүн буюу 98.7 хувьд, 2020 онд 210 хүн буюу 99.5 хувьд, 2021 онд 124 хүн буюу 66 хувьд, 2022 онд 171 хүн буюу 70.4 хувьд, 2023 онд 127 буюу 65.1 хувьд нь хорих ял оногдуулсан байна. Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хүнд хорих төрлийн ялыг хамгийн их оногдуулсан байна.

Харин 2021-2023 оны хувьд хорих ялаас гадна зорчих эрх хязгаарлах ялыг ихэвчлэн оногдуулсан байна. Тодруулбал 2021 онд 61 буюу 32.4 хувьд, 2022 онд 71 буюу 29.2 хувьд зорчих эрх хязгаарлах, 2023 онд 68 буюу 35 хувьд зорчих эрх хязгаарлах ял оногдуулсан байна.

Хууль, эрх зүйн зохицуулалтын асуудал:

2002 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгааны зохицуулалтыг тусгажээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар болон Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг зэрэг бусад төрийн болон төрийн бус байгууллагууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Гэвч энэ төрлийн асуудал эрхэлсэн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох байдал дутмаг байна.¹⁷

Тус хуулийн дээрх зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайлангийн “3.8.1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа” хэсгээс үзнэ үү.

¹⁷ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” ХЗҮХ, (УБ, 2024).

Энэхүү судалгааны үр дүнгээс үзвэл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа хангалтгүй байна.

Иймд энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудад тасралтгүй шинэчлэл, сайжруулалт хийх шаардлагатай. Мөн энэ төрлийн сургалтад хамрагдсан, туршлагатай мэргэжлийн боловсон хүчин тогтвортой байх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй юм. Хуулийн төслийн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны талаар нарийвчлан зохицуулсан нь дээрх асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй зохицуулалт болсон байна. Түүнчлэн тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүний хөрөнгө, орлогыг хураах, ял, шийтгэлийн дараа хяналт тавих, гадаад улсын холбогдогчийг албадан гаргах зэрэг урьдчилан сэргийлэхэд үр нөлөө бүхий зохицуулалтуудыг тусгасан байна.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж хуулийн төслийн үр нөлөөг үнэлснээр хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж, тухайн хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулна. Энэ хүрээнд хуулийн төслийн холбогдох зохицуулалтуудад дүн шинжилгээ хийнэ.

Хүснэгт 2.21. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн төслийн зорилготой нийцэж байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн нэр нь хуулийн төсөл хийгээд төслийн үзэл баримтлалын агуулгатай нийцэж байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөлд “мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис” гэж мөн “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж нэг нэр томъёог ялгамжтай байдлаар бичжээ.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслийн 7 дугаар бүлэгт заасан зарим зүйл, заалтад төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг ижил байна. Үүнийг нягтлан үзэх шаардлагатай.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөлд Зөвшөөрлийн тухай хуультай холбогдох зүйл, заалтыг тусгасан байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгасан байна.

Дээрх хуулийн төслийн дагалдах хуулийн төслөөс харвал, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2-т 20.18-20.31 дүгээр зүйлийг нэмэхээр тусгасан бөгөөд төслийн 2 дугаар зүйлд 20.32 /Шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах/ гэж өөрчлөхөөс тусгасан байна. Өөрөөр хэлбэл, ЭХНӨОТХ-ийн төсөлд 20.32 дугаар зүйлийг нэмэхээр тусгаагүй хэр нь төслийн 2 дугаар зүйлд тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

Мөн ЭХНӨОТХ-ийн төслийн 1 дүгээр зүйлийн 2-т “20.19 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авахаар захиалах, худалдан авах” гэж тусгасан боловч 2 дугаар зүйлд “20.19 /Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авахаар захиалах, худалдан авах/ гэж ялгаатай байдлаар тусгажээ. ЭХНӨОТХ-ийн төслийн 1, 2 дугаар зүйлд ялгамжтай байдлаар тусгагдсан зүйл, заалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.22. Нэг нэр томъёог ялгаатай байдлаар тусгасан байдал

1	ЭХНӨОТХ-ийн төслийн 1 дүгээр зүйл	ЭХНӨОТХ-ийн төслийн 2 дугаар зүйл
2	20.19 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авахаар захиалах, худалдан авах	20.19/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авахаар захиалах, худалдан авах/
3	20.20 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад дамжуулах, зуучлах	20.20/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад дамжуулах, зуучлах/
4	20.21 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад өгөх, хэрэглэх, хэрэглүүлэх	20.21/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад хэрэглэх, бусдад өгөх, бусдад хэрэглүүлэх/
5	20.27 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэх, тээвэрлэх, илгээх, хадгалах	20.27/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэх, тээвэрлэх, илгээх, хадгалах/
6	20.28 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах	20.28/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах
7	20.29 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний угтвар бодис хууль бусаар авах	20.29 /Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар авах

Дээрх хүснэгтээс харвал, нийтлэг байдлаар ЭХНӨОтХ-ийн төслийн 1 дүгээр зүйлд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис...” гэж бичсэн бол төслийн 2 дугаар зүйлд ижил зүйлийн нэрийг “мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис...” гэж бичжээ. Өөрөөр хэлбэл, нэг гэмт хэргийн зүйлийн нэр нь өөр хоорондоо ялгаатай байдлаар бичигджээ. Мөн тус төслийн 20.21 дүгээр зүйлийг бичихдээ үгийн байрлалыг өөр хооронд нь сольсон, “бусдад” гэх үгийг давтаж бичсэн гэх мэт нийтлэг алдаа байгааг дурдах нь зүйтэй. Иймд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн дагалдах хуулийн төслүүдийг сайтар нягталж, өөр хооронд нь уялдаа холбоотой, ойлгомжтой байдлаар тусгах шаардлагатай.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгааны хүрээнд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ төслийн зохицуулалт, агуулга нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд дүн шинжилгээ хийсэн бөгөөд дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу зорилт хэсэг нь дээрх хуулийн төсөл батлагдсаны дараа бий болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагаврыг бүхэлд нь оновчтой байдлаар тусгасан буюу хуулийн зорилгод нийцэж байна. Мөн одоо хэрэгжиж буй хуулийн зорилтын уламжлалт шинж чанарыг агуулсан байна. Гэхдээ удмын санг хамгаалах талаар хуулийн зорилтод тусгах эсэхийг эргэн харах нь зүйтэй.

- Хуулийн төслийн бүлэг зохицуулалтууд нь хууль батлагдсаны дараа бий болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагаврыг бий болгохоор байгаа бөгөөд хуулиар зохицуулах харилцааг бүхэлд нь зохицуулсан байна.

- Хуулийн төслийн 5 дугаар зүйлд тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор төрөөс баримтлах бодлого нь “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-тэй нийцэж байна. Гэвч тухайн төрөөс баримтлах бодлогыг тодорхойлохдоо зарим бодлогыг нарийвчилж тодорхойлоогүй байна. Түүнчлэн хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг бүхэлд нь нарийвчлан тодорхойлсон төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох нь зүйтэй. Иймд төрөөс баримтлах бодлогыг өргөн хүрээнд тодорхойлж, нарийвчлан тусгах талаар анхаарах шаардлагатай.

- Хуулийн төслийн 9, 10 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд төрөөс тавих хяналтын зохицуулалт нь үр дүнтэй зохицуулалт хэдий ч эм, эмийн түүхий эд үйлдвэрлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах талаар тусгахдаа шинэчилсэн стандартыг баримтлах нь зүйтэй байна.

2. Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төслийн 11-23 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн зохицуулалт нь хууль болон журмын уялдаагүй, тодорхойгүй, нэг мөр хэрэгжих боломжгүй байсныг нарийвчлан тодорхойлж, процессыг бүрэн тусгасан, тайлан гаргах, ил тод байдлыг хангаж байгаа нь ач холбогдолтой зохицуулалт болсон байна.

- Хуулийн төслийн 24-40 дүгээр зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагын зохицуулалт нь одоогийн эрх зүйн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах

шаардлагыг нэгдсэн байдлаар зохицуулж чадахгүй байгаа учир төрөл бүрээр нь тусгайлан зохицуулж, тавигдах шаардлагыг тусгасан одоогийн зохицуулалтаас илүү үр дүнтэй зохицуулалт байна.

- Хуулийн төслийн 41-49 дүгээр зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагын тогтолцооны зохицуулалт нь төрийн байгууллагын чиг үүргийг нарийвчлан зохицуулж одоо үүсээд буй хүндрэл бэрхшээлийг даван туулах гарц болохоор байна. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагуудыг өргөн хүрээнд тодорхойлж, хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан авч үзсэн нь ач холбогдолтой зохицуулалт байна.

3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Төслийн 3.1.8-д "... ашиглах, устгах, олж авах..." гэж, төслийн 3.1.9-д "... ашиглах, олж авах..." гэж тодорхойлсон нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд "устгах" үйлдэл хамаарахгүй байдлаар тусгасныг нягтлан үзэх шаардлагатай.
- Төслийн 3.1.21-д тус ойлголтыг ийнхүү тусгах шаардлагатай эсэхийг сайтар нягтлах.
- Төслийн 3 дугаар бүлэг нэг зүйлээс бүрдэж байх тул тус бүлгийг өөр бүлэгт нэгтгэн зохицуулах.
- Төслийн 6.1.8-д "...илүү хэмжээний..." гэснийг "... их хэмжээний..." гэж өөрчлөх.
- Төслийн 6.3-т "үр дүнтэй тэмцэж, урьдчилан сэргийлэх" гэх.
- Төслийн 7.1.4-т "сэтгээд" гэж алдаатай бичсэнийг "сэтгэцэд" гэж засах.
- Төслийн 9.1-д "хэрэглэх" гэх үгийг хоёр удаа бичсэний эхний үгийг хасах. Тус үгийг хассанаар тухайн зохицуулалтыг агуулгыг алдагдуулахгүй бөгөөд тухайн хэсэгт заасан "...бусад болон өөртөө хэрэглэх..." гэдэгт "хэрэглэх" гэх ойлголт нь хамаарч байна.
- Төслийн 11.3-т "...Энэ хуулийн 10.3-т зааснаас бусад тохиолдолд мөн хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэхийг хориглоно..." гэж хэт нуршуу, ойлгомжгүй байдлаар бичжээ. Иймд тус зохицуулалтыг өөрчлөн найруулах.
- Төслийн 12.2.9-д заасныг өөрчлөн найруулах. Тухайлбал, "дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн" гэснийг "олон улсын" гэж өөрчилж болох юм.
- Төслийн 13.1.6-д "... зүй бусаар хэрэглэдэг хүн бий эсэх..." гэж тусгажээ. Төслийн тус зохицуулалтад "хүн бий эсэх" гэснийг өөрчлөх. Тухайлбал, албан хаагч, ажилтан гэх мэт нэр томъёог ашиглаж болох юм.
- Төслийн 14.5-д "...цахим хэлбэрээр хариу өгнө..." гэснийг "цахимаар хариу өгнө" гэж өөрчлөх.
- Төслийн 24.5-д тайлангийн маягттай холбоотой зохицуулалт тусгагдаагүй учир төслийн 24.6-д заасныг дахин нягталж, засах нь зүйтэй.
- Төслийн 3.1.9-д "...1961 оны нэгдсэн конвенц..." гэж, төслийн 25.3-д "...1961 оны конвенцын 31 дүгээр зүйл..." гэж, төслийн 46.2-т "...1961 оны нэгдсэн конвенц..." гэж тус тус ялгамжтай байдлаар бичсэнийг нэг мөр болгох.

- Төслийн 25.7-д тайлангийн маягттай холбоотой зохицуулалт тусгагдаагүй учир төслийн 25.8-д заасныг дахин нягталж, засах нь зүйтэй.
- Төслийн 26.1-д заасан зохицуулалтын “бусад болон” гэснийг өөрчлөн, засаж сайжруулах.
- Төслийн 38.1-д заасан зохицуулалтад хоёр удаа “үндсэн дээр” гэж тусгасныг засах.
- Төслийн 55 дугаар зүйлийн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист магадлан шинжилгээ, дахин шинжилгээ хийх эрх бүхий байгууллага” гэснийг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист шинжилгээ хийх эрх бүхий байгууллага” гэж өөрчлөх.
- Төслийн 62.2.2-т заасан зохицуулалтыг өөрчлөн найруулах.
- Төслийн 64.1.3-т заасан зохицуулалтыг нарийвчлан тусгах.
- Төслийн 68 дугаар зүйлийг нягтлан, өөрчлөн найруулах.
- Төслийн 3.1.6, 46.1.12-т алдаа бичсэнийг үгийг засах. Зүй нь “...Нэгдсэн Үндэстний байгууллага...” гэх.
- Төслийн 3.1.6-д “... зөвлөмжид туссан...” гэснийг “...зөвлөмжид тусгасан...” гэж өөрчлөх.
- Төслийн 45 дугаар зүйлийн 45.1.7 дахь заалтыг 45.4.7 гэж буруу дугаарласныг засах.
- Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг 13.3.3 гэж буруу дугаарласныг засах.
- Төслийн 55.3-т “...импортлох тухай гэрээ...” гэснийг “гэрээ” гэж өөрчлөх.
- Төслийн 60.2.5-д заасан “...хүн ам дахь...” гэснийг “хүн амын” гэж өөрчлөх.
- Төслийн 61 дүгээр зүйлийн 61.2.5 дахь заалтын дараа 61.2.6 дахь заалтыг орхигдуулан 61.2.7 гэж дугаарласан байна. Иймд төслийн 61.2.7-61.2.9 дэх заалтыг 61.2.6-61.2.8 гэж өөрчлөх.
- Төслийн 67.3-т давхардуулан тусгасан “өмнө” гэх үгийн нэгийг хасах.
- Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “...бүрэн хянах...” гэсний “бүрэн” гэх үг нь хүч оруулсан утгатай байна. Иймд “бүрэн” гэх үгийг хасах.
- Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “...бүх үйл ажиллагааг...” гэсний “бүх” гэх үг нь хүч оруулсан утгатай байна. Иймд “бүх” гэх үгийг хасах.
- Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “...зөвхөн мөн хуулийн...”, төслийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “зөвхөн хүн, мал, амьтанд...” гэсний “зөвхөн” гэх үг нь хүч оруулсан утгатай байна. Энэ мэт хуулийн төслийн хэд хэдэн зүйл, заалтад “зөвхөн” гэх үгийг ашигласан байх бөгөөд зарим зүйл, заалтын хувьд “зөвхөн” гэх үгийг ашиглах шаардлагагүй байгааг анхааран үзэх нь зүйтэй.

4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төслийн 8 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллын зохицуулалт нь нарийвчлагдсан, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зохицуулалтад мөн тусаж байгаа зэргээр олон улсын сайн жишгийг дагасан боловсронгуй зохицуулалт байна.

- Хуулийн төслийн 50-55 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх зохицуулалт нь журмаар зохицуулсан байсныг хуульд тусгаж зохицуулж байгаагаараа Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т заасан хүний халдашгүй байх эрхийг бэхжүүлэхэд ач холбогдолтой байна.

- Хуулийн төслийн 56-61 дүгээр зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээний зохицуулалт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, магадлан шинжилгээ хийх үйл ажиллагааг одоогийн хуультай харьцуулахад бүрэн цогц байдлаар зохицуулсан нь үр дүнтэй байна. Түүнчлэн одоогийн зохицуулалтад үүсээд буй эрүүл мэндийн байгууллагын хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэж, харилцан уялдаатай ажиллах нөхцөл байдлыг хангах нь зүйтэй.

- Хуулийн төслийн 62-66 дугаар зүйл буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалт нь одоогийн нөхцөл байдалд тохирсон, бодлогын баримт бичигт нийцсэн, үр дүнтэй зохицуулалт байх нь тодорхойлогдож буй боловч урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, сурталчлах үйл ажиллагааг мөн мэдээллийн санд оруулах талаар анхаарч авч үзэх шаардлагатай.

- Хуулийн төслийн 67-70 дугаар зүйл нь төслийн зохицуулалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны талаар нарийвчлан зохицуулсан нь үүсээд буй асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй зохицуулалт болсон байна. Түүнчлэн тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүний хөрөнгө, орлогыг хураах, ял, шийтгэлийн дараа хяналт тавих, гадаад улсын холбогдогчийг албадан гаргах зэрэг урьдчилан сэргийлэхэд үр нөлөө бүхий зохицуулалтуудыг тусгасан байна.

5.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төсөлд 17 удаа “мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм” гэж, 66 удаа “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис” гэж нэг ойлголтыг хоёр өөр байдлаар тусгажээ. Иймд тус нэр томьёог нэг мөр болгох.

- Хуулийн төсөлд 2 удаа “гадаад улс, орны” гэж, 20 удаа “гадаад улс” гэх нэр томьёог ашигласан байна. Дээрх ойлголт нь ижил утгатай. Иймд тус нэр томьёог нэг мөр болгох.

- Хуулийн төслийн 56.9-д “...хэрэг бүртгэл, мөрдөн байцаах ажиллагаа...” гэх нэр томьёог тусгажээ. ЭХХШТХ-д “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа” гэж хуульчилсан байх тул тус хуультай нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй.

- Хуулийн төслийн 7 дугаар бүлэгт заасан зарим зүйл, заалтад төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг ижил байна. Үүнийг нягтлан үзэх шаардлагатай.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн дагалдах хуулийн төслүүдийг сайтар нягталж, өөр хооронд нь уялдаа холбоотой, ойлгомжтой байдлаар тусгах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992);
2. Төрийн мэдээлэл, тусгай дугаар IV боть, Монгол Улсын олон улсын гэрээ, (УБ, 2006);
3. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, (1961);
4. Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, (1971);
5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, (1988);
6. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, (2001);
7. Зөвшөөрлийн тухай хууль, (2022);
8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, (2002);
9. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, (1993);
10. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, (2018);
11. Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2015.02.24-ний өдрийн “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” 68 дугаар тушаал;
12. Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт;
13. Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт;
14. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам;
15. Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”
16. Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт;
17. Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар “Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тогтоол;
18. Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”;
19. Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”;
20. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/227 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Химийн шинжилгээ хийх журам”;
21. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, (2024);

22. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн товч танилцуулга, (2024);

Ном, өгүүлэл, нийтлэл, тайлан

Монгол хэлээр

1. Б.Болдбаатар, “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал”, *Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, (УБ, 2018);
2. Г.Совд, Монгол улсын Үндсэн хууль, хүний эрх /Харьцуулсан эрх зүй/, (УБ, 1999);
3. Г.Эрдэнэбат, Хүний халдашгүй эрх, (УБ, 2002);
4. ГХУСАЗЗын захиалгат үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа, (УБ, 2023), “Эс Ай Си Эй” ХХК.
5. ИРИМ хараат бус судалгааны хүрээлэн, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих Үндэсний хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ, (УБ, 2019);
6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ /Судалгааны тайлан/, ХЗҮХ, 2024;
7. Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал, судалгааны тайлан, (УБ, 2013);
8. Монгол Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, (УБ, 2013);
9. О.Мөнхсайхан, “Монгол улсын үндсэн хууль: туйлын эрхээс бусад үндсэн эрхийн хязгаарлалтад тавих гол нөхцөл” эрдэм шинжилгээний өгүүлэл, (2021);
10. С.Жанцан, Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудал, илтгэл, (УБ, 2012);
11. ХЗҮХ-ийн судалгааны тайлан, <https://nli.gov.mn/pdf/dontoh.pdf>
12. Цагдаагийн байгууллагын тоон мэдээ
13. Шүүн таслах ажиллагааны тоон мэдээ

ГУРАВ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН
ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Р.Хатансайхан

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

С.Нарантунгалаг

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2024.05.29.

	АГУУЛГА	
УДИРТГАЛ		173
I. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО		174
1.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох.		177
1.2. Үндэсний хороонд үүсэх зардлын тооцоо		181
1.3. Хар тамхитай тэмцэх алба		186
1.4. Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч		193
1.5. Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан		198
II. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО		204
2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох		204
2.2. Зардал тооцох		216
2.3. Тоон үзүүлэлтийг тооцох		221
2.4. Зардлын дүнг тооцож гаргах		224
2.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах		229
2.6. Нэмэлт зардлыг тооцох		229
ДҮГНЭЛТ, САНАЛ		230

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.3.4-т “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ” гэж Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан. Үүний дагуу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан тооцож, судалгаа хийх шаардлага үүссэн байна. Иймд энэхүү судалгаагаар тус хуулийн төслийн зардлын тооцоог хийсэн болно.

Энэхүү судалгааны зорилго нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, хялбарчлах болон бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд чиглэгдэнэ.

Тус хуулийн төсөлд иргэнд шинээр болон нэмэлт зардал үүсгээгүй байх тул энэхүү зардлын тооцооны судалгааг дараах үндсэн бүтцийн дагуу гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрийн байгууллагын зардлын тооцоо;
2. Хуулийн этгээдийн зардлын тооцоо;

Ингэхдээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар зохицуулагдаагүй буюу хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлтээр орсон эсхүл өөрчлөгдсөн чиг үүрэгтэй холбоотой зардлыг аргачлалын дагуу тооцоолов. Өөрөөр хэлбэл, өөрчлөгдөөгүй буюу өмнө нь байсан чиг үүрэгтэй холбогдох аливаа зардлыг тус судалгааны хүрээнд тооцоогүй болно.

Судалгааны үр дүнд үндэслэн, тус хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг тооцон, зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэж тайлан боловсруулав.

I. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 8.2.Энэ хуулийн 8.1-д заасан ангилал тус бүрд хамаарах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, угтвар бодисын жагсаалтыг Үндэсний хорооны саналыг үндэслэн Засгийн газар батална.
- 10.4.Энэ хуулийн 10.3-т заасан эрх бүхий байгууллагын жагсаалтыг Үндэсний хороо батална.
- 22.4.Энэ хуулийн 22.1, 22.2-т заасан тайлангийн маягтыг Үндэсний хороо батална.
- 24.6.Энэ хуулийн 24.5-д заасан тайлангийн маягтыг Үндэсний хороо батална.
- 25.8.Энэ хуулийн 25.7-д заасан тайлангийн маягтыг Үндэсний хороо батална.
- 26.6.Энэ хуулийн 26.5-д заасан мэдэгдлийн маягтыг Үндэсний хороо батална.
- 26.7.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг Монгол Улсын хилээр нэвтрүүлж болох хилийн боомтын жагсаалтыг Үндэсний хорооны саналыг үндэслэн Засгийн газар батална.
- 29.7.Энэ хуулийн 29.6.4-т заасан актын маягтыг Үндэсний хороо батална.
- 34.1.Эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглах төрийн байгууллагын жагсаалтыг Үндэсний хороо батална.
- 34.10.Эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал түүх, ашиглах тохиолдолд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг түүх хэмжээ, байршлыг Үндэсний хороо тогтооно.
- 40.2.Хар тамхитай тэмцэх алба жил бүрийн 6 дугаар сард мансууруулах сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлын ургалтад үзлэг хийж, устгах хэмжээ, байршлыг тогтооно.
- 35.2.Энэ хуулийн 35.1-д заасан үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

- 36.2.Энэ хуулийн 36.1-д заасан зорилгоор мал, амьтны эм ашиглах байгууллагын жагсаалтыг Үндэсний хорооны санал болгосноор Засгийн газар батална.
- 38.4.Энэ хуулийн 38.3-т заасан тайлангийн маягтыг Үндэсний хороо батална.
- 42.4.Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.
- 44.7.Галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурор, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
- 44.8.Хар тамхитай тэмцэх албаны албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, мэргэжлийн зэргийн, цолны, эрдмийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээг Засгийн газар тогтооно.
- 44.9.Хар тамхитай тэмцэх албаны мөрдөгч, гүйцэтгэх ажилтан тусгай ажиллагаанд оролцохдоо байгууллагын бэлгэ тэмдэг бүхий зориулалтын хувцас хэрэглэх бөгөөд уг хувцасны загварыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 50.3.Нийгэм-сэтгэл зүйн сорил авах, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах аргачлалыг Үндэсний хороо батална.
- 51.5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах, дээж авах, дээжийг хадгалах, шинжилгээнд хүргүүлэх журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 61.3.Энэ хуулийн 61.2-т заасан нийгмийн хамгааллын арга хэмжээний удирдамж, зааврыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 62.5.Мэдээллийн санд мэдээлэл оруулах хугацаа, маягт, журам, мэдээллийг мэдээллийн санд оруулах хэлбэр, шаардлага, цахимаар баримтжуулан хадгалах журмыг Үндэсний хороо батална.

Дор дурдсан чиг үүргийг бусад хууль, тогтоомжоор зохицуулагдсан гэсэн үндэслэлээр энэхүү зардлын тооцоонд оруулаагүй болно. Үүнд:

55.8.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист магадлан шинжилгээ хийхтэй холбогдох энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Шүүх шинжилгээний тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төсөлд, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах /Хүснэгт 1-д заасан/ дараах заалтууд байна. Үүнд:

Хүснэгт 3.1. Зардалд нөлөөлөх зүйл, заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл, заалт
42 дугаар зүйл.Үндэсний хороо, түүний чиг үүрэг 42.1.Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний хороо ажиллана.	42.8.7.энэ хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж, зөвлөмж, чиглэл өгөх; 42.8.9.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран ашиглах боломжтой дундын цахим мэдээллийн нэгдсэн санг байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих.
44 дүгээр зүйл.Хар тамхитай тэмцэх алба, түүний чиг үүрэг 44.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг соён гэгээрүүлэх, гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах чиг үүргийг Цагдаагийн төв байгууллагын даргын дэргэдэх Хар тамхитай тэмцэх алба хэрэгжүүлнэ.	44.4.1.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх; 44.4.2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах; 44.4.13.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт холбогдсон болон үйлдсэн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар тогтмол хэрэглэдэг, эмчилгээнд хамрагдсан этгээдийг бүртгэх, хяналт тавих; 44.4.14.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус хэрэглээний хор уршгийн талаар нэгдсэн мэдээг гаргах;
44.5.Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч хуульд заасан журмын дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	44.5.3.аж ахуйн нэгж, байгууллагын байранд нэвтрэн орох; 44.5.4.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банканд байгаа данс, гүйлгээг шалгах, түр зогсоох; 44.5.5.хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө битүүмжлэх; 44.5.6.албан тушаалтан, иргэнээс тайлбар гаргуулах, мэдүүлэг авах, түүнийг албадан ирүүлэх;
51 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах 51.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар хэрэглэсэн эсэхийг хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан шалгана.	51.2.1.газар дээр нь буюу зөөврийн техник хэрэгсэл, тандагч ашиглан шалгах; 51.2.2.магадлан шинжилгээ; 51.2.3.дахин шинжилгээ.

1.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

1. Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална.
Үүнд:
2. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
3. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;

Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 3.2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Үндэсний хороо	42.8.7.энэ хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж, зөвлөмж, чиглэл өгөх;	1. энэ хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах; 2. энэ хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж зөвлөмж өгөх; 3. энэ хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж чиглэл өгөх;
	42.8.9.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран ашиглах боломжтой дундын цахим мэдээллийн нэгдсэн санг байгуулах	1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран ашиглах боломжтой дундын цахим мэдээллийн нэгдсэн санг байгуулах,

Хар тамхитай тэмцэх алба	44.4.1.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;	1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах; 2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг бүртгэх;
	44.4.2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;	1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газарт үзлэг хийх; - Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг байлцуулах боломжгүй бол хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. ¹ - Үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн бол 3 хоногийн дотор эзэмшигчид, боломжгүй бол эзэмшигчийн оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ. ²
	44.4.13.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт холбогдсон болон үйлдсэн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар тогтмол хэрэглэдэг, эмчилгээнд хамрагдсан этгээдийг бүртгэх, хяналт тавих;	1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт холбогдсон болон үйлдсэн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх 1А.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн мэдээллийн сан - мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, захиргааны хэм хэмжээний акт; - олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн жагсаалт, зөвшөөрлийг олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон он, сар, өдөр, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, зөвшөөрөлд орсон өөрчлөлт; -энэ хуульд заасны дагуу ашиглах эрх бүхий байгууллагын мэдээлэл; -зөвшөөрөл эзэмшигч болон энэ хуульд заасан ашиглах эрх бүхий этгээдийн импортолсон, үйлдвэрлэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалж байгаа, устгасан, тээвэрлэсэн, экспортолсон, реэкспортолсон, бэлтгэсэн, зарцуулсан, эмнэлгээс үйлчилсэн, эмийн сангаас жороор олгосон, ашиглаж байгаа, ашигласан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, угтвар бодисын нэр, төрөл, гарал үүсэл, тоо, хэмжээ, огноо;

1 ЭХХШТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1.5 дахь заалт.

2 ЭХХШТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1.6 дахь заалт.

		-тусгай зөвшөөрөл эзэмшигч болон энэ хуульд заасны дагуу ашиглах эрх бүхий этгээдээс ирүүлсэн тайлан; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эмээр үйлчлэх эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн, байгууллага; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тэдгээрийг эзэмшиж, ашиглаж байгаа хуулийн этгээд; -.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм олгосон жор, жор олгосон эмч, эмнэлгийн байгууллага, өвчтөний нэр, хаяг, холбоо барих мэдээлэл, нас, хүйс, өвчний онош, олгосон эмийн нэр, төрөл, хэмжээ; -Монгол Улсын хилээр нэвтэрсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, бүртгэл; -Үндэсний хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл. 1Б.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн мэдээллийн сан -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчил үйлдэж ял, шийтгэл хүлээсэн хүн, хуулийн этгээд; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байсан, шалгагдаж байгаа хүн, хуулийн этгээд; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох гэмт хэрэгт гадаад улсад болон Монгол Улсад ял шийтгүүлж байсан, эсхүл шалгагдаж байгаа бөгөөд Монгол Улсад оршин суух хүсэлт гаргасан гадаадын болон харьяалалгүй хүний мэдээлэл; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох гэмт хэрэг, зөрчилд ял, шийтгэл эдэлж байгаа болон эдэлсэн, баривчлах шийтгэл хүлээж байгаа болон хүлээж байсан этгээдийн тоо мэдээ, хорих ял эдлүүлж байгаа хорих анги, байршил, дэглэмийн талаарх мэдээлэл -Монгол Улсад хууль бус эргэлтэд байгаа нь тогтоогдсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах тоног төхөөрөмжийн бүртгэл, төрлийн мэдээлэл; -Үндэсний хорооноос шаардлагатай гэж үзсэн мэдээлэл. 1В.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж мансуурсан болон хамааралтай хүнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай нь тогтоогдсон болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тогтмол хэрэглэдэг хүний бүртгэл мэдээлэл;
--	--	--

		-мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас гарах эмчилгээнд хамрагдсан болон эмчилгээний дараах хяналтад байгаа хүний бүртгэл, мэдээлэл; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж мансуурсан болон хамааралтай хүнд эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын жагсаалт, тэдгээрийн тайлан; -үндэсний хорооноос шаардлагатай гэж үзсэн мэдээлэл 2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар тогтмол хэрэглэдэг, эмчилгээнд хамрагдсан этгээдийг бүртгэх.
	44.4.14.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус хэрэглээний хор уршгийн талаар нэгдсэн мэдээг гаргах;	1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус хэрэглээний хор уршгийн талаар нэгдсэн мэдээг гаргах
Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч	44.5.3.аж ахуйн нэгж, байгууллагын байранд нэвтрэн орох;	1. аж ахуйн нэгж, байгууллагын байранд нэвтрэн орох³ - цагдаагийн алба хаагч бусдын орон байранд нэвтрэн орохдоо оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрлийг заавал авсан байна. -Оршин суугч, эзэмшигчийн эзгүйд орон байр, бусад газарт нэвтрэн орсон бол тэдгээрт даруй мэдэгдэх, боломжгүй бол 24 цагийн дотор мэдэгдэх арга хэмжээ авна. -Оршин суугч, эзэмшигчид мэдэгдэх боломжгүй бол түүний оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.
	44.5.4.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банканд байгаа данс, гүйлгээг шалгах, түр зогсоох;	1. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банканд байгаа данс, гүйлгээг шалгах; 2. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банканд байгаа данс, гүйлгээг түр зогсоох;
	44.5.5.хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө битүүмжлэх;	1. хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө битүүмжлэх;
	44.5.6.албан тушаалтан, иргэнээс тайлбар гаргуулах, мэдүүлэг авах, түүнийг албадан ирүүлэх;	1. Тайлбар гаргуулах 2. Мэдүүлэг авах
Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан	51.2.1.газар дээр нь буюу зөөврийн техник хэрэгсэл, тандагч ашиглан шалгах;	1.Газар дээр нь шинжилгээ авах 2.Эмчийн хяналт дор тухай бүр хөндлөнгийн гэрч байлцуулан, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулна 3.Хариуг шалгуулсан этгээдэд 24 цагийн дотор мэдэгдэх

	51.2.2. магадлан шинжилгээ;	1. Гомдлыг 3 хоногийн дотор хүлээн авах 2. А дээжийг магадлан шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад 3 хоногийн дотор хүргүүлэх 3. Хариуг шинжилгээ, хариуг шинжилгээ 5 хоногт хийж гүйцэтгэх 4. Шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн байгууллага, албан тушаалтанд 1 хоногийн дотор хүргүүлэх
	51.2.3. дахин шинжилгээ.	1. Б сорьцыг дахин шинжилгээ хийх хүсэлтийг хариу хүлээн авснаас 3 хоногийн дотор хүлээж авах. 2. Б сорьцыг хүлээж авснаас хойш 3 хоногийн дотор шинжилгээний байгууллагад шилжүүлэх 3. Магадлан шинжилгээний байгууллага дахин шинжилгээг 5 хоногийн дотор хийнэ. 4. Хариуг гарснаас хойш 1 хоногийн дотор Шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн байгууллагад хүргүүлнэ.

Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох хүрээнд, хуулийн төслийн дор дурдсан зарим зүйл, заалтыг зардлын тооцооноос хассан болно. Үүнд:

1. 43 дугаар зүйл. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг;
2. 45 дугаар зүйл. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг;
3. 46 дугаар зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг;
4. 47 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын чиг үүрэг;
5. 48 дугаар зүйл. Гаалийн байгууллагын чиг үүрэг;
6. 49 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын чиг үүрэгт хамаарах эрх зүйн хэм хэмжээ нь ерөнхий буюу зардлыг тооцох боломжгүй тул хассан болно.

1.2. Үндэсний хороонд үүсэх зардлын тооцоо

1.2.1. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.8.1-42.8.11-д Үндэсний хорооны бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд үүнээс 42 дугаар 42.8.7, 42.8.9-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх явцад зардал үүсэхээр байна. Тодруулбал хуулийн төслийн 42.8.7-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд 3 стандарт үйл ажиллагаа, 42.8.9-д бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд 1 стандарт үйл ажиллагаа шаардлагатай.

Хүснэгт 3.3. Үндэсний хорооны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах, зөвлөмж, чиглэл өгөх үйл ажиллагаатай холбоотой үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Үндэсний хороо	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах;	2,400	1	2,400
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж зөвлөмж өгөх;	2,400	1	2,400
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж чиглэл өгөх;	2,400	1	2,400
Нийт				7,200

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн зохицуулалтаас үзвэл Үндэсний хорооны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж зөвлөмж өгөх, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж чиглэл өгөх үйл ажиллагааны тохиолдлын тоо 1 байна.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1600 ажлын цаг буюу (1600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 3.4. Үндэсний хорооны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах, зөвлөмж, чиглэл өгөх үйл ажиллагаатай холбоотой төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)	Жилд шаардагдах ажлын цаг (Мин)	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)
Үндэсний хороо	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах;	2,400	96,000	0.025
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж зөвлөмж өгөх;	2,400	96,000	0.025
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцаж чиглэл өгөх;	2,400	96,000	0.025
Нийт				0.075

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.8.7, 42.8.9-д заасан Үндэсний хорооны чиг үүргийг хэрэгжүүлэхэд 7,200 минут зарцуулах буюу уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ 0.075 байна.

1.2.2. Гарэх зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцоходоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Үндэсний хорооны ажилтны цалинг “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 2 дугаар “Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ” хавсралтыг үндэслэж тогтоолоо. Үндэсний хорооны албан тушаалын ТЗ-7 зэрэглэл буюу үндсэн цалингийн хэмжээ нь 1,597,000 төгрөг байна.⁴

Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 2,136,400 төгрөг /үүнээс нийт суутгал болох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хасвал нэг сарын дундаж цалин 1,721,642 төгрөг/ байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 25,636,800 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 267,050 төгрөг буюу жилд 3,204,600 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар 28,841,400 төгрөг гэж тооцов.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 3.5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)	Нэг албан хаагчийн нэг жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал (Төгрөгөөр)
Үндэсний хорооны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэлтэй танилцах, зөвлөмж, чиглэл өгөх чиг үүргийн хүрээнд	0.075	28,841,400	2,163,105

1.2.3. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

4 Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)
ТЗ-1 2,329,000
ТЗ-2 2,218,000
ТЗ-3 2,093,000
ТЗ-4 1,974,000
ТЗ-5 1,862,000
ТЗ-6 1,757,000
ТЗ-7 1,597,000
ТЗ-8 1,452,000
ТЗ-9 1,200,000
ТЗ-10 1,100,000

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 3.6. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэг жилд зарцуулах зардал (Төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Үндэсний хорооны нийт албан хаагчид /0.075/ ногдох зардал		404,658

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 3.7. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)	Хүний нөөцийн зардал (Төгрөгөөр)	Материаллаг зардал (Төгрөгөөр)	Нийт
Улсын бүртгэлийн ерөнхий газар - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар	0.075	2,163,105	404,658	2,567,766

Уг хуулийн төслийн 42.8.7, 42.8.9 дэх заалтыг хэрэгжүүлэхэд үндэсний хорооны газар нөөцийн цалингийн зардалд нийт 2,163,105 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 404,658 нийт 2,567,766 (хоёр сая таван зуун жаран долоон мянга долоон зуун жаран зургаа) төгрөгийн зардал үүсэхээр байна.

1.2.4. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

1.2.4.1 Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Хуулийн төслийн 42.8.7, 42.8.9-д зааснаар тайлан, санал, зөвлөмж гаргах тохиолдлын тоо хамгийн багадаа 1 байна.

1.2.4.2 Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн 42.8.7, 42.8.9-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх давтамжийг тоог хамгийн бага утгаар авсан тус багасгах боломжгүй.

1.2.4.3 Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн 42.8.7, 42.8.9-д заасан мэдээллийн агуулгыг багасгах нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцэхгүй.

1.2.4.4 Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн 42.8.7, 42.8.9-д заасан мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой.

1.2.4.5 Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслөөр мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог тодорхой заасан тул уг тоог багасгах боломжгүй.

1.3 Хар тамхитай тэмцэх алба

1.3.1. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хуулийн төслийн 44.4.1, 44.4.2, 44.4.13 дахь заалтаас үзвэл Хар тамхитай тэмцэх алба дараах дөрвөн чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна. Үүнд

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах;

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг бүртгэх;
3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газарт үзлэг хийх;
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт холбогдсон болон үйлдсэн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг болно.

Хүснэгт 3.8. Хар тамхитай тэмцэх албаны стандарт үйл ажиллагаатай холбоотой үүсэх хүний нөөцийн зардал

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)
Хар тамхитай тэмцэх алба	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах;	30	1	30
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг бүртгэх.	30	1	30
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газарт үзлэг хийх;	180	1	180
	Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг байлцуулах боломжгүй бол хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.	180	1	180
	Үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн бол 3 хоногийн дотор эзэмшигчид, боломжгүй бол эзэмшигчийн оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.	60	1	60
Нийт				480

Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн танилцуулгаас үзвэл мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 2023 онд 238, зөрчил 197 гарсан байна.⁵ Иймд давтамжийн тоог 2023 онд мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нийт дүнд үндэслэн тооцлоо.

5 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2 дахь тал, <https://mojha.gov.mn:8085/core/files/6646c2f99fea4ca6d5eb002f>

Хүснэгт 3.9. Хар тамхитай тэмцэх албаны стандарт үйл ажиллагаатай холбоотой үүсэх хүний нөөцийн зардал

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа (Мин)	Тохиолдлын тоо	Давтамжийн тоо	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)
Хар тамхитай тэмцэх алба	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах;	30	1	435	13,050
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг бүртгэх.	30	1	435	13,050
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газарт үзлэг хийх;	180	1	435	78,300
	Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг байлцуулах боломжгүй бол хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.	180	1	435	78,300
	Үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн бол 3 хоногийн дотор эзэмшигчид, боломжгүй бол эзэмшигчийн оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.	60	1	435	26,100
Нийт					208,800

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1600 ажлын цаг буюу (1600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 3.10. Хар тамхитай тэмцэх албаны стандарт үйл ажиллагаатай холбоотой үүсэх нийт хүний нөөцийн зардал

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)	Жилд шаардагдах ажлын цаг (Мин)	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)
Хар тамхитай тэмцэх алба	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах;	13,050	96,000	0.13
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг бүртгэх.	13,050	96,000	0.13
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газарт үзлэг хийх;	78,300	96,000	0.82
	Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг байлцуулах боломжгүй бол хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.	78,300	9,6000	0.82
	Үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн бол 3 хоногийн дотор эзэмшигчид, боломжгүй бол эзэмшигчийн оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.	26,100	96,000	0.27
Нийт				2.18

Хар тамхитай тэмцэх алба хуулийн төслөөр хүлээсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээн авах, бүртгэх, үзлэг хийх, үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулах, үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн талаар мэдэгдэх зэрэг үүргийг хэрэгжүүлэхэд 208,800 минут зарцуулах буюу чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ 2.18 байна.

1.3.2. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Хар тамхитай тэмцэх албаны албан хаагчийн цалинг Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-ний дунджаар буюу 1,618,000 төгрөгөөр тооцсон.⁶ Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 2,136,400 төгрөг /үүнээс нийт суутгал болох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хасаж нэг сарын дундаж цалинг 1,721,642 төгрөг/ байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 25,636,800 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 267,050 төгрөг буюу жилд 3,204,600 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар 28,841,400 төгрөг гэж тооцов.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 3.11. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)	Нэг албан хаагчийн нэг жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал (Төгрөгөөр)
Хар тамхитай тэмцэх алба	2.18	28,841,400	62,874,252

1.3.3. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

6 Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089709864081&showType=1>

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 3.12. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэг жилд зарцуулах зардал (Төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Нийт албан хаагчид ногдох нийт зардал		11,762,046

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 3.13. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)	Хүний нөөцийн зардал (Төгрөгөөр)	Материаллаг зардал (Төгрөгөөр)	Нийт
Хар тамхитай тэмцэх алба	2.18	62,874,252	11,762,046	74,636,298

Хар тамхитай тэмцэх алба хуулийн төслөөр хүлээсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээн авах, бүртгэх, үзлэг хийх, үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулах, үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн талаар мэдэгдэх зэрэг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн цалингийн зардалд 62,874,252 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 11,762,046 төгрөг, нийт 74,636,298 (далан дөрвөн сая зургаан зуун гучин зургаан мянга хоёр зуун ерэн найм) төгрөгийн зардал үүсэхээр байна.

1.3.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

1.3.4.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх:

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Судалгаанаас үзвэл хар тамхитай тэмцэх алба хуулийн төслөөр хүлээсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдсан тухай мэдээллийг хүлээн авах, бүртгэх, үзлэг хийх, үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулах, үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн талаар мэдэгдэх зэрэг үүргийг хэрэгжүүлэх тоо цаашид өсөх хандлага ажиглагдаж байна. Иймд тохиолдлын тоог багасгах боломжгүй.

1.3.4.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн төслийн заалт хэрэгжсэнээр хар тамхитай тэмцэх албаны чиг үүрэг өргөжих бөгөөд хар тамхитай хэрэгжих хүрээнд мэдээлэл хүргэх давтамжийг багасгах нь сөрөг үр дагавартай.

1.3.4.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн төслийн заалт хэрэгжсэнээр хар тамхитай тэмцэх албаны зүгээс мэдээллийн агуулгыг багасгах боломжтой.

1.3.4.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:

Хар тамхитай тэмцэх албаны зүгээс мэдээллийг цахимаар хүлээн авах, бүртгэх боломжийг бий судлах шаардлагатай.

1.3.4.5. Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх:

Хуулийн төслөөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг хүрээнд мэдээллийг хүргэх байгууллагын хүрээ хязгаарыг тогтоож өгсөн тул тоог багасгах боломжгүй.

1.3.5. Мэдээллийн сан үүсгэх зардлын тухайд

Хуулийн төсөлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт холбогдсон болон үйлдсэн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг тусгажээ. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлын тооцоог ижил төстэй байдлаар харьцуулан судаллаа. Тодруулбал, Хууль зүй, дотоод хэргийн яам 2023 онд зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд холбогдох дэд бүтцийн техник, тоног төхөөрөмжийг худалдан авах болон программ хангамжийг боловсруулах тендер шалгаруулалтыг 2023 онд зарлажээ. Уг тендер шалгаруулалтын үнийн дүн нь 1,300,000,000 төгрөг байна. Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хуулийн төсөлд заасан мэдээллийг сан бүрдүүлэхэд 1,300,000,000 төгрөг шаардлагатай гэж үзлээ.⁷

7 <https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1679449857738>.

1.4. Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч

1.4.1. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистиكت тоон мэдээллийг тооцсон болно.

Хуулийн төслийн 44.5.3-44.5.6 дахь заалтад хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагчийн чиг үүргийг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллагын байранд нэвтрэн орох;
- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банканд байгаа данс, гүйлгээг шалгах, түр зогсоох;
- Хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө битүүмжлэх;
- Албан тушаалтан, иргэнээс тайлбар гаргуулах, мэдүүлэг авах, түүнийг албадан ирүүлэх зэрэг болно.

Хүснэгт 3.14. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа (Мин)	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)
Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч	Цагдаагийн алба хаагч бусдын орон байранд нэвтрэн орохдоо оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрлийг заавал авсан байна.	60	1	60
	Оршин суугч, эзэмшигчийн эзгүйд орон байр, бусад газарт нэвтрэн орсон бол тэдгээрт даруй мэдэгдэх, боломжгүй бол 24 цагийн дотор мэдэгдэх арга хэмжээ авна	60	1	60
	Оршин суугч, эзэмшигчид мэдэгдэх боломжгүй бол түүний оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ	60	1	60
	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банканд байгаа данс, гүйлгээг түр зогсоох	240	1	240
	Хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө битүүмжлэх	240	1	240
	Тайлбар гаргуулах	120	1	120
	Мэдүүлэг авах	60	1	60
Нийт				800

Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн танилцуулгаас үзвэл мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 2023 онд 238, зөрчил 197 гарсан байна.⁸ Иймд давтамжийн тоог 2023 онд мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нийт дүнд үндэслэн тооцлоо.

Хүснэгт 3.15. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх нийт хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа (Мин)	Тохиолдлын тоо	Давтамжийн тоо	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)
Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч	Цагдаагийн алба хаагч бусдын орон байранд нэвтрэн орохдоо оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрлийг заавал авсан байна.	60	1	435	26,100
	Оршин суугч, эзэмшигчийн эзгүйд орон байр, бусад газарт нэвтрэн орсон бол тэдгээрт даруй мэдэгдэх, боломжгүй бол 24 цагийн дотор мэдэгдэх арга хэмжээ авна	60	1	435	26,100
	Оршин суугч, эзэмшигчид мэдэгдэх боломжгүй бол түүний оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.	60	1	435	26,100
	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банканд байгаа данс, гүйлгээг түр зогсоох	240	1	435	104,400
	Хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө битүүмжлэх	240	1	435	104,400
	Тайлбар гаргуулах	120	1	435	52,200
Нийт					339,300

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

⁸ Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2 дахь тал, <https://mojha.gov.mn:8085/core/files/6646c2f99fea4ca6d5eb002f>

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1600 ажлын цаг буюу (1600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 3.16. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)	Жилд шаардагдах ажлын цаг (Мин)	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)
Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч	339,300	96,000	3.53

Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч хуулийн төслийн 44.5.3- 44.5.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийт 339,300 минут зарцуулах буюу уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ 3.53 байна.

1.4.2. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Хар тамхитай тэмцэх албаны албан хаагчийн цалинг Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-ний дунджаар буюу 1,618,000 төгрөгөөр тооцсон. Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 2,136,400 төгрөг /үүнээс нийт суутгал болох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хасаж нэг сарын дундаж цалинг 1,721,642 төгрөг/ байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 25,636,800 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 267,050 төгрөг буюу жилд 3,204,600 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар 28,841,400 төгрөг гэж тооцов.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 3.17. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)	Нэг албан хаагчийн нэг жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал (Төгрөгөөр)
Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч	3.53	28,841,400	101,810,142

1.4.3. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 3.18. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэг жилд зарцуулах зардал (Төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Нийт албан хаагчид ногдох нийт зардал		19,045,882

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 3.19. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)	Хүний нөөцийн зардал (Төгрөгөөр)	Материаллаг зардал (Төгрөгөөр)	Нийт
Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч	3.53	101,810,142	19,045,882	120,856,024

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагчийн цалингийн зардалд 101,810,142 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 19,045,882 төгрөг, нийт 120,856,024 (зуун хорин сая найман зуун тавин зургаан мянга хорин дөрөв) төгрөгийн зардал үүсэхээр байна.

1.4.4. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

1.4.4.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх:

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Хуулийн төслийн 44.5.3- 44.5.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагчийн тохиолдлын тоог хамгийн багаар авсан тул бууруулах боломжгүй. .

1.4.4.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх:

Мэдээлэл хүргүүлэх давтамжийг тоог нэмэгдүүлэх нь хуулийн төсөлд эерэг нөлөөтэй.

1.4.4.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн төслийн дагуу мэдээллийн агуулгыг бүрэн зөв шалгах нь тус хуулийн үзэл баримтлалд нийцнэ гэж үзэж байна.

1.4.4.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:

Хуулийн төслийн 44.5.3- 44.5.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч нь мэдээллийг цахимаар шийдвэрлэх боломжтой.

1.4.4.5. Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх:

Мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог хуулийн төслөөр тодорхойлсон тул уг тоог багасгах боломжгүй.

1.5. Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан

1.5.1. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хуулийн төслийн 51.2.1-51.2.3-д заасан газар дээр, магадлан, дахин шинжилгээ авах чиг үүргийг хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан хэрэгжүүлэхээр байна.

Хүснэгт 3.20. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа (Мин)	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)
Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан	Газар дээр нь шинжилгээ авах	120	1	120
	Эмчийн хяналт дор тухай бүр хөндлөнгийн гэрч байлцуулан, дуудурсний бичлэгээр баримтжуулах.	120	1	120
	Хариуг шалгуулсан этгээдэд 24 цагийн дотор мэдэгдэх	480	1	480
	Гомдлыг 3 хоногийн дотор хүлээн авах.	1,440	1	1,440
	А дээжийг магадлан шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад 3 хоногийн дотор хүргүүлэх	1,440	1	1,440
	Хариуг шинжилгээ, хариуг шинжилгээ 5 хоногт хийж гүйцэтгэх.	2,400	1	2,400
	Шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн байгууллага, албан тушаалтанд 1 хоногийн дотор хүргүүлэх.	480	1	480
	Б сорьцын дахин шинжилгээ хийх хүсэлтийг хариу хүлээн авснаас 3 хоногийн дотор хүлээж авах.	1,440	1	1,440
	Б сорьцыг хүлээж авснаас хойш 3 хоногийн дотор шинжилгээний байгууллагад шилжүүлэх.	1,440	1	1,440
	Магадлан шинжилгээний байгууллага дахин шинжилгээг 5 хоногийн дотор хийнэ.	2,400	1	2,400
	Хариуг гарснаас хойш 1 хоногийн дотор Шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн байгууллагад хүргүүлнэ.	480	1	480
Нийт				12,240

Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн танилцуулгаас үзвэл мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 2023 онд 238, зөрчил 197 гарсан байна.⁹ Иймд давтамжийн тоог 2023 онд мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нийт дүнд үндэслэн тооцлоо.

Хүснэгт 3.21. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх нийт хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа (Мин)	Тохиолдлын тоо	Давтамжийн тоо	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)
Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан	Газар дээр нь шинжилгээ авах	120	1	435	52,200
	Эмчийн хяналт дор тухай бүр хөндлөнгийн гэрч байлцуулан, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулах	120	1	435	52,200
	Хариуг шалгуулсан этгээдэд 24 цагийн дотор мэдэгдэх	480	1	435	208,800
	Гомдлыг 3 хоногийн дотор хүлээн авах	1,440	1	435	626,400
	А дээжийг магадлан шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад 3 хоногийн дотор хүргүүлэх	1,440	1	435	626,400
	Хариуг шинжилгээ, хариуг шинжилгээ 5 хоногт хийж гүйцэтгэх	2,400	1	435	1,044,000
	Шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн байгууллага, албан тушаалтанд 1 хоногийн дотор хүргүүлэх	480	1	435	208,800
	Б сорьцын дахин шинжилгээ хийх хүсэлтийг хариу хүлээн авснаас 3 хоногийн дотор хүлээж авах	1,440	1	435	626,400
	Б сорьцыг хүлээж авснаас хойш 3 хоногийн дотор шинжилгээний байгууллагад шилжүүлэх	1,440	1	435	626,400
	Магадлан шинжилгээний байгууллага дахин шинжилгээг 5 хоногийн дотор хийнэ.	2,400	1	435	1,044,000
	Хариуг гарснаас хойш 1 хоногийн дотор Шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн байгууллагад хүргүүлнэ.	480	1	435	208,800
Нийт					5,324,400

9 Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2 дахь тал, <https://mojha.gov.mn:8085/core/files/6646c2f99fea4ca6d5eb002f>

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1600 ажлын цаг буюу (1600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 3.22. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ (Мин)	Жилд шаардагдах ажлын цаг (Мин)	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)
Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан	532,440,0	96,000	55.4

Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны зүгээс хуулийн төслийн 51.2.1-51.2.3-т заасан газар дээр, магадлан, дахин шинжилгээ авах чиг үүргийг хэрэгжүүлэхэд 55.4 хүний нөөц шаардлагатай.

1.5.2. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Хар тамхитай тэмцэх албаны албан хаагчийн цалинг Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-ний дунджаар буюу 1,618,000 төгрөгөөр тооцсон. Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 2,136,400 төгрөг (үүнээс нийт суутгал болох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хасаж нэг сарын дундаж цалинг 1,721,642 төгрөг) байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 25,636,800 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 267,050 төгрөг буюу жилд 3,204,600 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар 28,841,400 төгрөг гэж тооцов.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 3.23. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)	Нэг албан хаагчийн нэг жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал (Төгрөгөөр)
Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан	55.4	28,841,400	1,597,813,560

1.5.3. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 3.24. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Нийт албан хаагчид ногдох нийт зардал		298,907,043

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 3.25. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (Хүний тоо)	Хүний нөөцийн зардал (Төгрөгөөр)	Материаллаг зардал (Төгрөгөөр)	Нийт
Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан	55.4	1,597,813,560	298,907,043	1,896,720,603

Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны зүгээс хуулийн төслийн 51.2.1-51.2.3-т заасан газар дээр, магадлан, дахин шинжилгээ авах чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн цалингийн зардалд нийт 1,597,813,560 төгрөг хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 298,907,043 төгрөг нийт 1,896,720,603 (нэг тэрбум найман зуун ерэн зургаан сая долоон зуун хорин мянга зургаан зуун гурав) төгрөгийн зардал үүсэхээр байна.

1.5.4. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

1.5.4.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх:

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Судалгаанаас үзвэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой зөрчил, гэмт хэргийн тоо өсөх хандлагатай. Иймд тохиолдлын тоог бууруулах боломжгүй.

1.5.4.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх:

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой мэдээллийг давтамжийг нэмэгдүүлэх нь эерэг нөлөө үзүүлнэ.

1.5.4.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:

Тус хуулийн төслийн дагуу мэдээллийн агуулгыг бүрэн дүүрэн, зөв хүргэх шаардлагатай бөгөөд ингэснээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэх юм ..

1.5.4.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:

Хуулийн төслийн 51.2.1-51.2.3-д заасан газар дээр, магадлан, дахин шинжилгээ авах чиг үүргийг цахимаар хэрэгжүүлэх боломжтой байна.

1.5.4.5. Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх:

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслөөр мэдээллийг хүргүүлэх байгууллагыг тодорхойлсон. Иймд уг тоог багасгах нь хуулийн төслийн үйлчлэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул уг тоог багасгах боломжгүй.

II. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төсөлд хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах /Хүснэгт 25-д заасан/ дараах заалтууд байна. Үүнд:

Хүснэгт 3.26. Зардалд нөлөөлөх зүйл, заалт

Хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл, заалт
13 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам	12 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага
13.1. Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:	12.1. Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд олгоно.
13.1.1. эрхлэх үйл ажиллагааны зорилго, төрөл, үндсэн чиглэл, үндэслэл, мэргэжлийн хүний нөөцийн танилцуулга, дотоод хяналтын ажилтан болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх ажилтны мэргэшлийн бэлтгэл, сургалтын гэрчилгээ;	12.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:
13.1.2. эрхлэх үйл ажиллагаанд холбогдох аюулгүй ажиллагааны стандарт шаардлагад нийцсэн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө;	12.2.1. техникийн болон аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг бүрэн хангасан байх;
13.3.3. үйл ажиллагаа эрхлэх байрны аюулгүйн стандарт шаардлага хангасан дүгнэлт;	12.2.2. үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр мэргэжлийн хүний нөөцтэй байх;
13.1.4. дотоод хяналт тавих алба, эсхүл хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр;	12.2.3. мансуурах, согтуурах донтой болон өөр бусад шалтгаанаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг ажилтангүй байх;
13.1.5. эм, эмийн түүхий эд хадгалах агуулахын талаарх эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;	12.2.4. ажиллагсдыг сургаж, дадлагажуулах төлөвлөгөөтэй байх;
13.1.6. тухайн хуулийн этгээдэд мансуурах, согтуурах донтой болон өөр бусад шалтгаанаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис зүй бусаар хэрэглэдэг хүн бий эсэх талаарх Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн лавлагаа.	12.2.5. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, эргэлт, зарцуулалтын бүртгэлийг хөтөлж, тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлэх үйл ажиллагааг зохицуулсан дотоод журамтай байх;
13.2. Энэ хуулийн 11.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 13.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:	12.2.6. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх ажилтанд тавих ажил, үүргийн шаардлагыг дотоод журмаар тогтоосон байх;
13.2.1. үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, үйлдвэрлэлийн дамжлага болон дотоод хяналтын тогтолцооны тухай дэлгэрэнгүй танилцуулга;	12.2.7. тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хуульд заасны дагуу явуулах нөхцөлийг хангасан барилга байгууламж, дэвшилтэт технологитой байх;
13.2.2. нэг жилд үйлдвэрлэх эм, эмийн түүхий эдийн нэр, тун, хэлбэр, тоо, хэмжээний талаарх мэдээлэл.	12.2.8. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагыг бүрэн хангасан байх;
	12.2.9. компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаарх дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх.

13.3. Энэ хуулийн 11.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 13.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ: 13.3.1. экспортлогч буюу импортлогч талтай байгуулсан гэрээний хуулбар; 13.3.2. экспортлогч буюу импортлогч талд тухайн улс орноос олгосон импорт, экспортын зөвшөөрлийн хуулбар; 13.3.3. экспортлох, импортлох эм, эмийн түүхий эдийн нэр, тун, хэлбэр, тоо, хэмжээний талаарх мэдээлэл. 13.4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу баримт бичгийн бүрдлийг шалгана.	12.3. Энэ хуулийн 11.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 12.2-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна: 12.3.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, дүгнэлттэй байх; 12.3.2. тарималжуулах ургамал нь байгалийн бүс, бүслүүрийн онцлогт тохирсон байх; 12.3.3. байгалийн, тарималжуулсан, нутагшуулсан ургамлын үр ашигласан байх; 12.3.4. ургамал тарималжуулах талбай, иж бүрэн техниктэй байх, ургамлыг хадгалах агуулахтай байх; 12.3.5. мэргэшсэн агрономичтой байх. 12.4. Мансуурах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчилд ял, шийтгэл хүлээж байсан хүнээр мансуурах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.
15 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хураамж 15.1. Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тэмдэгтийн хураамж төлнө.	11 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 11.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох дараах үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж болно: 11.1.1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх; 11.1.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох, экспортлох, реэкспортлох; 11.1.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх; 11.1.4. мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах эмийн сангийн үйлчилгээ эрхлэх; 11.1.5. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх; 11.1.6. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх; 11.1.7. мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх. 11.2. Энэ хуулийн 11.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн мөн хуулийн 11.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд олгож болно. 11.3. Энэ хуулийн 10.3-т зааснаас бусад тохиолдолд мөн хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэхийг хориглоно.

21 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг 21.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ: 21.1.1.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулах байршлын талаарх мэдээллийг 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх; 21.1.2.энэ хуулийн 21.1.1-д заасан байршлыг өөрчилсөн тохиолдолд шинэ байршлын талаарх мэдээллийг 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх; 21.1.3.өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, хүлээн авахаас зарцуулах буюу өөрийн эзэмшлээс гаргах хүртэлх эргэлтийг тухай бүр тэмдэглэж, бүртгэл хөтлөх; 21.1.4.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис дутсан, үрэгдсэн, илүүдсэн, эсхүл бүртгэлтэй холбоотой бусад зөрчил гарсан тохиолдолд хар тамхитай тэмцэх албанд 24 цагийн дотор мэдэгдэх; 21.1.5.энэ хуулийн 11.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг зөвхөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий гадаад улсын этгээдэд экспортлох; 21.1.6.хууль тогтоомжид заасан бусад.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ. 20 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
22 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайлан 22.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагааныхаа тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор хар тамхитай тэмцэх албанд хүргүүлнэ. 22.2.Энэ хуулийн 11.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрлэсэн эм, эмийн түүхий эдийн нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, устгасан тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор хар тамхитай тэмцэх алба болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	23 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайланг хадгалах 23.1.Хар тамхитай тэмцэх алба болон энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч мөн хуулийн 22.1, 22.2-г заасан тайланг хугацаагүй хадгална.

24 дүгээр зүйл. Мансууруулах эм, эмийн түүхий эд үйлдвэрлэхэд тавих шаардлага 24.1.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсноос бусад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэхийг хориглоно. 24.2.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг энэ хуулийн 11.1.1-д заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн хүн, мал, амьтанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зориулалтаар үйлдвэрлэж болно. 24.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх ажиллагааг магадлан итгэмжлэгдсэн лаборатори, энэ хуульд заасан эрх бүхий эрдэм, шинжилгээ, судалгааны төрийн байгууллагатай хамтран, эсхүл дангаар эрхэлж болно. 24.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эмийн магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргуулна. 24.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, бүтээгдэхүүний нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ. 20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
25 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлоход тавих шаардлага 25.1.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсноос бусад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлохыг хориглоно. 25.2.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг энэ хуулийн 11.1.2-т заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эм, эмийн түүхий эд үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж, экспортолж, реэкспортолж болно.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ.

25.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох, экспортлоход Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах эмийн тухай 1961 оны Конвенцын 31 дүгээр зүйл, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны Конвенцын 12, 13 дугаар зүйл, Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны Конвенцын 16 дугаар зүйлд заасныг баримтална. 25.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлж, өөрийн агуулахад татан авснаас хойш 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад импортлосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээг мэдээлнэ. 25.5.Гадаад улс, орны эм үйлдвэрлэгчийн Монгол Улс дахь албан ёсны гэрээт борлуулагч тусгай зөвшөөрөл эзэмшигч гадаад улс, орны үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг үндэслэн бусад улс, оронд тухайн үйлдвэрлэгчийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг реэкспортлож болно. 25.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн импортлосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нь чанар, стандарт, аюулгүй байдал болон гэрээний шаардлага хангаагүйгээс экспортлосон улс орон руу экспортлогчийн албан ёсны хүсэлтийг үндэслэн буцаан гаргаж, реэкспорт хийж болно. 25.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, гарал үүсэл, тоо хэмжээ, чанар, огноо, хүлээн авсан улс, орон, этгээдийн мэдээлэл, зорилго, шалтгаан, нэвтрүүлсэн хилийн боомт зэрэг мэдээллийг импортлосон, экспортлосон, реэкспортлосноос хойш 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
26 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хилээр нэвтрүүлэхэд тавих шаардлага 26.1.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсноос бусад болон тусгай зөвшөөрөлд заасан тоо, хэмжээг хэтрүүлэн, эсхүл тусгай зөвшөөрөлд заасан нэр, төрлөөс зөрүүтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хилээр нэвтрүүлэхийг хориглоно. 26.2.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг энэ хуулийн 11.1.6-д заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн мөн хуулийн 26.7-д заасан хилийн боомтоор хилээр нэвтрүүлж болно.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ. 20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

26.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө дээжийг хилийн боомтын гаалийн лабораторийн шинжилгээнд заавал хамруулна.	20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
27 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэхэд тавих шаардлага 27.1.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсноос бусад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэхийг хориглоно. 27.2.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдааг энэ хуулийн 11.1.3-т заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж болно. 27.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн, импортолсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон энэ хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглах эрх бүхий байгууллага, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах тусгай зөвшөөрөл бүхий эмийн санд худалдаж болно. 27.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисыг худалдахдаа худалдан авах гэрээ, өмнөх худалдан авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайлан, худалдан авагчийн захиалгыг үндэслэх ба гэрээ, тайлан, захиалгыг цахим болон цаасан хэлбэрээр баримтжуулан 5 жил хадгална. 27.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч худалдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ. 20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн;

	20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
28 дугаар зүйл. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмийн сангаас олгоход тавих шаардлага 28.1.Энэ хуулийн 28.2-т зааснаас бусад тохиолдолд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмийн сангаас олгохыг хориглоно. 28.2.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг энэ хуулийн 11.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан цахим жороор олгож болно. 28.3.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг хүчинтэй жор, үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэхийг үндэслэн жорд заасан хэмжээгээр олгоно. 28.4.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан нь үйлчлүүлэгчийн бичиг баримтыг шалгаж, жорд заасан өвчтөн, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн мөн эсэхийг нягтална. 28.14.Жорын зарцуулалтын тайланг энэ хуулийн 28.7-д заасан мэдээллийг тусган улирлаар гарган, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ. 20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
29 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэхэд тавих шаардлага 29.1.Энэ хуулийн 29.2-т зааснаас бусад тохиолдолд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэхийг хориглоно. 29.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмнэлгийн нөхцөлд, хөнгөвчлөх эмчилгээнд, эсхүл яаралтай тусламж, үйлчилгээнд эмчийн бичсэн эмчилгээний заалтын дагуу өвчтөнд хэрэглэх бөгөөд шаардлагатай тохиолдолд эмчийн бичсэн жорын дагуу эмчилгээнд олгож үйлчилнэ.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ.

29.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн захиалгыг бусад эмнээс тусад нь баталгаажуулна. 29.4.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага дараа онд хэрэглэх шаардлагатай мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр төрөл, тоо хэмжээг тооцон эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өмнөх оны 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ. 29.5.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага захиалсан, хүлээн авсан, хэрэглэсэн, үлдсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн талаарх огноо, тайланг улирлаар гарган дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
30 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүхэд тавих шаардлага 30.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг энэ хуулийн 30.2-т зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт тарималжуулах, түүхийг хориглоно. 30.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг энэ хуулийн 11.1.7-д заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр тарималжуулж, түүж болно. 30.3.Тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь түүж бэлтгэсэн, боловсруулсан, хэрэглэсэн, ашигласан, тээвэрлэсэн, түгээсэн, худалдсан, үлдсэн буюу хадгалсан ургамлын нэр, тоо хэмжээ, ургамал түүсэн талбайн байршил, хэмжээ, түүж бэлтгэсэн зорилго, түүсэн ургамлыг хүлээн авсан, худалдсан огноо, худалдан авсан этгээдийн нэр, хаяг, үйл ажиллагааны талаарх тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ. 20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан;

	20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
38 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэхэд тавихад шаардлага 38.1.Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн энэ хуулийн 11.1.6-д заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хууль, стандартад заасан хадгалах нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр тээвэрлэж болно. 38.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг тээвэрлэхдээ дараах шаардлагыг хангана: 38.2.1.дохиолол, дуу-дүрсний бичлэгийн системтэй холбогдсон зориулалтын автотээврийн хэрэгсэлтэй байх; 38.2.2.зориулалтын автотээврийн хэрэгсэл нь байршил тогтоогч, хэм болон чийг хэмжигчтэй байх. 38.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тээвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, тоо хэмжээ, тээвэрлэлтийн зам, чиглэл, тээвэрлүүлсэн болон хүлээн авсан этгээдийн нэр, хаяг, огноо зэрэг мэдээлэл бүхий тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ. 20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.

39 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгахад тавих шаардлага 39.2.Энэ хуулийн 11.1.1-11.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэх хугацаа дууссан, чанараа алдсан, үйлдвэрийн технологийн зааврын дагуу хийгдээгүй, чанарын баталгаажуулалтгүй, сав, баглаа боодлын битүүмжлэл, бүрэн бүтэн байдал алдагдсан, эсхүл шошго, нэр хаяггүй, үйлдвэрийн сав боглоо боодол, хаяг шошго алдаатай, хадгалалтын горим алдагдсан, нас барсан өвчтөн хэрэглэж байсан эмийн үлдэгдэл, төрөл, бүтэц, орцыг тодорхойлох боломжгүй, дахин ашиглах, хэрэглэх боломжгүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн хар тамхитай тэмцэх албатай хамтран устгана. 39.3.Энэ хуулийн 39.2-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгахдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 39.3.1.эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн устгалын комиссыг тухай бүр томилон, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулан устгах; 39.3.2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгахдаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын байцаагч болон хар тамхитай тэмцэх албаны төлөөллийг байлцуулах; 39.3.3.устгасан талаарх акт, дуу-дүрсний бичлэг зэрэг бусад баримт бичгийг цахим болон цаасан хэлбэрээр 5 жил хадгалах. 39.4.Энэ хуулийн 39.2-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь устгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, устгалд оруулсан хугацаа, байршил, устгуулсан байгууллагын нэр, устгасныг баримтжуулсан дуу-дүрсний бичлэг бүхий тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	18 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх 18.1.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаас гадна мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих нөхцөл, боломжгүй болсон нь хар тамхитай тэмцэх болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд түдгэлзүүлнэ. 20 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 20.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно: 20.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан; 20.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан; 20.1.3.хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн; 20.1.4.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан; 20.1.5.хуульд заасан үндэслэлээр нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг нэгээс дээш удаа түдгэлзүүлсэн.
--	--

Тус хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зүйл, заалтад өөрчлөлт орсон болон нэмж туссан, хуулийн этгээдийн зардалд нөлөөлөх зүйл, заалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно.

Хүснэгт 3.27. Хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэг, стандарт үйл ажиллагаа

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Тусгай зөвшөөрөл шинээр эзэмшигч хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд чөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах	Хуульд заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангах; Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хураамж төлөх	Эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг төлөх.
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг биелүүлэх	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулах байршлын талаарх мэдээллийг 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх; Өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, хүлээн авахаас зарцуулах буюу өөрийн эзэмшлээс гаргах хүртэлх эргэлтийг тухай бүр тэмдэглэж, бүртгэл хөтлөх;
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, эмийн түүхий эд үйлдвэрлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эмийн магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргуулах; Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, бүтээгдэхүүний нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлоход тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, гарал үүсэл, тоо хэмжээ, чанар, огноо, хүлээн авсан улс, орон, этгээдийн мэдээлэл, зорилго, шалтгаан, нэвтрүүлсэн хилийн боомт зэрэг мэдээллийг импортолсон, экспортолсон, реэкспортолсноос хойш 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх; Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө дээжийг хилийн боомтын гаалийн лабораторийн шинжилгээнд заавал хамруулах; Үйл ажиллагааныхаа тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисыг худалдахдаа худалдан авах гэрээ, өмнөх худалдан авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайлан, худалдан авагчийн захиалгыг үндэслэх ба гэрээ, тайлан, захиалгыг цахим болон цаасан хэлбэрээр баримтжуулан 5 жил хадгална. Тусгай зөвшөөрөл эзэмшигч худалдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.
Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмийн сангаас олгоход тавих шаардлагыг хангах	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм хүлээн авсан хүний овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, гэрийн хаяг, огноо, жор баригчийн мэдээлэл зэргийг тусгасан тайланг улирлаар гарган, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.
Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэхэд тавих шаардлагыг хангах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага дараа онд хэрэглэх шаардлагатай мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр төрөл, тоо хэмжээг тооцон эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өмнөх оны 1 дүгээр улиралд багтаан хүргүүлэх; Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага захиалсан, хүлээн авсан, хэрэглэсэн, үлдсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн талаарх огноо, тайланг улирлаар гарган дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагын эмийн сан нь хүлээн авсан, олгосон, устгасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр, цувралын дугаар, огноо болон зарцуулалтын бүртгэл хөтөлж, бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр 5 жил хадгалж, энэ хугацаа дууссаны дараа байгууллагын архивд шилжүүлэх.
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь түүж бэлтгэсэн, боловсруулсан, хэрэглэсэн, ашигласан, тээвэрлэсэн, түгээсэн, худалдсан, үлдсэн буюу хадгалсан ургамлын нэр, тоо хэмжээ, ургамал түүсэн талбайн байршил, хэмжээ, түүж бэлтгэсэн зорилго, түүсэн ургамлыг хүлээн авсан, худалдсан огноо, худалдан авсан этгээдийн нэр, хаяг, үйл ажиллагааны талаарх тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэхэд тавих шаардлагыг хангах	Дохиолол, дуу-дүрсний бичлэгийн системтэй холбогдсон зориулалтын автотээврийн хэрэгсэлтэй байх; Зориулалтын автотээврийн хэрэгсэл нь байршил тогтоогч, хэм болон чийг хэмжигчтэй байх Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тээвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, тоо хэмжээ, тээвэрлэлтийн зам, чиглэл, тээвэрлүүлсэн болон хүлээн авсан этгээдийн нэр, хаяг, огноо зэрэг мэдээлэл бүхий тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.
---	--	---

2.2. Зардал тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тус бүрд зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг харгалзан үзэв. Үүнд:

- 1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
- 2. Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;
- 3. Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно. Цаг хугацааг тооцохдоо зарцуулах хугацааг минутаар тооцож гаргана.

Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуйн нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцох бөгөөд зарим тохиолдолд тусгай мэдлэг, мэргэжил, ур чадвар шаардсан үйл ажиллагаанд өндөр цалин, хангамж олгож буй тохиолдлыг анхаарч авч үздэг.

Мөн нэг сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааснаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргана.

Хүснэгт 3.28. Аж ахуйн нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин, (Мянган төгрөгөөр)¹⁰

	2021	2022	2023
Улсын дундаж	1,279.4	1,503.8	2,235.4

Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын сарын дундаж цалин сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлтэй байна. Иймд 2023 оны дундаж

10 Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, өмчийн хэлбэр, хүйс, улирал, жилээр https://www.1212.mn/mn/statistic/statcate/48171320/table-view/DT_NSO_0400_023V1

цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг 2,235,400 төгрөг байхаар, ажиллах хугацааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар тооцлоо. Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр /22*8=176 цаг, 176*60=10,560 минут/ ажилладаг байна.

Үндсэн цалин / Ажиллах хугацаа = Ажлын хөлс /төгрөг/

2,235,400 / 176 цаг = 12701 төгрөг /цагт/

2,235,400 / 10560 минут = 211 төгрөг /мин/

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр= ажлын 8 цаг

1 цаг = ажлын 60 минут

Хүснэгт 3.29. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлс (Цаг, минутаар)

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд чөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах	Хуульд заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангах; Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	2,400	211	506,400
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хураамж төлөх	Эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг төлөх.	60	211	12,660
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг биелүүлэх	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулах байршлын талаарх мэдээллийг 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх;	60	211	12,660
		Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулах байршлын талаарх мэдээллийг 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх;	480	211	101,280
		Өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, хүлээн авахаас зарцуулах буюу өөрийн эзэмшлээс гаргах хүртэлх эргэлтийг тухай бүр тэмдэглэж, бүртгэл хөтлөх;	96,000 ¹¹	211	20,256,000
Нийт					20,889,000

11 Тус чиг үүргийг бүтэн жилийн турш хэрэгжүүлэх чиг үүрэг гэж үзэн зарцуулах хугацааг жилээр тооцсон болно.

Хүснэгт 3.30. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлс (Цаг, минутаар)

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, эмийн түүхий эд үйлдвэрлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эмийн магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргуулах;	480	211	101,280
		Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, бүтээгдэхүүний нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	480	211	101,280
Нийт					202,560

Хүснэгт 3.31. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг , минутаар

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлоход тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, гарал үүсэл, тоо хэмжээ, чанар, огноо, хүлээн авсан улс, орон, этгээдийн мэдээлэл, зорилго, шалтгаан, нэвтрүүлсэн хилийн боомт зэрэг мэдээллийг импортлох, экспортлох, реэкспортолноос хойш 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	960	211	202,560
		Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө дээжийг хилийн боомтын гаалийн лабораторийн шинжилгээнд заавал хамруулах;	480	211	101,280

		Үйл ажиллагааныхаа тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх.	480	211	101,280
		Үйл ажиллагааныхаа тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх.	480	211	101,280
Нийт					506,400

Хүснэгт 3.32. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисыг худалдахдаа худалдан авах гэрээ, өмнөх худалдан авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайлан, худалдан авагчийн захиалгыг үндэслэх ба гэрээ, тайлан, захиалгыг цахим болон цаасан хэлбэрээр баримтжуулан 5 жил хадгална.	96,000	211	20,256,000
		Тусгай зөвшөөрөл эзэмшигч худалдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	480	211	101,280
Нийт					20,357,280

Хүснэгт 3.33. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмийн сангаас олгоход тавих шаардлагыг хангах	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм хүлээн авсан хүний овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, гэрийн хаяг, огноо, жор баригчийн мэдээлэл зэргийг тусгасан тайланг улирлаар гарган, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	480	211	101,280
Нийт					101,280

Хүснэгт 3.34. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэхэд тавих шаардлагыг хангах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага дараа онд хэрэглэх шаардлагатай мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр төрөл, тоо хэмжээг тооцон эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өмнөх оны 1 дүгээр улиралд багтаан хүргүүлэх.	480	211	101,280
		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага захиалсан, хүлээн авсан, хэрэглэсэн, үлдсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн талаарх огноо, тайланг улирлаар гарган дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	480	211	101,280

		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагын эмийн сан нь хүлээн авсан, олгосон, устгасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр, цувралын дугаар, огноо болон зарцуулалтын бүртгэл хөтөлж, бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр 5 жил хадгалж, энэ хугацаа дууссаны дараа байгууллагын архивд шилжүүлэх.	96,000	211	20,256,00
Нийт					20,559,840

Хүснэгт 3.35. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь түүж бэлтгэсэн, боловсруулсан, хэрэглэсэн, ашигласан, тээвэрлэсэн, түгээсэн, худалдсан, үлдсэн буюу хадгалсан ургамлын нэр, тоо хэмжээ, ургамал түүсэн талбайн байршил, хэмжээ, түүж бэлтгэсэн зорилго, түүсэн ургамлыг хүлээн авсан, худалдсан огноо, худалдан авсан этгээдийн нэр, хаяг, үйл ажиллагааны талаарх тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	480	211	101,280
Нийт					101,280

Хүснэгт 3.36. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд хөдөлмөр эрхэлж буй ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тээвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, тоо хэмжээ, тээвэрлэлтийн зам, чиглэл, тээвэрлүүлсэн болон хүлээн авсан этгээдийн нэр, хаяг, огноо зэрэг мэдээлэл бүхий тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	480	211	101,280
Нийт					101,280

2.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хэчнээн хуулийн этгээдэд, жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцоходоо тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцоходоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);

Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Дээрх чиг үүргийн тохиолдлын тоог тогтоох боломжгүй буюу хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулагдах боломжтой тул тохиолдлыг тоог 1 хуулийн этгээдээр зардлыг тооцлоо.

Хүснэгт 3.37. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоон үзүүлэлтийг тодорхойлох нь

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Тусгай зөвшөөрөл шинээр эзэмшигч хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах	Хуульд заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангах;	1	1	1
		Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	1	1	1
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хураамж төлөх	Эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг төлөх.	1	1	1
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг биелүүлэх	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулах байршлын талаарх мэдээллийг 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх;	1	1	1
		Өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, хүлээн авахаас зарцуулах буюу өөрийн эзэмшлээс гаргах хүртэлх эргэлтийг тухай бүр тэмдэглэж, бүртгэл хөтлөх;	1	1	1

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, эмийн түүхий эд үйлдвэрлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эмийн магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргуулах;	1	1	1
		Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, бүтээгдэхүүний нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	1	4	4
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлоход тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, гарал үүсэл, тоо хэмжээ, чанар, огноо, хүлээн авсан улс, орон, этгээдийн мэдээлэл, зорилго, шалтгаан, нэвтрүүлсэн хилийн боомт зэрэг мэдээллийг импортолсон, экспортолсон, реэкспортлосноос хойш 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	1	1	1
		Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө дээжийг хилийн боомтын гаалийн лабораторийн шинжилгээнд заавал хамруулах;	1	1	1
		Үйл ажиллагааныхаа тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх.	1	4	4
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдахдаа худалдан авах гэрээ, өмнөх худалдан авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайлан, худалдан авагчийн захиалгыг үндэслэх ба гэрээ, тайлан, захиалгыг цахим болон цаасан хэлбэрээр баримтжуулан 5 жил хадгална.	1	1	1
		Тусгай зөвшөөрөл эзэмшигч худалдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	1	4	4

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмийн сангаас олгоход тавих шаардлагыг хангах	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм хүлээн авсан хүний овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, гэрийн хаяг, огноо, жор баригчийн мэдээлэл зэргийг тусгасан тайланг улирлаар гарган, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	1	4	4
Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэхэд тавих шаардлагыг хангах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага дараа онд хэрэглэх шаардлагатай мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр төрөл, тоо хэмжээг тооцон эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өмнөх оны 1 дүгээр улиралд багтаан хүргүүлэх.	1	1	1
		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага захиалсан, хүлээн авсан, хэрэглэсэн, үлдсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн талаарх огноо, тайланг улирлаар гарган дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	1	4	4
		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагын эмийн сан нь хүлээн авсан, олгосон, устгасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр, цувралын дугаар, огноо болон зарцуулалтын бүртгэл хөтөлж, бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр 5 жил хадгалж, энэ хугацаа дууссаны дараа байгууллагын архивд шилжүүлэх.	1	1	1
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь түүж бэлтгэсэн, боловсруулсан, хэрэглэсэн, ашигласан, тээвэрлэсэн, түгээсэн, худалдсан, үлдсэн буюу хадгалсан ургамлын нэр, тоо хэмжээ, ургамал түүсэн талбайн байршил, хэмжээ, түүж бэлтгэсэн зорилго, түүсэн ургамлыг хүлээн авсан, худалдсан огноо, худалдан авсан этгээдийн нэр, хаяг, үйл ажиллагааны талаарх тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	1	4	4
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тээвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, тоо хэмжээ, тээвэрлэлтийн зам, чиглэл, тээвэрлүүлсэн болон хүлээн авсан этгээдийн нэр, хаяг, огноо зэрэг мэдээлэл бүхий тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	1	4	4

2.4. Зардлын дүнг тооцож гаргах

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

Хүснэгт 3.38. Нийт зардлын дүн

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зардал	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд чөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах	Хуульд заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангах;	506,400	1	506,400
		Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	12,660	1	12,660
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хураамж төлөх	Эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг төлөх.	12,660	1	12,660
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг биелүүлэх	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулах байршлын талаарх мэдээллийг 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх	101,280	1	101,280
		Өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, хүлээн авахаас зарцуулах буюу өөрийн эзэмшлээс гаргах хүртэлх эргэлтийг тухай бүр тэмдэглэж, бүртгэл хөтлөх;	20,256,000	1	20,256,000
Нийт					20,889,000
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, эмийн түүхий эд үйлдвэрлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эмийн магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргуулах;	101,280	1	101,280

		Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, бүтээгдэхүүний нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	10,1280	4	405,120
Нийт					506,400
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлоход тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, гарал үүсэл, тоо хэмжээ, чанар, огноо, хүлээн авсан улс, орон, этгээдийн мэдээлэл, зорилго, шалтгаан, нэвтрүүлсэн хилийн боомт зэрэг мэдээллийг импортлох, экспортлох, реэкспортлохноос хойш 3 хоногийн дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	202,560	1	202,560
		Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө дээжийг хилийн боомтын гаалийн лабораторийн шинжилгээнд заавал хамруулах;	101,280	1	101,280
		Үйл ажиллагааныхаа тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хар тамхитай тэмцэх албанд хүргүүлэх.	101,280	4	405,120
Нийт					708,960
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдахдаа худалдан авах гэрээ, өмнөх худалдан авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайлан, худалдан авагчийн захиалгыг үндэслэх ба гэрээ, тайлан, захиалгыг цахим болон цаасан хэлбэрээр баримтжуулан 5 жил хадгална.	20,256,000	1	20,256,000

		Тусгай зөвшөөрөл эзэмшигч худалдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан, хадгалсан, устгасан огноо, тайланг эм, эмийн түүхий эд бүрээр улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	101,280	4	405,120
Нийт					20,661,120
Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг эмийн сангаас олгоход тавих шаардлагыг хангах	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм хүлээн авсан хүний овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, гэрийн хаяг, огноо, жор баригчийн мэдээлэл зэргийг тусгасан тайланг улирлаар гарган, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	101,280	4	405,120
Нийт					405,120
Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэхэд тавих шаардлагыг хангах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага дараа онд хэрэглэх шаардлагатай мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр төрөл, тоо хэмжээг тооцон эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өмнөх оны 1 дүгээр улиралд багтаан хүргүүлэх.	101,280	1	101,280
		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага захиалсан, хүлээн авсан, хэрэглэсэн, үлдсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн талаарх огноо, тайланг улирлаар гарган дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	101,280	4	405,120

		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагын эмийн сан нь хүлээн авсан, олгосон, устгасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэр, цувралын дугаар, огноо болон зарцуулалтын бүртгэл хөтөлж, бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр 5 жил хадгалж, энэ хугацаа дууссаны дараа байгууллагын архивд шилжүүлэх.	20,256,000	1	20,256,000
Нийт					20,762,400
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь түүж бэлтгэсэн, боловсруулсан, хэрэглэсэн, ашигласан, тээвэрлэсэн, түгээсэн, худалдсан, үлдсэн буюу хадгалсан ургамлын нэр, тоо хэмжээ, ургамал түүсэн талбайн байршил, хэмжээ, түүж бэлтгэсэн зорилго, түүсэн ургамлыг хүлээн авсан, худалдсан огноо, худалдан авсан этгээдийн нэр, хаяг, үйл ажиллагааны талаарх тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	101,280	4	405,120
Нийт					405,120
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэхэд тавих шаардлагыг хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тээвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, тоо хэмжээ, тээвэрлэлтийн зам, чиглэл, тээвэрлүүлсэн болон хүлээн авсан этгээдийн нэр, хаяг, огноо зэрэг мэдээлэл бүхий тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор хар тамхитай тэмцэх алба болон эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.	101,280	4	405,120
Нийт					405,120

Хүснэгт 3.39. Нийт зардлын товч

Хуулийн этгээдийн нэр, төрөл	Зардлын дүн
Тусгай зөвшөөрөл шинээр эзэмшигч хуулийн этгээд	20,889,000
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	506,400
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	708,960
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	20,661,120

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	405,120
Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	20,762,400
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	405,120
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	405,120
Нийт	64,743,240

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран дээрх зардал хуулийн этгээд тус бүрд үүсэхээр байна. Тус зардал нь хуулийн этгээдийн тооноос шууд хамааралтай болохыг дурдах нь зүйтэй.

2.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1. Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлийг заасан. Тус 7 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдүүд хуулийг заавал мөрдөх тул хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй.

2.5.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн төсөлд зааснаар тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд улирал бүр үйл ажиллагааны тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, хүлээн авахаас зарцуулах буюу өөрийн эзэмшлээс гаргах хүртэлх эргэлтийг тухай бүр тэмдэглэж, бүртгэл хөтлөх, баримт бүртгэл, тайлангийн мэдээллийг архивлаж хадгалах чиг үүргийг тусгасан байна. Тайлан хүргүүлэх давтамжийн тоо нь жилд 4 удаа буюу улирал бүр байхаар заасан нь хуулийн зорилтод тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэхэд эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах чиг үүрэгтэй байна. Иймд мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах нь хуулийн төслийн зорилтод нийцэхгүй гэж үзэж байна.

2.5.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:

Дээр заасан мэдээллийн агуулгыг бүрэн зөв бүртгэж, тайлагнах нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилтод нийцэх тул мэдээллийг багасгах чиглэлийг баримтлах нь зохимжгүй гэж үзлээ.

2.5.4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:

Хуулийн төслийн 62 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын улсын хэмжээний цахим мэдээллийн нэгдсэн сангийн талаар зохицуулсан ба тус мэдээллийн санд тайлан, мэдээлэл оруулах үүрэг бүхий этгээд нэвтрэх эрх авах, мэдээлэл оруулах, үйлдэл баталгаажуулах ажлыг цахимаар гүйцэтгэхээр заасан. Иймд мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой байна.

2.6. Нэмэлт зардлыг тооцох

Энэ хэсэгт тус хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийн улмаас хуулийн этгээдэд бусад төрлийн нэмэлт зардал гарахгүй гэж тооцоолов.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн төсөлд зардлын тооцоо хийх нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох зорилготой байдаг. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төр, хуулийн этгээдэд учрах зардлыг урьдчилан тодорхойлох, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэж, дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Нэг. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Хуулийн төслөөр Үндэсний хороо, Хар тамхитай тэмцэх алба, Хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч, Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд нийт 3,394,780,691 (гурван тэрбум гурван зуун ерэн дөрвөн сая долоон зуун наян мянга зургаан зуун ерэн нэг) төгрөгийн зардал гарахаар байна.

Үндэсний хороо хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.8.7, 42.8.9 дэх заалтыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн цалингийн зардалд нийт 2,163,105 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 404,658 нийт 2,567,766 (хоёр сая таван зуун жаран долоон мянга долоон зуун жаран зургаа) төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хар тамхитай тэмцэх алба хуулийн төслөөр хүлээсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээн авах, бүртгэх, үзлэг хийх, үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулах, үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн талаар мэдэгдэх зэрэг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн цалин зардалд 62,874,252 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 11,762,046 төгрөг, нийт 74,636,298 (далан дөрвөн сая зургаан зуун гучин зургаан мянга хоёр зуун ерэн найм) төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хуулийн төсөлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт холбогдсон болон үйлдсэн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд 1,300,000,000 төгрөг зарцуулахаар байна.

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлийн 44.5.3- 44.5.6 дахь заалтад хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагчийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хар тамхитай тэмцэх албаны гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагчийн цалингийн зардалд 101,810,142 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 19,045,882 төгрөг, нийт 120,856,024 (нэг зуун хорин сая найман зуун тавин зургаан мянга хорин дөрөв) төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хар тамхитай тэмцэх алба, цагдаа, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны зүгээс хуулийн төслийн 51 дүгээр зүйлийн 51.2.1-51.2.3 дахь заалтад заасан газар дээр, магадлан, дахин шинжилгээ авах чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн цалингийн зардалд нийт 1,597,813,560 төгрөг хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 298,907,043 төгрөг нийт 1,896,720,603 (Нэг тэрбум найман зуун ерэн зургаан сая долоон зуун хорин мянга зургаан зуун гурав) төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хоёр. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлийг заасан. Тус 7 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд тус бүрд үүсэх зардлыг тооцооллоо. Тухайлбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд 506,400 төгрөг, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг импортлох, экспортлох, реэкспортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд 708,960 төгрөг, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд 20,661,120 төгрөг, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд 405,120 төгрөг, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд 20,762,400 төгрөг, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг тарималжуулах, түүх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд 405,120 төгрөг, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд 405,120 төгрөгийн зардал тус тус үүсэхээр байна гэж тооцов. Тус зардал нь тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тооноос шууд хамаарна.

Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд улирал бүр үйл ажиллагааны тайланг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх, өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, хүлээн авахаас зарцуулах буюу өөрийн эзэмшлээс гаргах хүртэлх эргэлтийг тухай бүр тэмдэглэж, бүртгэл хөтлөх, баримт бүртгэл, тайлангийн мэдээллийг архивлаж хадгалах чиг үүргийг тусгасан онцлогтой байна. Үүнээс, тайлан хүргүүлэх давтамжийн тоо нь жилд 4 удаа буюу улирал бүр байхаар заасан нь хуулийн зорилтод тусгасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэхэд эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах чиг үүрэгтэй ба уг мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах нь хуулийн төслийн зорилтод нийцэхгүй гэж үзлээ. Мөн үйл ажиллагааны тайлан гаргах, хүргүүлэх, бүртгэл мэдээлэл хөтлөх, тайлан баримт, мэдээллийг хадгалах, архивлах үйл ажиллагаа нь практикт буюу тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүдэд хэвшсэн үйл ажиллагаа байхыг дурдах нь зүйтэй.